

# “ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЭКСПОРТЫН ЗАХ ЗЭЭЛ, БОЛОМЖИТ ХУВИЛБАРУУДЫН СУДАЛГАА, ЗӨВЛӨМЖ”

## Зөвлөх үйлчилгээний эцсийн тайлан
## “Монгол улсын аялал жуулчлалын эвентийн стратеги төлөвлөгөө, бүтээгдэхүүн хөгжлийн дүн шинжилгээ, зөвлөмж”

АФИМ Монголиа ТББ

2022 он

## *Агуулга*


НЭГ. МОНГОЛЫН АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН БОЛОМЖИТ АРВАН ЭВЕНТ .......... 9

1.1. ТӨСЛИЙН ТАНИЛЦУУЛГА.......9

1.1.1 Товч танилцуулга.......9

1.1.2 Төслийн зорилго, зорилтууд.......10

1.1.3 Аялал жуулчлалын салбарт төрөөс баримтлах бодлого, баримт бичиг.......11

1. 2. АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН ЭВЕНТ.......11

1.2.1 Аялал жуулчлалын бүтээгдэхүүн, түүний төрөл.......11

1.2.2 Аялал жуулчлалын эвент, төрөл, онцлог.......12

1.3. ДЭЛХИЙН АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН ЭВЕНТИЙН ЭДИЙН ЗАСГИЙН НӨЛӨӨЛЛИЙН ШИНЖИЛГЭЭ.......17

1.3.1 Эдийн засгийн нөлөөллийг тооцох онолын үндэслэл.......17

1.3.2 Эдийн засгийн нөлөөллийг тооцох үндсэн үзүүлэлтүүд.......20

1.3.3 Дэлхийн топ эвентүүдийн эдийн засгийн нөлөөллийн шинжилгээ.......20

1.4. МОНГОЛ УЛСАД ЗОХИОН БАЙГУУЛАГДСАН ТОП 5 ЭВЕНТИЙН ЭДИЙН ЗАСГИЙН НӨЛӨӨЛЛИЙН СУДАЛГАА.......23

1.4.1 Эдийн засгийн нөлөөллийн судалгаа.......23

1.4.2 Сайжруулах санал, зөвлөмж.......27

1. 5. МОНГОЛ УЛСААС 5 ЦАГИЙН НИСЛЭГИЙН ЗАЙД ЗОХИОН БАЙГУУЛАГДСАН НҮҮДЛИЙН СОЁЛЫН ЭВЕНТҮҮД, ТЭДГЭЭРТ ХИЙСЭН ДҮН ШИНЖИЛГЭЭ, СВОТ АНАЛИЗ.......28

1. 5.1 Монгол улсаас 5 цагийн нислэгийн зайд зохион байгуулагдсан нүүдлийн соёлын эвентүүд...28

1.5.2 Монголоос нислэгийн 5 цагийн зайд зохион байгуулагддаг нүүдэлчдийн соёлын эвентүүдийг харьцуулсан дүн шинжилгээ.......32

1.6. МОНГОЛ УЛСАД ЗОХИОН БАЙГУУЛАГДСАН АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН ЭВЕНТҮҮДИЙГ ЭДИЙН ЗАСГИЙН ҮЗҮҮЛЭЛТЭЭР ЭРЭМБЭЛЭХ НЬ.......36

1.7. МОНГОЛ УЛСАД ЗОХИОН БАЙГУУЛАГДАХ БОЛОМЖИТ 10 ЭВЕНТИЙГ ТОДОРХОЙЛЖ, ЭДИЙН ЗАСГИЙН НӨЛӨӨЛЛИЙН ҮЗҮҮЛЭЛТҮҮД ДЭЭР ҮНДЭСЛЭН ЭРЭМБЭЛЭХ НЬ.......41

1.7.1 Монгол улсад зохион байгуулагдах боломжит 10 эвентийг тодорхойлох нь.......41

1.7.2 Боломжит 10 эвентийг эрэмбэлэх нь:.......46

1.8. ДҮГНЭЛТ.......49

ХОЁР. МОНГОЛ УЛСЫН АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН БОЛОМЖИТ ШИЛДЭГ АРВАН ЭВЕНТИЙН ЭДИЙН ЗАСГИЙН ҮР НӨЛӨӨЛЛИЙН ШИНЖИЛГЭЭ.......52

2.1. НИСЛЭГИЙН 5 ЦАГИЙН ЗАЙД ЗОХИОН БАЙГУУЛАГДДАГ НҮҮДЛИЙН СОЁЛЫН АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН ЭВЕНТҮҮДИЙН ӨРСӨЛДӨӨНИЙ НӨХЦӨЛ БАЙДАЛ.......52

2.1.1 Өрсөлдөгч эвентүүд.......52

2.1.2 Өрсөлдөөнийг тодорхойлох арга зүй.......52

2.2. АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН ЭВЕНТИЙН ЗАХ ЗЭЭЛИЙН БОЛОМЖИЙН ШИНЖИЛГЭЭ.......56

2.2.1 Аялал жуулчлалын эвентийн зах зээлийн боломжийг тодорхойлох арга зүй.......56

2.2.2 Монгол улсаас 5 цагийн нислэгийн зайд зохион байгуулагдаж буй нүүдлийн соёлын эвентийн зах зээлийн бодит хэмжээг тодорхойлох нь.......58

2.2.3 Эвентийн зах зээлийн шингээх боломжийг тооцох үзүүлэлтүүд.......62

2.2.4 Эвентийн зах зээлийн шингээх боломжийг тооцох нь.......66

2.3. ЭВЕНТ ЗОХИОН БАЙГУУЛАХТАЙ ХОЛБООТОЙ ЗАРДАЛ БА ШААРДЛАГАТАЙ ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ.......68

2.4. ЭВЕНТИЙН ЭРСДЛИЙН ХҮЧИН ЗҮЙЛ.......72

2.5. ДҮГНЭЛТ ....................................................................................................80
ГУРАВ. ЭРСДЛИЙГ БУУРУУЛАХ ТӨЛӨВЛӨГӨӨ, ЗӨВЛӨМЖ ......................... 82
3.1. ЭВЕНТИЙН ЭРСДЛИЙГ БУУРУУЛАХ ТӨЛӨВЛӨГӨӨ ..........................................82
3.1.1 Эрсдэл, түүний ангилал ....................................................................82
3.1.2 Эрсдлийн үнэлгээ хийх ....................................................................84
3.1.3 Эрсдэл бууруулах төлөвлөгөө ....................................................................95
3.1.4 Эрсдлийг хянах ....................................................................99
3.2. АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН ЭВЕНТИЙГ САЙЖРУУЛАХ ТАЛААР ЗӨВЛӨМЖ ..........................100
3.2.1 Олон улсад эвент зохион байгуулахад тавих шаардлага,стандартууд: ......................................100
3.2.2 Монгол улсын эвентүүдийн оролцогч талуудын судалгаа ....................................102
3.2.3 Эвент зохион байгуулах, оролцоход үүсч буй хүндрэл, бэрхшээлүүд ....................................104
3.2.4 Эвент зохион байгуулагчид, оролцогчдоос дэвшүүлсэн саналууд ....................................108
3.2.5 Судалгааны үр дүн, хэсгийн дүгнэлт ....................................112
3.2.6 Эвентийн үйл ажиллагааг сайжруулах зөвлөмж ....................................113
ДӨРӨВ. БОЛОМЖИТ, ШИЛДЭГ 10 ЭВЕНТИЙН СТРАТЕГИ ТӨЛӨВЛӨГӨӨ. 118
4.1. ЭВЕНТҮҮДИЙН ЗАХ ЗЭЭЛИЙН БАЙР СУУРЬ ....................................118
4.1.1 Аялал жуулчлалын эвентийн шинжилгээ хийх арга зүй ....................................118
4.1.2 Монгол улсын шилдэг 10 эвентийн зах зээлд эзлэх хувь хэмжээ ....................................119
4.1.3 Монгол улсын боломжит, шилдэг 10 эвентийн свот шинжилгээ ....................................122
4.2 МОНГОЛ УЛСЫН БОЛОМЖИТ, ШИЛДЭГ 10 ЭВЕНТИЙН ЗОРИЛТОТ ЗАХ ЗЭЭЛ ................132
4.2.1 Эвентийн зорилтот зах зээлийг сонгох арга зүй ....................................132
4.3. ЭВЕНТИЙН СТРАТЕГИЙН ЗОРИЛТ, ҮР ДҮНТЭЙ ХЭРЭГЖҮҮЛЭХ ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТҮҮД, ОРОЛЦОГЧ ТАЛУУДЫН ҮҮРЭГ ....................................135
4.3.1 Эвентийн стратегийн зорилт, шалгуур үзүүлэлтийг тодорхойлоход хэрэглэгдэх арга зүй........135
4.3.2 Монгол улсын эвент аялал жуулчлал хөгжүүлэх зорилго, зорилтуудад хийсэн дүн шинжилгээ ....................................137
4.3.3 Боломжит 10 эвентийн стратегийн зорилго, зорилт, шалгуур үзүүлэлт, талуудын оролцоо ....142
4.4. ДҮГНЭЛТ ....................................160
ХАВСРАЛТ ....................................162
ХАВСРАЛТ 1. МОНГОЛ УЛСЫН АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН ЭВЕНТҮҮД ....................................162
ХАВСРАЛТ 2. ҮНЭЛГЭЭНИЙ ДЭЛГЭРЭНГҮЙ ХУУДАС ....................................165
ХАВСРАЛТ 3. ФОКУС БҮЛГИЙН ЯРИЛЦЛАГЫН ТЭМДЭГЛЭЛ ....................................168
ХАВСРАЛТ 4. БОАЖЯ-НЫ АЛБАН ТООТ ....................................170
ХАВСРАЛТ 5. ЗАРИМ НҮҮДЛИЙН СОЁЛЫН ЭВЕНТҮҮД ....................................172
ХАВСРАЛТ 6. ЮНЕСКО-ИЙН СОЁЛЫН БИЕТ БУС ӨВИЙН КОНВЕНЦ: Яаралтай хамгаалах шаардлагатай болон Төлөөллийн жагсаалт ....................................175
ХАВСРАЛТ 7. НЭГ ХҮНД НОГДОХ ДНБ, АЙМГУУДЫН ӨРСӨЛДӨХ ЧАДВАР ....................................176
ХАВСРАЛТ 8. ТҮҮВЭР СУДАЛГАА, АРГАЧЛАЛ ....................................177
ХАВСРАЛТ 9: ААН, КОМПАНИУДААС АВСАН СУДАЛГААНЫ ҮР ДҮН ....................................178
ХАВСРАЛТ 10. НИЙСЛЭЛ, АЙМАГ ОРОН НУТГИЙН БОАЖГ-ЫН МЭРГЭЖИЛТНҮҮДЭЭС АВСАН СУДАЛГААНЫ ҮР ДҮН ....................................185
ХАВСРАЛТ 11. ТҮҮВЭР СУДАЛГАА, ДҮГНЭЛТ ....................................190
ХАВСРАЛТ 12. ЭРСДЛИЙН ҮНЭЛГЭЭНИЙ ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТ, ЗААВАРЧИЛГАА ....................................193

ХАВСРАЛТ 13. ЭВЕНТИЙН ЭРСДЛИЙГ БУУРУУЛАХ ТӨЛӨВЛӨГӨӨ........................................195
ХАВСРАЛТ 14. ЭВЕНТ ЗОХИОН БАЙГУУЛАХ ГАРЫН АВЛАГА.................................................197
ХАВСРАЛТ 15. ЭВЕНТЭД ТАВИГДАХ ҮНДСЭН ШААРДЛАГА /ТӨСӨЛ/ ...................................208
АШИГЛАСАН МАТЕРИАЛЫН ЖАГСААЛТ...................................................... 212

## *Хүснэгтийн жагсаалт*


**Хүснэгт 1. 1 Эвентийн үзүүлэх нөлөөллийн төрөл** ..... 15
**Хүснэгт 1. 2 Эдийн засгийн нөлөөллийн үзүүлэлтүүд** ..... 20
**Хүснэгт 1. 3 Дэлхийн томоохон эвентийн нэр, орлогын хэмжээ** ..... 21
**Хүснэгт 1. 4 Дэлхийн топ 3 эвентийн эдийн засгийн нөлөөллийн үзүүлэлт** ..... 21
**Хүснэгт 1. 5 Дэлхийн топ 3 эвентийн эдийн засгийн анхдагч, хоёрдогч болон нийт нөлөөллийн тооцоо** ..... 22
**Хүснэгт 1. 6 МУ-д зохион байгуулагдсан топ 5 эвент, 2019 оны байдлаар** ..... 23
**Хүснэгт 1. 7 Шууд ба шууд бус нөлөөллийн тооцоо** ..... 26
**Хүснэгт 1. 9 Нийт оролцогчдын тоогоор эрэмбэлсэн байдал** ..... 37
**Хүснэгт 1. 10 Гадаад жуулчдын тоогоор эрэмбэлсэн байдал** ..... 39
**Хүснэгт 1. 11 Аялал жуулчлалын нийт эвентийн тоо, бүс нутгаар** ..... 41
**Хүснэгт 1. 12 Үнэлгээний шалгуур үзүүлэлт, тэдгээрт харгалзах оноо** ..... 43
**Хүснэгт 1. 13 Аялал жуулчлалын бус улирал, сарыг 2019 статистик мэдээлэлд тулгуурлан тодорхойлсон байдал** ..... 44
**Хүснэгт 1. 14 Үнэлгээний оноо** ..... 44
**Хүснэгт 1. 15 Монгол улсын боломжит 10 аялал жуулчлалын эвентийн жагсаалт** 44
**Хүснэгт 1. 16 Монгол улсын боломжит 10 аялал жуулчлалын эвентийг бүс нутаг, улирлаар харуулбал** ..... 45
**Хүснэгт 1. 17 Монгол улсад зохион байгуулагдах боломжит 10 аялал жуулчлалын эвентийн эрэмбэ, нийт оролцогчдын тоогоор** ..... 47
**Хүснэгт 1. 18 Монгол улсад зохион байгуулагдах боломжит 10 аялал жуулчлалын эвентийн эрэмбэ, гадаад жуулчдын тоогоор** ..... 47
**Хүснэгт 1. 19 Монгол улсад зохион байгууагдах боломжит 10 аялал жуулчлалын эвентийн эрэмбэ, ажиллах хүчний тоогоор** ..... 48
**Хүснэгт 1. 20 Монгол улсад зохион байгуулагдах боломжит 10 аялал жуулчлалын эвентийн эрэмбэ, гаргасан зардлын хэмжээгээр** ..... 49

**Хүснэгт 2. 1  ХХИ-ийн тайлбар** ..... 53
**Хүснэгт 2. 2 Эвент ба эвентийн зах зээлд эзлэх хувь** ..... 54
**Хүснэгт 2. 3 Улсуудын хүлээж авсан гадаад жуулчдын тоо, аялал жуулчлалын зах зээлийн хэмжээ, өрсөлдөгч орнуудаар, 2019 он** ..... 58
**Хүснэгт 2. 4 Зах зээлийн боломжит хэмжээ, ам. доллар** ..... 60
**Хүснэгт 2. 5 Агаарын хэлэлцээрийн багтаамж, багтаамж ашиглалтын хувь** ..... 61
**Хүснэгт 2. 6 Нислэгт тэнцэх чадварын гэрчилгээтэй агаарын хөлгүүд** ..... 61
**Хүснэгт 2. 7 Аймгуудын өрсөлдөх чадварын индексийн үзүүлэлтүүд** ..... 62
**Хүснэгт 2. 8 Аймаг, нийслэлийн нэг хүнд ногдох ДНБ** ..... 63
**Хүснэгт 2. 9 Аймаг, нийслэлийн байршуулах хэрэгслийн даац** ..... 64
**Хүснэгт 2. 10 Аймгуудын хүлээж авсан гадаад, дотоодын жуулчдын тоо, 2019 он** ..... 65
**Хүснэгт 2. 11 Эвент зохион байгуулагддаг зах зээл** ..... 66
**Хүснэгт 2. 12 Эвентийн зах зээлийн шингээх боломж** ..... 66
**Хүснэгт 2. 13 Эвентийн зах зээлийн шингээх боломжийн үнэлгээ** ..... 67
**Хүснэгт 2. 14 Зах зээлийн эрэмбэ, бүлгээр** ..... 67
**Хүснэгт 2. 15 Монгол улсад зохион байгуулагдах боломжит топ 10 эвентийн зардлын мэдээлэл** ..... 68

**Хүснэгт 3. 1 Аялал жуулчлалын эвентийн эрсдлийн ангилал** ..... 84
**Хүснэгт 3. 2 Эрсдлийн матриц** ..... 88
**Хүснэгт 3. 3 Эвентийн эрсдлийн үнэлгээний үр дүн** ..... 89

**Хүснэгт 3. 4 Төлөвлөлтийн үе шатны орчны эрсдэлүүд ба тэдгээрийн үнэлгээ**.... 90
**Хүснэгт 3. 5 Төлөвлөлтийн үе шатны үйл ажиллагааны эрсдэлүүд ба тэдгээрийн үнэлгээ**............ 90
**Хүснэгт 3. 6 Зохион байгуулалтын үе шатны орчны эрсдэлүүд ба тэдгээрийн үнэлгээ**............ 91
**Хүснэгт 3. 7 Зохион байгуулалтын үе шатны үйл ажиллагааны эрсдэлүүд ба тэдгээрийн үнэлгээ**............ 92
**Хүснэгт 3. 8 Эвент бүр дээрх хамгийн өндөр үнэлэгдсэн эрсдлүүд**............ 93
**Хүснэгт 3. 9 Эрсдлийн тохиох магадлал, үр дагаварт харгалзах эрсдэл бууруулах арга хэмжээ**............ 96
**Хүснэгт 3. 10 Эрсдлийн түвшинд харгалзах эрсдэл бууруулах арга хэмжээ**............ 97
**Хүснэгт 3. 11 Монгол улсын эвентүүлийн зохион байгуулагч талууд**............ 102
**Хүснэгт 3. 12. Монгол улсын эвентүүдийн зохион байгуулагч талуудын төрөл**... 103
**Хүснэгт 3. 13  Эвентүүдийн зохиогдох хугацаа**............ 104

**Хүснэгт 4. 1 Аялал жуулчлалын боломжит 10 эвентийн ангилал**............ 119
**Хүснэгт 4. 2 Эвентийн ангилал**............ 119
**Хүснэгт 4. 3 Эвентийн дотоодын зах зээлд эзлэх хувь хэмжээ**............ 120
**Хүснэгт 4. 4 “Монгол төрийн их наадам”-ын свот шинжилгээ**............ 122
**Хүснэгт 4. 5 “Улаанбаатар өвлийн наадам”-ын свот шинжилгээ**............ 123
**Хүснэгт 4. 6 “PLAYTIME хөгжмийн наадам”-ын свот шинжилгээ**............ 123
**Хүснэгт 4. 7 “Хийморь морьт харваа” фестивалийн свот шинжилгээ**............ 124
**Хүснэгт 4. 8 “Алтан бүргэд” бүргэдийн баярын свот шинжилгээ**............ 125
**Хүснэгт 4. 9 “Хөх сувд” Хөвсгөлийн мөсний баярын свот шинжилгээ**............ 125
**Хүснэгт 4. 10 “Монгол туургатны язгуур соёслын олон улсын их наадам”-ын свот шинжилгээ**............ 126
**Хүснэгт 4. 11 “Талын түмэн адуу” эвентийн свот шинжилгээ**............ 127
**Хүснэгт 4. 12 “Түмэн тэмээний баяр” эвентийн свот шинжилгээ**............ 128
**Хүснэгт 4. 13 “Хонины найр” эвентийн свот шинжилгээ**............ 129
**Хүснэгт 4. 14 Нэгдсэн свот шинжилгээ**............ 129
**Хүснэгт 4. 15 Боломжит 10 эвентийн зорилтот зах зээл сонголт**............ 132
**Хүснэгт 4. 16 TOWS матриц ашиглан стратеги тодорхойлох**............ 136
**Хүснэгт 4. 17 Монгол улсад эвент аялал жуулчлалыг хөгжүүлэх зорилго, зорилтуудыг тодорхойлоход харгалзан үзэх бусад бодлогын баримт бичгийн уялдаа холбоо**............ 138
**Хүснэгт 4. 18 Эвентийн зорилго, зорилт, шалгуур үзүүлэлт, талуудын оролцоо**. 142
**Хүснэгт 4. 19 Эвентүүдэд оролцох гадаад жуулчдын тоо,хүлээгдэж буй дүнгээр**............ 154
**Хүснэгт 4. 20 Боломжит 10 эвентийн стратегийн зорилтуудыг хэрэгжүүлэх үйл ажиллагааны чиглэлийн TOWS матриц**............ 156

## *Графикийн жагсаалт*

**График 2. 1 Аялалын зах зээлийн хэмжээ, өрсөлдөгч орнуудаар**............ 59
**График 2. 2 Жуулчдын тоо, 1989-2020 он, сая хүнээр**............ 72
**График 2. 3 Монгол улсын хилээр орж ирсэн жуулчдын тоо, 2015-2020**............ 73
**График 2. 4 Агаарын тээврийн орлого, тэрбум ам.доллар, 2003-2020 он**............ 75
**График 2. 5 Дэлхийн тэргүүлэх онлайн аялал зуучлалын байгууллагуудын зах зээлийн үнэлгээ 2020**............ 76

**График 3. 1 Монгол улсын эвент зохион байгуулагчдын төрөл**............ 103

**График 3. 2 Эвентүүдийн зохиогдох хугацаа** ........ 104
**График 3. 3 Эвентэд оролцоход гардаг түгээмэл хүндрэлүүд** ........ 106
**График 3. 4 Эвентийг зохион байгуулахад гардаг хүндрэл** ........ 107
**График 3. 5 Эвентийн түгээмэл хүндрэл бэрхшээлүүд, судалгаанд оролцогч орон нутгийн БОАЖГ-ын мэргэжилтнүүдийн үзэж буйгаар** ........ 107
**График 3. 6 Эвентийн талаар шүүмжлэлтэй хандсан асуудлууд, орон нутгийн БОАЖГ-ын мэргэжилтнүүдийн үзэж буйгаар** ........ 108
**График 3. 7 Эвентийн үйл ажиллагааг сайжруулах санал, аж ахуйн нэгжүүдийн хариулсан байдлаар** ........ 109
**График 3. 8 Жуулчдыг татахын тулд эвентийн хувьд анхаарах зүйлс, БОАЖГ-ын мэргэжилтнүүдийн үзэж буйгаар** ........ 109
**График 3. 9 Эвентийг үр дүнтэй зохион байгуудахад төрөөс хэрэгтэй дэмжлэгүүд, орон нутгийн БОАЖГ-ын мэргэжилтнүүдийн үзэж буйгаар** ........ 110
**График 3. 10 Эвентийг үр дүнтэй зохион байгуупахад олон улсын байгууддага болон мэргэжлийн судлаачдын зүгээс хэрэгтэй дэмжлэгүүд, БОАЖГ-ын мэргэжилтнүүдийн үзэж буйгаар** ........ 110
**График 3. 11 Эвентийг үр дүнтэй зохион байгуулахад нутгийн иргэд, байгууллагуудын зүгээс хэрэгтэй дэмжлэгүүд, БОАЖГ-ын мэргэжилтнүүдийн үзэж буйгаар** ........ 111
**График 3. 12 Эвентийн талаар жуулчдын санал хүсэлт, ачлал жуулчлалын компаниудын хариулсан байдлаар** ........ 111

**График 4. 1 Эвентийн оролцох гадаад жуулчдын тоо, хүлээгдэж байгаа байдлаар** ........ 155

### *Зургийн жагсаалт*

**Зураг 1. 1 Аялал жуулчлалын эвентийн төрөл, хэлбэрүүд** ........ 13
**Зураг 1. 2 Үржүүлэгчийн нөлөө** ........ 18
**Зураг 1. 3 Нислэгийн 5 цагийн зайг тооцсон радиус** ........ 29
**Зураг 1. 4 Нислэгийн 5 цагийн зайд орших олон улсын нисэх онгоцны буудлууд руу хийх 2021 оны зуны тогтмол нислэгийн цагийн хуваарь** ........ 30
**Зураг 1. 5 “Дэлхийн нүүдэлчдийн наадам” /World Nomad Games/ - Азийн орэуудын угсаатануудын фестиваль, Киргизстан улс** ........ 32
**Зураг 1. 6”Нүүдэлчдийн ертөнц” Nomads’ World Festival, Казахстан улс** ........ 33
**Зураг 1. 7 “Этно Ауыл” аялал жуулчлалын ЭКСПО, Казахстан улс** ........ 34
**Зураг 1. 8 “Казах ертөнц” нүүдэлчдийн цэцэрлэгт хүрээлэн, Казахстан улс** ........ 34
**Зураг 1. 9 Бутан улсын “Нүүдэлчдийн фестивал” ба “Пара цечү” буддын шашны цам бүжгийн эвент** ........ 35
**Зураг 1. 10 Боломжит эвентүүдийн газар зүйн байршил** ........ 46
**Зураг 1. 11 Боломжит эвентүүдийн улирлын хамаарал** ........ 46

**Зураг 2. 1 Аялал жуулчлалын бүтээгдэхүүн, үйлчилгээний чанарын хүчин зүйлс** 74

**Зураг 3. 1 Эрсдэл бууруулах төлөвлөгөө боловсруулах алхам** ........ 98

## *Товчлол*

**МУ** - Монгол Улс
**УИХ** - Улсын Их Хурал
**ЗГ** - Засгийн Газар
**БОАЖЯ-Байгаль орчин, аялал жуулчлалын яам**
**ҮСХ** - Үндэсний статистикийн Хороо
**МБ** - Монголбанк
**НҮБ** - Нэгдсэн үндэстний байгууллага
**ЭЗХААБ** - Эдийн засгийн хамтын ажиллагаа, хөгжлийн байгууллага /OECD/
**ДНБ** - Дотоодын нийт бүтээгдэхүүн
**ОХУ** - Оросын Холбооны Улс
**БНХАУ** - Бүгд Найрамдах Хятад Ард Улс
**БОАЖГ-Байгаль орчин, аялал жуулчлалын газар**
**НАЖГ** - Нийслэлийн аялал жуулчлалын газар
**ӨМӨЗО** - Өвөр Монголын Өөртөө Засах Орон
**ХХИ** - Херфиндал-Хершманы индекс
**ШӨХТГ** - Шударга өрсөлдөөн хэрэглэгчийн төлөө газар
**НИТАЖ** - Нутгийн иргэдэд түшиглэсэн аялал жуулчлал
**СВОТ** - SWOT шинжилгээ буюу S-Strength буюу давуу тал, W-Weakness буюу сул тал, O-Opportunity буюу боломж, T-Threat буюу аюул занал
**ЮНЕСКО** - Нэгдсэн Үндэстний Байгууллагын Боловсрол, Шинжлэх ухаан, Соёлын байгууллага (UNESCO-United Nations Education, Scientific and Culture Organization)
**СМАРТ** – SMART арга, S-Specific-тодорхой, нарийвчилсан, M-Measurable-хэмжигдэхүйц, A-Attainable-хүрч чадахуйц /Achievable/, R-Relevant-чухал /Realistic/, T-Time-Bound-хугацаа хязгаартай

# НЭГ. МОНГОЛЫН АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН БОЛОМЖИТ АРВАН ЭВЕНТ

## 1.1. ТӨСЛИЙН ТАНИЛЦУУЛГА

### 1.1.1 Товч танилцуулга

Аялал жуулчлал нь дэлхийн улс орнуудын нийгэм, эдийн засагт бодитойгоор нөлөөлдөг орчин үеийн тогтвортой хөгжлийн чухал бүрэлдэхүүн юм. 2009 оны дэлхийн эдийн засгийн хямралаас хойш дэлхийд хамгийн хурдацтай хөгжиж буй салбаруудын нэг нь аялал жуулчлал бөгөөд дэлхийд тавд орох хурдацтай өсөлттэй салбар болсон бол 2018 оны байдлаар аялал жуулчлалын бизнес нь газрын тосны экспортын дараа орох гурав дахь том салбар болж өргөжсөн байна.

Дэлхийн олон улсын аялал жуулчлалын орлого 2013 оноос хойш жилд дунджаар 1.4 их наяд ам.доллар байсан бол 2018 онд 1.7 их наяд ам.доллартай тэнцэв.[1] Нэг ирэхэд хүлээн авсан дэлхийн дундаж баримт 1036 ам.доллар байв. Аялал жуулчлалын гол зорилго нь амралт, зугаа цэнгэл (56%), найз нөхөддөө зочлох, эрүүл мэнд, шашин шүтлэг болон бусад (27%), ажил хэрэгч, мэргэжлийн аялал жуулчлал (13%) байв.

Олон улсын аялал жуулчлалын оролтын орлого (ITIR) нь Монгол улсын хувьд 2019 онд 607.2 сая доллар байсан ба энэ нь ДНБ-ний 4%-ийг эзэлж байна.

Манай улс 2019 онд хамгийн их буюу 577 мянган гадаадын жуулчин хүлээн авч, аялал жуулчлалын салбараас 607 сая ам.долларын орлого оруулж, 88 мянган ажлын байр бий болгосон. Улсын хэмжээнд бүртгэлтэй 570 гаруй тур оператор компани (МАЖХ, 2020), 460 зочид буудал, 400 гаруй жуулчны бааз үйл ажиллагаа явуулж байна[2].

Гэтэл сүүлийн жилүүдэд дэлхий нийтийг хамарсан “COVID-19” цар тахлын дэгдэлтээс шалтгаалан аялал жуулчлал, агаарын тээврийн салбарууд хамгийн их алдагдлыг хүлээж, Монгол Улсын хувьд аялал жуулчлалын салбарын алдагдал 3 их наяд гаруй төгрөгт хүрч[3], тус салбарт үйл ажиллагаа явуулж буй 1600 гаруй аж ахуйн нэгж байгууллагын 88 мянга гаруй ажлын байр[4] эрсдэлд ороод байна.

Манай улсад ирэх жуулчдын тоо Ковид-19 цар тахлын өмнө буюу 2019 онд 577.3 мянга байсан бол 2020 онд энэ тоо 58.859 мянга болж 90 хувиар буураад байна.[5]

Монгол улс дахь аялал жуулчлал нь улирлын чанартай бөгөөд Монгол орны бүс бүрт харилцан адилгүй байдаг. Хангай, Төв, Улаанбаатарын бүс гэхэд

---

[1] Дэлхийн аялал жуулчлалын байгууллага, жилийн аялал жуулчлалын статистик мэдээлэл
[2] БОАЖЯ, “Байгаль орчин, Аялал жуулчлалын салбарын 2021-2024 оны стратеги төлөвлөгөө”, 2021, 5ху
[3] Уртнасан,Н. 2021.10.26, “Tourism forum Mongolia 2021”, электрон эх үүсвэр: http://www.shuud.mn/a/534679
[4] Уртнасан,Н. 2021, электрон эх үүсвэр: https://www.mne.mn/?p=14584
[5] ҮСХ, Монгол Улсын Статистикийн Мэдээллийн Мэдээллийн Сан

олон улсын нийт жуулчдын 94%-ийг эзэлж, баруун болон зүүн бүс 6%-ийг хүлээн авдаг байна. Зургадугаар сараас есдүгээр сар хүртэлх дөрвөн сарын хугацаанд нийт жуулчдын 54% нь ирдэг байна.

Манай улсын аялал жуулчлалын салбар нь олон улсад өрсөлдөхүйц салбарт тооцогддог. Өөрөөр хэлбэл аялал жуулчлалын салбар нь үл шавхагдах нөөцүүдийг ашиглан үлэмж хэмжээний орлого олох боломжтой эдийн засгийн салбар юм.

Аялал жуулчлалын орлогын хувьд 2019 онд нэг гадаад жуулчин 1658 ам.доллар зарцуулж байсан[6] бөгөөд энэ нь дэлхийн дунджаас хэд дахин бага үзүүлэлт юм. Харин манай иргэдийн хувьд гадаад улсад дунджаар 7 хонох хугацаандаа 2007 ам.доллар зарцуулж байна. Тиймээс аялал жуулчлалын салбарт шинэ бүтээгдэхүүн бий болгох, зорин очих газрыг нэмэгдүүлэх, түүх соёлын дурсгалыг хадгалах, хамгаалах, аялал жуулчлалын салбарын бүтээгдэхүүнийг эдийн засгийн эргэлтэд оруулах явдал чухал ач холбогдолтой.

Монгол улсын аялал жуулчлалын тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.4 -т "*аялал жуулчлалын бүтээгдэхүүн гэж аялал жуулчлалын байгууллагаас үзүүлж байгаа жуулчдын сонирхлыг татах, тэдний аялах тав тухтай нөхцөлийг хангасан төлбөрт үйлчилгээ*" гэж заасан байдаг.

НҮБ-ын Дэлхийн аялал жуулчлалын байгууллага аялал жуулчлалын бүтээгдэхүүн гэдэг нь "*Хүрэх, ашиглах маркетингийн гол цөм болох тодорхой сонирхлын төвийг тойрсон байгалийн, соёлын болон хүний хүчээр бүтээсэн нөөц, сонирхол татахуйц байгууламж, үйлчилгээ зэрэг биет ба биет бус элементүүдийн нэгдэл юм*" гэж тодорхойлсон байдаг.

### 1.1.2 Төслийн зорилго, зорилтууд

Энэхүү төсөл нь Монгол улсын уул уурхайгаас бусад экспортын нэг үйлчилгээний экспортын гол хэсэг болох олон улсын аялал жуулчлалын салбарын чадавхийг бэхжүүлэх чиглэлээр эдийн засагт хамгийн их нөлөө үзүүлдэг "аялал жуулчлалын эвент"-ийг тодорхойлох, эвентийн стратеги төлөвлөгөө, эрсдлийн үнэлгээ хийх зорилготой. Төслийн зорилтууд нь:

1) Монгол улсад болох аялал жуулчлалын боломжит эвентүүдийг эрэмбэлэх, тодорхойлох;
2) Монгол улсад зохион байгуулагдаж буй шилдэг 10 аялал жуулчлалын эвентийн эдийн засгийн нөлөөлөлд дүн шинжилгээ хийх;
3) Эвентийн эрсдлийг бууруулах төлөвлөгөө боловсруулах, аялал жуулчлалын эвентийн зөвлөмжийн баримт бичгийг боловсронгуй болгох;
4) Эвентийн стратеги төлөвлөгөө боловсруулах болно.

[6] Аялал жуулчлалын салбарын өнөөгийн байдал, шийдвэрлэх асуудлууд, Монголбанк, түүвэр судалгааны үр дүн 2019

### 1.1.3 Аялал жуулчлалын салбарт төрөөс баримтлах бодлого, баримт бичиг

Монгол улсын засгийн газар болон олон улсын байгууллагуудаас аялал жуулчлалыг эрчимтэй хөгжүүлэх олон улсад өрсөлдөх чадварыг дээшлүүлэх чиглэлд цөөнгүй бодлогын арга хэмжээ, төсөл хөтөлбөрүүдийг хэрэгжүүлж байна. Үүнд:

- “Алсын хараа 2050” Монгол улсын урт хугацааны хөгжлийн бодлого /УИХ-ын 2020 оны 52 дугаар тогтоол/;
- Монгол Улсын “АЖ-ын тухай” хууль /2000 оны 05-р сарын 05/
- “Төрөөс аялал жуулчлалыг хөгжүүлэх талаар баримтлах бодлого” /ЗГ-ын 2019 оны 333 дугаар тогтоол/;
- Аялал жуулчлалын Үндэсний Хөтөлбөр
- Монгол улсын Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр;
- Монгол улсыг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл;
- Дэлхийн банкны Экспортыг дэмжих төсөл;
- Азийн хөгжлийн банкны Аялал жуулчлалыг тогтвортой хөгжүүлэх төсөл зэрэг болно.

## 1. 2. АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН ЭВЕНТ

### 1.2.1 Аялал жуулчлалын бүтээгдэхүүн, түүний төрөл

НҮБ-ын Дэлхийн аялал жуулчлалын байгууллагаас “Тодорхой сонирхлын төвийн эргэн тойрон дахь байгалийн, соёлын болон хүний нөөц, сонирхол татахуйц байгууламж, үйлчилгээ, үйл ажиллагаа гэх мэт биет болон биет бус элементүүдийн хослолыг аялал жуулчлалын бүтээгдэхүүн гэнэ” гэж тодорхойлсон.

Аялал жуулчлалын бүтээгдэхүүнийг дараах байдлаар ангилж болно. Үүнд:

*а/ Байгалийн аялал жуулчлалын бүтээгдэхүүн*

Энэ төрлийн бүтээгдэхүүнд ихэвчлэн жуулчдыг татах байгалийн хүчин зүйлс ордог. Өвөрмөц газар, өтгөн ой, уул, нуур, зэрэг байгалийн тогтоц нь дэлхийн жуулчдын сонирхлыг татах төв болж ирсэн.

*б/ Хүний гараар бүтээгдсэн аялал жуулчлалын бүтээгдэхүүн*

Энэ төрлийн бүтээгдэхүүнд хүний гараар бүтсэн бүтээгдэхүүнүүд орно. Жишээ нь: Музей, казино, парк гэх мэт.

*в/ Тодорхой байршилд суурилсан аялал жуулчлалын бүтээгдэхүүн*

Хэрэв сонирхол татахуйц газар нь тодорхой газар, тодорхой цаг хугацаанд л байх боломжтой бол үүнийг тодорхой байршилд суурилсан аялал жуулчлалын бүтээгдэхүүн гэдэг. Энэ төрлийн бүтээгдэхүүнд наран шарлагын газар, хөшөө дурсгал, түүхэн газрууд багтдаг ба хүний гараар бүтээгдсэн аялал жуулчлалын бүтээгдэхүүн юм.

*г/ Баяр ёслол, үйл ажилгаанд суурилсан аялал жуулчлалын бүтээгдэхүүн*

Баяр ёслолын арга хэмжээнд жуулчид оролцогч болон үзэгчийн хувиар оролцдог. Тухайн улсын уламжлалт баяр ёслолууд жуулчдыг ихээр татдаг.

**Манай улсын аялал жуулчлалын салбарын суурь бүтээгдэхүүн нь** онгон дагшин байгаль, Монголын уламжлалт соёл, ёс заншил бөгөөд нүүдлийн соёл, үзэсгэлэнт байгаль, Монгол улсын болон Чингис хааны түүх зэрэгт нь жуулчид хамгийн ихээр татагддаг.

### 1.2.2 Аялал жуулчлалын эвент, төрөл, онцлог

Өнөө үед эвент аялал жуулчлал нь аливаа улс орны аялал жуулчлалыг өдөөгч, дэмжигч хамгийн гол хүчин зүйлүүдийн нэг болж байдаг учраас дэлхийн ихэнх улс орнууд төрөл бүрийн эвентүүдийг шинээр сэдэж бүтээгдэхүүн болгон, хэрэглэгчдэд санал болгох их өрсөлдөөнд орж байна. Ингэснээр аялал жуулчлал өндөр хөгжсөн улс орон, бүс нутаг төдийгүй хот, тосгон бүр өөрийн имиж болсон эвентүүдийг зах зээлд байршуулан амжилттай өрсөлдөх болжээ.[7]

Эдийн засгийн хамтын ажиллагаа, хөгжлийн байгууллага /OECD/-ийн тодорхойлсоноор аялал жуулчлалын эвент гэдэг нь “Аялал жуулчлалын салбарын хамгийн хурдацтай хөгжиж буй салбар бөгөөд үр дүнтэй удирдан зохион байгуулж чадвал бүс нутгийн хөгжлийг дэмжих, дэд бүтцийг сайжруулах, урлаг-спортын цогцолбор газруудад хөрөнгө оруулалт татах томоохон эх үүсвэр юм” гэж дүгнэсэн байдаг.[8] Иймд учраас аялал жуулчлалын эвентүүдийг, тэр дундаа олон улсын түвшинд хүрсэн мега эвентүүдийг зохион байгуулах нь тухайн улс орны хувьд эдийн засгийн өсөлтөнд нөлөөлөх, ажлын байрыг бий болгох, иргэдийн амьдрах орчинг сайжруулах хэрэгсэл гэж үздэг байна.

**Эвент** /event/ гэдгийг толь бичигт тайлбарласнаар "үйл явдал, чухал үзэгдэл, уралдаан тэмцээн, арга хэмжээ" зэрэг салаа утгуудыг агуулдаг бол "Эвент аялал жуулчлал" гэдэг үг хэллэгийг анх 1987 онд Шинэ Зеландын Аялал жуулчлалын хэлтэс тайланд "Эвент аялал жуулчлал нь олон улсын аялал жуулчлалын нэн хурдацтай өсч буй төрөл хэлбэр юм" хэмээн цохон тэмдэглэжээ.[9]

Орон нутгийн наадам, багт наадам, цэнгүүнээс авахуулаад олимп гэх мэт олон улсын спортын томоохон арга хэмжээнд хүртэл бараг бүх тэмдэглэлт үйл явдлуудыг “Аялал жуулчлалын эвент” хэмээн нэрлэж болох юм. Үйл явдлууд нь тодорхой хугацааны хувьд богино хугацаатай байдаг бөгөөд ихэвчлэн ганц хоёрхон хоног үргэлжилдэг боловч зарим томоохон арга хэмжээ нэлээд удаан үргэлжлэх боломжтой байдаг (жишээлбэл, Их дуулга теннисний тэмцээн эсвэл Тур де Францын хувьд хэдэн долоо хоног, Европын соёлын нийслэл эсвэл Дэлхийн Экспо зэрэг хэдэн сар хүртэл үргэлжилдэг). Тогтмол үзвэр үйлчилгээ нь зочдыг улирлын чанартай эсвэл удаан хугацаагаар татах хандлагатай байдаг.

[7] Ч.Болорхүү, “Монголын аялал жуулчлалын эвентийн хөгжил, цаашдын хандлага” МАЖХ. 2019 он
[8] OECD (2017), “Major events as catalysts for tourism”, *OECD Tourism Papers*, 2017/02, OECD Publishing, Paris. http://dx.doi.org/10.1787/a0e8a96f-en

[9] Donald Getz, “Event tourism: Definition, evolution, and research”, Tourism Management 29 (2008) 403–428, 406p

Энэ хэсэгт фокус бүлгийн цахим ярилцлагын үеэр гарсан саналыг тусгаж эвентүүдийн төрөл, ангиллыг дэлгэрэнгүй байдлаар судалж оруулав. Фокус бүлгийн ярилцлагын тэмдэглэл, үр дүнг хавсралт хэсгээс үзнэ үү.

Аялал жуулчлалын эвентийг дараах байдлаар ангилдаг. Үүнд:

- Хамрах хүрээгээр
- Онцлог шинжээр
- Салбараар

Фокус бүлгийн цахим ярилцлагын үеэр судлаачдаас ирүүлсэн саналд эвентүүдийг өргөн хүрээгээр авч үзэх, салбарын яамдуудад хүсэлт тавьж, хамтран ажиллах санал оруулсан. Гэхдээ энэ удаагийн тайланд төсөл гүйцэтгэгч судлаачдын зүгээс зөвхөн аялал жуулчлалын эвентийг тэр тусмаа Монгол улсын дүр төрх болсон соёлын эвентүүдийг нарийвчилж авч үзсэн болно.

**Зураг 1. 1 Аялал жуулчлалын эвентийн төрөл, хэлбэрүүд** [10]




Аялал жуулчлалын эвентийг хамрах хүрээгээр нь дараах төрлүүдэд ангилдаг. Үүнд:

- **Даян дэлхийн**: Олимпийн их наадам, Дэлхийн хөл бөмбөгийн аварга шалгаруулах тэмцээн гэх мэт даян дэлхийн хүн ардыг өргөн хэмжээнд хамарсан эвентүүд орно. Онцлог нь: Жуулчдын эрэлт өндөр, үнэ цэнэ өндөр[11]
- **Олон улсын:** Үндэсний хэмжээнд зохиогдож буй дотоодын болон олон улсын чанартай наадам, спорт, соёл, урлагийн тэмцээн, аварга шалгаруулах гэх мэт. Жишээ нь: марафон, дугуйн уралдаан, урлаг хөгжмийн тоглолтууд. Онцлог нь: Жуулчдын эрэлт өндөр, үнэ цэнэ өндөр
- **Бүс нутгийн:** Тодорхой зорилтот газрын хүмүүст чиглэсэн эвентүүд. Онцлог:Жуулчдын эрэлт дунд, дунд үнэ цэнэ
- **Орон нутгийн:** Багт наадам, улирлын баяр наадмууд, гэх мэт орон нутгийн иргэд зохион байгуулж оролцдог эвентүүд. Онцлог: Жуулчдын эрэлт бага, бага үнэ цэнэ

[10] OECD (2017), "Major events as catalysts for tourism", *OECD Tourism Papers*, 2017/02, 11 page
[11] Үнэ цэнийг хэмжихдээ ирсэн жуулчдын тоо, эдийн засгийн үр ашиг, зах зээлд эзлэх хувь хэмжээ, зохион байгуулж байгаа газар орны иргэдэд хэрэгтэй байдал, байгальд ээлтэй, тогтвортой байдал зэрэг орно.

Аялал жуулчлалын эвентүүдийг онцлог шинжээр нь дараах дөрвөн үндсэн бүлэгт хувааж болно. Үүнд:

Нэгд, **Ниш эвент** /Niche events/: Ихэвчлэн утга зохиолын, хоолны, адал явдалт спорт, хөгжмийн наадам гэх мэт тухайн нэг чиглэлээр дагнасан цөөн боловч төлбөрийн өндөр чадвартай үзэгчид бүхий эвентүүд энэ бүлэгт багтана. (жишээ нь Гластонберигийн хөгжмийн наадам). Ийм арга хэмжээг зохион байгуулах нь харьцангуй хямд бөгөөд илүү өндөр төлбөрийн чадвартай үзэгчдийг татах магадлалтай юм.

Хоёрт, **оролцоот спортын эвент** /Participatory sports events/: Оролцооны спортын арга хэмжээ энэ бүлэгт багтах бөгөөд жишээлбэл: Дэлхийн мастеруудын тоглоом, дэлхийн цагдаа, галын тоглоом, төмрийн тамирчин, бага насны спортын тэмцээн гэх мэт. Эдгээр нь зохион байгуулагч орны гаднаас ирсэн олон мянган өрсөлдөгчдийг татдаг “Destination-Зорин очих газар” арга хэмжээ бөгөөд ихэнх нь олон хүн (эхнэр, нөхөр, найз нөхөд, гэр бүл) дагуулж амралтаараа ирдэг байна. 2015 онд Шотландад зохион байгуулагдсан The 2015 World Orienteering Championships тэмцээнд 6000 зочин ирсэн бөгөөд 9 сая фунт стерлингээс илүү нэмэлт зардал гарсан байна.

Гуравт, **гол соёлын эвент** /Signature cultural events/: “Заавал үзэх ёстой" гэсэн олон улсын нэр хүндийг олж авсан үйл явдлууд энэ хэсэгт багтах бөгөөд тухайлбал, Остин, Техас дахь South by South West (SXSW), Барселон дахь Sonar festival, Мельбурн дахь White Nights болон Шотландын Edinburgh Fringe Festival ба Hogmanay гэх мэт.

Дөрөвт, **олон улсын спортын эвент** /International sports events/: Энэ хэсэгт олон улсын спортын арга хэмжээ багтах бөгөөд жишээлбэл: Дэлхийн цомын регби, Тур де Франс, төрөл бүрийн спортын (хөнгөн атлетик, усан сэлэлт, гимнастик гэх мэт) тэмцээнүүдийг дурдаж болно. Ийм арга хэмжээ нь олон тооны оролцогчид, үзэгчдийг татахаас гадна дэлхийн өнцөг булан бүрт телевизийн өргөн хүрээг хамарч, тухайн орны нэр хүнд, брэндийг өсгөхөд чухал үүрэг гүйцэтгэдэг. Энэ төрлийн хамгийн том арга хэмжээ нь зуны олимпийн наадам, хөл бөмбөгийн дэлхийн аварга шалгаруулах тэмцээн болно. Гэсэн хэдий ч олон улсын спортын жижиг арга хэмжээнүүд нь санхүүгийн хувьд эрсдэл багатай байдаг.

Аялал жуулчлалын эвентийг салбараас нь шалтгаалж дараах байдлаар хувааж болно. Үүнд:

1. Соёлын эвент
2. Шашны эвент
3. Энтертайнмэнт
4. Бизнес, ажил хэргийн эвент
5. Спортын эвент
6. Боловсрол, шинжлэх ухааны эвент

1989 онд Канадын Калгарийн их сургуулийн профессор Доналд Гетц "Тусгай эвент аялал жуулчлалын бүтээгдэхүүнүүдийг тодорхойлох нь" сэдэвт нийтлэлдээ

эвентүүдийн гүйцэтгэх үүрэг, төрөл хэлбэрүүдийг тодорхойлсон.[12] Энэ бүтээлд дурдсанаар аялал жуулчлалын эвентийн онцлох гол 5 шинж чанарыг дурдсан байна. Үүнд:

- Олон нийтэд нээлттэй байх;
- Нэг үндсэн зорилгын хүрээнд жилд нэг ба түүнээс дээш давтамжтайгаар зохион байгууллагддаг;
- Урьдчилан тодорхойлсон цагт зохион байгуулах;
- Зохион байгуулалттай хөтөлбөрийн дагуу үйл ажиллагаа явуулах;
- Аялал жуулчлалын бүс нутагт зохион байгуулагдах;

Аливаа фестиваль, эвент нь хүмүүсийг хөгжөөн зугаацуулах элементүүдийг багтаасан байхаас гадна дараах хэдэн энгийн зарчим үйлчилнэ.[13]

- Эвентийг зохион байгуулагчид болон эвентийн талбарт ажиллагсад нь ирсэн зочдод чин сэтгэлээсээ хандаж үйлчлэх. Олны дундаас ялгарч танигдахаар нэгэн жигд хувцасласан байх.
- Бүх зүйлсийг урьдчилан төлөвлөсөн байх. Хуваарийн дагуу үйл ажиллагааг зохион байгуулах. Оролцогчдыг хүлээлгэх, уйдаах, хуваариа солих гэх мэт асуудал гаргахгүй байх.
- Оролцогчдын хүсэл сонирхлыг урьдчилан мэдэрч түүнд тохируулан зохион байгуулах. Хүүхдүүдэд зориулсан үзүүлбэр, залуучуудад зориулсан тоглолт гэх мэт.

Эвентийг амжилттай зохион байгуулж, боломжит үр ашиг хүртэхийн тулд дараах зарчмыг баримталдаг. Үүнд:

- Жуулчдын байх хоногийг уртасгах;
- Жуулчдын зарцуулах зардлыг өсгөх;
- Очих газрын талаарх мэдээллээр сайн хангах;
- Иргэний бахархал эсвэл олон нийтийн эв нэгдлийг нэмэгдүүлэх зэрэг арга хэмжээг хэрэгжүүлэх шаардлагатай байдаг.

Аялал жуулчлалын эвент нь дараах хүснэгтэнд үзүүлсэн байдлаар зохион байгуулагч газар, оронд нөлөөлж байдаг.

### Хүснэгт 1. 1 Эвентийн үзүүлэх нөлөөллийн төрөл

| Нөлөөллийн төрөл | Эерэг | Сөрөг |
|---|---|---|
| **Эдийн засгийн** | Гадаад вальютын орлого нэмэгдэх | Эвентийн үед үнийн өсөлт бий болох |
| | ДНБ-д оруулах хувь нэмэр өсөх | Үл хөдлөх хөрөнгийн спекуляци |
| | Ажлын байр нэмэгдүүлэх | Алдагдсан боломжийн өртөг |

[12] https://www.coris.uniroma1.it/sites/default/files/Event%20tourism%20Definition%20evolutionand%20research.pdf
[13] Ч.Болорхүү, "Монголын аялал жуулчлалын эвентийн хөгжил, цаашдын хандлага" МАЖХ. 2019 он

| | | |
|---|---|---|
| | Төлбөрийн баланс сайжрах<br>Дэд бүтцийн хөрөнгө оруулалтыг дэмжих<br>Орон нутгийн эдийн засагт оруулах хувь нэмэр нэмэгдэх | Хөрөнгийн хэмжээ хангалтгүй байх<br>Эвентийн зардлын тооцоог хангалтгүй хийгээгүйгээс алдагдал хүлээх |
| **Аялал жуулчлалын** | Эвент болох бүс нутгийн талаарх ойлголт, мэдлэг нэмэгдэх<br>Бүс нутаг дахь хөрөнгө оруулалт, арилжааны үйл ажиллагааны боломжийн талаар мэдлэг нэмэгдэх<br>Жуулчид буудаллах байр, аялал жуулчлалын газруудыг шинээр бий болгох | Үнийн хөөрөгдөл, дэд бүтэц муу байснаас муу нэр хүндтэй болох<br>Орон нутгийн ажиллах хүч, засгийн газрын дэмжлэгийн төлөө шинэ өрсөлдөөн гарч болзошгүй тул одоо байгаа аж ахуйн нэгжүүдээс сөрөг хандлага гарах |
| **Биет/Байгаль орчин** | Барилга байгууламж барих<br>Орон нутгийн дэд бүтэц сайжрах<br>Өвийг хадгалах, хамгаалах | Экологийн хор хохирол<br>Байгалийн процесс алдагдах<br>Бохирдол<br>Соёлын өвийг сүйтгэх<br>Даац хэтрэх |
| **Соёлын** | Эвентэд хандах орон нутгийн сонирхол, оролцоог нэмэгдүүлэх<br>Бүс нутгийн үнэ цэнэ | Аялал жуулчлалыг зохион байгуулах зорилгоор үйл явдал, үйл ажиллагааны мөн чанарыг өөрчлөх<br>Гэмт хэргийн гаралт нэмэгдэх боломжтой<br>Олон нийтийн бүтцийн өөрчлөлт<br>Нийгмийн шилжилт |
| **Сэтгэл зүйн** | Орон нутгийн бахархал, олон нийтийн сэтгэл санаа өөдрөг байх<br>Орон нутгийн бус ойлголтын талаарх мэдлэгийг дээшлүүлэх | Соёлын шок |
| **Улс төр /Захиргааны/** | Бүс нутаг, үнэт зүйлсийг олон улсад хүлээн зөвшөөрөх чадварыг дээшлүүлэх<br>Эвент зохион байгуулчдын ур чадварыг хөгжүүлэх | Улс төрчдийн үнэт зүйлсийг тусгахын тулд үйл явдлын жинхэнэ мөн чанарыг гуйвуулах<br>Захиргааны зардлыг нэмэгдүүлэх<br>Эвентийг зохион байгуулахтай зэрэгцэн хууль ёсны бус шийдвэр гаргахад эвентийг ашиглах |

*Эх сурвалж: Фестиваль болон эвентийн эдийн засгийн нөлөөллийг тооцох: Судалгааны аргачлал*

## 1.3. ДЭЛХИЙН АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН ЭВЕНТИЙН ЭДИЙН ЗАСГИЙН НӨЛӨӨЛЛИЙН ШИНЖИЛГЭЭ

### 1.3.1 Эдийн засгийн нөлөөллийг тооцох онолын үндэслэл

Аливаа аялал жуулчлалын эвентийн зорилго нь ашиг олох, соёлоо сурталчилж, соёлын өвийг хамгаалах, спортын эвент бол спортын төрлийг сурталчилж, олонд таниулах гэх мэт олон янз байдаг. Гэхдээ эцсийн дүндээ тухайн эвент ямар зорилготой байхаас үл хамаараад эдийн засгийн хувьд үр ашигтай байсан эсэхийг тодорхойлох хэрэгцээ зайлшгүй тулгардаг. Аливаа салбарын болон үйл ажиллагааны эдийн засгийн нөлөөллийг тооцохдоо тухайн эдийн засагт үзүүлж буй шууд, шууд бус, дам нөлөөллийг тооцох замаар эдийн засагт үзүүлэх нийт нөлөөллийг тооцдог.

Аялал жуулчлалын салбарын хувьд мөн л эдийн засагт үзүүлж буй нөлөөллийг шууд болон шууд бус, индукцийн нөлөөллөөр тооцно.

**Шууд нөлөө (Direct effect)**: Аялал жуулчлалын эвентээс эдийн засагт шууд үзүүлж байгаа үр  нөлөө юм. Тухайн орлого, ажлын байр, цалин, татварт бий болж буй  өөрчлөлт шууд нөлөөллийн үр дүн юм.

**Шууд бус нөлөө (indirect effect)**: Аялал жуулчлалын байгууллагын үйлчилгээгээр ханган  нийлүүлэгчийн борлуулалт, ашиг, ажлын байранд гарч буй өөрчлөлтийг тооцно.

**Дам нөлөө (induced effect)**: Аялал жуулчлалын эвентээс шууд болон шууд бус хэлбэрээр олсон өрхийн орлогын өөрчлөлтөөр эдийн засагт гарах өөрчлөлтийг  хэлнэ. Өөрөөр хэлбэл аялал жуулчлалын эвентээс байгууллага болон тэдгээрийг бараа,  үйлчилгээгээр ханган нийлүүлэгч байгууллагын ажиллагсад дотоодын зах зээлд худалдан  авалт хийснээр бусад салбарын ажлын байр, орлого, татварт гарч буй өөрчлөлтүүдийг тооцно.

Дээр дурдсан нөлөөллүүдийг хамтатган эдийн засгийн нийт нөлөө гэнэ.

Эвентийн тухайн бүс нутгийнхаа макро эдийн засагт үзүүлэх эдийн засгийн нөлөөг анхдагч болон хоёрдогч эдийн засгийн нөлөө гэж ангилдаг.

- *Анхдагч эдийн засгийн нөлөө* гэдэг бол оролцогчдоос судалгаа авах эсхүл бизнесийн борлуулалтыг хэмжих замаар хэмждэг эвентийн эдийн засгийн шууд нөлөөг хэлдэг.

- *Хоёрдогч эдийн засгийн нөлөө* гэдэг нь тухайн эдийн засагт шинээр мөнгө орж ирж байгаагаас бий болж үүсч буй эдийн засгийн нөлөөг хэлдэг. Жишээлбэл усанд чулуу шидэхэд усны гадаргуу дээр онгдоход анхдагч нөлөө үүсэх бол чулуу цааш үсрэн хэд хэдэн тойрог үүсгэх ба тэдгээр нь хоёрдогч нөлөө болно. Үүнийг дараах зурагт харуулсанчлан үржүүлэгчийн тусламжтайгаар хэмждэг. [14]

[14] Estimating the economic impacts of festivals and events: a research guide

**Зураг 1. 2 Үржүүлэгчийн нөлөө**




Хоёрдогч нөлөөллийг тооцох нь тухайн бүс нутаг дахь салбар хоорондын хамаарал, бараа, үйлчилгээний импорт зэргийг тооцдог учраас илүү зөв тооцоолол болдог. Энэ нь тухайн бүс нутаг дахь шинэ зардлын алдангийг тооцож, үржүүлэгчийг ашиглах замаар хэмждэг.

**Анхдагч эдийн засгийн нөлөөг тооцох нь:**

Анхдагч эдийн засгийн нөлөөг тооцохдоо оролцогчдоос түүвэр судалгаа авах эсхүл бизнесийн цар хүрээг хэмжих замаар үнэлдэг. Судалгаагаар оролцогчдын зардлын мэдээллүүдийг дэлгэрэнгүй гаргаж ирнэ. Эвентийн оролцогчдыг дотоодын ба гадаадын (тухайн орон нутгийн бус) гэж ангилж тоог нь гаргах ба нэгэнт гадны оролцогчдын тоог гаргасан бол түүнийг нэг оролцогчийн гаргасан дундаж зардлаар үржүүлж шууд нөлөөллийг тооцно.

*Шууд эдийн засгийн нөлөө=гадны оролцогчдын тоо*оролцогчдын дундаж зардал*

**Хоёрдогч болон нийт эдийн засгийн нөлөөг тооцох нь:**

Хоёрдогч нөлөөг тооцохдоо тухайн бүс нутаг дахь ажил хөдөлмөр эрхлэлт, бараа үйлчилгээ худалдан авах зэрэг дотооддоо үлдэх мөнгийг тооцно. Бүс нутгаас гарах мөнгийг тооцох замаар алдангийг тооцно. Нэг ёсондоо үржүүлэгчийг ашиглах замаар тооцсон тооцооллыг хоёрдогч эдийн засгийн нөлөө гэж үзнэ.

Улс орны түвшинд эдийн засгийн нөлөөллийг тооцоход орц гарцын загвар, зардал үр ашгийн шинжилгээ гэх мэт хэд хэдэн аргачлал хэрэглэдэг бол бүс нутгийн хэмжээнд орц, гарцын загвар (Archer, 1982, Mules, 1996) илүү тохиромжтой байдаг.

Энд үржүүлэгчийн нөлөөг тооцохдоо Кейнсийн үржүүлэгчийг ашиглаж болно.

**Кейнсийн үржүүлэгч:**

$$k = \frac{1}{1 - c(1 - t) + m}$$

*k*-Кейнсийн үржүүлэгч

c =өрхийн ахиу хэрэглэх хандлага

t = ДНБ (Эсхүл бүсийн ДНБ)-ээс татвар авах ахиу хандлага

m = ДНБ-ээс импортлох ахиу хандлага .

Жишээлбэл, дундаж хэрэглэх хандлага 0.9, татварын хувь 30%, импортлох хандлага 0.25 байвал k = 1.6 байна.

Орон нутгийн түвшинд бол улсын хэмжээний тоо мэдээг ашиглаад m-ийг тооцоход хүндрэлтэй байдаг. Тиймээс байршлийн санал (location quotient (LQ))-ийг тооцох замаар үнэлгээ хийж болно.

$$LQ_i = (ER_i / TER) / (EN_i / TEN)$$

$ER_i$ =i бүс нутаг дахь тухайн салбар дахь ажил эрхлэлт

TER = тухайн муж дахь нийт ажил эрхлэлт

$EN_i$ = Тухайн улс дахь i салбар дахь ажил эрхлэлт

TEN =Тухайн улс дахь нийт ажил эрхлэлт.

Тухайлбал: Хэрвээ тухайн бүс нутаг ажил эрхлэлтийнхээ 20 %-ийг тухайн салбарт зарцуулдаг, харин улс ажил эрхлэлтийнхээ 25 %-ийг тухайн салбарт зарцуулдаг бол LQ нь 0.8 байна. Энэ нь тухайн бүс нутаг тэрхүү салбарын бүтээгдэхүүн, үйлдэрлэлийн 80 %-ийг дангаараа хангадаг харин үлдсэн 20 %-ийг гаднаас импортоор оруулж ирдэг гэсэн үг. Тиймээс импортлох ахиу хандлага нь тухайн салбарын хувьд 20% байна гэсэн үг.

Нийт ДНБ-д үзүүлэх нөлөө: Жуулчдын зардал*k=ДНБ-д үзүүлэх нөлөө

Өөрөөр хэлбэл Кейнсийн үржүүлэгч ямар байгаагаас шалтгаалаад жуулчдын зардлын хэдэн хувь тухайн ДНБ-д яаж нөлөөлөхийг тооцно гэсэн үг. [15]

[15] Estimating the economic impacts of festivals and events: a research guide

### 1.3.2 Эдийн засгийн нөлөөллийг тооцох үндсэн үзүүлэлтүүд

Өмнөх хэсэгт харуулсанчлан эдийн засгийн нөлөөллийг тооцох аргачлалд ямар ямар үзүүлэлтүүд ашиглагдсаныг нэгтгэн дараах хүснэгтэнд харуулбал:

**Хүснэгт 1. 2 Эдийн засгийн нөлөөллийн үзүүлэлтүүд**

| Үзүүлэлт | Тайлбар |
|---|---|
| **Оролцогчдын тоо** | Нийт оролцогчдын тоо |
| **Үүнээс: Гадны оролцогчдын тоо (Жуулчдын тоо)** | Нийт оролцогчдын тоо, үүнээс гадны оролцогчдын тоог ангилж харуулах нь эдийн засгийн шууд нөлөөллийг тооцоход ашиглагдана. |
| **Оролцогчдын дундаж зардал** | Энэхүү зардлын хэмжээг оролцогчдоос түүвэр судалгаа авах замаар тодорхойлно. Эсхүл жуулчдын болон гадны оролцогчдын дундаж зардлын талаар тодорхой судалгааны үр дүн, тоо мэдээ ашиглаж болно. |
| **Ажиллах хүчний тоо** | Тухайн эвентэд оролцсон ажиллах хүчний тоо. Тухайн эвентийн тоо мэдээлэл хомс тохиолдолд зохион байгуулсан ажиллах хүчний тоогоор баримжаа авах зорилгоор ашиглах. |
| **Зардлын хэмжээ** | Зохион байгуулагч талаас гаргасан зардлаар баримжаа болгох үүднээс тоо мэдээлэл тодорхой бус үед ашиглах боломжтой. |
| **Орлогын хэмжээ** | Орлогын хэмжээ хэрвээ тодорхой бол эдийн засгийн нөлөөллийг үнэлэхэд баримжаа болгон ашиглах боломжтой. Гэхдээ энэ нь ихэнхдээ эдийн засгийн шууд нөлөөллийг тооцоход зөвхөн ашиглагдана. |

### 1.3.3 Дэлхийн топ эвентүүдийн эдийн засгийн нөлөөллийн шинжилгээ

Цар тахлаас өмнөх буюу 2020 оны 1 дүгээр сараас өмнө зохион байгуулагдсан дэлхийн томоохон эвентүүдийг орлогоор нь жагсааж дараах хүснэгтэд эрэмбэлэн харуулав. Дэлхийн хамгийн том эвентүүдийг нэг дор орлогоор нь жагсаасан мэдээлэл байхгүй бөгөөд харин бид дэлхийн мега эвентүүдийн мэдээллийг тус бүрээр нь цуглуулан дүн шинжилгээ хийсэн болно.

### Хүснэгт 1. 3 Дэлхийн томоохон эвентийн нэр, орлогын хэмжээ

| № | Эвентийн нэр | Байршил | Зохион байгуулагд -сан он | Орлогын хэмжээ /тэрбум ам.дол/ |
|---|---|---|---|---|
| 1 | Зуны Олимпын наадам[16] | Бразил, Рио Де Жанеро | 2016 | 6.2 |
| 2 | Хөлбөмбөгийн дэлхийн аварга /FIFA/ [17] | ОХУ | 2018 | 5.357 |
| 3 | Харбины олон улсын мөс, цасны баримал фестиваль[18] | БНХАУ, Харбин | 2018 | 4.4 |
| 4 | Өвлийн Олимпын наадам[19] | БНСУ, Пёнчан | 2018 | 2.245 |
| 5 | Карниваль /CARNIVAL (Rio de Janeiro, Brazil)/[20] | Бразил, Рио Де Жанеро | 2020 | 1.88 |
| 6 | Октоборфесть /Oktoberfest/[21] | ХБНГУ | 2019 | 1.56 |
| 7 | Голф Турнаментс[22] | АНУ | 2017 | 1.28 |
| 8 | MARDI GRAS (New Orleans, Louisiana)[23] | АНУ | 2019 | 1 |
| 9 | Индиан пример лиг[24] | Энэтхэг | 2020 | 0.5 |

Дээрх хүснэгтээс харахад Бразилийн Рио Де Жанеро хотод 2016 онд зохион байгуулагдсан зуны олимпын наадам, ОХУ-д 2018 онд зохион байгуулагдсан FIFA дэлхийн аварга, БНХАУ-ын Харбин хотноо 2018 онд зохион байгуулагдсан Харбины олон улсын мөс, цасны баримал фестиваль орлогоороо эхний 3 байранд эрэмбэлэгдэв.

Иймээс дэлхийн топ 3 эвент дээр тулгуурлан эдийн засгийн нөлөөллийн шинжилгээг хийж үзье:

### Хүснэгт 1. 4 Дэлхийн топ 3 эвентийн эдийн засгийн нөлөөллийн үзүүлэлт

| Үзүүлэлт | Рио 2016, Бразил | FIFA 2018, ОХУ | Харбины олон улсын мөс, цасны баримал фестиваль, 2018 |
|---|---|---|---|

16 *https://olympics.com/ioc/news/olympic-games-rio-2016-economic-legacy*

17 https://digitalhub.fifa.com/m/337fab75839abc76/original/xzshsoe2ayttyquuxhq0-pdf.pdf

18 https://www.thediplomaticaffairs.com/2021/01/11/7th-harbin-international-ice-and-snow-sculpture-festival-in-china/

19 https://www.forbes.com/sites/christinasettimi/2018/02/08/by-the-numbers-the-2018-pyeongchang-winter-olympics/?sh=4730299c7fb4

20 https://www.globaltimes.cn/content/1178561.shtml

21 https://www.oktoberfest.net/oktoberfest-statistics/

22 https://www.thengfq.com/company/pga-tour/

23 https://www.mardigrasneworleans.com/history/history-faqs

24 https://www.indiatvnews.com/sports/cricket/bcci-earns-rs-4000-crore-in-revenue-from-ipl-2020-says-treasurer-arun-dhumal-666818

| | | | |
|---|---|---|---|
| Нийт оролцогчдын тоо /A/ | 2.9 сая[25] | 5 сая | 18 сая |
| Гадаадын жуулчдын тоо /B/ | 1.17 сая[26] | 2.9 сая | - тоо тодорхойгүй |
| 1 гадаад жуулчны дундаж зардал, ам.дол /Co/ | 1213.29[27] | 1240.155[28] | 679[29] |
| **Кейнсийн үржүүлэгч тооцоход шаардлагатай тоон мэдээлэл** | | | |
| **Ахиу хэрэглэх хандлага /c/** | 0.75[30] | 0.8[31] | 0.74[32] |
| **Ахиу импортлох хандлага /m/** | 0.25 | 0.3 | 0.23[33] |
| **Татвар авах ахиу хандлага /t/** | 0.275 | 0.13 | 0.45 |

Өмнө нь урьдчилан тодорхойлсон эдийн засгийн нөлөөллийн үзүүлэлтүүдийг дээрх хүснэгтэд харуулсан. Тэдгээр үзүүлэлтүүдэд үндэслэн эдийн засгийн нөлөөллийг тооцох үнэлгээг дараах хүснэгтэд хийж үзүүллээ.

### Хүснэгт 1. 5 Дэлхийн топ 3 эвентийн эдийн засгийн анхдагч, хоёрдогч болон нийт нөлөөллийн тооцоо

| ***Эвентийн нэр*** | ***Кейнсийн үржүүлэгч*** **/k=1/(1-c(1-t)+m)/[34]** | ***Эдийн засгийн шууд буюу анхдагч нөлөө*** **/Шууд эдийн засгийн нөлөө=гадны оролцгсодын тоо*оролцогчдын дундаж зардал/** | ***Эдийн засгийн хоёрдогч нөлөө*** **/ Жуулчдын зардал*k/** | ***Нийт эдийн засгийн нөлөө*** **/Анхдагч нөлөө+хоёр-догч нөлөө/** |
|---|---|---|---|---|
| **Рио 2016, Бразил** | 1.416 | 1.419 тэрбум ам.дол | 2.009 тэрбум ам.дол | 3.428 тэрбум ам.дол |
| **FIFA 2018, ОХУ** | 1.656 | 3.596 тэрбум ам.дол | 5.95 тэрбум ам.дол | 9.546 тэрбум ам.дол |
| **Харбины олон улсын мөс, цасны баримал фестиваль, 2018** | 1.215 | - | - | - |

*Эх үүсвэр: Судлаачийн тооцоо*

Дээрх тооцооллоос харахад, хэдийгээр шууд орлогын хэмжээгээр нэгдүгээрт эрэмбэлэгдээгүй ч 2018 онд ОХУ-д зохион байгуулагдсан FIFA 2018

25 https://stillmed.olympic.org/media/Document%20Library/OlympicOrg/Games/Summer-Games/Games-Rio-2016-Olympic-Games/Media-Guide-for-Rio-2016/IOC-Marketing-Report-Rio-2016.pdf

26 https://stillmed.olympic.org/media/Document%20Library/OlympicOrg/Games/Summer-Games/Games-Rio-2016-Olympic-Games/Media-Guide-for-Rio-2016/IOC-Marketing-Report-Rio-2016.pdf

27 http://rededoesporte.gov.br/en/news/tourists-give-olympic-games-thumbs-up-and-want-to-visit-brazil-again

28 https://www.theeconomyjournal.eu/texto-diario/mostrar/1522249/the-economic-impact-of-the-russia-world-c

29 https://www.budgetyourtrip.com/china/harbin

30 http://www.levyinstitute.org/pubs/conf_june10/Dantas_Rezende.pdf

31 Consumer potential of households, its differentiation and dynamics in the new economy: evidence from Russia, Advances in Social Science, Education and Humanities Research, volume 240, 2018

32 http://revecon.ro/articles/2011-1/2011-1-7.pdf

33 https://www.linkedin.com/pulse/us-china-international-trade-indices-comprehensive-2020-abou-hamia-1f?trk=read_related_article-card_title

34 Судлаачийн тооцоо

хөл бөмбөгийн дэлхийн аварга шалгаруулах тэмцээний эдийн засгийн нөлөөлөл хамгийн их буюу 9.5 тэрбум ам.долларт хүрсэн байна. Бразилийн Рио Де Жанеро хотод зохион байгуулагдсан зуны олимпын наадмын эдийн засгийн нийт нөлөө 3.4 тэрбум ам.долларт хүрсэн байна. Харин БНХАУ-ын Харбин хотноо 2018 онд зохион байгуулагдсан мөсний фестивалийн албан ёсны зарим тоо баримт олдоогүй тул үнэлгээ хийх боломжгүй байлаа.

## 1.4. МОНГОЛ УЛСАД ЗОХИОН БАЙГУУЛАГДСАН ТОП 5 ЭВЕНТИЙН ЭДИЙН ЗАСГИЙН НӨЛӨӨЛЛИЙН СУДАЛГАА

### 1.4.1 Эдийн засгийн нөлөөллийн судалгаа

Бид энэхүү бүлэгтээ Монгол улсад зохион байгуулагдсан топ 5 эвентийг тодорхойлж, тэдгээрийн эдийн засгийн нөлөөллийг тооцох зорилготой. Үүний тулд бид энэхүү тайлангийн 7 дугаар бүлэгт тодорхойлсон боломжит топ 10 аялал жуулчлалын эвентүүд болоод аймаг, нийслэлийн аялал жуулчлалын газрын мэргэжилтнүүдээс ирүүлсэн голлох эвентүүдийн мэдээлэлд үндэслэн эдийн засгийн нөлөөллийг тооцох гол үзүүлэлтүүд болох оролцогчдын тоо, гадаад жуулчдын тоо, зардал, ажиллах хүчний тоогоор эрэмбэлэн топ гэж үзсэн 5 эвентийг дараах хүснэгтэнд тодорхойллоо.

**Хүснэгт 1. 6 МУ-д зохион байгуулагдсан топ 5 эвент, 2019 оны байдлаар**

| № | Эвентийн нэр | Эвентийн байршил | Эвентийн хугацаа |
|---|---|---|---|
| 1 | Монгол төрийн үндэсний их баяр наадам /Төв цэнгэлдэх/ | УБ | 7-р сарын 11-13 |
| 2 | Плэйтайм олон улсын хөгжмийн наадам | УБ | 7-р сарын 5-7 |
| 3 | Алтан бүргэд-Бүргэдийн баяр | Баян-Өлгий аймаг Бугат сум | 10-р сарын эхний 7 хоногт |
| 4 | Хөх сувд - Хөвсгөлийн мөсний баяр | Хөвсгөл-Хатгал | 3 сарын эхний өдрүүдэд |
| 5 | Улаанбаатарын өвлийн наадам | УБ-хүрээлэн ба Скай резорт | 2-р сард |

*Эх үүсвэр: Аймаг, нийслэлийн аялал жуулчлалын газрын мэргэжилтнүүдийн ирүүлсэн тоо, мэдээлэлд үндэслэв.*

*Тайлбар: Оролцогчдын тоо, гадаад жуулчдын тоо, зардал, ажиллах хүчний тоогоор эрэмбэлэн тус бүр топ 5 эвентийг тодорхойлсон бөгөөд үүний үр дүнд 9 эвентийн нэр тодорхойлогдсон. Үүнээс оролцогчдын тоогоор хамгийн өндөр гэж үзсэн топ 5 эвентийг сонгосон болно.*

*Монгол төрийн үндэсний их баяр наадам:*

Жил бүрийн 7-р сарын 11, 12, 13-ны өдрүүдэд зохион байгуулагддаг. 2019 онд бид Тулгар төр байгуулагдсаны 2228 жил, Ардын хувьсгалын 98 жилийн ойн баярыг тэмдэглэн өнгөрүүлсэн. Наадмын нээлтийн үйл ажиллагааг 3000 орчим гадны жуулчин үзэж сонирхсон байна. Үндэсний их баяр наадам нь гадны жуулчдын хамгийн их сонирхсон, үзэхийг хүсдэг, Монгол орны уламжлал, соёлын том эвент болсон байна. Түүнчлэн үндэсний их баяр наадмыг үзэж сонирхонгоо наадмын үеэр болдог бусад эвентүүдэд оролцох тохиолдол их байдаг.

*Плэйтайм /Playtime/:*[35]

2002 онд анх үүсгэн байгуулагдаж, эдүгээ 20 дахь жилдээ зохион байгуулагдах гэж байгаа энэхүү наадам нь орчин үеийн хөгжмийн урлагаар дамжуулан Улаанбаатар хотыг Азийн тэргүүлэх хөгжмийн аялал жуулчлалын хот болгох болон бүтээлч үйлдвэрлэлийн салбарыг хөгжүүлэх замаар Монгол улсын тогтвортой хөгжилд хувь нэмэр оруулах эрхэм зорилготой юм. Плэйтайм дээр 100 гаруй хамтлаг, уран бүтээлчид өөрсдийн уран бүтээлээ 50,000 гаруй үзэгчдэд 3 хоногийн турш хүргэдэг.

2027 он гэхэд Азийн шилдэг 5 хөгжмийн фестивалийн нэг болох зорилготой ажиллаж байгаа аж.

"Плэйтайм-2019"-ийг нийт 32000 хүн үзэж сонирхсон байна. Үүнээс 450 орчим нь гадны жуулчид байсан. Уг арга хэмжээ нь гаргасан зардал, ажиллагсадынхаа тоогоор ч дээгүүр байранд бичигдэж байгаа аялал жуулчлалын нэг эвент юм.

*Алтан бүргэд-Бүргэдийн баяр, Баян-Өлгий аймаг:*[36]

Дэлхийн өвд бүртгэлтэй Казах ард түмний бүргэдээр ан хийх соёлын өвийг дэлхийд таниулсан аялал жуулчлалын том арга хэмжээ юм. 1999 онд буюу анх удаа зохиогдсон Бүргэдийн баярт 30  жуулчин ирж байсан бол 2019 онд нийт 1000-3000 жуулчин ирсэн байна.

Уг арга хэмжээний үеэр Көкбар, Кыз хуар, Тенге илүү, Сур харваа зэрэг тэмцээнүүдийг зохион байгуулдаг ба жуулчдад зориулсан тэмцээн уралдаан ч явагддаг.

*Хөх сувд - Хөвсгөлийн мөсний баяр:*[37]

Хөх сувд мөсний баяр нь 2000 оноос хойш жил бүр 3-р сарын эхний өдрүүдэд зохион байгуулагддаг. Мөсний баяр анх зохион байгуулагдснаасаа эхлэн гадаад, дотоодын жуулчдын  сонирхлыг татаж жил бүр оролцогчдын тоо нэмэгдэж ирсэн. Анхны жил нутгийн 70 гаруй  иргэд оролцож байсан бол 2013 онд 10,0 /арван мянга/, 2019 онд 30,0 /гучин мянга/ дотоодын тэр дундаа гадаадын  15 орноос 120 орчим жуулчин хүрэлцэн ирсэн байна.

Мөсний баярт хүрэлцэн ирсэн гадаадын жуулчид хөтөлбөрт орсон уралдаан тэмцээнүүдэд нээлттэй оролцох боломжтой бөгөөд 2019 оноос эхлэн жуулчдад зориулсан "Competition for tourists" арга хэмжээг зохион байгуулж байна.

*Улаанбаатарын өвлийн наадам:*[38]

Нийслэлийн аялал жуулчлалын газар, мэргэжлийн холбоод хамтран 2010 оноос хойш жил бүрийн 2-р сард Улаанбаатар хотод зохион байгуулж ирсэн.

Уг арга хэмжээ нь тусгай сонирхлын аялал жуулчлалыг хөгжүүлэх, жуулчны улирлын хугацааг уртасгах, өвлийн улирлын уламжлалт болон орчин үеийн экстрим спортыг түгээн дэлгэрүүлэх, өвлийн улиралд Улаанбаатар хотод ирэх жуулчдын тоог нэмэгдүүлэх зорилготой.

---

[35] www.playtime.mn
[36] Баян-Өлгий аймгийн Байгаль орчин, аялал жуулчлалын газрын мэдээлэл
[37] Хөвсгөл аймгийн Байгаль орчин, аялал жуулчлалын газрын мэдээлэл
[38] Нийслэлийн байгаль орчин, аялал жуулчлалын газрын мэдээлэл

Энэхүү эвент нь оролцогчдын тоогоор дээгүүрт орж буй бөгөөд 2019 оны арга хэмжээнд нийт 9000 гаруй хүн оролцсоноос 200 гаруй нь гадаадын жуулчид байсан.

**<u>Судалгааны арга зүй:</u>**

Монгол улсад зохион байгуулагдсан топ 5 эвентийн эдийн засгийн нөлөөллийн судалгааг хийхдээ дэлхийн топ 3 эвентийн эдийн засгийн нөлөөг үнэлсэн судалгааны аргыг мөн хэрэглэсэн. Ингэхдээ тухайн эвентийн эдийн засагт үзүүлж буй шууд болон шууд бус, индукцийн нөлөөллийг тооцож, нийлбэр дүнгээр нийт эдийн засагт үзүүлэх нөлөөг тооцсон.

Анхдагч эдийн засгийн нөлөөг тооцохдоо аймаг, нийслэлийн Байгаль орчин, аялал жуулчлалын газрын мэргэжилтнүүдээс болон холбогдох тур операторуудаас түүвэр судалгаа, судалгаа авах байдлаар мэдээллүүдийг цуглуулсан болно.

Эдийн засгийн анхдагч буюу шууд нөлөөг дараах байдлаар үнэлсэн.

*Шууд эдийн засгийн нөлөө=гадны оролцочдын тоо*оролцогчдын дундаж зардал*

Хоёрдогч нөлөөг тооцохдоо Кейнсийн үржүүлэгчийг тооцож улмаар холбогдох үнэлгээг хийсэн.

**Кейнсийн үржүүлэгч:**

$$k = \frac{1}{1 - c(1 - t) + m}$$

$k$-Кейнсийн үржүүлэгч

**c =өрхийн ахиу хэрэглэх хандлага**

t = ДНБ (Эсхүл бүсийн ДНБ)-ээс татвар авах ахиу хандлага

m = ДНБ-ээс импортлох ахиу хандлага.

**Ашигласан тоон мэдээлэл:**

Ахиу импортлох хандлага-1.6[39]

Ахиу хэрэглэх хандлага-0.236[40]

Ахиу татвар ногдуулах хандлага-0.25[41]

Судалгааны хүрээнд аялал жуулчлалын эвентийн хоёрдогч буюу шууд бус нөлөөг тооцоход хэрэглэгдэх Кейнсийн үржүүлэгчийг тооцох боломжтой боллоо. Кейнсийн үржүүлэгчийг тооцвол:

$$k = \frac{1}{1 - 0.236(1 - 0.25) + 1.6} = 0.4127$$

[39] Импорттой өрсөлдөх аж үйлдвэрийн бүтээгдэхүүний шинжилгээ, Монголбанк, Судалгааны ажил, товхимол 14, 2019

[40] Монголбанк, Судалгааны ажил, товхимол 13, 2018

[41] Хувь хүний орлогын албан татварын тухай хууль

*Жуулчдын зардлын судалгаа:* [42]

Жуулчид дунджаар **1,658** ам.доллар буюу дараах байдлаар зардал гаргасан байна. Үүнд:
- тээвэрт 421 ам.доллар,
- байр сууцанд 400 ам.доллар,
- бараа, бүтээгдэхүүн худалдан авахад 319 ам.доллар,
- хоол унданд 246 ам.доллар,
- бусад үйлчилгээнд 272 ам.долларыг зарцуулжээ

Судалгаанаас харахад жуулчид дунджаар **13 хоногийг** Монголд өнгөрүүлдэг байна.

Иймээс дээрх зардлын дүнгээс тээврийн зардлаас бусад зардлыг 13 хоногт хувааж дунджаар Монголд өнгөрүүлсэн нэг хоног тутамд зарцуулах зардлын дүнг тооцсон. Тээврийн зардлын хувьд Баян-Өлгий, Хөвсгөл аймгуудыг 2019 оны байдлаар хот хоорондын тээврийн дундаж үнээр тооцоолол гаргасан болно.

## Хүснэгт 1. 7 Шууд ба шууд бус нөлөөллийн тооцоо

| | **Эвентийн нэр** | **жуулчдын тоо** | **Оролцогчдын дундаж зардал, ам доллараар** | **Оролцогчдын дундаж зардал, төгрөгөөр**[43] | **Эдийн засгийн шууд буюу анхдагч нөлөө% төгрөгөөр / Шууд эдийн засгийн нөлөө=гадны оролцогчдын тоо*оролцогчдын дундаж зардал/** | **Эдийн засгийн хоёрдогч нөлөө / Жуулчдын зардал*k/, төгрөгөөр** | **Нийт эдийн засгийн нөлөө, Төгрөгөөр** |
|---|---|---|---|---|---|---|---|
| 1 | Үндэсний их баяр наадам | 3,000 | 154.80 | 412,316.30 | 1,098,221,786.60 | 510,488,813.01 | 1,747,437,717.81 |
| 2 | Алтан бүргэд-Бүргэдийн баяр | 1,000 | 159.90 | 425,900.37 | 425,900,365.80 | 175,769,080.97 | 601,669,446.77 |
| 3 | Плэйтайм | 450 | 154.80 | 412,316.30 | 185,542,335.72 | 76,573,321.95 | 262,115,657.67 |
| 4 | УБ өвлийн наадам | 200 | 103.20 | 274,877.53 | 54,975,506.88 | 22,688,391.69 | 77,663,898.57 |
| 5 | Хөх сувд мөсний баяр | 120 | 128.80 | 343,064.21 | 41,167,705.15 | 16,989,911.92 | 58,157,617.07 |

*Эх үүсвэр: Судлаачийн тооцоо*

[42] Аялал жуулчлалын салбарын өнөөгийн байдал, шийдвэрлэх асуудлууд, Түүвэр судалгааны үр дүн Монголбанк, 2019

[43] 1 ам.долларын төгрөгтэй харьцах ханш 2019 оны жилийн дунджаар 2663.542 гэж Монголбанкны албан ёсны сайтаас ашиглан тооцоо хийв.

Ийнхүү манай судалгааны үр дүнд “Үндэсний их баяр наадам 2019” нь манай улсын эдийн засагт шууд болон шууд бус байдлаар нийт 1.7 тэрбум төгрөгийн орлого оруулсан байна. Өөрөөр хэлбэл энэ мөнгөн дүнд манай улсад гаднаас буюу жуулчдаас оруулсан наадмын нээлт, хаалт, үзвэр, худалдаа, үйлчилгээ, хоол, хүнс, бусад худалдан авалт зэрэг байдлаар шууд нөлөө үзүүлэхээс гадна тэдгээрт үйлчилсэн бусад салбарын орлого, иргэдийн хөдөлмөрийн хөлс гэх мэт шууд бусаар нийт оруулсан орлогын дүн болно.

Харин эдийн засгийн нөлөөллөөрөө үндэсний их баяр наадмын дараа Баян-Өлгий аймагт зохион байгуулагдсан Бүргэдийн баярт нийт 1000 орчим гадаадын жуулчин оролцсон ба нийт 601 сая төгрөгийн шууд ба шууд бус орлогыг манай улсын эдийн засагт оруулжээ.

### 1.4.2 Сайжруулах санал, зөвлөмж

Монгол улсад зохион байгуулагдсан топ 5 эвентийн эдийн засгийн нөлөөллийн судалгааг хийсний дүнд дараах санал зөвлөмжийг гаргаж байна. Үүнд:

Юуны өмнө нийслэл, аймаг орон нутгийн аялал жуулчлалын газар хамтран БОАЖЯ-аас тусгайлсан маягт, түүвэр судалгааны загвар боловсруулан зохион байгуулсан эвент бүрийн дараа оролцогчдоос тэр дундаа гадны жуулчдаас сэтгэл ханамж, зардлын талаар судалгаа авч байх. Ингэснээрээ эдийн засгийн нөлөөллийг үнэлэх анхан шатны тоо мэдээлэл зөв, оновчтой тодорхойлогдож улмаар эдийн засгийн нөлөөллийг зөв үнэлэх боломжтой;

Эвентийн эдийн засгийн нөлөөг тооцоход голлох үзүүлэлт болох оролцогчдын тоо, гадны жуулчдын тоо, ажиллах хүч, орлого, зардлыг хэрхэн тооцох талаар аргачлал боловсруулах. Одоогийн байдлаар ҮСХ-ны даргын 2011 оны 01/80 дугаар тушаалаар батлагдсан “Аялал жуулчлалын статистикийн үзүүлэлт тооцох аргачлал”-ыг ҮСХ тоо мэдээ гаргахдаа ашигладаг боловч энэ нь хэт ерөнхий байгаа тул өөрийн салбарын онцлогт тохирсон дэлгэрэнгүй тоо, мэдээлийг гаргах талаар анхаарч ажиллах. Учир нь аймаг орон нутгууд эдгээр тооцоогоо хийдэггүй бөгөөд тооцсон зарим орон нутгийн хувьд янз бүрээр тооцоог гаргаж байгаа нь судалгаа хийхэд бэрхшээлтэй байлаа. Иймээс цаашид нэгдсэн нэг стандартаар судалгаа гаргах шаардлагатай гэж үзэж байна;

Аялал жуулчлалын эвентийг зохион байгуулахдаа тухайн эвентийн уламжлал соёлын гэх мэт үзүүлэлтүүдийг харгалзан үздэг атлаа улс орны эдийн засагт үзүүлэх нөлөөг тэр бүр чухалчилдаггүй байдал ажиглагдсан. Иймээс аялал жуулчлалын эвентийн эдийн засгийн нөлөөлөлд онцгой анхаарах, орлогыг хэрхэн нэмэгдүүлэхэд дорвитой арга хэмжээ авах;

Улс орны эдийн засагт үзүүлж буй нөлөөллийг сайжруулах гол үзүүлэлт бол тухайн эвентэд оролцсон гадаадын жуулчдын тоо бөгөөд үүнийг нэмэгдүүлэх, бүтээгдэхүүн үйлчилгээний төрлийг олшруулах, жуулчдын өдөрт зарцуулах зардлын хэмжээг өсгөх тал дээр илүү анхаарах шаардлагатай. Эвентийн үеэр үндэсний үйлдвэрлэгч аж ахуйн нэгж болон иргэдийг дэмжин оролцуулах, бараа бүтээгдэхүүнээ сурталчлах, худалдан борлуулах боломжоор хангах;

Жуулчдын хувьд аяллын талаар мэдээлэл дутмаг байдаг нь хамгийн том бэрхшээл болохыг Монголбанкнаас 2019 онд авсан түүвэр судалгааны үр дүнгээс харж болох ба эвентүүдийн талаар илүү тодорхой мэдээллийг англи болон бусад хэл дээр түгээх тал дээр анхаарах;

Монголбанкны түүвэр судалгааны үр дүнд жуулчдын зарцуулсан зардлыг шинжилж үзвэл үзвэр, үйлчилгээнд хамгийн бага зардал гаргасан гэсэн байдаг. Иймээс эвентийн уеэр үзвэр үйлчилгээний тоо, чанарыг нэмэгдүүлэх шаардлагатай.

## 1. 5. МОНГОЛ УЛСААС 5 ЦАГИЙН НИСЛЭГИЙН ЗАЙД ЗОХИОН БАЙГУУЛАГДСАН НҮҮДЛИЙН СОЁЛЫН ЭВЕНТҮҮД, ТЭДГЭЭРТ ХИЙСЭН ДҮН ШИНЖИЛГЭЭ, СВОТ АНАЛИЗ

### 1. 5.1 Монгол улсаас 5 цагийн нислэгийн зайд зохион байгуулагдсан нүүдлийн соёлын эвентүүд

“Монгол улсын тогтвортой хөгжлийн үзэл баримтлал 2030” бодлогын баримт бичигт аялал жуулчлалын салбарын зорилт 1-т “Монгол улс нүүдлийн соёл, аялал жуулчлалын олон улсын төв болно” хэмээн тодорхойлсон байдаг.

Аялал жуулчлалын эвентийг дэмжих дэд бүтэц

Монгол банкны 2019 онд хийсэн “Аялал жуулчлалын салбарын өнөөгийн байдал, шийдвэрлэх асуудлууд” түүвэр судалгааны тайланд дурдсанаар нийт 34 тур опературыг оролцуулсан санал асуулгад олон улсын нислэг, тээврийн хүрэлцээгүй байдал голлох саад бэрхшээлүүдийн нэг болж байна хэмээн хариулсан байна.

Бид энэ хэсэгт Монгол улсаас нислэгийн 5 цагт байх соёлын аялал жуулчлалын эвентүүдийн судалгааг хийж оруулсан болно. 5 цагийн нислэгийн зай гэдэг нь ойролцоогоор 3000 км /Япон-Кансай ОУНОБ/ орчим зай юм. Нислэгийн ийм хугацаанд шууд нислэгтэй нисэх онгоцны буудлууд болон шууд нислэггүй ч дамжин нисэх боломжтой бусад томоохон хотуудыг судлаж үзвэл дараах байдалтай байна. Үүнд:

1. БНХАУ-ын Гуанжоу, Хонгконг, Хөх хот, Тяньжин, Хайлаар, Манжуур
2. БНСУ-ын Сөүл, Пусан
3. Япон улсын Токио, Кансай
4. ОХУ-ын Улаан-Үүд, Эрхүү

Ази, европыг чиглэсэн нислэгийн 50 гаруй хувь нь манай улсын нутаг дэвсгэр дээгүүр өнгөрч байна. Манай улс үзүүлэлтэд тулгуурласан навигацийн 10 агаарын замтай болж байгаа. Агаарын шулуун замаар хоёр хөрштэй холбогдвол Манай улсад ашигтай байх болно. 2017 онд өнгөрөлтийн нислэг 110,970 болж нэмэгдсэн байна.[44]




**Зураг 1. 3 Нислэгийн 5 цагийн зайг тооцсон радиус**

**<u>5 цагийн нислэгийн зайд байрлах нислэггүй томоохон хотууд:</u>**

1. Казахстан улсын Алма-Ата, Астана
2. Киргизстан улсын Бишкек
3. Непал улсын Катманду
4. Бутан улсын Тимпу
5. Энэтхэг улсын Гангток, Шиллонг
6. Лаос улсын Луангпрабанг
7. Вьетнам улсын Ханой
8. БНХАУ-ын Хайнань
9. ОХУ-ын Владивосток, Хабаровск, Кранснoярск, Новосибирь, Барнаул, Омск

[44] ИНЕГ-ын НААХЗА-ны дарга Ё.Эрдэнэбат. 2018

**Зураг 1. 4 Нислэгийн 5 цагийн зайд орших олон улсын нисэх онгоцны буудлууд руу хийх 2021 оны зуны тогтмол нислэгийн цагийн хуваарь**

**2021 оны зуны тогтмол нислэгийн цагийн хуваарь**

| **Нислэгийн хугацаа** | **Нислэгийн чиглэл** | **Аялалын дугаар** | **Агаарын тээвэрлэгч** | **Даваа** | | **Мягмар** | | **Лхагва** | | **Пүрэв** | | **Баасан** | | **Бямба** | | **Ням** | | **Хүчинтэй хугацаа** |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | **Нисэх** | **Буух** | **Нисэх** | **Буух** | **Нисэх** | **Буух** | **Нисэх** | **Буух** | **Нисэх** | **Буух** | **Нисэх** | **Буух** | **Нисэх** | **Буух** | |
| 2ц30мин | БЭЭЖИН - БУЯНТ-УХАА | MGL-224 | | 09:30 | 12:00 | 21:10 | 23:40 | 09:30 | 12:00 | 21:10 | 23:40 | 21:10 | 23:40 | 09:30 | 12:00 | 21:10 | 23:40 | |
| | БЭЭЖИН - БУЯНТ-УХАА | MGL-228 | | | | 01:40 | 04:10 | | | 02:00 | 04:30 | | | | | 02:00 | 04:30 | |
| 4ц40мин | ХОНГКОНГ - БУЯНТ-УХАА | MGL-298 | | | | | | 18:20 | 23:00 | | | | | | | | | |
| | ХОНГКОНГ - БУЯНТ-УХАА | MGL-298 | | | | 12:05 | 16:45 | | | 12:05 | 16:45 | 12:05 | 16:45 | | | 12:05 | 16:45 | |
| | ХОНГКОНГ - БУЯНТ-УХАА | MGL-2972 | | 18:30 | 23:10 | | | | | | | | | 16:45 | 21:20 | | | |
| 4ц35мин | ТОКИО - БУЯНТ-УХАА | MGL-502 | | 14:40 | 19:15 | 14:40 | 19:15 | 14:40 | 19:15 | | | 14:40 | 19:15 | 14:40 | 19:15 | 14:40 | 19:15 | |
| | ТОКИО - БУЯНТ-УХАА | MGL-502 | | | | | | | | 14:40 | 19:15 | | | | | | | |
| 2ц55мин | СӨУЛ - БУЯНТ-УХАА | AAR-567 | ASIANA AIRLINES | | | 20:55 | 23:50 | | | 20:55 | 23:50 | | | 20:55 | 23:50 | | | 2021.03.30 - 2021.10.30 |
| 4ц10мин | ГУАНЖОУ - БУЯНТ-УХАА | MGL-236 | | 03:50 | 08:00 | | | | | | | 03:50 | 08:00 | | | | | |
| 3ц40мин | КАНСАЙ - БУЯНТ-УХАА | MGL-506 | | | | | | 14:20 | 18:00 | | | | | 14:20 | 18:00 | | | |
| 2ц40мин | СӨУЛ - БУЯНТ-УХАА | MGL-302 | | 14:20 | 17:00 | 14:20 | 17:00 | 14:20 | 17:00 | 14:20 | 17:00 | 14:20 | 17:00 | 14:20 | 17:00 | 14:20 | 17:00 | |
| | СӨУЛ - БУЯНТ-УХАА | MGL-308 | | 01:35 | 04:15 | | | | | 01:35 | 04:15 | | | | | | | |
| 4ц30мин | ХОНГКОНГ - БУЯНТ-УХАА | EZA-232 | eznis | | | | | 13:05 | 17:35 | | | | | 13:05 | 17:35 | | | |
| 3ц10мин | Бусан - БУЯНТ-УХАА | EZA-202 | eznis | | | | | | | 13:00 | 16:10 | | | | | 17:30 | 20:40 | |
| 1ц10мин | ЭРХҮҮ - БУЯНТ-УХАА | MNG-102 | | 12:00 | 13:10 | | | | | | | 12:00 | 13:10 | | | | | |
| | ЭРХҮҮ - БУЯНТ-УХАА | MNG-102 | | | | | | 12:00 | 13:10 | | | | | | | | | |
| 1ц40мин | ХӨХ ХОТ - БУЯНТ-УХАА | MNG-802 | | 16:50 | 18:30 | | | 16:50 | 18:30 | | | 16:50 | 18:30 | | | | | |
| 2ц30мин | Тяньжин - БУЯНТ-УХАА | MNG-808 | | | | | | 01:00 | 03:30 | | | 01:00 | 03:30 | | | 01:00 | 03:30 | |
| 1ц50мин | ХАЙЛААР - БУЯНТ-УХАА | MML-852 | | | | | | 15:30 | 17:20 | | | | | 15:30 | 17:20 | | | |
| 1ц50мин | Манжуур - БУЯНТ-УХАА | MML-882 | | | | | | | | 16:30 | 18:20 | | | | | 16:30 | 18:20 | |
| 1ц30мин | УЛААН-ҮД - БУЯНТ-УХАА | MML-728 | | | | | | | | 15:50 | 17:20 | | | | | 15:50 | 17:20 | |
| 2ц40мин | СӨУЛ - БУЯНТ-УХАА | KAL-867 | | 09:00 | 11:40 | | | 09:00 | 11:30 | 09:00 | 11:40 | 09:00 | 11:30 | 09:00 | 11:40 | 09:00 | 11:30 | 2021.03.28 - 2021.10.30 |
| 1ц50мин | ХӨХ ХОТ - БУЯНТ-УХАА | CCA-753 | | | | 09:30 | 11:20 | | | | | | | 09:30 | 11:20 | | | 2021.03.30 - 2021.10.30 |
| 2ц15мин | БЭЭЖИН - БУЯНТ-УХАА | CCA-901 | | 08:35 | 10:50 | 08:35 | 10:50 | 08:35 | 10:50 | 08:35 | 10:50 | 08:35 | 10:50 | 08:35 | 10:50 | 08:35 | 10:50 | 2021.03.28 - 2021.10.30 |
| 3ц05мин | Бусан - БУЯНТ-УХАА | ABL-411 | | | | 08:35 | 11:40 | | | | | 08:35 | 11:40 | | | 08:35 | 11:40 | 2021.03.30 - 2021.10.29 |

## <u>Улаанбаатар хотоос 3000 км-ийн доторх зайд болдог аялал жуулчлалын томоохон эвентүүд:</u>

Интернэтийн хайлтын систем дээр Mongolia гэдэг үгтэй хамт Nomadic tourism гэсэн үгс хамгийн их гарч ирсэн. Аялал жуулчлалын бүтээгдэхүүнийг үнэлэх үзүүлэлтийн нэг нь хайлтын систем дэх илэрц байдаг ба үүнийг дэлгэрүүлж судлахыг фокус бүлгийн ярилцлагын үеэр судлаачид бидэнд зөвлөсөн. Хавсралтаар хүснэгт 8-д  үзүүлсэн нүүдлийн соёлын эвентүүдийн талаар дэлгэрэнгүй мэдээллийг оруулсан болно.

**Хүснэгт 1. 8 Нислэгийн 5 цагийн зайд зохион байгуулагддаг нүүдлийн соёлын эвентүүд**

| № | Үзүүлэлт эвент | Эхэлсэн хугацаа, байршил | Уриа үг | Жилд оролцох гадаадын жуулчид | Онцлох зүйлс |
|---|---|---|---|---|---|
| 1 | “Дэлхийн нүүдэлчдийн наадам” /World Nomad Games/ -Азийн орнуудын угсаатнуудын фестиваль. Киргизстан улс | 2014 оноос 2 жил тутамд 1 удаа зохиогддог. | 2016 оны наадамд “Хэрэв Чингис хаан амьд байсан бол дэлхийн нүүдэлчдийн наадмын хойморт залрах байлаа” уриа үгээр эхэлсэн. | 2016 онд 40 орны 2000 гаруй тамирчид, аялал жуулчлалын зорилгоор 60,000 гадаадын гийчид ирж сонирхсон байна. | Нүүдэлчдийн олимп хэлбэрээр уламжлалт эд өлгийн зүйлс ашиглан тэмцээн зохион байгуулах, өв соёл сурталчилж гадаадын тамирчдыг олноор хамруулж чаджээ. |
| 2 | “Нүүдэлчдийн ертөнц” Nomads’ World Festival | "Кошпендилер Алеми" буюу “World of Nomads festival” бол Казахстаны нийслэлд жил бүр зохион байгуулагддаг олон улсын нүүдэлчдийн соёлын наадам бөгөөд энэ нь гэгээлэг сэтгэл хөдлөлийг төрүүлээд зогсохгүй олон зууны гүнээс нүүдэлчин мэт сэтгэгдэл төрүүлэх, нүүдэлчин ард түмний ертөнцөд умбах боломжийг олгодог. | | | |
| 3 | “Этно Ауыл” аялал жуулчлалын цогцолбор | Казакстан улс EXPO-2017 үзэсгэлэнгийн хүрээнд | 2018 оны 06-р сарын 30-наас 7-р сарын 1-ны өдрүүдэд “Нүүдэлчдийн ертөнц” этнофестивалийг зохион байгуулсан | Энэ хотхон нээгдсэн эхний 2 өдөрт нийт 18 мянган зочид хүрэлцэн иржээ | 2500 м.кв талбайг хамарсан 40 гэр, 8 хэсгээс бүрдэх цогцолбор. Этник хөгжмийн урсгалыг хүчтэй хөгжүүлж, шинэ хамтлаг, дуучдыг олноор бэлдэж байна. |
| 4 | “Казах ертөнц” нүүдэлчдийн цэцэрлэгт хүрээлэн | Казахын хаант улс байгуулагдсаны 550 жилийн ойг угтаж, Тараз хотын анхны ерөнхийлөгчийн цэцэрлэгт хүрээлэнд “Казах ертөнц” түүх-угсаатан зүйн хүрээлэнг нээсэн | | Хүрэлцэн ирсэн хүмүүс уламжлалт тоглоом наадгайгаар тоглодог. | Энд нүүдэлчин ард түмний соёл, уламжлалт зан үйлийг жуулчдад сонирхуулдаг. |
| 5 | Нүүдэлчдийн фестиваль /Nomad Festival/ Бутан улс | 2009 оноос хойш Бутаны төв Бумтанг Зонгхаг мужид орших Нагаспел хотод нийслэл Тимфу хотоос найман цагийн зайтай газарт жил бүрийн хоёрдугаар сарын сүүлийн долоо хоногт бүтэн 2 өдрийн турш зохион байгуулдаг. | | 2019 оны Бутаны “Нүүдэлчдийн баяр”-т гадаадын 7 жуулчин оролцсон байна. | Жил бүр болдог Бутаны Нүүдэлчдийн баяр нь соёлын баялаг өв, сайн сайхан байдаараа алдартай. |
| 6 | Paro Tsechu[45] фестиваль /масктай бүжиг буюу цам харайх/ Бутан улс зэрэг болно. | Бутаны хаан Синдху Ража үхлийн ирмэг дээр байх үед Гуру Падмасамбхава /2 дахь будда гэгддэг/ өөрийн хүч чадал, итгэл үнэмшлээрээ Бумтангийн хөндийд хэд хэдэн тшечу бүжиг /Eight Manifestations/ тоглосон нь хааны өвчнийг анагаасан түүхтэй. 1644 онд Паро Дзонг ариусгасны дараа маск өмссөн бүжиг, уламжлалт дууны хэлбэрээр томоохон баяр хийснээс хойш жил бүр тэмдэглэж байна.[46] | | 2019 оны Paro Tsechu фестивальд гадаадын 394 жуулчин оролцсан байна. Баярыг билгийн тооллын дагуу 2 дахь сарын 10-наас эхэлдэг. | Буддын шашны итгэл нь хүний амьдралыг сайн сайхны зам руу хэрхэн чиглүүлж болохыг харуулдаг энэ эвент нь Бутаны соёл, Буддын шашны түүхийн талаар маш их зүйлийг 5 хоногт үзүүлдэг онцлогтой. |

*Эх сурвалж: Судлаачийн тооцоо*

[45] https://www.tourism.gov.bt/uploads/attachment_files/tcb_K11a_BTM%202019.pdf
[46] https://www.holidify.com/pages/paro-tshechu-1149.html

### 1.5.2 Монголоос нислэгийн 5 цагийн зайд зохион байгуулагддаг нүүдэлчдийн соёлын эвентүүдийг харьцуулсан дүн шинжилгээ

“Монгол **улсын тогтвортой хөгжлийн үзэл баримтлал-2030” бодлогын баримт бичигт манай улсыг “Нүүдлийн соёл, аялал жуулчлалын олон улсын төв”** болгохоор тусгасан бол **“Алсын хараа-2050” Монгол улсын урт хугацааны хөгжлийн бодлогод “Монгол улс нь ү**ндэсний оюун санаа, өв соёл, сэтгэлгээнд тулгуурласан бүтээгч Монгол хүн төвтэй нүүдлийн соёл иргэншлийг хадгалсан тэргүүлэх улс болж үндэсний онцлог бүхий **нүүдлийн өв, түүх, соёлд түшиглэсэн аялал жуулчлалыг** бүсчлэн хөгжүүлэх”-ээр тус тус тусгасан байдаг.

Иймд аялал жуулчлалын гол бүтээгдэхүүн, үйлчилгээний нэг болох эвент үйл ажиллагааг төлөвлөх, хэрэгжүүлэхдээ үндэсний онцлогт тулгуурласан нүүдлийн соёл, уламжлалыг харуулах хэрэгтэй бөгөөд үүний тулд өрсөлдөгч, зарим талаар хамтрагч орнуудын ижил төстэй онцлог бүхий эвентүүдийг судлах зайлшгүй шаардлагатай юм.

Өмнөх бүлэгт дурдсан нислэгийн 5 цагийн зайд зохион байгуулагддаг эвент тус бүрийн хувьд давуу, сул тал болон бидний хувьд хамтран ажиллах боломжийг тодорхойлох зорилгоор дараах SWOT анализийг хийж гүйцэтгэлээ. Үүнд:

**Зураг 1. 5 “Дэлхийн нүүдэлчдийн наадам” /World Nomad Games/ - Азийн орэуудын угсаатануудын фестиваль, Киргизстан улс**

| SWOT анализ | | |
|---|---|---|
| | **Strengths: Давуу тал** | Маркетинг сайтай тул гадаадын тамирчдын тоо, оролцоо өсөж байгаа<br>ЮНЕСКО байгууллагаас дэмжиж оролцдог |
| | **Weaknesses: Сул тал** | Мэргэжлийн тамирчид оролцдог тул хамрах хүрээ хязгаарлагдмал<br>Урлагийн буюу биет бус өвийн чиглэлээр өрсөлдүүлээгүй тул Монгол улс энэ чиглэлийн эвент хийж болох |
| | **Opportunities: Боломж** | Монголын үндэсний урлаг, спортын төрлүүдээр баяжуулж хамтран зохион байгуулах<br>Киргизийн үндэсний спортын төрлүүдээр мэргэжлийн тамирчид бэлтгэн оролцуулж өндөр амжилт гаргах |
| | **Threats: Аюул** | Монгол улсын “Төрийн наадам” зэрэг үндэсний өв шингэсэн томоохон эвентийн өрсөлдөгч бүтээгдэхүүн болж болзошгүй<br>Дэлхийн нүүдэлчдийн соёлын өв хадгалагч нь Киргиз улс гэж олон улсад хоногших эрсдэлтэй |
| **Эвентийн онцлог** | | • Жуулчдад зөвхөн үзүүлэх, харуулах бус өөрсдөө оролцох боломжийг хангасан гэдгээрээ онцлог<br>• Гэхдээ энэ оролцоо нь энгийн нэг оролцож үзэх хэлбэрээр бус мэргэжлийн тамирчид шиг өрсөлдөөнтэй хэлбэрээр оролцож олимп шиг зохион байгуулж байгаагаараа онцлог<br>• Шагнал урамшуулал, медаль нь үндэсний онцлог шинжийг хадгалсан байгаа нь сонирхолтой |

| | |
|---|---|
| | • 2016 оны 2-р олимп дээр холливудын од Стивен Сигал нээлтийн ажиллагаанд морь унан орж ирсэн нь үзэгчдийн сонирхлыг ихэд татаж байсан |
| **Ашиглаж болох санаа** | • Монголын үндэсний онцлогийг харуулсан тэмцээний төрлүүд бүхий шинэ нүүдэлчдийн олимпийг зохион байгуулж болно. Гэхдээ зөвхөн Монгол улсаас дэлхийн өвд бүртгэгдсэн соёлын өвийн төрлүүдийг ашигласан байх нь гол чухал ялгарал болох юм.<br>• Мөн өөрөөр мэргэжлийн тэмцээн байдлаар биш зөвхөн сонирхогчийн түвшинд зохих түвшний сургалтанд хамрагдсаны дараагаар зохион байгуулдаг эвент байж болно. Тухайлбал нум сум харвах, морь унах гэх мэт<br>• Үндэсний соёлын биет бус өвийн наадмыг мөн зохих түвшний сургалтанд хамрагдсаны дараагаар нэгдсэн цугларалт хэлбэрээр хийж өрсөлдөөнтэй зохион байгуулагдахаар эвентийг санаачилж болно. Морин хуур, цуур, хөөмий гэх мэт |
| **Хамтарч ажиллах боломж** | • Манай улсаас 2016 онд “Монголын шувуулахуйн холбоо” ТББ, “Тэнгэрийн чоно” кино орлон тоглогчдын холбоо болон “Монголын нохой судлалын холбоо”-ны дэргэдэх анч тайга нохойн “Талын салхи” үржлийн газраас тэмцээнд оролцсон боловч Монгол улсаас нохой, шонхор, бүргэдийг хилээр гаргаагүй учир өөрсдийн нохой, шувуугаар өрсөлдөж чадаагүй байна.<br>• Баян-Өлгийн бүргэдчид болон Монгол тайга нохой зэрэг нөөц боломжоо ашиглан Монгол улсаас баг тамирчид бэлтгэн оролцуулах боломжтой.<br>• Мөн 2 жил тутамд 1 удаа явагдах тул Монгол улсад 2024 оны нүүдэлчдийн олимпийг зохион байгуулахаар санал дэвшүүлж болох юм.<br>• 2018 оны 3-р олимпод Монгол улсаас 15 төрөлд 60 тамирчин өрсөлдсөн ба 12 уран бүтээлчид оролцсон нь манай улсын оролцоо өссөнийг харуулж байна.<br>• 2018 оны 3-р олимпоос эхлэн бөхийн төрөлд нь “Монгол үндэсний бөх” нэмэгдсэнээр бусад орны хүмүүс үндэсний бөхөөр барилдаж өрсөлдөх боломжийг олгож эхэлсэн нь онцлог болсон. |

### Зураг 1. 6”Нүүдэлчдийн ертөнц” Nomads’ World Festival, Казахстан улс

| | | |
|---|---|---|
| **SWOT анализ** | **Strengths: Давуу тал** | • Европ тивийн Унгар улстай хамтран энэхүү арга хэмжээг зохион байгуулдаг.<br>• Үзүүлбэр болон оролцооны тэмцээн хоёрыг хослуулан зохион байгуулдаг.<br>• Спортын үзүүлбэрүүдээс гадна домбра хөгжмийн баяр, гудамжны бүжгийн чуулган, ОУ-ын үлээвэр найрал хөгжмийн тэмцээн, тоглолтуудаар баяжуулсан хөтөлбөртэй. |
| | **Weaknesses: Сул тал** | Оролцогч, үзэгчдийн тоо харьцангуй цөөн.<br>4 дэх удаагаа 2019 онд зохион байгуулсан эхэлж буй эвент. |
| | **Opportunities: Боломж** | • Монгол улсаас Кокпар тэмцээнд баг тамирчид оролцож улсаа танилцуулж байгаа.<br>• Шувуучлахуй болон үндэсний тулааны урлагийн чиглэлээр хамтран ажиллах боломжтой. |
| | **Threats: Аюул** | Манай улсын Баян-Өлгий аймгийн бүргэдээр ан агнах уламжлалыг биднээс илүү Казакстан улс дэлхий дахинд сурталчилан таниулах оролдлого хийж байна. |

| | |
|---|---|
| **Эвентийн онцлог** | • Морин уралдааныг тулааны урлагтай хослуулан хийж эвентийн онцлогийг гаргасан байдаг.<br>• Казах үндэстэний өв уламжлалыг цогцоор нь харуулж чадсан гэдэг утгаараа давтагдашгүй. |

| | |
|---|---|
| **Ашиглаж болох санаа** | Наадмын үзэл баримтлалыг Унгар улсад жил бүр зохион байгуулдаг Түрэг үндэстнүүдийн Их Курултын /Их хуралдай/ загвар дээр үндэслэсэн гэж тайлбарладаг. Иймд бид мөн адил “Их хуралдай” хэрхэн зохион байгуулдаг байсан заншлыг судлаж бие даасан эвентийг санаачилж болох юм. |
| **Хамтарч ажиллах боломж** | • Казах түмний Кокпар /тулам булаалдах/ үндэсний тэмцээнд 2019 онд манай улсаас оролцож байсан.<br>• Нүүдэлчдийн соёлын наадамд Монгол үндэсний Бух ноцолдооны төрлийг нэмж оруулан сурталчлах боломжтой<br>• Тулааны урлагийн фестивальд Морин дээрх харвааны төрлийг нэмж оруулан үндэсний соёлоо сурталчлах боломжтой. |

## Зураг 1. 7 “Этно Ауыл” аялал жуулчлалын ЭКСПО, Казахстан улс

| | | |
|---|---|---|
| **SWOT анализ** | **Strengths: Давуу тал** | • Казахстаны нийслэл хотноо Этно-ауыл цогцолборыг байгуулсан учир байнгын үзэгч, зочинтой байх боломжтой.<br>• Этник хөгжмийн урсгалыг хүчтэй хөгжүүлж, шинэ хамтлаг дуучдыг энэ цогцолборт тоглолт хийлгэдэг. |
| | **Weaknesses: Сул тал** | Nomads’ World Festival зэрэг цөөхөн том эвенттэй бөгөөд тус цогцолборын үйл ажиллагаа бүрэн тогтмолжоогүй байна. |
| | **Opportunities: Боломж** | • Нүүдэлчдийн урлаг соёлын үзүүлбэрүүдэд Монгол үндэсний өв соёлын үзүүлбэр нэмж болох юм.<br>• Монгол улсын казах иргэдээс бүрдсэн мэргэжлийн баг гаргаж энэ цогцолборт тогтсон хугацаанд тогтмол тоглолт үзүүлдэг хуваарьтай болох боломжтой. |
| | **Threats: Аюул** | Нүүдэлчдийн урлаг, спортыг аялал жуулчлалтай холбосон цогцолбор гэдэг утгаараа цаашид олон улсыг хамарсан нүүдлийн соёлын эвентүүдийг Казахстаны энэ цогцолборт хийдэг болж болзошгүй. |
| **Эвентийн онцлог** | | Нүүдэлчдийн урлаг соёлын эвентүүдийг зохион байгуулдаг онцлогтой. |
| **Ашиглаж болох санаа** | | Нүүдэлчдийн урлагийн их наадам /биет бус соёлын өв/ -ийг санаачлан зохион байгуулж болно. |
| **Хамтарч ажиллах боломж** | | Одоогоор манай улсаас уг цогцолбортой хамтран эвент зохион байгуулж амжаагүй байгаа ч Монгол үндэстний соёлын эвентүүдийг энд зохион байгуулах боломжтой. Жишээ нь “Хэл хуурын наадам” гэх мэт |

## Зураг 1. 8 “Казах ертөнц” нүүдэлчдийн цэцэрлэгт хүрээлэн, Казахстан улс

| | | |
|---|---|---|
| **SWOT анализ** | **Strengths: Давуу тал** | • **Угсаатан зүйн чиглэлээр дагнасан үзүүлбэр үзүүлдэг**<br>• **Казах үндэстний соёлыг харуулсан байнгын ажиллагаатай цэцэрлэгт хүрээлэнг бий болгосон** |
| | **Weaknesses: Сул тал** | • Онцгойлсон эвент байхгүй бөгөөд музей, цэцэрлэгт хүрээлэн хэлбэрээр ажилладаг |
| | **Opportunities: Боломж** | • Бусад нүүдлийн соёлын эвентүүдийг зохион байгуулах боломжтой. |
| | **Threats: Аюул** | • Жуулчдын сонирхолыг бусад зорин очих газрууд татах |

| | |
|---|---|
| **Эвентийн онцлог** | • Угсаатан зүйн чиглэлээрээ дагнасан гэдгээрээ онцлог |
| **Ашиглаж болох санаа** | • Зөвхөн Казак үндэстэн төдийгүй Монгол үндэстний угсаатан зүйн цэцэрлэгт хүрээлэнг Төв аймагт байгуулах боломжтой. Учир нь Төв аймгийн Зуун мод хотноо Археологийн музей шинээр байгуулагдаж байгаа явдал юм. |
| **Хамтарч ажиллах боломж** | • Баян-Өлгий аймагтай хамтран угсаатан зүйн MICE туризмыг хөгжүүлэх боломжтой |

## Зураг 1. 9 Бутан улсын “Нүүдэлчдийн фестивал” ба “Пара цечү” буддын шашны цам бүжгийн эвент

| | | |
|---|---|---|
| **SWOT анализ** | **Strengths: Давуу тал** | • **Бутаны нүүдэлчин уламжлал, соёлын өв болон буддын шашны соёлыг харуулдаг.** |
| | **Weaknesses: Сул тал** | • Жуулчид бага зочилдог, гадаад сурталчилгаа хангалтгүй |
| | **Opportunities: Боломж** | • Энэ 2 эвентээ нэгтгэн нүүдлийн соёл, буддын шашны соёлыг хослон харуулах нэг том эвент зохион байгуулах боломжтой. |
| | **Threats: Аюул** | • Жуулчдын сонирхолыг бусад зорин очих газрууд татах |
| **Эвентийн онцлог** | | • Угсаатан зүйн чиглэлээрээ дагнасан гэдгээрээ онцлог |
| **Ашиглаж болох санаа** | | • Цамын бүжгийг хэрхэн 5 хоногийн хөтөлбөр болгон баяжуулах |
| **Хамтарч ажиллах боломж** | | • Манай улсын Даншиг наадамтай хамтран 1 аялал зарлаж болно |

Монголоос нислэгийн 5 цагийн зайд зохион байгуулагддаг нүүдэлчдийн соёлын эвентүүдийг харьцуулан дүгнэж цаашид хамтарч ажиллах, санаа авч хэрэгжүүлэх боломжийг дараах байдлаар тодорхойлж болно. Үүнд:

**<u>Хамтарч хорших боломж:</u>**

- Монгол улс, ӨМӨЗО, Казахстан, Киргизстан 4 улсыг дамжсан “Нүүдлийн АЖ-ын ОУ-ын маршрут” бүхий цуврал мега эвентүүдийг зохион байгуулж 21 хоногийн багц хөтөлбөрийг олон улсын зах зээлд танилцуулах
- Казакстан, ОХУ-ын Алтайн хязгаар, БНХАУ-ын Шинжаан-Уйгарыг холбосон “Алтайн алтан цагираг” үүсгэсэн ОУ-ын АЖ-ын маршрутыг хэрэгжүүлж үүнд нийцсэн Монголын үндэсний өв, соёл уламжлал бүхий эвентийг Ховд, Баян-Өлгий, Увс аймагт төлөвлөж хэрэгжүүлэх
- Дээрх эвентүүдэд Монгол улсаас мэргэжлийн тамирчид, урлагийнхан бүхий баг бүрдүүлж оролцох
- Монгол үндэсний бөх, бух ноцолдоон, морин дээрх сур харваа, шувуучлахуй гэх мэт олон өв соёлын үзүүлбэрийг Казахстан, Киргизстан улсын дээрх эвентүүд дотор нэмж оруулан гадаадын тамирчдыг өрсөлдүүлэн шагнаж, үндэсний өв соёлоо сурталчлах
- Бутаны “Пара цечү” буюу цам бүжгийн баяртай манай улсын даншиг наадмыг хослуулан 1 багц аялал болгон үзүүлэх

**Ялгарч онцгойрох боломж:**

- Бусад орнуудын нүүдэлчдийн эвентүүд дээр байхгүй байгаа төрөл, чиглэлээр дагнасан томоохон эвентийг Монгол улс санаачлан зохион байгуулах боломжтой. Тухайлбал:
    - Нүүдэлчдийн хоол, ундны баярын фестиваль /World Nomadic Food Festival/
    - Нүүдэлчдийн соёлын биет бус өвийн их наадам /World Nomadic Intangible cultural heritage Fair-WNICHF/
    - Монголчуудын цайны баяр /Tea day of Mongolia/-ыг дэлхийн цайны өдрөөр тааруулан тэмдэглэдэг болох, улмаар “Олон улсын цайны их замын аялал жуулчлалын холбоо”-той хамтран цайны замын аялалыг зохион байгуулах
- Монгол улсад хаврын улиралд дэлхийгээр тархсан Монголчуудын соёлын биет өвүүдийг нэгтгэн жилд 1 удаа танилцуулга хийж “GREAT MONGOLIA FAIR” баяр наадмыг цагаан сарын баярын үеэр зохион байгуулвал давхар өвлийн аялал жуулчлалыг дэмжих боломжтой юм.
- Монгол улсад өнөөг хүртэл зохион байгуулагдаж ирсэн эвентүүд ихэнхдээ үзүүлбэр, танилцуулгын зорилготой жуулчдын хувьд зөвхөн үзэх боломжтой байж ирсэн хандлагыг өөрчилж жуулчдын оролцоог илүү их дэмжих хэрэгтэй. Орчин үед “Бүтээлч аялал жуулчлал” буюу “Creative tourism”-ийг нүүдлийн соёл, уламжлалтай ухаалгаар хослуулан хэрэгжүүлэх шаардлагатай болж байна.

Нүүдэлчдийн соёл, уламжлалыг аялал жуулчлалын бүтээгдэхүүн болгож байгаа улс орнуудын туршлага харилцан адилгүй боловч ерөнхийд нь дараах байдлаар дүгнэж болохоор байна. Үүнд:

- Нүүдэлчдийн соёлын наадмыг олон улсын тэмцээн, уралдаан хэлбэрээр жуулчдын оролцоог ханган зохион байгуулж байгаа туршлага байна.
- Нүүдэлчдийн соёлын олон өв дурсгал, уламжлалаас аль нэгийг нь товойлгон харуулж дэлхий дахинд брэнд болгон таниулж байгааг Киргизстаны /уламжлалт спорт тоглоом/ жишээнээс харж болохоор байна.
- Жуулчдын оролцоо, тэмцээн зохиохоос илүүтэй соёл уламжлалаа таниулах, үзүүлэх чиглэлийг түлхүү баримталж буйг Монгол улс, Унгар улсын жишээг дурдаж болох юм.

## 1.6. МОНГОЛ УЛСАД ЗОХИОН БАЙГУУЛАГДСАН АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН ЭВЕНТҮҮДИЙГ ЭДИЙН ЗАСГИЙН ҮЗҮҮЛЭЛТЭЭР ЭРЭМБЭЛЭХ НЬ

Өмнөх хэсэгт эдийн засгийн нөлөөллийг үнэлэх дараах үзүүлэлтүүдийг тодорхойлсон. Үүнд:

1. Нийт оролцогчдын тоо;
2. Гадаад жуулчдын тоо;
3. Оролцогчдын дундаж зардал;
4. Ажиллах хүчний тоо;
5. Зардлын хэмжээ;
6. Орлогын хэмжээ.

Судлаачдын баг Монгол улсад зохион байгуулагдсан эвентийн өнөөгийн байдал, эдийн засгийн нөлөөлөл, тулгамдаж буй асуудлуудыг судлах зорилгоор нийслэл, аймаг орон нутгуудийн Байгаль орчин, аялал жуулчлалын газрын мэргэжилтнүүд, тур операторууд болон бусад оролцогчдоос түүвэр судалгааг авч байгаа ба энэхүү судалгааны хүрээнд манай улсад сүүлийн жилүүдэд зохион байгуулагдсан (Ковид-19 цар тахлын улмаас эвентүүдийг 2020-2021 онуудад эрэмбэлэх боломжгүй тул цар тахлын өмнөх буюу 2019 оны байдлаар харгалзан үзэв) нийт 100 аялал жуулчлалын эвентийн мэдээллийг цуглуулсан.

Судалгаанд хамрагдсан оролцогчид мэдээллээ дутуу ирүүлсэн, зарим тоо мэдээлэл гарах боломжгүй гэх зэргээс шалтгаалаад нийт 100 эвентээс 50 эвентийн мэдээллийг нэгтгэн холбогдох үзүүлэлтүүдээр эрэмбэлэв.

### Хүснэгт 1. 8 Нийт оролцогчдын тоогоор эрэмбэлсэн байдал

| № | Эвентийн нэрс | Аймаг | Нийт оролцогчдын тоо |
|---|---|---|---|
| 1 | Монгол төрийн наадам | УБ, Төв цэнгэлдэх | 35,000 |
| 2 | Плэйтайм олон улсын хөгжмийн наадам | Улаанбаатар | 32,120 |
| 3 | Наурызын баяр | Баян-Өлгий | 20,000 |
| 4 | Уяхан замбуу тивийн наран | Дундговь | 20,000 |
| 5 | Мөнгөлөг шагшуурга - цас мөсний баяр /Хар-Ус нуур/ | Ховд | 15,010 |
| 6 | Цайны зам өв соёлын наадам | Ховд | 15,000 |
| 7 | Хөх сувд | Хөвсгөл | 10,068 |
| 8 | Айрагны баяр | Булган, Улаанбаатар | 10,000 |
| 9 | Улаанбаатарын өвлийн наадам | Улаанбаатар | 9,000 |
| 10 | Наурызын Eagle festival | Баян-Өлгий | 8,000 |
| 11 | Нүүдэлчдийн соёлын наадам /Улаагчны хар нуур/ | Завхан | 7,700 |
| 12 | Дээлтэй Монгол | Улаанбаатар | 7,000 |
| 13 | Хансонар бүргэдийн баяр | Баян-Өлгий | 6,000 |
| 14 | Дэлгэрхаан уулын тахилга, цагаан адууны баяр | Хөвсгөл | 6,000 |
| 15 | Мөсний баяр | Баян-Өлгий | 6,000 |
| 16 | Бүргэдийн баяр | Улаанбаатар | 5,000 |
| 17 | Талын салхи олон улсын мото наадам | Улаанбаатар | 5,000 |

| | | | |
|---|---|---|---|
| 18 | Цаатан фестивал | Хөвсгөл | 4,500 |
| 19 | Цаатан наадам /Далай тур бааз/ | Хөвсгөл | 4,130 |
| 20 | Алтайн нүүдэлчдийн баяр | Баян-Өлгий | 4,000 |
| 21 | Наадам найт show | | 4,000 |
| 22 | Гонгорын бумбаны тахилга /Амарбаясгалант хийд/ | Сэлэнгэ | 3,238 |
| 23 | Бүргэдийн баяр | Баян-Өлгий | 3,000 |
| 24 | Сарлаг наадам | Хөвсгөл | 3,000 |
| 25 | Хуралдай наадам-Шонхорын баяр /Чингисийн хүрээ бааз/ | Улаанбаатар | 3,000 |
| 26 | “Хийморь” морьт харваа, морин тулааны фестиваль | Улаанбаатар | 3,000 |
| 27 | Ээж хайрхан ханш нээх өдөр | Сэлэнгэ | 2,530 |
| 28 | Цасны наадам | Хөвсгөл | 2,500 |
| 29 | Элсэн манханы баяр /Хонгорын элс/ | Өмнөговь | 2,470 |
| 30 | Сарлагийн баяр | Өмнөговь | 2,225 |
| 31 | Талын түмэн адуу | Хэнтий | 1,820 |
| 32 | Алтайн Урианхайн мөсний баяр, мөсөн сур харваа | Баян-Өлгий | 1,500 |
| 33 | Ёохор хатар ардын урлагийн наадам (Буриад үндэстний урлаг спортын наадам) | Хэнтий | 1,120 |
| 34 | Түмэн тэмээний баяр | Өмнөговь | 776 |
| 35 | Гал шар хурдан адууны баяр | Хэнтий | 700 |
| 36 | Даян дээрхийн шагайн тойром | Хөвсгөл | 700 |
| 37 | Тогорууны баяр | Хэнтий | 690 |
| 38 | Улаанбаатар марафон - олон улсын гүйлт | Улаанбаатар | 650 |
| 39 | Агтана хүрээт хүлэгч эрсийн наадам, Олон улсын гэрэл зурагчдын наадам | Сүхбаатар | 600 |
| 40 | Элсний фестиваль /Эрээн нуур бааз ба Гүн нуур-өөрчлөгддөг/ | Говь-Алтай | 565 |
| 41 | Талын тайга нохойн үзүүлбэр | Хэнтий | 525 |
| 42 | Ганга нуурын чуулга | Сүхбаатар | 500 |
| 43 | “Малчны баяр” арга хэмжээ /“Онгийн хийд” байгалийн дурсгалт газар/ | Дундговь | 500 |

| | | | |
|---|---|---|---|
| 44 | Их говийн тэмээ | Дундговь | 400 |
| 45 | Чингис Фестивал Олон улсын соёл урлагийн наадам (Хүүхдийн олон улсын урлагийн наадам) | Хэнтий | 375 |
| 46 | Монгол нүүдэлчдийн нэг өдөр | Өмнөговь | 350 |
| 47 | Ээж уулын элбэрэл | Говь-Алтай | 350 |
| 48 | Адуучин айрагны баяр | Дундговь | 300 |
| 49 | “Хонины найр” | Төв | 130 |
| 50 | Sunrise to sunset гүйлт | Хөвсгөл | 75 |
| | **НИЙТ** | | |

*Эх үүсвэр: Аймаг, нийслэлийн аялал жуулчлалын газрын мэргэжилтнүүдийн ирүүлсэн тоо, мэдээлэлд үндэслэв*

## Хүснэгт 1. 9 Гадаад жуулчдын тоогоор эрэмбэлсэн байдал

| № | Эвентийн нэрс | Аймаг | Гадаад жуулчдын тоо |
|---|---|---|---|
| 1 | Монгол төрийн наадам | УБ, Төв цэнгэлдэх | 3,000 |
| 2 | Наадам найт show | | 3,000 |
| 3 | Хансонар бүргэдийн баяр | Баян-Өлгий | 1,800 |
| 4 | Цаатан фестивал | Хөвсгөл | 1,500 |
| 5 | Дээлтэй Монгол наадам | Улаанбаатар | 1,000 |
| 6 | Алтайн нүүдэлчдийн баяр | Баян-Өлгий | 1,000 |
| 7 | Бүргэдийн баяр | Баян-Өлгий | 1,000 |
| 8 | Цасны наадам | Хөвсгөл | 500 |
| 9 | Плэйтайм /Playtime/ хөгжмийн наадам | Улаанбаатар | 450 |
| 10 | “Хийморь” морьт харваа, морин тулааны фестиваль | Улаанбаатар | 450 |
| 11 | Цаатан наадам /Далай тур бааз/ | Хөвсгөл | 330 |
| 12 | Талын түмэн адуу | Хэнтий | 320 |
| 13 | Улаанбаатар марафон - Олон улсын гүйлт | Улаанбаатар | 300 |
| 14 | Талын салхи - Олон улсын мото наадам | Улаанбаатар | 250 |
| 15 | Хуралдай наадам-Шонхорын баяр /Чингисийн хүрээ бааз/ | Улаанбаатар | 250 |
| 16 | Улаанбаатарын өвлийн наадам | Улаанбаатар | 200 |

| | | | |
|---|---|---|---|
| 17 | Нүүдэлчдийн соёлын наадам /Улаагчны хар нуур/ | Завхан | 200 |
| 18 | Бүргэдийн баяр | Улаанбаатар | 200 |
| 19 | “Малчны баяр” арга хэмжээ /“Онгийн хийд” байгалийн дурсгалт газар/ | Дундговь | 200 |
| 20 | Их говийн тэмээ | Дундговь | 200 |
| 21 | Тэмээний баяр | Өмнөговь | 156 |
| 22 | Тогорууны баяр | Хэнтий | 140 |
| 23 | Ёохор хатар ардын урлагийн наадам (Буриад үндэстний урлаг спортын наадам) | Хэнтий | 120 |
| 24 | Уяхан замбуу тивийн наран | Дундговь | 100 |
| 25 | Монгол нүүдэлчдийн нэг өдөр | Өмнөговь | 100 |
| 26 | Sunrise to sunset гүйлт | Хөвсгөл | 75 |
| 27 | Элсэн манханы баяр /Хонгорын элс/ | Өмнөговь | 70 |
| 28 | Хөх сувд | Хөвсгөл | 68 |
| 29 | Адуучин айрагны баяр | Дундговь | 60 |
| 30 | Ээж мод ханш нээх өдөр | Сэлэнгэ | 30 |
| 31 | Сарлагийн баяр  (Өмнөговь) | Өмнөговь | 25 |
| 32 | Чингис Фестивал - Олон улсын соёл урлагийн наадам (Хүүхдийн олон улсын урлагийн наадам) | Хэнтий | 15 |
| 33 | Мөнгөлөг шагшуурга - Цас мөсний баяр /Хар-Ус нуур/ | Ховд | 10 |
| 34 | Гонгорын бумбаны тахилга /Амарбаясгалант хийд/ | Сэлэнгэ | 10 |
| 35 | “Хонины найр” | Төв | 10 |
| 36 | Элсний фестиваль /Эрээн нуур бааз ба Гүн нуур-өөрчлөгддөг/ | Говь-Алтай | 5 |
| 37 | Талын тайга нохойн үзүүлбэр | Хэнтий | 5 |
| 38 | Наурызын баяр | Баян-Өлгий | - |
| 39 | Цайны зам өв соёлын наадам | Ховд | - |
| 40 | Наурызын Eagle festival | Баян-Өлгий | - |
| 41 | Дэлгэрхаан уулын тахилга, цагаан адууны баяр | Хөвсгөл | - |
| 42 | Мөсний баяр | Баян-Өлгий | - |

| | | | |
|---|---|---|---|
| 43 | Сарлаг наадам | Хөвсгөл | - |
| 44 | Алтайн Урианхайн мөсний баяр, мөсөн сур харваа | Баян-Өлгий | - |
| 45 | Гал шар хурдан адууны баяр | Хэнтий | - |
| 46 | Даян дээрхийн шагайн тойром | Хөвсгөл | - |
| 47 | Агтана хүрээт хүлэгч эрсийн наадам, Олон улсын гэрэл зурагчдын наадам | Сүхбаатар | - |
| 48 | Ганга нуурын чуулга | Сүхбаатар | - |
| 49 | Ээж уулын элбэрэл | Говь-Алтай | - |
| 50 | Айрагны баяр | Булган, Улаанбаатар | |
| | **НИЙТ** | | |

*Эх үүсвэр: Аймаг, нийслэлийн аялал жуулчлалын газрын мэргэжилтнүүдийн ирүүлсэн тоо, мэдээлэлд үндэслэв*

## 1.7. МОНГОЛ УЛСАД ЗОХИОН БАЙГУУЛАГДАХ БОЛОМЖИТ 10 ЭВЕНТИЙГ ТОДОРХОЙЛЖ, ЭДИЙН ЗАСГИЙН НӨЛӨӨЛЛИЙН ҮЗҮҮЛЭЛТҮҮД ДЭЭР ҮНДЭСЛЭН ЭРЭМБЭЛЭХ НЬ

### 1.7.1 Монгол улсад зохион байгуулагдах боломжит 10 эвентийг тодорхойлох нь

Монгол улсад тогтмол зохион байгуулагдаж буй аялал жуулчлалын 100 эвентийн мэдээллийг судалгаандаа ашиглав. Эдгээр эвентүүдийг бүс нутгаар нь ангилж үзвэл дараах байдалтай байна. Үүнд:

**Хүснэгт 1. 10 Аялал жуулчлалын нийт эвентийн тоо, бүс нутгаар**

| № | Бүс | Эвентийн тоо |
|---|---|---|
| 1 | Улаанбаатарын бүс | 18 |
| 2 | Баруун бүс | 15 |
| 3 | Хангайн бүс | 28 |
| 4 | Төвийн бүс | 27 |
| 5 | Зүүн бүс /8+2/ | 12 |
| | **НИЙТ** | **100** |

Эдгээр эвентүүдийн дэлгэрэнгүй мэдээллийг Хавсралт 1-д харуулав. Хавсралт 1-ийг үзнэ үү.

Бид оноо өгөх (Scoring) аргыг ашиглан аялал жуулчлалын эвентүүдийг үнэлэх үнэлгээний дэлгэрэнгүй хуудсыг боловсруулан, судалгаандаа ашигласан 70 эвентийг

үнэлж, эрэмбэлсэн. Үнэлгээний шалгуур үзүүлэлтүүдийг дараах хүснэгтэнд харуулав.

### Хүснэгт 1. 11 Үнэлгээний шалгуур үзүүлэлт, тэдгээрт харгалзах оноо

| № | Үнэлгээ Шалгуур үзүүлэлт | 1 оноо | 2 оноо | 3 оноо | 4 оноо | 5 оноо |
|---|---|---|---|---|---|---|
| 1 | Хэрэглэгчдийн тоо /Оролцсон гадаад жуулчдын тоо/ | Гадаад жуулдын тоо-50 хүртэл | Гадаад жуулчдын тоо-51-100 хүртэл | Гадаад жуулчдын тоо 101-150 хүртэл | Гадаад жуулчдын тоо 151-300 хүртэл | Гадаад жуулчдын тоо 301-1000 хүртэл |
| 2 | Тогтмолжсон байдал /Дахин давтагдаж олон удаа хийгдсэн байдал/ | 1 жил зохиогдсон | 2 жил зохиогдсон | 3 жил зохиогдсон | 4 жил зохиогдсон | 5-аас дээш жил зохиогдсон |
| 3 | Тэнцвэржүүлэх байдал* /АЖ-ын бус улирлыг дэмжихэд чиглэсэн байдал/ | Жуулчдын 15% -аас их хувь ирдэг сард | Жуулчдын 10% -14% ирдэг сард | Жуулчдын 8% -10% ирдэг сард | Жуулчдын 5%-8% ирдэг сард | Жуулчдын 4% -аас бага хувь ирдэг сард |
| 4 | Өв тээгч байдал /Түүх, соёл урлагийн уламжлалыг хадгалах, хамгаалах сурталчлах байдал/ | Соёлын өвийг элемент, агуулга огт багтаагаагүй бол | Соёлын өвийн элемент, агуулга бага зэрэг багтаасан бол | “Төлөөллийн үндэсний жагсаалт, яаралтай хамгаалах шаардлагатай жагсаалт”-д багтаагүй бусад соёлын өвийг багтаасан бол** | Төлөөллийн үндэсний жагсаалт болон яаралтай хамгаалах шаардлагатай соёлын биет бус өвийн үндэсний жагсаалтад багтсан соёлын өвийг багтаасан бол | Дэлхийд бүртгэгдсэн соёлын өвийг багтаасан бол |
| 5 | Өвөрмөц байдал /Бусад бүс нутаг, эвентүүдээс ялгарах имиж бүрдүүлсэн байдал/ | Бусад эвентүүдээс ялгарах онцлог имиж байхгүй бол | Аймаг, орон нутгийн хэмжээнд онцлог дүр төрхийг агуулсан бол | Монгол улсад ялгарах онцлог дүр төрхийг илэрхийлсэн байх | Тив, бүс нутагт ялгарах онцлог дүр төрхийг илэрхийлсэн байх | Дэлхийд ялгарах онцлог дүр төрхийг илэрхийлсэн байх |
| 6 | Цогц байдал /Байршил болон цаг хугацааны хувьд бусад аялал жуулчлалын нөөц, бүтээгдэхүүнтэй холбогдох боломжтой эсэх/ | Байршлын хувьд бусад эвент, аялал жуулчлалын нөөцөөс хол бүс нутагт | Байршлын хувьд 2-5 тооны эвент, аялал жуулчлалын нөөц бүхий бүс нутагт | Байршлын хувьд 6-10 тооны эвент, аялал жуулчлалын нөөц бүхий бүс нутагт | Байршлын хувьд 10-12 тооны эвент, аялал жуулчлалын нөөц бүхий бүс нутагт | Байршлын хувьд 13-с дээш тооны эвент, аялал жуулчлалын нөөц бүхий бүс нутагт |

* АЖ-ын бус улирал, сарыг 2019 оны статистик мэдээлэлд тулгуурлан тодорхойлсон байдал.

** “Соёлын өвийн Төлөөллийн үндэсний жагсаалт, яаралтай хамгаалах шаардлагатай жагсаалт”-ыг хавсаргав.

Шинээр зохион байгуулж буй эвентийн хувьд шаардлагагүй шалгуур үзүүлэлт /хасаж үнэлнэ/

### Хүснэгт 1. 12 Аялал жуулчлалын бус улирал, сарыг 2019 статистик мэдээлэлд тулгуурлан тодорхойлсон байдал

| Сарууд | Тухайн сард ирсэн жуулчид | Нийт тоо | Тухайн жилд ирсэн жуулчдын тоонд эзлэх сарын хувь | Улирлын хамаарлын тоон үнэлгээ |
|---|---|---|---|---|
| 1 | 23,952 | 23,952 | 4.1 | 4 |
| 2 | 17,991 | 41,943 | 3.1 | 5 |
| 3 | 33,439 | 75,382 | 5.8 | 4 |
| 4 | 33,439 | 108,821 | 5.8 | 4 |
| 5 | 42,943 | 151,764 | 7.4 | 3 |
| 6 | 65,642 | 217,406 | 11.4 | 2 |
| 7 | 103,149 | 320,555 | 17.9 | 1 |
| 8 | 100,203 | 420,758 | 17.4 | 1 |
| 9 | 57,138 | 477,896 | 9.9 | 3 |
| 10 | 40,896 | 518,792 | 7.1 | 3 |
| 11 | 30,964 | 549,756 | 5.4 | 4 |
| 12 | 27,506 | 577,262 | 4.8 | 4 |

*Эх үүсвэр: НАЖГ*

### Хүснэгт 1. 13 Үнэлгээний оноо

| 1 оноо | 2 оноо | 3 оноо | 4 оноо | 5 оноо |
|---|---|---|---|---|
| Жуулчдын 15% -аас их хувь ирдэг сар | Жуулчдын 10% -14% ирдэг сар | Жуулчдын 7%-9% ирдэг сар | Жуулчдын 4%-6% ирдэг сар | Жуулчдын 4%-аас бага хувь ирдэг сар |

Эдгээр 6 шалгуур үзүүлэлтүүдээр нийт 100 эвентүүдийг эрэмбэлж үнэлгээний дэлгэрэнгүй үр дүнгээс захиалагч талын тавьсан өвлийн улирлын эвентүүдийг дэмжих, хавар болон намрын улирлын боловч баруун ба зүүн бүс нутагт болдог эвентүүдийг дэмжих зэрэг нөхцөлүүдийн дагуу цаашид бусад эвентээс илүү анхаарч дэмжих шаардлагатай “Монгол улсын боломжит 10 аялал жуулчлалын эвент”-ийг тодорхойллоо.

Эдгээр 10 эвентийн талаарх мэдээллийг дараах хүснэгтээр харуулав.

### Хүснэгт 1. 14 Монгол улсын боломжит 10 аялал жуулчлалын эвентийн жагсаалт

| № | Эвентийн нэрс | Байршил |
|---|---|---|
| 1 | Алтан бүргэд - Бүргэдчидийн баяр | Баян-Өлгий-Бугат |
| 2 | Монгол туургатаны язгуур соёлын олон улсын их наадам | Увс-Түргэн-ОТ |

| | | |
|---|---|---|
| 3 | Монгол төрийн их наадам /Төв цэнгэлдэх/ | УБ |
| 4 | Плэйтайм /Playtime/ хөгжмийн наадам | УБ-Монгол шилтгээн |
| 5 | Талын түмэн адуу | Хэнтий-Батноров |
| 6 | Түмэн тэмээний баяр | Өмнөговь. Булган |
| 7 | Улаанбаатарын өвлийн наадам | УБ-хүрээлэн ба Скай резорт |
| 8 | "Хийморь" Олон улсын морьт харвааны тэмцээн /Чингисийн хүрээ бааз/ | УБ |
| 9 | Хонины найр | Төв-Алтанбулаг |
| 10 | Хөх сувд - Хөвсгөлийн мөсний баяр | Хөвсгөл-Хатгал |

Эдгээр боломжит 10 эвентийг бүс нутаг болон улирлын хамаарлыг харуулбал дараах байдалтай байна.

**Хүснэгт 1. 15 Монгол улсын боломжит 10 аялал жуулчлалын эвентийг бүс нутаг, улирлаар харуулбал**

| № | Эвентийн нэрс | Бүс нутаг | | Болох хугацаа |
|---|---|---|---|---|
| 1 | Алтан бүргэд - Бүргэдчидийн баяр | Баруун бүс | | 10-р сарын эхний 7 хоногт |
| 2 | Монгол туургатаны язгуур соёлын олон улсын их наадам | Баруун бүс | | 8-р сарын эхний 7 хоногт |
| 3 | Монгол төрийн их наадам /Төв цэнгэлдэх/ | Улаанбаатарын бүс | | 7-р сарын 11-13 |
| 4 | Плэйтайм /Playtime/ хөгжмийн наадам | Улаанбаатарын бүс | | 7-р сарын 16, 17, 18 |
| 5 | Талын түмэн адуу | Зүүн бүс | | 11 дүгээр сарын 1-3-нд |
| 6 | Түмэн тэмээний баяр | Төвийн бүс | | 3-р сарын 5-7 |
| 7 | Улаанбаатарын өвлийн наадам | Улаанбаатарын бүс | | 2-р сард |
| 8 | "Хийморь" Олон улсын морьт харвааны тэмцээн /Чингисийн хүрээ бааз/ | Улаанбаатарын бүс | | 9-р сарын 17-20 |
| 9 | Хонины найр | Төвийн бүс | | 7-р сарын 28 |
| 10 | Хөх сувд - Хөвсгөлийн мөсний баяр | Хангайн бүс | | 3 сарын эхний өдрүүдэд |

| | |
|---|---|
| | Улаанбаатарын бүс |
| | Баруун бүс |
| | Хангайн бүс |
| | Төвийн бүс |
| | Зүүн бүс |

Тайлбар: Эдгээр эвентүүдийн хувьд ямар нэгэн эрэмбэ тогтоогоогүй байдлаар дээрх хүснэгтэнд харуулав.

**Зураг 1. 10 Боломжит эвентүүдийн газар зүйн байршил**




**Зураг 1. 11 Боломжит эвентүүдийн улирлын хамаарал**




## 1.7.2 Боломжит 10 эвентийг эрэмбэлэх нь:

Өмнөх хэсэгт тодорхойлсон эдийн засгийн үзүүлэлтүүд дээр үндэслээд боломжит 10 эвентийг эрэмбэлье.

### Хүснэгт 1. 16 Монгол улсад зохион байгуулагдах боломжит 10 аялал жуулчлалын эвентийн эрэмбэ, нийт оролцогчдын тоогоор

| № | Эвентийн нэр | Эвентийн байршил | Нийт оролцогчдын тоо |
|---|---|---|---|
| 1 | Монгол төрийн их наадам /Төв цэнгэлдэх/ | УБ | 35000 |
| 2 | Плэйтайм | Улаанбаатар | 32120 |
| 3 | Алтан бүргэд - Бүргэдчдийн баяр | Баян-Өлгий-Бугат | 15000 |
| 4 | Хөх сувд - Хөвсгөлийн мөсний баяр | Хөвсгөл-Хатгал | 10068 |
| 5 | Улаанбаатарын өвлийн наадам | УБ-хүрээлэн ба Скай ресорт | 9000 |
| 6 | Монгол туургатаны язгуур соёлын олон улсын их наадам | Увс-Түргэн-Онцын тасархай | 3150 |
| 7 | “Хийморь” морьт харваа, морин тулааны фестиваль | Улаанбаатар | 3000 |
| 8 | Талын түмэн адуу | Хэнтий-Батноров | 1820 |
| 9 | Түмэн тэмээний баяр | Өмнөговь.Булган | 776 |
| 10 | “Хонины найр” | Төв-Алтанбулаг | 130 |

*Эх үүсвэр: Аймаг, нийслэлийн аялал жуулчлалын мэргэжилтнүүдийн ирүүлсэн тоо, мэдээнд үндэслэв.*

Ийнхүү дээрх хүснэгтэнд үзүүлсэнчлэн нийслэл, аймаг орон нутгийн аялал жуулчлалын мэргэжилтнүүдээс ирүүлсэн тоо, мэдээнд үндэслэн боломжит 10 эвентийг оролцогчдын тоогоор эрэмбэлэхэд Монгол төрийн их наадам оролцогчдын тоогоор тэргүүлсэн байна.

### Хүснэгт 1. 17 Монгол улсад зохион байгуулагдах боломжит 10 аялал жуулчлалын эвентийн эрэмбэ, гадаад жуулчдын тоогоор

| № | Эвентийн нэр | Эвентийн байршил | Гадаад жуулчдын тоо |
|---|---|---|---|
| 1 | Монгол төрийн их наадам /Төв цэнгэлдэх/ | УБ | 3000 |
| 2 | Алтан бүргэд - Бүргэдчдийн баяр | Баян-Өлгий-Бугат | 1000 |
| 3 | Плэйтайм | Улаанбаатар | 450 |
| 4 | “Хийморь” морьт харваа, морин тулааны фестиваль | Улаанбаатар | 450 |
| 5 | Талын түмэн адуу | Хэнтий-Батноров | 320 |
| 6 | Улаанбаатарын өвлийн наадам | УБ-хүрээлэн ба Скай ресорт | 200 |

| | | | |
|---|---|---|---|
| 7 | Түмэн тэмээний баяр | Өмнөговь.Булган | 156 |
| 8 | Монгол туургатаны язгуур соёлын олон улсын их наадам | Увс-Түргэн-Онцын тасархай | 150 |
| 9 | Хөх сувд - Хөвсгөлийн мөсний баяр | Хөвсгөл-Хатгал | 68 |
| 10 | “Хонины найр” | Төв-Алтанбулаг | 10 |

*Эх үүсвэр: Аймаг, нийслэлийн аялал жуулчлалын мэргэжилтнүүдийн ирүүлсэн тоо, мэдээнд үндэслэв.*

Дээрх хүснэгтэнд үзүүлсэнчлэн, нийслэл, аймаг орон нутгийн аялал жуулчлалын мэргэжилтнүүдээс ирүүлсэн тоо, мэдээнд үндэслэн боломжит 10 эвентийг гадаад жуулчдын тоогоор эрэмбэлэхэд Монгол төрийн их наадам оролцогчдын тоогоор тэргүүлсэн байна.

### Хүснэгт 1. 18 Монгол улсад зохион байгуулагдах боломжит 10 аялал жуулчлалын эвентийн эрэмбэ, ажиллах хүчний тоогоор

| № | Эвентийн нэр | Эвентийн байршил | Ажиллах хүчний тоо |
|---|---|---|---|
| 1 | Монгол төрийн их наадам /Төв цэнгэлдэх/ | УБ | - |
| 2 | Хөх сувд - Хөвсгөлийн мөсний баяр | Хөвсгөл-Хатгал | 3000 |
| 3 | Плэйтайм | Улаанбаатар | 250 |
| 4 | Улаанбаатарын өвлийн наадам | УБ-хүрээлэн ба Скай ресорт | 130 |
| 5 | Талын түмэн адуу | Хэнтий-Батноров | 120 |
| 6 | Монгол туургатаны язгуур соёлын олон улсын их наадам | Увс-Түргэн-Онцын тасархай | 50 |
| 7 | “Хонины найр” | Төв-Алтанбулаг | 20 |
| 8 | “Хийморь” морьт харваа, морин тулааны фестиваль | Улаанбаатар | 18 |
| 9 | Түмэн тэмээний баяр | Өмнөговь.Булган | 16 |
| 10 | Алтан бүргэд - Бүргэдчдийн баяр | Баян-Өлгий-Бугат | 8 |

*Эх үүсвэр: Аймаг, нийслэлийн аялал жуулчлалын мэргэжилтнүүдийн ирүүлсэн тоо, мэдээнд үндэслэв.*

Боломжит 10 эвентийг тухайн эвентэд ажилласан ажиллах хүчний тоогоор эрэмбэлэхэд Хөх сувд - Хөвсгөлийн мөсний баяр 3000 хүн ажилласан тул мэдээлэл ирүүлсэн эвентүүдийн хувьд уг үзүүлэлтээр тэргүүллээ. “Монгол төрийн их наадам 2019”-ийн үеэр ажилласан ажилласан хүчний тоон мэдээлэл олдоогүй тул үнэлэх боломжгүй байлаа. Ажиллах хүчний тоог олохдоо нийслэл,

аймаг орон нутгийн аялал жуулчлалын мэргэжилтнүүдийн ирүүлсэн тоонд үндэслэсэн ба төрийн албан хаагчдын тоог хасч тооцсон болно.

**Хүснэгт 1. 19 Монгол улсад зохион байгуулагдах боломжит 10 аялал жуулчлалын эвентийн эрэмбэ, гаргасан зардлын хэмжээгээр**

| № | Эвентийн нэр | Эвентийн байршил | Зардал, сая төгрөгөөр |
|---|---|---|---|
| 1 | Монгол төрийн их наадам | УБ | 2,900 |
| 2 | Плэйтайм олон улсын хөгжийн наадам | УБ | 130 |
| 3 | Хөх сувд - Хөвсгөлийн мөсний баяр | Хөвсгөл | 74 |
| 4 | Улаанбаатарын өвлийн наадам | УБ | 58 |
| 5 | Монгол туургатаны язгуур соёлын олон улсын их наадам | Увс | 50 |
| 6 | Талын түмэн адуу | Хэнтий | 50 |
| 7 | Түмэн тэмээний баяр | Өмнөговь | 27 |
| 8 | “Хийморь” морьт харваа, морин тулааны фестиваль | УБ | 25 |
| 9 | Алтан бүргэд-бүргэдийн баяр | Баян Өлгий | 14 |
| 10 | Хонины найр | Төв | 4.5 |

*Эх үүсвэр: Аймаг, нийслэлийн аялал жуулчлалын мэргэжилтнүүдийн ирүүлсэн тоо, мэдээнд үндэслэв.*

Монгол улсад зохион байгуулах боломжит 10 эвентийг зохион байгуулагч талын гаргасан зардлын хэмжээгээр эрэмбэлэхэд “Монгол төрийн наадам 2019” улсын төсвөөс нийт 2.9 тэрбум төгрөг зарцуулсан үзүүлэлттэйгээр тэргүүлж байна.

Харин зарим эвентүүдийн хувьд оролцогчдын тоо, жуулчдын тоо өндөр байсан хэдий ч гаргасан зардлын хэмжээ, ажиллах хүчний хэмжээгээр нэлээд бага байсан нь сонирхол татаж байна.

Эдийн засгийн нөлөөллийн үнэлгээ хийх үзүүлэлт болох орлогын хэмжээ болоод гадаад жуулчны зарцуулсан зардлыг тооцох боломжгүй тул тэдгээрийг ашиглан эрэмбэлсэнгүй.

## 1.8. ДҮГНЭЛТ

Дэлхийн банкны Экспортыг дэмжих төслийн дэмжлэгтэйгээр Монгол улсын БОАЖЯ, ХХААХҮЯ-ны захиалгаар хэрэгжиж буй “Үйлчилгээний экспортын зах зээл, экспортын боломжит хувилбаруудын судалгаа, зөвлөмж” төслийн хүрээнд “Монгол улсын аялал жуулчлалын эвентийн стратеги төлөвлөгөө, бүтээгдэхүүн хөгжлийн дүн шинжилгээ, зөвлөмж боловсруулах” зөвлөх үйлчилгээний ажлын

хүрээнд “Монгол улсын аялал жуулчлалын боломжит 10 эвент” судалгааг хийж дараах дүгнэлтүүдийг гаргаад байна. Үүнд:

Аялал жуулчлалын орлогын хувьд 2019 онд нэг гадаад жуулчин 1658 ам.доллар зарцуулж байсан[47] бөгөөд энэ нь дэлхийн дунджаас хэд дахин бага үзүүлэлт юм. Харин манай иргэдийн хувьд гадаад улсад дунджаар 7 хонох хугацаандаа 2007 ам.доллар зарцуулж байна. Тиймээс аялал жуулчлалын салбарт шинэ бүтээгдэхүүн бий болгох, зорин очих газрыг нэмэгдүүлэх, түүх соёлын дурсгалыг хадгалах, хамгаалах аялал жуулчлалын салбарын бүтээгдэхүүнийг эдийн засгийн эргэлтэд оруулах явдал чухал ач холбогдолтой.

Бразилийн Рио Де Жанеро хотод 2016 онд зохион байгуулагдсан зуны олимпын наадам, ОХУ-д 2018 онд зохион байгуулагдсан FIFA дэлхийн аварга, БНХАУ-ын Харбин хотноо 2018 онд зохион байгуулагдсан Харбины олон улсын мөс, цасны баримал фестиваль орлогоороо эхний 3 байранд эрэмбэлэгдэв.

Хэдийгээр шууд орлогын хэмжээгээр нэгдүгээрт эрэмбэлэгдээгүй ч 2018 онд ОХУ-д зохион байгуулагдсан FIFA 2018 хөлбөмбөгийн дэлхийн аварга шалгаруулах тэмцээний эдийн засгийн нөлөөлөл хамгийн их буюу 9.5 тэрбум ам.долларт хүрсэн байна. Бразилийн Рио Де Жанеро хотод зохион байгуулагдсан зуны олимпын наадмын эдийн засгийн нийт нөлөө 3.4 тэрбум ам.долларт хүрсэн байна.

Эдийн засгийн нөлөөллийг үнэлэхдээ нийт оролцогчдын тоо, гадаад жуулчдын тоо, оролцогчдын дундаж зардал, ажиллах хүчний тоо, зардлын хэмжээ, орлогын хэмжээ гэсэн үзүүлэлтүүдийг авч үзнэ.

Манай судалгааны үр дүнд “Монгол төрийн их баяр наадам 2019” нь манай улсын эдийн засагт шууд болон шууд бус байдлаар нийт 1.7 тэрбум төгрөгийн орлого оруулсан байна. Өөрөөр хэлбэл энэ мөнгөн дүнд манай улсад гаднаас буюу жуулчдаас оруулсан наадмын нээлт, хаалт, үзвэр, худалдаа, үйлчилгээ, хоол, хүнс, бусад худалдан авалт зэрэг байдлаар шууд нөлөө үзүүлэхээс гадна тэдгээрт үйлчилсэн бусад салбарын орлого, иргэдийн хөдөлмөрийн хөлс гэх мэт шууд бусаар нийт оруулсан орлогын дүн болно.

Монгол улсаас нислэгийн 5 цагийн зайтай бүсд зохион байгуулагддаг нүүдлийн соёлын 4 эвент байна. Үүнд: “Дэлхийн нүүдэлчдийн наадам”, Нүүдэлчдийн ертөнц, Этно Ауыл аялал жуулчлалын цогцолбор, Казах Ертөнц нүүдэлчдийн цэцэрлэгт хүрээлэн багтаж байна.

Бусад орнуудын нүүдэлчдийн эвентүүд дээр байхгүй байгаа төрөл, чиглэлээр дагнасан томоохон эвентийг Монгол улс санаачлан зохион байгуулах боломжтой.

[47] Аялал жуулчлалын салбарын өнөөгийн байдал, шийдвэрлэх асуудлууд, Монголбанк, түүвэр судалгааны үр дүн 2019

Нийслэл, аймаг орон нутгийн аялал жуулчлалын мэргэжилтнүүдээс ирүүлсэн тоо, мэдээнд үндэслэн боломжит 10 эвентийг оролцогчдын тоогоор эрэмбэлэхэд Монгол төрийн их наадам оролцогчдын тоогоор тэргүүлсэн байна.

Нийслэл, аймаг орон нутгийн аялал жуулчлалын мэргэжилтнүүдээс ирүүлсэн тоо, мэдээнд үндэслэн боломжит 10 эвентийг гадаад жуулчдын тоогоор эрэмбэлэхэд Монгол төрийн их наадам оролцогчдын тоогоор тэргүүлсэн байна.

# ХОЁР. МОНГОЛ УЛСЫН АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН БОЛОМЖИТ ШИЛДЭГ АРВАН ЭВЕНТИЙН ЭДИЙН ЗАСГИЙН ҮР НӨЛӨӨЛЛИЙН ШИНЖИЛГЭЭ

## 2.1. НИСЛЭГИЙН 5 ЦАГИЙН ЗАЙД ЗОХИОН БАЙГУУЛАГДДАГ НҮҮДЛИЙН СОЁЛЫН АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН ЭВЕНТҮҮДИЙН ӨРСӨЛДӨӨНИЙ НӨХЦӨЛ БАЙДАЛ

### 2.1.1 Өрсөлдөгч эвентүүд

Өмнөх тайлангийн 5-р бүлгийн хүснэгт 8-д Улаанбаатар хотоос нислэгийн 5 цагийн зайд зохион байгуулагддаг нүүдлийн соёлын эвентүүдийг тодорхойлсон. Үүнд:

1. “Дэлхийн нүүдэлчдийн наадам” /World Nomad Games/ - Азийн орнуудын угсаатнуудын фестиваль Киргизстан улс
2. “Нүүдэлчдийн ертөнц” /"Кошпендилер Алеми"/ Казакстан улс
3. “Наадам” фестиваль БНХАУ-ын ӨМӨЗО
4. Нүүдэлчдийн фестиваль /Nomad Festival/ Бутан улс
5. Paro Tsechu[48] фестиваль /масктай бүжиг буюу цам харайх/ Бутан улс зэрэг болно.

Дээрх эвент дээр нэмээд боломжит эвентээр сонгогдсон 10 эвентүүдийг дараах байдлаар авч үзлээ.

- Алтан бүргэд - Бүргэдийн баяр
- Плэйтайм олон улсын хөгжмийн наадам
- Монгол төрийн их наадам
- Хонины найр
- Талын түмэн адуу
- Түмэн тэмээний баяр
- Улаанбаатарын өвлийн наадам
- “Хийморь” морьт харваа, морин тулааны фестиваль
- Монгол туургатны язгуур соёлын олон улсын их наадам
- Хөх сувд - Хөвсгөлийн мөсний баяр

### 2.1.2 Өрсөлдөөнийг тодорхойлох арга зүй

Зах зээлийн нөхцөл байдал болон өрсөлдөөний талаар хийх тооцоо, үнэлгээ нь тухайн зах зээлийн хэмжээ, хэлбэрээс шалтгаалдаг. Үүнд:

1. Бүтээгдэхүүний зах зээл (product market),
2. Газар зүйн зах зээл (geographic market) зэргийг авч үзэж болно.

Бүтээгдэхүүний зах зээлд худалдан авдаг, худалдаалдаг бараа, бүтээгдэхүүнийг авч үздэг. Харин газар зүйн зах зээл гэж тухайн бүтээгдэхүүнийг

[48] https://www.tourism.gov.bt/uploads/attachment_files/tcb_K11a_BTM%202019.pdf

худалдан авах эсхүл зарж борлуулахад байршил хэрхэн нөлөөлж байгааг үнэлдэг. [49]

Зах зээлийн үнэлгээг тооцохдоо түгээмэл хэрэглэгддэг индексийг авч үзье:

**CR буюу төвлөрлийн харьцаа болон Херфиндаль Хершманы индекс (ХХИ)**

**CR буюу төвлөрлийн харьцаа:** Энэхүү индекс нь тухайн зах зээл дэх хамгийн том k ширхэг аж ахуйн нэгжийн нийт зах зээлд эзлэх хувийн нийлбэрээр илэрхийлэгддэг. Томъёогоор илэрхийлбэл:

$$CR_k = \sum_{i=1}^{k} s_i$$

Тухайн зах зээлд үйл ажиллагаа явуулдаг хамгийн том дөрвөн компанийн зах зээлд эзлэх хувийг хэмждэг. Зах зээлд манлайлдаг k компанийг авч үзээд үлдсэн жижиг аж ахуйн мэдээллийг авч үздэггүйгээрээ онцлогтой.

Төвлөрлийн харьцаа нь 1-ээс 100-ийн хооронд утга авах бөгөөд 80-100 хувь бол төвлөрлийн түвшин өндөр, 50-80 хувь бол төвлөрлийн түвшин дундаж, 0-50 хувь бол төвлөрлийн түвшин бага гэж үздэг.

**Херфиндал-Хершманы индекс (ХХИ):**Хамгийн өргөн дэлгэр хэрэглэгддэг энэхүү индекс нь тухайн зах зээл дэх аж ахуй нэгжүүдийн зах зээлд эзлэх хувийн квадратуудын нийлбэрээр тодорхойлогддог. Томьёогоор илэрхийлбэл:

$$HHI = \sum S_i^2$$

$S_i$- i дугаар салбарын зах зээлд эзлэх хувь

ХХИ нь нэгтэй тэнцүү гарсан нөхцөлд тухайн зах зээлд ганц нийлүүлэгч (монополь) байна. Энэ индексийн давуу тал нь зах зээлд тэргүүлж буй компаниудын хэмжээ харилцан адилгүй байхыг харуулдаг. Хэрвээ зах зээлд нэг юм уу хоёр компани тухайн зах зээл дэх дөрвөн компаниас давамгайлж байвал ХХИ нь зах зээлд эзлэх хувь нь бараг тэнцүү дөрвөн том компанитай нөхцөлтэй харьцуулахад өндөр утгатай байна.

### Хүснэгт 2. 1 ХХИ-ийн тайлбар

| ХХИ-ийн утга | Төвлөрөл |
|---|---|
| ХХИ<1000 | Тухайн зах зээлийг хангалттай тооны өрсөлдөгчтэй төвлөрөл байхгүй гэж үзнэ. |
| 1000<ХХИ<1800 | Тухайн зах зээлийг дунд зэргийн төвлөрөлтэй гэж үзнэ |
| ХХИ>1800 | Тухайн зах зээлд төвлөрлийн түвшин өндөр буюу өрсөлдөөн хязгаарлагдмал гэж үзнэ |

I. [49] A Framework for the Design and Implementation of Competition Law and Policy, OECD

*Эх сурвалж: ШӨХТГ*

Судалгааны ажлын даалгаварт тусгагдсаны дагуу Улаанбаатар хотоос нислэгийн 5 цагийн зайд зохион байгуулагддаг нүүдлийн эвентүүдийн өрсөлдөөний нөхцөл байдлыг энэхүү тайланд судлав. Дээр дурдсанчлан тус судалгааны ***бүтээгдэхүүний зах зээл нь*** нүүдлийн соёлын эвент бол ***газар зүйн зах зээл нь*** Улаанбаатар хотоос нислэгийн 5 цагийн зайтай байршлууд болно.

### Хүснэгт 2. 2 Эвент ба эвентийн зах зээлд эзлэх хувь

| № | Эвентийн нэрс | Улс орон | Нийт оролцогчдын тоо | Оролцсон гадаадын жуулчдын тоо | Зах зээлд эзлэх хувь |
|---|---|---|---|---|---|
| 1 | "Дэлхийн нүүдэлчдийн наадам" /World Nomad Games/ - Азийн орнуудын угсаатнуудын фестиваль. | Киргизстан | 150,000 | 73,000 | **92.49** |
| 2 | "Нүүдэлчдийн ертөнц" Nomads' World Festival "Кошпендилер Алеми" | Казакстан | 7,000 | 90 | **0.11** |
| 3 | "Наадам" фестиваль | БНХАУ-ын ӨМӨЗО | 100,000 | 0 | **0.00** |
| 4 | Nomad Festival | Бутан | | 7 | **0.01** |
| 5 | Paro Tsechu[50] фестиваль | Бутан | | 394 | **0.50** |
| 6 | Алтан бүргэд - Бүргэдийн баяр | МУ | | 800 | **1.01** |
| 7 | Плэйтайм | МУ | 32,000 | 450 | **0.57** |
| 8 | Монгол төрийн их наадам /Төв цэнгэлдэх/ | МУ | | 2,900 | **3.67** |
| 9 | Хонины найр | МУ | | 60 | **0.08** |
| 10 | Талын түмэн адуу | МУ | | 300 | **0.38** |
| 11 | Түмэн тэмээний баяр | МУ | | 300 | **0.38** |
| 12 | Улаанбаатарын өвлийн наадам | МУ | | 58 | **0.07** |
| 13 | "Хийморь" морьт харваа, морин тулааны фестиваль | МУ | | 450 | **0.57** |
| 14 | Монгол туургатаны язгуур соёлын олон улсын их наадам | МУ | | 50 | **0.06** |
| 15 | Хөх сувд - Хөвсгөлийн мөсний баяр | МУ | | 68 | **0.09** |
| | НИЙТ | | | **78,927** | **100.00** |

[50] https://www.tourism.gov.bt/uploads/attachment_files/tcb_K11a_BTM%202019.pdf

Дээрх тооцооллоос харахад нийт зах зээлийн 92.49 хувийг Киргизстан улсад зохион байгуулагддаг “Дэлхийн нүүдэлчдийн наадам” /World Nomad Games/ - Азийн орнуудын угсаатнуудын фестиваль дангаараа эзэлж байна. Тус судалгаанд сонгон авсан Монголын 10 эвентийн хувьд нийт зах зээлийн 7 орчим хувийг эзэлж байна. Тухайлбал Плэйтайм эвентийг нүүдэлчний соёлын эвент гэж шууд үзэхгүй ч тухайн арга хэмжээний хүрээнд нүүдлийн хэв шинж, соёлыг агуулсан хамтлаг, дуучид оролцдог мөн тус эвентийн сонирхол, оролцоо өндөр байсан тул сонгосон болно.

Улаанбаатар хотоос 5 цагийн нислэгийн зайд зохион байгуулагддаг нүүдэлчдийн соёлын эвентээс зах зээлд эзлэх хувь хамгийн өндөр 4 эвентийг дор харуулав. Үүнд:

1. “Дэлхийн нүүдэлчдийн наадам” /World Nomad Games/ - Азийн орнуудын угсаатануудын фестиваль. Киргизстан улс-**92.49 хувь**;
2. Монгол төрийн их наадам-**3.67 хувь**;
3. Алтан бүргэд - Бүргэдчдийн баяр-**1.01 хувь**;
4. “Хийморь” морьт харваа, морин тулааны фестиваль-**0.57** хувь тус тус байна.

Дээрх 4 эвентийн төвлөрлийн харьцааны нийлбэрийг тооцвол:

$$CR_4 = \sum_{i=1}^{4} s_i = 92.49+3.67+1.01+0.57 = \mathbf{97.74\%}$$

буюу энэ зах зээлийн төвлөрлийн түвшин өндөр буюу хангалттай тооны өрсөлдөгч байхгүй байна гэсэн үг.

Нүүдлийн соёлын аялал жуулчлалыг сонирхогч жуулчдын зах зээлд өрсөлдөгч эвентүүдийн эзлэх хувь хэмжээг тооцоолж, өрсөлдөөний нөхцөл байдал СВОТ шинжилгээ хийж үзэхэд:

**Давуу тал:**

- Нүүдлийн соёлын аялал жуулчлалын бүтээгдэхүүн санал болгож өрсөлдөгч орнуудтай харьцуулахад Монгол улсад зохион байгуулагддаг нэг эвентийн зах зээлд эзлэх хувь хэмжээ бага боловч олон төрлийн эвентүүдийг өөр цаг хугацаанд санал болгодог нь давуу талтай байж болохоор байна.
- Зах зээлд голлох байр суурь эзэлж байгаа Киргизстаны эвенттэй харьцуулахад манай улсын эвентүүд илүү натурал, унаган соёлоо хадгалж үлдэж чадсан ард түмэн гэдгээрээ илүү давуу талтай байна.

**Сул тал:**

- Киргизстан улсын “World Nomad Game” зах зээлийн 92.49%-ийг дангаараа эзэлж байгаа нь олон улсад хүчтэй маркетинг явуулж чадсаныг илтгэж байгаа бөгөөд манай улсын хувьд хангалттай нөөц, боломж, бүтээгдэхүүн байгаа боловч эвентээ дэлхийн нийтэд таниулах, сурталчлан хөгжүүлэх бодлого, төлөвлөлт, маркетинг дутагдаж байгаа нь харагдаж байна.

**Боломж:**

- Манай улсын хувьд цоо шинэ эвент бий болгох гэхээс илүүтэй одоо байгаа боломжит эвентүүдийн менежментийг сайжруулах, зөв маркетинг хийх хэлбэрээр зах зээлээ тэлэх боломжтой
- Гадны эвентүүдийн гол ялгарал нь жуулчдын оролцоог дэмжих явдал бөгөөд жуулчдыг зөвхөн үзэгч төдийгөөр бус оролцогч хэлбэрээр эвентийг зохион байгуулж зах зээлээ тэлэх боломж байж болох юм.

**Аюул занал:**

- Зах зээлийн төвлөрөл ихтэй (дангаараа 92%-ийг бүрдүүлж байгаа) Киргизстаны нүүдлийн соёлын эвентийг нүүдэлчдийн Этно олимп хэлбэрээр өргөжүүлж “дэлхийн хэмжээний олимп” болгох зорилго тавьж ажиллахыг үгүйсгэхгүй байна.
- Өрсөлдөгч орнуудтай харьцуулахад манай улсын Ковид-19 цар тахлын эсрэг хатуу арга хэмжээ нь манайд ирэх жуулчдын шийдвэрт сөргөөр нөлөөлж болзошгүй байна.

СВОТ шинжилгээгээр нүүдлийн соёлын эвентийг хөгжүүлэхэд бидэнд байгаа давуу тал, боломж нь сул тал, аюул заналаас хүчтэй, далайцтай биш байгаа нь зах зээлийн төвлөрлийн харьцаа, өрсөлдөөнийг нэмэгдүүлэх, нүүдлийн соёлын эвентийн цар хүрээ, нөлөөг өсгөх шаардлагатайг нотолж байна. Ингэхдээ аялал жуулчлалын олон улсын стандарт, шалгуурыг хангасан, тодорхой зорилт бүхий арга хэмжээг үе шаттай авч хэрэгжүүлэх зайлшгүй шаардлагатай юм.

## 2.2. АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН ЭВЕНТИЙН ЗАХ ЗЭЭЛИЙН БОЛОМЖИЙН ШИНЖИЛГЭЭ

### 2.2.1 Аялал жуулчлалын эвентийн зах зээлийн боломжийг тодорхойлох арга зүй

Зах зээлийн боломжийн шинжилгээг хийхдээ өмнөх бүлэгт тодорхойлсон өрсөлдөгч аялал жуулчлалын эвентүүдийн зах зээлийн бодит хэмжээг, Монгол Улсын аялал жуулчлалын зах зээлийн бодит хэмжээтэй харьцуулж тодорхойлно. Үүний дараа Монгол улсын аялал жуулчлалын зах зээлийн боломжит хэмжээг улс орны хувьд таамаглана. Эцэст нь эвентийн зах зээлийн боломж буюу шингээх чадварыг тодорхойлж, эрэмбэлнэ.

Зах зээлийг судлахдаа дараах ойлголтуудыг авч үздэг. Үүнд:

- Зах зээлийн бодит хэмжээ: Энэ нь тухайн зах зээл дэх тухайн бүтээгдэхүүн, үйлчилгээний бодит борлуулалтын хэмжээг хэлнэ.
- Зах зээлийн боломжит хэмжээ[51]: Энэ нь үндсэндээ өгөгдсөн бизнесийн орчин дахь тухайн бүтээгдэхүүн үйлчилгээний боломжит хамгийн их борлуулалтын орлогыг хэлнэ.

[51] Azoev G.L.Sumarokova E.V (2020) Benchmarking of Market capacity assessment methods and their application to digital products

- Зах зээлийн шингээх боломж: Энэ үзүүлэлт нь урт хугацаанд өндөр өгөөжтэй байх зах зээлийг олж тодорхойлдог бөгөөд хөрөнгө оруулалтын шийдвэр гаргалт хийхэд тусалдаг. Өөрөөр хэлбэл аль зах зээл рүү хөрөнгө оруулалт хийвэл илүү үр өгөөжтэй байхыг хэлж өгдөгөөрөө ач холбогдолтой.

- 


Зах зээлийн боломжийг үнэлэхдээ оноо өгөх аргаар бенчмаркинг хийж эрэмбэлэв. Оноо өгөх аргыг ашиглахдаа Марковизын боловсруулсан онооны системийг баримтлаж аялал жуулчлалын эвентийн зах зээлийн боломжийг үнэлсэн. Ингэхдээ дараах 3 үндсэн хүчин зүйлийг төлөөлж чадах үзүүлэлтийг үнэлгээндээ ашигладаг. Үүнд:

- Эрэлтийн тал
- Нийлүүлэлтийн тал
- Гадаад субьект

*Эрэлтийн тал*: тодорхой газар нутаг, хүн ам, дэд бүтэц, тодорхой бүтээгдэхүүн болон түүний өрсөлдөх бүтээгдэхүүний хэрэглээ зэргийг илэрхийлэх хүчин зүйл

*Нийлүүлэлтийн тал:* Бүтээгдэхүүний нийлүүлэх үнэ, хэмжээ, өрсөлдөөний нөхцөл

*Гадаад хүчин зүйл:* Засгийн газрын бодлого, шашин, уламжлал зэрэг.

Марковизын системээр зах зээлийн боломжийг үнэлэхдээ үнэлгээнд ашиглаж байгаа үзүүлэлтүүдийг жинлэсэн дундаж оноогоор үржүүлдэг. Өөрөөр хэлбэл хамгийн өндөр оноо авсан сегмент хамгийн өндөр боломжтой зах зээл гэсэн үг юм. Нийт үнэлгээнд ашиглагдаж байгаа үзүүлэлтүүдийн онооны нийлбэрээр тухайн сегментийн оноо гарна. Үзүүлэлтүүдийг жинлэхдээ дараах зарчмыг баримтална. Хамгийн их нөлөө үзүүлнэ гэж үзсэн үзүүлэлтэд хамгийн өндөр оноо өгнө, түүний дараах үзүүлэлтэд хоёр дахь өндөр оноог өгнө.

Үнэлгээний үзүүлэлтийг сонгохдоо эрэлтийн хүчин зүйлд тухайн газар нутгийг зорин очсон гадаад жуулчдын тоо, нийлүүлэлтийн талын хүчин зүйлсд тухайн газар нутгийн байршуулах хэрэгслийн даац, аймгуудын өрсөлдөх чадварын индекс, нэг хүнд ногдох ДНБ авч үзлээ. Гадаад хүчин зүйлсийг төлөөлөх үзүүлэлтийг нөлөөлөл багатай гэж үзэн уг судалгаанд оруулаагүй болно.

### 2.2.2 Монгол улсаас 5 цагийн нислэгийн зайд зохион байгуулагдаж буй нүүдлийн соёлын эвентийн зах зээлийн бодит хэмжээг тодорхойлох нь

Дараах хүснэгтэд нүүдлийн соёлын эвентээр өрсөлдөгч улсуудын аялал жуулчлалын салбарын орлого, жуулчдын тоо болон аялал жуулчлалын салбарын орлогын ДНБ-д эзлэх хувь, дэлхийн аялал жуучлалын дундаж үзүүлэлтийг харьцуулан харуулав.

**Хүснэгт 2. 3 Улсуудын хүлээж авсан гадаад жуулчдын тоо, аялал жуулчлалын зах зээлийн хэмжээ, өрсөлдөгч орнуудаар, 2019 он**

| № | Улс | Нийт хүлээж авсан гадаад жуулчдын тоо | Аялал жуулчлалын салбараас олсон орлого, ам.доллар | Зах зээлд эзлэх хувь, борлуулалтын орлогоор | Зах зээлд эзлэх хувь, хүлээж авсан жуулчдын тоогоор |
|---|---|---|---|---|---|
| 1 | Казакстан | 8,515,000 | 2,922,000,000 | 51% | 43% |
| 2 | БНХАУ ӨМӨЗО | 1,890,000 | 1,340,000,000 | 24% | 10% |
| 3 | Киргизстан | 8,508,000 | 708,000,000 | 12% | 43% |
| 4 | Монгол | 577,262 | 607,213,369 | 11% | 3% |
| 5 | Бутан | 316,000 | 120,000,000 | 2% | 2% |
|  | Нийт | 19,806,262 | 5,697,213,369 | 100% | 100% |

*Эх сурвалж:* www.1212.mn, www.theglobaleconomy.com/

Дээрх хүснэгтэнд 2019 оны байдлаар өрсөлдөгч 5 улсын аялал жуулчлалын зах зээлийн хэмжээг харуулсан бөгөөд Монгол Улс зах зээлийн хэмжээгээ 4 дүгээрт жагсаж байна.

Дээрх хүснэгтээс харахад гадаад жуулчдаас хамгийн их орлого олсон мөн хамгийн олон гадаад жуулчид айлчилсан улс нь Казакстан улс байна. Харин БНХАУ-ын ӨМӨЗО нь гадаад жуулчдын тоогоороо Киргизстан улсын дараа орж байгаа ч гадаад жуулчдаас олсон орлогоороо хоёрдугаарт эрэмблэгдэж байна. Киргизстан улс жуулчдын тоогоороо их боловч нэг жуулчнаас олох орлогын хэмжээ багатай учраас нийт аялал жуулчлалын салбарын орлогоор 3 дугаарт орсон байна. Бутан улсын хувьд хүлээж авсан жуулчдын тоо, аялал жуулчлалын салбараас олсон орлогоороо ч тэр зах зээлд 2%-ийг тус тус эзэлсэн ба хамгийн сүүлд жагслаа.

**График 2. 1 Аялалын зах зээлийн хэмжээ, өрсөлдөгч орнуудаар**




*Эх үүсвэр: www.1212.mn, www.theglobaleconomy.com/*

**Зах зээлийн боломжит хэмжээг тооцох нь**

Зах зээлийн боломжит хэмжээ буюу багтаамж гэдэг нь тодорхой цаг хугацаанд тухайн үнийн түвшинд бараа, үйлчилгээний борлуулалтын хамгийн их хэмжээг хэлэх ба эрэлтийн болоод нийлүүлэлтийн хэмжээгээр аль алинаар нь тодорхойлогддог. Бид энэ хэсэгт нийлүүлэлт талаас нь тодорхойлсон болно.

Зах зээлийн боломжит хэмжээг хэмжихэд дараах томъёог өргөн хэрэглэдэг[52].

$$Q= n*q*p$$

Q – Зах зээлийн нийт эрэлт буюу боломжит хэмжээ
n – Зах зээл дэх нийт хэрэглэгчдийн тоо
q – Дундаж хэрэглэгчийн жилийн туршид хийх худалдан авалтын тоо
p – Тухайн бүтээгдэхүүний дундаж үнэ

Аялал жуулчлалын эвентийн зах зээлийн тухайд бид дараах байдлаар тооцоог хийв.

n – Монгол Улсын байршуулах хэрэгслийн 1 сарын хүчин чадал
q –Аялал жуулчлалын идэвхитэй сар болох 1-3 сар
p – Нэг жуулчны нэг өдөрт зарцуулж буй дундаж зардал[53]

Монгол улсад жуулчид хүлээн авах хүчин чадлыг тооцвол нэг сард бүрэн хүчин чадлаараа ажиллавал 1,796,790 хүн байршуулах хүчин чадалтай (энэ бүлгийн 2.3 дахь хэсгийг үзнэ үү). Доорх хүснэгтэнд1 сар, 2 сар, 3 сарын турш

[52] Market capacity assessment for educational service, Galina A.Kalugina,2020
[53] Монгол банкны аялал жуулчлалын салбарын түүвэр судалгаа

байршуулах хэрэгслийн дээд хэмжээгээрээ жуулчид хүлээж авбал зах зээлийн боломжит хэмжээ буюу борлуулалт ямар хэмжээтэй байхыг зах зээлийн ашиглалтын 3 түвшинтэй (100%, 60%, 20%) байхаар таамаглан тооцон гаргалаа.

### Хүснэгт 2. 4 Зах зээлийн боломжит хэмжээ, ам. доллар

| Зах зээл ашиглалтын хувь | Зах зээлийн боломжит хэмжээ | | |
|---|---|---|---|
| | 1 сар | 2 сар | 3 сар |
| 100% | 229,159,832 | 458,319,665 | 687,479,497 |
| 50% | 114,579,916 | 229,159,832 | 343,739,748 |
| 20% | 57,289,958 | 114,579,916 | 171,869,874 |

Монгол Улс аялал жуулчлалын идэвхитэй 3 сардаа 268,994 жуулчин хүлээж авсан (Хамгийн өндөр жуулчин хүлээж авсан 2019 оны байдлаарх) бөгөөд уг 3 сарын хугацаан дахь бодит хэмжээ нь 34,307,080 ам.доллар байгаа нь зах зээлээ 100% ашигласан боломжит хэмжээнээс 20 дахин, 50% ашигласан боломжит хэмжээнээс 10 дахин 20% ашигласнаас 5 дахин бага үзүүлэлт юм.

Chaiwat Baimai, Jose Luis Daniel (2009) нарын “Market Potential for Tourism in Emerging Markets” судалгааны ажилд тухайн улсыг зорин очиж буй жуулчдын тоо буюу эрэлтийг 6 бие даасан хувьсагчаас (зочид буудал, улс орны өв соёл, хамгаалалтад авсан газрын тоо, вальютын ханш, зар сурталчилгааны зардал, гэмт хэрэгтнүүдийн тоо) хамааруулан шугаман регрессийн загвар үнэлж үзэхэд зочид буудал, улс орны өв соёл, гэмт хэрэгтнүүдийн тоо гэсэн үзүүлэлтүүд ач холбогдолтой гарсан байна.

**Агаарын тээвэрлэлт**

Нөгөө талаар нийлүүлэлт талаас тээврийн хэрэгслийн багтаамж, түүн дотроо жуулчдын хамгийн их үйлчлүүлдэг агаарын тээврийн хүчин чадлыг энэ хэсэгт тоймлон авч үзлээ.

Олон улсын агаарын тээврийн хувьд 2019 онд дотоодын 4 агаарын тээвэрлэгч / ”МИАТ” ХК, “Аэро Монголиа” ХХК, “Хүннү Эйр” ХХК, “Изинис Эйрвэйз” ХХК/, гадаадын 8 агаарын тээвэрлэгч / Кореан Эйр, Эйр Чайна, Аэрофлот, Туркиш Эйрлайнс, Эйр Бусан, Ангара Эйрлайнс, Ашиана Эйрлайнс, СКАТ/ Бээжин, Сөүл, Токио, Хонконг, Москва, Берлин, Франкфурт, Бангкок, Бусан, Хөххот, Эрхүү, Улаан-Үд, Хайлаар, Манжуур, Эрээн, Бишкек, Стамбул, Гуанжоу, Нурсултан, Осака, Тяньжин зэрэг нийт 21 чиглэлд хуваарьт болон хуваарьт бус нислэг үйлдсэн байна[54].

Энд бид Монгол Улсын агаарын тээврийн багтаамжийн талаар тоон мэдээллийг харуулав. Монгол Улсын Засгийн газар дэлхийн 39 улс, 100 гаруй хот руу агаарын хэлэлцээртэй байдаг.

[54] Статистикийн эмхэтгэл, 2019, Иргэний нисэхийн ерөнхий газар

### Хүснэгт 2. 5 Агаарын хэлэлцээрийн багтаамж, багтаамж ашиглалтын хувь

| № | Хэлэлцээр | Багтаамж (Суудал нийлүүлэлт) жилээр | Багтаамж ашиглалтын хувь |
|---|---|---:|---:|
| 2 | Korean Air Aisana Air Busan | 668,000 | 68% |
| 3 | Air China | 700,000 | 30% |
| 4 | Japan | 438,000 | 18% |
| 5 | Turkish Airline | 105,000 | 39% |
| 6 | Russia, Aeroflot | 145,000 | - |
| 7 | German | 168,000 | 10% |
| 8 | Изинис Эйрвэйз | 370,000 | 24% |
| | Нийт | 2,594,000 | |

*Эх сурвалж: Зам, тээврийн хөгжлийн яамны мэдээ*

Дээрх хүснэгтээс харахад хэлэлцээрээр тохирсон агаарын нислэгийн багтаамж ашиглалтын хувь Солонгос Улсыг эс тооцвол маш хангалтгүй байна. Энэ нь Монгол Улс жуулчдыг татдаг эрэлт ихтэй зорин очих газар биш байна гэдгийг харуулж байна.

Дээрх хэлэлцээрээс гадна Монгол Улсад нислэг үйлдэх чаналын гэрчилгээтэй 20 онгоц байгаа. Үүнийг доорх хүснэгтээр харуулав.

### Хүснэгт 2. 6 Нислэгт тэнцэх чадварын гэрчилгээтэй агаарын хөлгүүд

| Агаарын хөлгийн маяг | Бүртгэлийн дугаар | Үйлдвэрлэгч | Хүчинтэй хугацаа | Агаарын тээвэрлэгч |
|---|---|---|---|---|
| | | Монгол Улсад бүртгэлтэй агаарын хөлөг | | |
| B737-800 | JU-1015 Boeing | Boeing | 20.05.28 | |
| B767-300ER | JU-1021 | Boeing | 20.11.28 | МИАТ ХК |
| B737-800 | JU-1088 | Boeing | 20.11.18 | |
| EMB-145 LR | JU-1800 | Embraer | 20.05.29 | Аэро Монголиа ХХК |
| EMB-145 LR | JU-1802 | Embraer | 20.07.05 | |
| ATR 72-212A | JU-8801 | ATR-CIE Avions De Transport Regional | 20.06.18 | |
| ATR 72-212A | JU-8802 | ATR-CIE Avions De Transport Regional | 20.06.03 | Хүннү Эйр ХХК |
| ERJ190-100LR | JU8811 | Embraer | 20.05.21 | |
| B737-300 | JU8889 | Boeing | 20.07.17 | Монголиан Эйрвэйз Карго ХХК |
| CESSNA 208B | JU-9991 | CESSNA Aircraft Company | 20.04.06 | Геосан ХХК |
| CESSNA 208B | JU-9993 | CESSNA Aircraft Company | 20.04.15 | |

| | | | | |
|---|---|---|---|---|
| CESSNA 208B | JU-2114 | CESSNA Aircraft com | 20.07.09 | Блу Скай Авиэшн ХХК |
| Airtractor AT602 | JU1918 | Airtractor Inc | 20.03.17 | Томас Эйр ХХК |
| АН-2 | JU-9069 | PZL Mielec, Poland | 20.02.20 | ”Велталь-Авиа Стар” ХХК |
| CESSNA 208B | JU-7777 | CESSNA Aircraft Company | 20.03.17 | ”Скай Жет” ХХК |
| CESSNA 208B | JU-9999 | CESSNA Aircraft Company | 20.01.30 | “Тэнгэрийн Улаач Шинэ” ХХК |
| | | Гадаад улсад бүртгэлтэй агаарын хөлөг | | |
| B737-800 | EI-CXV | Boeing | 20.07.02 | |
| B767-300 | EI-FGN | Boeing | 20.07.14 | МИАТ ХК |
| B737-8 MAX | EI-MNG | Boeing | 20.01.29 | |
| B737-700 | EI-ULN | Boeing | 20.01.29 | “Изинис Эйрвэйз” ХХК |

### 2.2.3 Эвентийн зах зээлийн шингээх боломжийг тооцох үзүүлэлтүүд

**Аймгуудын өрсөлдөх чадварын индекс**

Аймгуудын өрсөлдөх чадварын индексийг 2012 оноос эхлэн Эдийн засгийн бодлого, өрсөлдөх чадварын судалгааны төвөөс жил бүр гаргадаг болсон. Аймгуудын хөгжлийн өнөөгийн түвшин, өрсөлдөх чадварыг 180 орчим үзүүлэлтийн дагуу тодорхойлсноор аймгуудыг харьцуулах, чиг хандлагыг тодорхойлох боломжтой болж байна. Уг индексийг тооцохдоо үндсэн 4 бүлгийн нийт 16 дэд бүлэг үзүүлэлтүүдийг тооцдог.

**Хүснэгт 2. 7 Аймгуудын өрсөлдөх чадварын индексийн үзүүлэлтүүд**

| Эдийн засгийн тамир тэнхээ | Засаглалын үр ашиг | Бизнесийн үр ашиг | Дэд бүтэц |
|---|---|---|---|
| ○ Эдийн засаг<br>○ Эдийн засгийн салбарууд<br>○ Хүн амын амжиргааны түвшин<br>○ Хөдөлмөр эрхлэлт | ○ Аймгийн төсөв<br>○ Институцийн тогтолцоо<br>○ Бизнесийн эрхзүй<br>○ Нийгмийн тогтолцоо | ○ Бизнесийн орчин<br>○ Хөдөлмөрийн зах зээл, бүтээмж<br>○ Санхүү<br>○ Менежментийн хэвшил | ○ Үндсэн дэд бүтэц<br>○ Технологийн дэд бүтэц<br>○ Шинжлэх ухаан, боловсрол, соёл |

- Эрүүл мэнд, хүрээлэн буй орчин

**Эдийн засгийн тамир тэнхээ** үзүүлэлтээр тухайн аймгийн макро эдийн засгийн ерөнхий төлөв байдал, эдийн засгийн салбаруудын хөгжил, хүн амын амжиргааны түвшин, хөдөлмөр эрхлэлт зэрэг шалгуурыг хэмжиж гаргадаг.

**Засаглалын үр ашиг** үзүүлэлтээр өрсөлдөх чадварыг дэмжих аймгийн удирдлагын бодлого шийдвэр, аймгийн төсөв, институцийн тогтолцоо, бизнесийн эрх зүй, нийгмийн тогтолцоо гэсэн дэд бүлгүүдийг хамруулж гаргадаг.

**Бизнесийн үр ашиг** үзүүлэлтээр тухайн аймгийн бизнесийн байгууллагуудын үр ашигтай, хариуцлагатай, шинэлэг үйл ажиллагаа явуулах чадамжийг судлахын тулд бизнесийн орчин, хөдөлмөрийн зах зээл, бүтээмж, санхүү, менежментийн хэвшилтэй холбоотой үзүүлэлтүүдийг оруулдаг.

**Дэд бүтцийн** үзүүлэлтээр аймгуудын дэд бүтэцтэй холбоотой технологи, шинжлэх ухаан, боловсрол, эрүүл мэнд, соёл, хүрээлэн буй орчин зэргийг бүхэлд нь тооцож авч үздэг.

Аймгуудын өрсөлдөх чадварын индекс нь аль аймагт зохиогдож буй эвентэд хөрөнгө оруулалт хийх нь илүү үр өгөөжтэй болохыг тооцоход чухал үүрэг гүйцэтгэнэ.

**Нэг хүнд ногдох ДНБ:** Нэг хүнд ногдох ДНБ нь тухайн газар нутгийн амьдралын түвшин, иргэдийн худалдан авах чадамжийг харуулах үзүүлэлт бөгөөд бараа бүтээгдэхүүний үнийн өөрчлөлт үүнд хамаардаггүй. Өөрөөр хэлбэл аймгуудын хөгжлийн түвшинг хэмжих үзүүлэлт юм.

### Хүснэгт 2. 8 Аймаг, нийслэлийн нэг хүнд ногдох ДНБ

| № | Аймаг, нийслэл | Нэг хүнд ногдох ДНБ |
|---|---|---|
| 1 | Архангай | 6,367 |
| 2 | Баян-Өлгий | 4,099 |
| 3 | Баянхонгор | 5,148 |
| 4 | Булган | 6,007 |
| 5 | Говь-Алтай | 5,759 |
| 6 | Говьсүмбэр | 6,449 |
| 7 | Дархан-Уул | 5,079 |
| 8 | Дорноговь | 6,607 |
| 9 | Дорнод | 11,583 |
| 10 | Дундговь | 7,969 |

| | | |
|---|---|---|
| 11 | Завхан | 5,852 |
| 12 | Орхон | 20,297 |
| 13 | Сүхбаатар | 8,195 |
| 14 | Өвөрхангай | 5,584 |
| 15 | Сэлэнгэ | 6,819 |
| 16 | Төв | 6,677 |
| 17 | Увс | 4,760 |
| 18 | Ховд | 6,045 |
| 19 | Хөвсгөл | 5,263 |
| 20 | Хэнтий | 6,137 |
| 21 | Өмнөговь | 12,113 |
| 22 | Улаанбаатар | 17,327 |

**Нийслэл, орон нутгийн байршуулах хэрэгслийн даац:** Аялал жуулчлалын бүтээгдэхүүний ханган нийлүүлэлт байршуулах хэрэгсэл, тээврийн хэрэгсэл, хоол үйлдвэрлэлийн салбарын хүчин чадлаар үргэлж хязгаарлагдаж байдаг.

Бид энэ хэсэгт байршуулах хэрэгслийг авч үзлээ. Өөрөөр хэлбэл зах зээлийн боломж тооцоход нийлүүлэлтийн талын хүчин зүйлсэд тооцов.

Байршуулах хэрэгсэлд дараах төрлүүд байна. Үүнд:

1. Зочид буудал
2. Дэн буудал
3. Жуулчны бааз
4. Амралтын газар
5. Рашаан сувилалын газар
6. Гэр буудал (5-аас хэтрэхгүй гэр)
7. НИТАЖ айлын орон тоо
8. Отоглох цэг

**Хүснэгт 2. 9 Аймаг, нийслэлийн байршуулах хэрэгслийн даац**

| № | Аймаг, нийслэл | НИЙТ | Төрлүүд | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | Зочид буудал | Дэн буудал | Рашаан сувилал | Жуулчны бааз | Гэр буудал |
| 1 | Архангай | 4,864 | 141 | 407 | 210 | 2,726 | 1,380 |
| 2 | Баян-Өлгий | 1,549 | 425 | 95 | 180 | 704 | 145 |
| 3 | Баянхонгор | 1,515 | 300 | 31 | 541 | 514 | 129 |
| 4 | Булган | 4,542 | 95 | 103 | 1,234 | 905 | 2,205 |
| 5 | Говь-Алтай | 516 | 165 | 129 | 155 | 67 | |
| 6 | Говьсүмбэр | 67 | 38 | 17 | | 12 | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| 7 | Дархан-Уул | 2,632 | 758 | 116 | | 1,758 | |
| 8 | Дорноговь | 2,050 | 616 | 263 | 230 | 430 | 511 |
| 9 | Дорнод | 1,091 | 271 | 198 | | 285 | 337 |
| 10 | Дундговь | 1,490 | 125 | 89 | 60 | 1,004 | 212 |
| 11 | Завхан | 1,296 | 152 | 311 | 236 | 597 | |
| 12 | Орхон | 978 | 603 | 95 | | 280 | |
| 13 | Сүхбаатар | 555 | 243 | 39 | | 248 | 25 |
| 14 | Өвөрхангай | 4,198 | 682 | 212 | 550 | 2,094 | 660 |
| 15 | Сэлэнгэ | 1,000 | 317 | 57 | 174 | 452 | |
| 16 | Төв | 7,465 | | 46 | 712 | 5,878 | 829 |
| 17 | Увс | 1,572 | 375 | 28 | 52 | 1,052 | 65 |
| 18 | Ховд | 471 | 111 | | | 360 | |
| 19 | Хөвсгөл | 6,766 | 245 | 80 | | 3,659 | 2,782 |
| 20 | Хэнтий | 3,673 | 309 | 646 | 806 | 1,856 | 56 |
| 21 | Өмнөговь | 4,201 | 1,026 | | | 2,128 | 1,047 |
| 22 | Улаанбаатар | 7,402 | | | | | |
| **Нэг өдрийн ор хоног** | | **59,893** | | | | | |
| **Нэг сарын ор хоног** | | **1,796,790.0** | | | | | |

*Эх сурвалж: БОАЖЯ-ны 2020 оны тайлан, мэдээ*

Тухайн газар нутгийг зорин очих жуулчдын тоо: Доорх хүснэгтэнд тухайн эвент зохион байгуулагддаг зах зээлийг зорин очсон жуулчдын тоог харуулав.

### Хүснэгт 2. 10 Аймгуудын хүлээж авсан гадаад, дотоодын жуулчдын тоо, 2019 он

| № | Аймаг | Жуулчдын тоо | | Нийт |
|---|---|---|---|---|
| | | Гадаад жуулчдын тоо | Дотоод жуулчдын тоо | |
| 1 | Архангай | 21,822 | 76,708 | 98,530 |
| 2 | Баян-Өлгий | 6,000 | 6,000 | 12,000 |
| 3 | Баянхонгор | 2,000 | 70,080 | 72,080 |
| 4 | Булган | 6,825 | 40,827 | 47,652 |
| 5 | Говь-Алтай | 1,752 | 19,124 | 20,876 |
| 6 | Говьсүмбэр | 213 | 7,474 | 7,687 |
| 7 | Дархан-Уул | 4,108 | 25,712 | 29,820 |
| 8 | Дорноговь | 2,161 | 58,309 | 60,470 |
| 9 | Дорнод | 7,729 | 16,000 | 23,729 |
| 10 | Дундговь | 16,767 | 5,285 | 22,052 |
| 11 | Завхан | 5,388 | 44,598 | 49,986 |
| 12 | Орхон | 422 | 27,434 | 27,856 |
| 13 | Сүхбаатар | 964 | 23,150 | 24,114 |
| 14 | Өвөрхангай | 26,237 | 31,666 | 57,903 |
| 15 | Сэлэнгэ | 1,000 | 5,000 | 6,000 |
| 16 | Төв | 72,000 | 70,000 | 142,000 |
| 17 | Увс | 45,104 | 31,850 | 76,954 |

| | | | | |
|---|---|---|---|---|
| 18 | Ховд | 6,892 | 45,630 | 52,522 |
| 19 | Хөвсгөл | 26,137 | 56,531 | 82,668 |
| 20 | Хэнтий | 6,105 | 65,030 | 71,135 |
| 21 | Өмнөговь | 42,132 | 12,955 | 55,087 |

*Эх сурвалж: БОАЖЯ-ны 2020 оны тайлан, мэдээ*

### 2.2.4 Эвентийн зах зээлийн шингээх боломжийг тооцох нь

Эвентийн зах зээлийн шингээх боломжийг тооцохдоо тухайн эвентийн зохион байгуулагддаг зах зээлийг авч үзсэн. Эвентийн зах зээлийн шингээх боломжийг тооцсоноор аль зах зээлд хөрөнгө оруулалт хийвэл урт хугацаанд үр ашигтай байхыг хэлж өгдөгөөрөө давуу талтай юм.

**Хүснэгт 2. 11 Эвент зохион байгуулагддаг зах зээл**

| № | Аялал жуулчлалын боломжит 10 эвент | Зохион байгуулагддаг зах зээл |
|---|---|---|
| 1 | Алтан бүргэд-бүргэдийн баяр | Баян Өлгий |
| 2 | Плэйтайм олон улсын хөгжийн наадам | УБ |
| 3 | Монгол төрийн их наадам | УБ |
| 4 | Хонины найр | Төв |
| 5 | Талын түмэн адуу | Хэнтий |
| 6 | Түмэн тэмээний баяр | Өмнөговь |
| 7 | Улаанбаатарын өвлийн наадам | УБ |
| 8 | “Хийморь” морьт харваа, морин тулааны фестиваль | УБ |
| 9 | Баруун Монгол ардын язгуур урлагийн наадам | Увс |
| 10 | Хөх сувд - Хөвсгөлийн мөсний баяр | Хөвсгөл |

Зах зээлийн боломжийг үнэлэхдээ абсольют утгуудыг Марковизын оноо өгөх системийн дагуу нэг суурьтай болгож дараах байдлаар үнэлэв.

**Хүснэгт 2. 12 Эвентийн зах зээлийн шингээх боломж**

| Зах зээл | Нэг хүнд ногдох ДНБ | Өрсөлдөх чадварын индекс | Байршуулах хэрэгслийн хүчин чадал | Тухайн газар нутгийг зорин очсон жуулчдын тоо | Нийт оноо |
|---|---|---|---|---|---|
| Улаанбаатар | 7 | 6.5 | 6.5 | 7 | 27 |
| Өмнөговь | 6 | 6.5 | 6.5 | 6 | 25 |
| Төв | 4.5 | 4.5 | 5 | 4.5 | 18.5 |
| Хэнтий | 4.5 | 4.5 | 4 | 4.5 | 17.5 |
| Хөвсгөл | 2.5 | 3 | 3 | 3 | 11.5 |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| Увс | 2.5 | 1.5 | 1.5 | 1.5 | 7 |
| Баян-Өлгий | 1 | 1.5 | 1.5 | 1.5 | 5.5 |

Энэхүү бүлгийн 2.3-т тодорхойлсон доорх үзүүлэлтэд судлаачдын зүгээс хэр хэмжээний нөлөө үзүүлнэ гэж үзэж буйгаас шалтгаалан үзүүлэлтүүдийг жинлэсэн. Тухайлбал:

- Нэг хүнд ногдох ДНБ: 0.4
- Аймгуудын өрсөлдөх чадварын индекс: 0.4
- Байршуулах хэрэгслийн даац: 0.4
- Эрэлт буюу тухайн газар нутгийг зорин очсон гадаад жуулчдын тоо: 0.6

Өөрөөр хэлбэл эрэлтийн талын хүчин зүйлсэд илүү ач холбогдол өгч 0.6 коэффициентийг өгсөн бол нийлүүлэлтийн талын хүчин зүйлсэд 0.4 коэффициентийг өгөв.

Дээр дурдсан үзүүлэлтийг оноосон жингээр үржүүлж үр дүнг гаргав.

### Хүснэгт 2. 13 Эвентийн зах зээлийн шингээх боломжийн үнэлгээ

| Зах зээл | Нэг хүнд ногдох ДНБ (0.4) | Өрсөлдөх чадварын индекс (0.4) | Байршуулах хэрэгслийн хүчин чадал (0.4) | Тухайн газар нутгийг зорин очсон жуулчдын тоо (0.6) | Нийт оноо |
|---|---|---|---|---|---|
| Улаанбаатар | 2.8 | 2.6 | 2.6 | 4.2 | 12.2 |
| Өмнөговь | 2.4 | 2.6 | 2.6 | 3.6 | 11.2 |
| Төв | 1.8 | 1.8 | 2 | 2.7 | 8.3 |
| Хэнтий | 1.8 | 1.8 | 1.6 | 2.7 | 7.9 |
| Хөвсгөл | 1 | 1.2 | 1.2 | 1.8 | 5.2 |
| Увс | 1 | 0.6 | 0.6 | 0.9 | 3.1 |
| Баян-Өлгий | 0.4 | 0.6 | 0.6 | 0.9 | 2.5 |

### Хүснэгт 2. 14 Зах зээлийн эрэмбэ, бүлгээр

| № | Зах зээлийн шингээх боломж | Эрэмбэ | Газар нутаг | Нийт оноо | Бүлгийн дундаж |
|---|---|---|---|---|---|
| **1** | Өндөр | 1 | Улаанбаатар | 12.2 | 11.7 |
| | | 2 | Өмнөговь | 11.2 | |
| **2** | Дунд | 3 | Төв | 8.3 | 8.1 |
| | | 4 | Хэнтий | 7.9 | |
| **3** | Бага | 5 | Хөвсгөл | 5.2 | 3.6 |
| | | 6 | Увс | 3.1 | |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| | | 7 | Баян-Өлгий | 2.5 | |

Дээрх хүснэгтээс харахад хамгийн өндөр зах зээлийн шингээх боломжтой нь нийслэл Улаанбаатар, Өмнөговь аймгууд гарсан байна.

Мөн зах зээлийн шингээх боломжийн түвшингээрээ дундаж бүлэгт орсон Төв, Хэнтий аймгууд болон зах зээлийн өндөр боломжтой бүлэг хооронд 3.6 пунктын зөрүүтэй байна. Харин зах зээлийн боломж багатай бүлгийн дундаж оноо зах зээлийн боломж өндөр бүлгээс даруй 3.2 дахин бага байна. Хөвсгөл аймгийн хувьд бүлэг дотроо хамгийн өндөр оноотой байх бөгөөд дунд бүлэгт харьяалагдах боломж байгааг онооны дүнгээс харж болж байна.

## 2.3. ЭВЕНТ ЗОХИОН БАЙГУУЛАХТАЙ ХОЛБООТОЙ ЗАРДАЛ БА ШААРДЛАГАТАЙ ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ

Энэхүү тайлангийн өмнөх бүлэгт /Хүснэгт 1.16/ Монгол улсад зохион байгуулагдах боломжит 10 эвентийг тодорхойлсон. Эдгээр эвентийн хувьд бидний судалж буй хугацаа болох 2019 оны байдлаар хичнээн төгрөгийн зардал гаргасан талаар дараах хүснэгтэд харуулав.

**Хүснэгт 2. 15 Монгол улсад зохион байгуулагдах боломжит топ 10 эвентийн зардлын мэдээлэл**

| № | Эвентийн нэр | Эвентийн байршил | Нийт зардлын хэмжээ, сая төгрөг /2019/ | Эх үүсвэр |
|---|---|---|---|---|
| 1 | Монгол төрийн их наадам | УБ | 2900 | 13.7 хувь (400 сая) нь үйл ажиллагааны орлогоос, 86.3 хувь нь улсын болон орон нутгийн төсвөөс |
| 2 | Плэйтайм | УБ | 130 | 100 хувь зохион байгуулагч аж ахуйн нэгжийн төсөв |
| 3 | Улаанбаатарын өвлийн наадам | УБ-хүрээлэн ба Скай ресорт | 58 | 100 хувь орон нутгийн төсвөөс |
| 4 | “Хийморь” морьт харваа, морин тулааны фестиваль | УБ | 25 | 100 хувь зохион байгуулагч аж ахуйн нэгжийн төсөв |
| 5 | Хонины найр | Төв | 4.5 | 100 хувь зохион байгуулагч аж ахуйн нэгжийн төсөв |
| 6 | Талын түмэн адуу | Хэнтий-Батноров | 50 | 80 хувь нь хандив, тусламж, 10 хувь нь зохион байгуулагч байгууллагын хөрөнгөөр, 10 хувь нь орон нутгийн төсөв |
| 7 | Түмэн тэмээний баяр | Өмнөговь.Булган | 27 | 100 хувь зохион байгуулагч аж ахуйн нэгжийн төсөв |

| | | | | |
|---|---|---|---|---|
| 8 | Хөх сувд - Хөвсгөлийн мөсний баяр | Хөвсгөл-Хатгал | 74 | 27 хувь нь улсын төсөв, 13.5 хувь нь орон нутгийн төсөв, 59.4 хувь нь төсөл хөтөлбөр, хандиваар |
| 9 | Алтан бүргэд - Бүргэдчдийн баяр | Баян-Өлгий-Бугат | 14 | 71.4 хувь нь улсын төсвөөс, 28.5 хувь нь хандив тусламж, зохион байгуулагч байгууллагын хөрөнгөөр |
| 10 | Баруун Монголын ЯУН/Увс | Увс | 50 | 100 хувь зохион байгуулагч байгууллагын хөрөнгөөр |

*Эх үүсвэр: Судалгааны багийн хийсэн түүвэр судалгааны тоо баримтад үндэслэв.*

Боломжит 10 эвентийн хувьд эвент зохион байгуулагчид, аймаг, нийслэл орон нутгийн байгаль орчин аялал жуулчлалын мэргэжилтнүүд зэрэгтэй эдгээр эвентүүдийн талаар цаашид хэрхэн сайжруулах талаар стратеги төлөвлөгөө байгаа эсэх, түүнтэй уялдан гарах зардал, шаардлагатай хөрөнгө оруулалтын талаар фокус бүлгийн уулзалтуудыг зохион байгуулсан. Зарим эвентийн хувьд стратеги төлөвлөгөө гэх зүйлгүй, гэхдээ эвентийн үйл ажиллагааг өргөжүүлэх зорилго байгаа талаар дурдаж байсан. Ингээд зарим эвентийн хувьд ирээдүйн төлөвлөгөө болоод холбогдох зардал, шаардлагатай хөрөнгө оруулалтын талаар фокус бүлгийн ярилцлагын үеэр дурдагдсан зүйлийг доор үзүүлэв.

**Монгол туургатаны язгуур соёлын олон улсын их наадам:**

Уг наадмын гол зохион байгуулагч нь “Онцын тасархай тур” ХХК ба “Ойрад түмэн” ТББ-тай хамтран зохион байгуулдаг. Эдгээр нь нэг удирдлагатай байгууллагууд юм.

Энэхүү наадмыг 2006 оноос хойш тасралтгүй зохион байгуулж байна. Уг наадам нь жил бүрийн 8 дугаар сард Увс аймагт 2 өдрийн турш зохион байгуулагддаг. Жилд ойролцоогоор 2000 орчим хүн оролцдог ба 2019 онд нийт 50 гадаадын жуулчин, 150 гадаад оролцогч, 100 орчим дотоодын жуулчид болон нийт 2000 орчим гадаад, дотоодын жуулчид оролцсон. 2019 онд зохион байгуулсан наадмын хувьд 50 орчим сая төгрөгийн зардал гаргасан ба харин 2.5 сая төгрөгийн шууд орлого уг эвентээс олсон. Ямар нэгэн улсын болоод орон нутгийн төсвөөс дэмжлэг туслалцаа, хандив аваагүй. Цаашид уг арга хэмжээг түшиглэн аялал жуулчлалын арга хэмжээнүүд зохион байгуулахаар төлөвлөж байгаа.

Наадмын арга хэмжээг илүү үр дүнтэй байлгах зорилгоор тайз, чимэглэл, эрчим хүчний эх үүсвэрийг шийдвэрлэх шаардлага байгаа ба үүнд шаардагдах төсөв 2019 оны тооцооллоор нийт 180 сая орчим төгрөг гэсэн тооцоо гарсан.[55]

**Талын түмэн адуу:**

“Мөнх харилцаа” ТББ-аас жил бүр зохион байгуулдаг “Талын түмэн адуу” эвент нь 2013 оноос хойш жил бүр Хэнтий аймагт зохион байгуулагддаг 3 өдөр үргэлжилдэг. 2019 онд зохион байгуулагдсан уг арга хэмжээнд нийт 5000 орчим хүн оролцсон ба үүнээс 320 гадаад жуулчин, 1500 орчим дотоодын жуулчин оролцсон.

[55] “Онцын тасархай тур” ХХК-ийн захирал н.Батсүхтэй хийсэн фокус судалгааны ярилцлагын хэсгээс

“Талын Түмэн Адуу-2019” арга хэмжээг нийт 50 орчим сая төгрөгөөр зохион байгуулсан ба уг төсвийн 80 хувь буюу 40 орчим сая төгрөгийг хандив тусламжаар, 10 хувийг буюу 5 сая төгрөгийг компаний өөрийн хөрөнгөөр, 10 хувь буюу 5 сая төгрөгийг орон нутгийн төсвөөс гаргасан байна. Цаашид Хаан банк болоод бусад аж ахуйн нэгжүүд уг арга хэмжээг илүү өргөн хүрээтэй болгохоор хамтран ажиллах боломжтой гэдгээ илэрхийлсэн байна.[56]

Тухайн арга хэмжээг зохион байгуулсан зохион байгуулагчтай хийсэн ярилцлагын үеэр уг эвентийг илүү сайжруулахын тулд гадаад сурталчилгаа, маркетинг нэн шаардлагатай байна. Ялангуяа тухайн орны жуулчинд зориулсан эвентийг сурталчилсан контент нэн чухал байгаа ба үүнд хөрөнгө оруулалт шаардлагатай байгаа талаар дурдсан. [57]

**Түмэн тэмээний баяр:**

“Гайхамшигт говь аялал жуулчлалын холбоо” ТББ-аас Өмнөговь аймгийн Булган сумын ЗДТГ-тай хамтран 1997 оноос хойш жил бүр зохион байгуулж байна. Тус эвент нь дэлхийд ховорхон хоёр бөхт тэмээн сүргийг хайрлан хамгаалах, тэмээнд олон нийтийн анхаарлыг хандуулах, тэмээчин ардын хөдөлмөрийг үнэлэх, тэмээний амьдын үнэлэмжийг нэмэгдүүлэх, аялал жуулчлалаас ард иргэдийн ашиг орлогыг нэмэгдүүлэх зорилготой.

2019 онд зохион байгуулагдсан уг арга хэмжээнд 86 гадаад жуулчин, 400 орчим дотоодын жуулчин оролцсон.

Цаашид Азийн тэмээн холбооноос зохион байгуулдаг өвлийн “Nomadic game”-ийн хэсгийн тоглолтуудыг Монголд зохион байгуулах төлөвлөгөөтэй байна. Өмнө нь энэхүү арга хэмжээг манай улсад зохион байгуулахаар зохион байгуулагч талтай хэлэлцээр хийж байсан боловч цар тахлын улмаас цуцлагдсан. Уг арга хэмжээнд оролцох хүмүүсийн зардал, зочид буудлын төлбөр гэх мэтийг зохион байгуулж буй улс даадаг ба зарим улсын хувьд ЗГ нь өөрөө даагаад орлогоо авдаг туршлага байдаг. [58]

Мөн дээрх арга хэмжээг зохион байгуулж олон жуулчин ирэх тохиолдолд даацын асуудлаас болоод хүндрэл учрах эрсдэлтэй байгааг зохион байгуулагч дурдсан.

Иймээс цаашдын шаардлагатай зардал, хөрөнгө оруулалтын хувьд жуулчин хүлээн авах даацыг нэмэгдүүлэх, олон улсын арга хэмжээг зохион байгуулахад хамтран хөрөнгө оруулах шаардлага тулгарч байгаа нь фокус бүлгийн ярилцлагаас тодорхой харагдаж байна.

Боломжит 10 эвентүүдийн хувьд хөрөнгө оруулалт шаардлагатай гэж үзэж буй нийтлэг зүйлсийн хувьд:

***Мобайл буюу хөдөлгөөнт кэмпүүдэд хөрөнгө оруулалт шаардлагатай.*** Гадаад болон дотоодын жуулчдын тоо өсөхөд даацын хязгаарлагдмал байдал эрсдэл учруулдаг. Ихэнхдээ эвент зохион байгуулагчид нүүдэлчин амьдралын хэв шинжийг харуулах зорилгоор нутгийн айл өрхийг түшиглэн гэр бариулж, байршуулах арга хэмжээг авдаг байсан. Тэдний хувьд орон нутагт түшиглэсэн мобайл буюу хөдөлгөөнт кэмпүүдэд хөрөнгө оруулалт

[56] Хэнтий аймгийн БОАЖГ-ын мэргэжилтэнээс ирүүлсэн “Талын түмэн адуу 2019” эвентийн тайлан
[57] “Мөнх харилцаа” ТББ-ын Ерөнхий захирал н.Цэрэнбаттай хийсэн фокус судалгааны ярилцлагын хэсгээс
[58] “Гайхамшигт говь аялал жуулчлалын холбоо” ТББ-ын захирал н.Ариунсанаатай хийсэн фокус ярилцлагын хэсгээс

шаардлагатай гэж үзэж байгаа. Мөн Монголбанкнаас 2019 онд хийсэн түүвэр судалгааны үр дүнд гадны жуулчдад хамгийн их хүндрэл учруулсан асуудлуудад ариун цэврийн өрөө, зочлох газруудын асуудал байсныг дурдсан байдаг. [59]

***Мэдээлэл сурталчилгааны контентийг гадаад хэл дээр бэлтгэн тараахад хөрөнгө оруулалт шаардлагатай.*** Гадны жуулчин татах зорилгоор мэдээлэл түгээх, сурталчилгааны ажил нилээд хомс байдгийг дурдсан ба тухайн улсын жуулчны онцлогт тохируулан Англи болон бусад хэлээр мэдээлэл бэлтгэх, контент бэлтгэх нэн чухал байгаа ба үүнд хөрөнгө оруулалт шаардлагатай байгааг онцолсон. Нөгөө талаас Монголбанкнаас 2019 онд хийсэн түүвэр судалгааны үр дүнд гадны жуулчид мэдээлэл хомс байсан нь бэрхшээл болдог талаар дурдсан.[60] Гадаад хэл дээр бэлтгэсэн танилцуулга брошур, хөтөлбөр зэрэг нь Англи болон бусад хэл дээр байхгүй байгааг эвентийн оролцогсод тухайн үед шүүмжилж байсан. Тухайлбал "Талын түмэн адуу 2019" эвентийн үеэр Хаан банкнаас ивээн тэтгэж хийлгэсэн судалгааны тайланд "Гадаад хэл дээр ямар ч мэдээлэл байхгүй. Хөтөлбөр Англи хэл дээр байгаа хэдий ч тэр нь үг, үсгийн алдаа ихтэй байна. Гадаадын жуулчдад зориулсан ямар ч хөтөлбөр, арга хэмжээ, тэднийг татах үйл ажиллагаа огт байсангүй" гэжээ.

***Мэргэжлийн маркетингийн баг, эвентийн найруулагч шаардлагатай ба үүнд холбогдох зардал, хөрөнгө оруулалт хэрэгтэй.*** Эвентийн найруулга тал дээр маркетингийн баг ажиллах, зөвлөх үйлчилгээ үзүүлэх, хамтран ажиллах хэрэгцээ байгаа ба үүнд шаардлагатай зардлыг санхүүжүүлэх, хөрөнгө оруулалт хийх хэрэгтэй гэж зохион байгуулагчид үзэж байна.

***Мэргэжлийн хөтөч бэлтгэх, тэдгээрийн Англи хэлний мэдлэгийг дээшлүүлэх тал дээр хүний нөөцийн нэгдсэн бодлого хэрэгжүүлэх, холбогдох зардал, хөрөнгө оруулалтыг шийдвэрлэх шаардлагатай.*** Энэ тал дээр холбогдох судалгаануудад хөтөч, орчуулагчийн хэлний мэдлэг муу байгаа нь мэдээлэл авахад саад болж байсан.

***Эвентийг илүү мэргэжлийн болгох, гадны жуулчдыг ихээр татахын тулд олон улсын мэргэжлийн холбоодод гишүүнээр элсэх, тэдгээрийн холбогдох дүрэм журам, стандартыг нэвтрүүлэх шаардлагатай.*** Тухайлбал аялал жуулчлалын ISO стандартыг нэвтрүүлэх чиглэлээр зардал санхүүжүүлэх, хөрөнгө оруулалт хийх хэрэгцээ байгааг зохион байгуулагчид хэлж байна.

Эвент зохион байгуулагчид ганц нэг удаа тухайн эвентийг зохион байгуулахад санхүүжилт олгохдоо бус урт хугацааны дэд бүтцийг бий болгох чиглэлд анхаарч хөрөнгө оруулалт хийх нь зүйтэй байгааг онцолж байсан.

---

[59] Аялал жуулчлалын өнөөгийн байдал, шийдвэрлэх асуудлууд, Монголбанк, 2019
[60] Аялал жуулчлалын өнөөгийн байдал, шийдвэрлэх асуудлууд, Монголбанк, 2019

## 2.4. ЭВЕНТИЙН ЭРСДЛИЙН ХҮЧИН ЗҮЙЛ

Аялал жуулчлалын салбар нь эдийн засгийн бусад салбаруудтай нягт уялдаатайгаар тогтвортой хөгжилд чиглэсэн ногоон эдийн засгийн бодлого хэрэгжих хамгийн боломжит салбар юм.

НҮБ-ийн Дэлхийн аялал жуулчлалын байгууллага (UNWTO)-аас 2018 онд аялал жуулчлалын үйлдвэрлэл дэлхийн ДНБ-ний 10 хувь, барааны экспортын 7 хувь, үйлчилгээний экспортын 30 хувийг тус тус эзэлж, 10 хүн тутмын нэг нь тус салбарт ажилладаг талаар мэдээлжээ. Түүнчлэн 2020 онд дэлхийн жуулчдын тоо 1995 онтой харьцуулахад 3 дахин нэмэгдэж 1.6 тэрбумд хүрэх бөгөөд Ази, Номхон далайн бүс нутагт аялах жуулчдын тоо дэлхийн бусад бүсүүдээс илүү хурдацтай нэмэгдэж байгааг судалгаа тогтоожээ[61].

Гэсэн хэдий ч тус салбар нь эрсдлийн хүчин зүйл хамгийн өндөртэй салбар болох нь дэлхийн нийтийг хамарсан эдийн засгийн хямрал, зөрчил мөргөлдөөн, өвчин эмгэгтэй он жилүүдэд аялан жуулчлагчдын тоо буурсанаас тодорхой харагдаж байна.

Доорх зурагт сүүлийн 30 жилийн жуулчлагчдын тоон өөрчлөлтийг харуулав.

### График 2. 2 Жуулчдын тоо, 1989-2020 он, сая хүнээр




*Эх үүсвэр: UNFTO*

АНУ-д 2001 онд гарсан терорист халдлагаас хамааран дэлхийн аялал жуулчлалд хамрагдагсдын тоо 2001 онд 693 сая болж өмнөх жилээс 0.6 хувиар[62] буурсан. 2019 онд дэлхий дахинд 1.4 тэрбум[63] хүн аялал, жуулчлалын үйлчилгээг авч байсан бол 2020 онд дэлхийн жуулчдын тоо сүүлийн 30-аад жилд байгаагүйгээр багассан ба 74 хувиар буурсан байна.

---

[61] Аялал жуулчлалын салбарын өнөөгийн байдал, шийдвэрлэх асуудлууд, түүвэр судалгаа, 2019 он, Монгол банк
[62] The impact of 9/11 and other terrible global events on tourism in the U.S. and Hawaii
[63] https://www.statista.com/statistics/209334/total-number-of-international-tourist-arrivals/

2020 оны жуулчдын тоог бүс нутгаар авч үзэн 2019 онтой харьцуулахад Америк тивд 69 сая буюу 69 хувиар, Европ тивд 221 сая буюу 70 хувиар, Африк тивд 18 сая буюу 75 хувиар, Ойрх дорнодод 16 сая буюу 75 хувиар, Ази номхон далайн бүс нутагт 57 сая буюу 84 хувиар тус тус буурсан. Ийнхүү жуулчдын тоо багассанаас 1.7 их наяд ам.долларын[64] алдагдалтай ажиллахад хүрсэн.

Манай орны хувьд цар тахлын нөлөөгөөр жуулчдын тоо 90 орчим хувиар буурсан нь аялал жуулчлалын салбарыг зогсонги байдалд оруулж, эрсдлийг нэмэгдүүлсэн. Цар тахлын үед бараг бүх улсууд хөл хорионы хатуу дэглэмд шилжин, хилээ хаан, хязгаарлалт хийж гадаад, дотоодын урсгал хөдөлгөөнийг хорьсонтой холбоотойгоор аялал жуулчлалын салбар хамгийн их уналтанд ороод байна.

**График 2. 3 Монгол улсын хилээр орж ирсэн жуулчдын тоо, 2015-2020**




*Эх үүсвэр: ҮСХ*

Дээрх тоон мэдээллээс харахад аялал жуулчлал нь гадаад болон дотоод хүчин зүйлсийн нөлөөнд өртөмтгий, эмзэг, эрсдэл өндөртэй салбар гэдэг нь нотлогдож байна.

НҮБ-ын дэлхийн аялал жуулчлалын байгууллагаас аялал жуулчлалын 4 үндсэн эрсдлийг тодорхойлсон байдаг (UNWTO, 2015).

1. **Аялан жуулчлалтай холбоотой эрсдэл** (гэрээг үл хүндэтгэх, залилан мэхлэх, эрүүл ахуй, ариун цэврийн шаардлага хангаагүй байдал, гал түймэр, газар хөдлөлт)
2. **Аялал жуулчлалын салбараас гадуурх хүн ба байгууллагын эрсдэл** (нийгмийн мөргөлдөөн, дайн, терроризм, зохион байгуулалттай гэмт хэрэг, хүний наймаа)

[64] https://www.unwto.org/covid-19-and-tourism-2020

3. **Хувийн эрсдэл** аялагчдад (эрүүл мэндийн байдал, гэмт хэрэг, орон нутгийн оршин суугчидтай зөрчилдөх, аюултай бүсээр зочлох, мөнгө болон баримт бичгээ алдах гэх мэт)
4. **Хүрээлэн буй орчноос үүсэх эрсдэл** (байгалийн, цаг уурын, тахал өвчний (вакцин хийлгэх, оюултай газар очих, байгалийн гамшиг, тахлын үед аюулд өртөх)

Дээрх 4 эрсдэлт байдал нь аялал жуулчлалын салбарын бүтээгдэхүүн, үйлчилгээнд хамаарах эрсдлийн хүчин зүйлс юм.

Аялал жуулчлалын бүтээгдэхүүн, үйлчилгээний эрсдэлт байдалд бүтээгдэхүүний чанар онцгой ач холбогдолтой. Тиймээс аялал жуулчлалын бүтээгдэхүүн, үйлчилгээний чанарыг дараах 5 хүчин зүйлсээр үнэлдэг. Тухайн бүтээгдэхүүн, үйлчилгээний чанарыг сайжруулах, эрсдлийн хүчин зүйлийг бууруулах нь нэг зүйлийн хоёр тал юм.

**Зураг 2. 1 Аялал жуулчлалын бүтээгдэхүүн, үйлчилгээний чанарын хүчин зүйлс**




***Үзмэр, харах зүйлс***: Жуулчдын сонирхолыг татаж буй бүхий л зүйлс үүнд хамрагдана. (байгаль, түүх соёлын, үйлчилгээ тоног төхөөрөмж гэх мэт)

***Тээвэр:*** Аялалд ашиглаж буй бүх тээврийн хэрэгслийн үйлчилгээ багтана. (агаарын, авто замын, усан замын, ердийн хөсөг гэх мэт)

***Байр:*** Жуулчдын тав тух амрах хэрэгцээг хангахад зориулагдсан төрөл бүрийн байр, сууцны үйлчилгээ орно. (зочид буудал, жуулчны бааз, амралтын газрууд гэх мэт)

***Хоол:*** Жуулчдад үйлчилж байгаа бүх төрлийн хоол, ундааны үйлчилгээний газрууд хамрагдана. (ресторан, түргэн хоолны газар гэх мэт)

***Чиглүүлэгч, зөвлөх үйлчилгээ:*** Жуулчдад үйлчилж байгаа хөтөч тайлбарлагч, тур компаниуд болон жолоочийг энэ хэсэгт хамруулна.

Дээрх хүчин зүйлсэд хамаардаг тухайн бүтээгдэхүүн, үйлчилгээний нөлөөг тоймловол:

**Зочид буудал**

2019 онд дэлхий дахинд зочид буудлын салбарын үнэлгээ 1.2 их наяд ам.долларт хүрсэн бөгөөд өндөр зэрэглэлийн үйлчилгээ бүхий зочид буудал нь тус бизнесийн зардлын томоохон хэсэг нь байдаг бөгөөд дэлхийн сүлжээ Shangri-la, Hilton, InterContinental, Wyndham зэрэг зочид буудлыг бид мэднэ. Тансаг

зэрэглэлийн зочид буудалд нэг өдөрт дунджаар 850 орчим ам.долларыг төлдөг байна.

### Агаарын тээвэр

2010 оноос хойш дэлхий дахинд аялж буй жуулчдын тоо 1 тэрбумыг давсан. Дундаж нислэгийн зардал 350-360 орчим ам. доллар байдаг бөгөөд 2009-2019 оны хооронд агаарын тээврийн үйлчилгээ жилд дунджаар 5.3 хувиар өссөн үзүүлэлттэй дэлхийд томоохонд тооцогдох, эдийн засгийн өндөр өгөөжтэй салбар байсан. Цар тахлын улмаас агаарын тээврийн үйл ажиллагаа доголдсон бөгөөд шинжээчдийн тооцоогоор 2022 оны I улирлаас тус салбар буцаж сэргэх хандлагатай байна.

**График 2. 4 Агаарын тээврийн орлого, тэрбум ам.доллар, 2003-2020 он[65]**




*Эх үүсвэр: UNFTO*

### Байгалийн цогцолбор

Байгалийн цогцолбор тур болон, музей үзмэр, түүхэн газруудад түшиглэсэн худалдаа үйлчилгээний сүлжээ нь аялал жуулчлалын салбарын томоохон ажлын байр болдог. 2019 онд АНУ-ын Дисней мажик ланд паркаар 21 сая орчим хүн үйлчлүүлсэн бөгөөд нэг хүний тасалбарын дундаж өртөг нь 150 ам.доллар болдог байна.

### Сүлжээ хоолны газар

Жуулчдын ялангуяа баруун Европ болон хойд Америкийн аялагчид тухайн орны хоолны соёлтой танилцахыг хүсдэг бөгөөд орон орны онцлог бүхий хоолны цэсийг томоохон сүлжээ ресторануудаар дамжуулан борлуулдаг байна. АНУ-ын

65 https://www.statista.com/statistics/278372/revenue-of-commercial-airlines-worldwide/

нэг иргэн аялалд явахдаа өдөрт дунджаар 35-50 ам.доллар зарцуулдаг гэсэн тооцоо байдаг.

**Зуучлагч байгууллага**

2019 онд Монгол улсад ирсэн нийт аялагчид, жуулчдын 63 хувь нь өөрийн орны болон манай орны ямар нэгэн жуулчлалын байгууллагад төлбөр төлж, аялал жуулчлалынхаа хөтөлбөрийн хуваарийг гаргасан байна. Харин дэлхий дахинд онлайн аялалын багц борлуулдаг томоохон байгууллагууд байдаг. Тухайлбал, АНУ-ын Airbnb компанийн зах зээлийн үнэлгээ 87 орчим триллион ам.доллар бөгөөд тус компанийн үйл ажиллагаанд гадаадын аялал жуулчлал гэхээсээ илүү дотооддоо зорчих аялалын багц хамгийн их борлуулалттай байдаг.

Дараах зурагт аялал жуулчлалын компанийн зах зээлийн үнэлгээ, улсуудаар үзүүлэв.

**График 2. 5 Дэлхийн тэргүүлэх онлайн аялал зуучлалын байгууллагуудын зах зээлийн үнэлгээ 2020**




*Эх үүсвэр: UNFTO*

Манай улсын хувьд аялал жуучлалын салбар нь 60 гаруй жилийн түүхтэй бөгөөд анх төрийн өмчит “Жуулчин” компани үйл ажиллагаа явуулж эхэлсэн бол өдгөө уг салбарт 1200 гаруй тур оператор компани /идэвхтэй үйл ажиллагаа явуулж буй 120 гаруй/, 370 зочид буудал, 300 гаруй жуулчны бааз үйл ажиллагаа явуулж, нийт 50 мянга гаруй хүн тус салбарт ажиллаж байна.

Судалгаагаар тур оператор компаниуд дунджаар 1.100 ам.долларын үнэтэй аялалын багцтай бөгөөд жилд дунджаар 400 орчим жуулчин хүлээн авдаг гэсэн тооцоо байна. Удирдах ажилтнуудын хувьд 2 хүн тутмын нэг нь аялал жуулчлалын мэргэжилтэй бөгөөд 10 гаруй жилийн туршлагатай гэжээ.

Тоон мэдээллээс өөрийн орны тур оператор компаниар дамжуулан аялалаа захиалсан жуулчид дунджаар 2.187 ам.доллар зарцуулсан байхад

Монголын тур оператор компаниас аялал худалдан авсан жуулчид дунджаар 2.048 ам.долларыг төлсөн байна. Тус төлбөрт тухайн жуулчны худалдан авсан ноолууран эдлэл, гар урлал, бэлэг дурсгалын зүйлс багтсан байна.

Харин аялалын багц худалдан авахгүйгээр өөрөө зохион байгуулсан жуулчид дунджаар 1.658 ам.доллар зарцуулсан байна.

Үүнд:

- тээвэрт 421 ам.доллар,
- байр сууцанд 400 ам.доллар,
- бараа, бүтээгдэхүүн худалдан авахад 319 ам.доллар,
- хоол унданд 246 ам.доллар,
- бусад үйлчилгээнд 272 ам.долларыг тус тус зарцуулжээ.

Аялалын багц худалдан авсан жуулчдыг улсаар авч үзвэл: БНСУ болон Франц улсын иргэдийн 64% нь Монголын тур оператор компаниар дамжуулан аялсан бол ХБНГУ-ын жуулчид гадаадын тур оператор компаниар дамжсан байна.

Судалгаагаар жуулчид дунджаар 13 хоногийг Монголд өнгөрүүлдэг бөгөөд аялалын мэдээллийн дутмаг байдал нь Монголд ирэхээс өмнөх хамгийн том бэрхшээл болохыг онцолжээ.

Манай тур оператор компаний хувьд аялал жуулчлалын идэвхитэй үйл ажиллагаа явуулж, орлого хуримтлуулах хугацаа нь дунджаар 6 сар байдаг ба жуулчны бус улиралд ихэвчлэн дараа жилийн бэлтгэл ажлаа базаадаг, бас сул зогсолт хийдэг байна.

Монгол улсын аялал жуулчлалын (нүүдлийн соёл уламжлал, зан заншил, байгаль, түүхийн) эвентийн харьцуулсан шинжилгээг дараах байдлаар гаргав.

**Аялал жуулчлалын эвентийг хөгжүүлэх боломж, давуу тал:**

- Монголд ирэх гадаадын жуулчдын тоо жил бүр нэмэгдэж байна.
- Эвент үзэж сонирхох дотоодын жуулчдын тоо мөн нэмэгдэж байна.
- Шинэ технологи, хэвлэл мэдээллийн хэрэгсэл ашиглан зах зээлд үйл ажиллагаагаа сурталчлах боломжтой.
- Жуулчдын эрэлт, захиалгад тулгуурлан нэг буюу хэд хэдэн эвентийг нэг хугацаанд зохион байгуулах боломжтой.
- Эвентийн үеэр бэлэг дурсгалын зүйл зарж борлуулах буюу нэмэлт аялал жуулчлалыг хөгжүүлэх боломжтой.
- Аялал жуулчлалын эвент нь оролцогч үзэгчдээ бодит, жинхэнэ практикт шууд татан оролцуулдаг. Өнөө цагт байгаль, түүх, соёлын ихэнх хэсэг нь виртуал орчинд суурилсан байдаг бол эвент нь бодит орчинд суурилсан байдгаараа давуу талтай.
- Монгол улс нь нүүдэлчин соёлоо авч үлдсэн цөөн тооны улсын нэг бөгөөд энэ нь жуулчдын сонирхлыг татах томоохон хэсэг юм.

- Монголд ирж буй жуулчдын 50-иас илүү хувь нь нүүдлийн соёл, ахуй, түүхийг сонирхож ирдэг.
- Гадаад, дотоодын жуулчид  залуу үеийнхэндээ онгон байгаль, нүүдлийн соёлыг таниулж мэдүүлэх ач холбогдолтой

**Аялал жуулчлалын эвентийг хөгжүүлэхэд тулгарч буй саад бэрхшээл, сул тал**

- Эвентийг чанартай сайн зохион байгуулахад үүсдэг томоохон асуудал нь санхүүжилт юм
- Эвентийн талаарх мэдээлэл хомс, тасалбарын түгээлт, хүрэлцээ тааруу
- Дэлхий нийтийг хамарсан цар тахал, дайн самуун, халдлага зэрэг давагдашгүй хүчин зүйлс нь эвентийн үйл ажиллагаанд шууд нөлөөлдөг, зогсоодог.
- Орон нутагт зохион байгуулдаг эвентэд төсвийн дэмжлэг бага, хувийн секторын чадавх сул
- Эвентээс ихэвчлэн хотоос алслагдсан бүсэнд зохион байгуулагддаг бөгөөд зам тээврийн аюулгүй байдал нь гадаад жуулчдыг аюулгүй байдалдаа санаа зовоохол хүргэдэг
- Эвентийн үйл ажиллагаанд оролцох дотоодын эрэлт тааруу байдаг
- Тухайн нэг жуулчин олон эвентэд оролцох боломж хязгаарлагдмал
- Эвентийг зохион байгуулах цаг хугацааны болон орон зайн зардал өндөр
- Орон нутагт зохион байгуулагддаг эвентийн цар хүрээ, далайц бага байдаг
- Эвентийн байнга тогтмолжсон байдал муу
- Эвентийн зохион байгуулалт тааруу байдаг
- Цаг агаарын нөхцөл байдалд өртөмтгий (цаг агаарын урьдчилан тааварлах боломжгүй нөхцөл)
- Эвент зохион байгуулагдаж байгаа газар нийтийн үйлчилгээ тэр дундаа нийтийн бие засах газрын олдоц, ариун цэврийн асуудал, машины зогсоол зэргийн хүрэлцээ тааруу байдаг

Монгол улсын аялал жуулчлалын салбарын өрсөлдөх чадварын индексээс харахад үнийн өрсөлдөх чадвар, байгалийн нөөц гэсэн үзүүлэлтээр дээгүүр эрэмблэгддэг ч тээврийн дэд бүтэц, олон улсад нээлттэй байдал, жуулчны үйлчилгээний дэд бүтэц гэсэн үзүүлэлтүүд тааруу байдаг.

Аялал жуулчлалын эвентийг хөгжүүлэхэд тулгарч буй  хүндрэл бэрхшээлийг нэгтгэн дараах эрсдэлт хүчин зүйлээр тоймлон гаргаж байна.

- Үйлчилгээний чанар, стандарт муу
- Хүний нөөцийн хүрэлцээ, чадавх сул
- Аялалын мэдээллийн дутмаг байдал

- Таксины үйлчилгээ, халаасны хулгай зам тээврийн байдал жуулчдыг аюулгүй байдал, нийтийн бие засах газрын олдоц, ариун цэврийн асуудал
- Жуулчдад визний төлбөр, виз хүсэх явц хүндрэлтэй
- Зам тээвэр, дэд бүтцийн асуудалтай
- Олон улсын нислэг, тээврийн хүрэлцээгүй байдал, нислэгийн үнэ өндөр
- Жуулчны улирлаас шалтгаалсан сул зогсолт ихтэй
- Эвент арга хэмжээ батлагдсан хуваарь байхгүй
- Хууль эрх зүйн орчин, бодлогын тогтворгүй, тодорхойгүй байдал ихтэй

Дараах бүтээгдэхүүн, үйлчилгээний чанарыг сайжруулах нь аялал жуулчлалын салбарын эрсдэлт хүчин зүйлсийг бууруулахад нөлөөтэй болохыг онцолж байна. Үүнд:

**Агаарын тээвэр**

Олон улсын нислэгийн тийзийн үнэ бусад орнуудтай харьцуулахад өндөр байгаа нь Монгол улсын хувьд өрсөлдөөний сул талыг бий болгож байна. Иймд олон улсын нислэгийн салбарт өрсөлдөөнийг нэмэгдүүлж, тийзний үнийг бууруулах арга хэмжээ авах харин дотоодын нислэгийн хувьд цаг хоцрох, нисэх цагийн тодорхойгүй байдал, нислэгийн тоо хэмжээг эрэлтэд тулгуурлан нэмэгдүүлэх зэрэгт анхаарах.

**Визийн үйлчилгээ**

Аялал жуулчлал өндөр хөгжсөн орнууд руу визгүй аялах нь нийтлэг болсон тул аялалын визэнд ач холбогдол өгөх, жуулчид визний төлбөр, виз хүсэх явцыг хүндрэлтэй байдаг гэснээс гадна онлайнаар виз авах боломжийг нэмэгдүүлэхийг онцолжээ.

**Нийтийн үйлчилгээ: бие засах газар, машины зогсоол**

Монгол улсад аялж байгаа гадаадын жуулчдад тулгардаг хамгийн хүндрэлтэй асуудал нь нийтийн бие засах газрын олдоц, ариун цэврийн асуудал байдгийг жуулчдын түүвэр судалгаа онцолсон. Иймээс жуулчдын дайран өнгөрөх амралт, зогсоолын цэгүүдэд нийтийн бие засах газар байгуулах, стандартыг хангах, тогтмол ажиллуулах.

**Дэд бүтэц, замын түгжрэл**

Дэд бүтцийн хөгжил, тэр дундаа авто замын засвар, жуулчны улиралд замын хөдөлгөөн, түгжрэлтэй холбоотой хүндрэлд анхаарах. Халаасны хулгай, таксины үйлчилгээ, зам тээврийн аюулгүй байдал санаа зовоосон гэдгийг судалгаа онцолсон. Мөн үйлчилгээний ажилтнуудын гадаад хэлний мэдлэгийг сайжруулах, аялалын хөтчийг сургах, дадлагажуулах зэрэг болно.

Аялал жуулчлалын салбар нь дотоод төдийгүй гадаад хүчин зүйлийн нөлөөнд өртөмтгий, эмзэг салбар бөгөөд дайн байлдаан, нийтийг хамарсан халдварт өвчин, байгалийн гамшиг, улс төрийн тогтворгүй байдал, эдийн засгийн хямрал, үнийн өсөлт зэрэг нь тус салбарт хүчтэй сөрөг нөлөө үзүүлдэг.

Гэсэн хэдий ч тус салбар нь дэлхий дахинаа ажлын байр бий болгогч хамгийн том салбар юм. Тус салбарт ажиллагсдаас нарийн мэдлэг, ур чадвар, бүтээлч хөдөлмөр шаарддаг бөгөөд дэлхийн хэмжээнд 10 ажлын байр тутмын нэг нь аялал жуулчлалын салбарт хамаардаг бол нэг жуулчин хүлээн авахад 20 ажлын байр идэвхждэг гэсэн тооцоо байдаг байна.[66]

Монгол улсад аялал жуулчлалын салбарын эдийн засгийн үр өгөөжийг нэмэгдүүлэхийн тулд дээр дурдсан бүтээгдэхүүн, үйлчилгээнийхээ чанарыг сайжруулах нь эрсдлийг бууруулах хамгийн чухал хүчин зүйл болж байна.

## 2.5. ДҮГНЭЛТ

Нислэгийн 5 цагийн зайд зохион байгуулагддаг аялал жуулчлалын эвентийн өрсөлдөөний нөхцөл байдлыг өмнөх тайланд дурдсан олон улсын эвентүүдийн судалгааг өргөжүүлж Киргизстан, Казахстан, БНХАУ-ын ӨМӨЗО, Бутаны эвентийг харьцуулан судалж үзсэн. Эдгээр эвентийн болон Монгол улсын боломжит 10 эвентийн хувьд нүүдлийн аялал жуулчлалын бүтээгдэхүүнийг худалдан авсан жуулчны зах зээлд эзлэх хувийг тооцож үзэхэд Киргизстан улсын “World nomad games” ганцаараа 92%-ийг эзэлж байхад Монголын 10 эвент 6.8 хувийг эзэлж байна.

Нүүдлийн соёлын аялал жуулчлалыг сонирхогч жуулчдын зах зээлд өрсөлдөгч эвентүүдийн эзлэх хувь хэмжээг тооцоолж, өрсөлдөөний нөхцөл байдал SWOT шинжилгээ хийснээр зах зээлд эзлэх хувь хэмжээг нэмэгдүүлэх, өрсөлдөөнийг идэвхжүүлэхийн тулд манай улсын нүүдлийн соёлын эвентүүдийг чадавхижуулж олон улсын стандартыг нэвтрүүлэх, нэгдсэн маркетингийн бодлогыг төрөөс илүү идэвхтэй болгох зэрэг арга хэмжээг авч хэрэгжүүлэх шаардлагатай хэмээн дүгнэж байна.

Монгол улсаас 5 цагийн нислэгийн зайд зохион байгуулагдаж буй нүүдлийн эвентийн зах зээлийн хэмжээг тодорхойлоход гадаад жуулчдаас хамгийн их орлого олсон мөн хамгийн олон гадаад жуулчин айлчилсан улс нь Казакстан улс байна. Харин БНХАУ-ын ӨМӨЗО нь гадаад жуулчдын тоогоороо Киргизтан улсын дараа орсон боловч гадаад жуулчдаас олсон орлогоороо хоёрдугаарт эрэмбэлэгдсэн байна.

Зах зээлийн боломжийн шинжилгээ буюу аль зах зээлд хөрөнгө оруулалт хийвэл урт хугацаанд үр ашигтай вэ гэдгийг тооцохын тулд эрэлт, нийлүүлэлтийн дараах хүчин зүйлсүүдийг тооцон үнэлэв.

- Аймгийн өрсөлдөх чадварын индекс
- Нэг хүнд ногдох ДНБ
- Байршуулах хэрэгслийн даац
- Эрэлт буюу тухайн газар орныг зорин очсон жуулчдын тоо

Үнэлгээгээр хамгийн өндөр боломжтой зах зээл нь Улаанбаатар хот, Өмнөговь, Төв, Хэнтий аймгууд байв.

[66] Дэлхийн аялал жуулчлалын байгууллагын тайлан, 2019

Судалгааны багийн зүгээс Монгол улсад зохион байгуулагдах боломжит 10 эвентийг зохион байгуулахтай холбоотой зардал ба шаардлагатай хөрөнгө оруулалтыг тооцох зорилгоор холбогдох аймгуудын аялал жуулчлал хариуцсан мэргэжилтнүүдээс анкет судалгааны арга, цахим уулзалтанд ярилцлагын арга тус тус ашиглаж судалгаа хийлээ.

Боломжит 10 эвентийг 2019 оны байдлаар нийт 3 357 500 000 төгрөг зарцуулан зохион байгуулсан байх бөгөөд эдгээр зардлын 77.4 хувь буюу 2.6 тэрбум төгрөгийг улсын нэгдсэн төсөв болон орон нутгийн төсвөөр санхүүжүүлсэн. Үлдсэн 22.6 хувь болох 759.2 сая төгрөгийн хөрөнгийг санаачлагч аж ахуй нэгж байгууллага, нутгийн иргэдийн хандив тусламж, эвентийн орлогоос буцаан санхүүжүүлсэн байна.

Боломжит 10 эвентийг зохион байгуулах зардлын 86.4 хувийг “Төрийн наадам” зохион байгуулах зардал эзэлж байгаа бол бусад эвентийг зохион байгуулах зардлын 74 хувийг буюу 336.9 сая төгрөгийг төсвийн бус хөрөнгөөр хийж гүйцэтгэжээ.

Боломжит 10 эвентийн хувьд хөрөнгө оруулалт шаардлагатай гэж үзэж буй нийтлэг зүйлсийн хувьд мобайл буюу хөдөлгөөнт кэмпүүдэд хөрөнгө оруулалт хийх, мэдээлэл сурталчилгааны контентийг гадаад хэл дээр бэлтгэн тараахад хөрөнгө оруулалт хийх, мэргэжлийн маркетингийн баг, эвентийн найруулагч ажиллуулах зардалд хөрөнгө оруулалт хийх, мэргэжлийн хөтөч бэлтгэх, тэдгээрийн англи хэлний мэдлэгийг дээшлүүлэх тал дээр хүний нөөцийн нэгдсэн бодлого хэрэгжүүлэхэд гарах зардлыг санхүүжүүлэх, эвентүүдийг илүү мэргэжлийн болгох, гадны жуулчдыг ихээр татах зэрэг ажлуудыг хийж гүйцэтгэх шаардлагатай.

Монгол улсын эвентүүдийг илүү амжилтанд хүргэхийн тулд олон улсын мэргэжлийн холбоодод гишүүнээр элсэх, тэдгээрийн холбогдох дүрэм журам, стандартыг нэвтрүүлэх шаардлагатай гэж үзэж байна.

Судалгааны үр дүнгээс үзэхэд аялал жуулчлалын эвентийг хөгжүүлэхэд үйлчилгээний чанар, хүний нөөцийн хүрэлцээ, аялал жуулчлалын мэдээллийн дутмаг байдал, таксины үйлчилгээ, халаасны хулгай, зам тээвэр дэд бүтцийн байдал, жуулчдын аюулгүй байдал, нийтийн бие засах газрын олдоц, ариун цэврийн асуудал, жуулчдын визний хүндрэл, олон улсын нислэгийн хүрэлцээгүй, үнэ өндөр байдаг зэрэг олон эрсдэлт хүчин зүйлсийг нэрлэж байна.

# ГУРАВ. ЭРСДЛИЙГ БУУРУУЛАХ ТӨЛӨВЛӨГӨӨ, ЗӨВЛӨМЖ

## 3.1. ЭВЕНТИЙН ЭРСДЛИЙГ БУУРУУЛАХ ТӨЛӨВЛӨГӨӨ

### 3.1.1 Эрсдэл, түүний ангилал

**Эрсдэл гэж юу вэ?**

Олон улсын стандарт "ISO 31000"-д эрсдлийг "Зорилгод тодорхойгүй байдлын үзүүлэх нөлөө" гэж тодорхойлсон байна. Энгийн үгээр эрсдэл нь тухайн эвентээс хүлээж байсан үр дүнгээс бодит байдал зөрөх магадлал юм.

Эрсдлийг тодорхойлох 2 арга байдаг[67].

1. Эрсдлийн жагсаалттай тулгах: Тухайн салбарт түгээмэл учирдаг эрсдлүүдийг жагсаана.
2. Мэргэжилтнүүдийн мэдлэгийг ашиглах: Төслийн хэсэг бүр дээр тухайн чиглэлийн мэргэжилтнүүдээс зөвлөгөө авах.

Эрсдлийн хүчин зүйлсийг нарийвчлан авч үзэхдээ аливаа төсөлд учрах нийтлэг эрсдэл болон салбарын онцлогоос хамаарсан эрсдлийн хүчин зүйл, эвент зохион байгуулахтай холбоотой эрсдэл гэж 3 хувааж авч үзэв.

**1. Нийтлэг эрсдэл**

**Эрсдлийг эх сурвалжаар нь ангилсан нь:**

- Техникийн-Хөгжим, техник хэрэгсэл, машин тээврийн хэрэгсэл ажиллахгүй байх;
- Зардлын- Төлөвлөсөн хэмжээнээс их зардал гарах;
- Цагийн хуваарийн- Сайн төлөвлөөгүйгээс эвент хуваарийн дагуу явагдахгүй байх;
- Гэрээ-гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлэхгүй байх, гэрээнд заагаагүй нөхцөл байдал үүсэх;
- Цаг агаар- Цаг агаар муудах;
- Санхүүгийн-Санхүүгийн дутагдалд орох, зардлаа нөхөж чадахгүй байх;
- Улс төрийн-Улс төрийн нөхцөл байдал;
- Хууль эрх зүй- Аливаа бодлого, шийдвэр, зохицуулалт;
- Байгалийн-ган, зуд болох, гал түймэр, газар хөдлөх;
- Хүмүүс-нутгийн иргэд ба жуулчдын дунд таагүй байдал бий болох
- Гэмт хэрэг аюулгүй байдал- нийгмийн мөргөлдөөн, дайн, терроризм, зохион байгуулалттай гэмт хэрэг, хүний наймаа, мөнгө болон баримт бичгээ хулгайд алдах

**Үйл ажиллагааны үе шатаас хамааруулж ангилсан нь:**

- Төлөвлөлтийн үе шат;

[67] Төр хувийн хэвшлийн түншлэлийн гарын авлага (2013), Эдийн засгийн хөгжлийн яам

- Зохион байгуулалтын үе шат;
- Эвент зохион байгуулсны дараах үе шат

**Үүсэн гарах байдлаар нь:**

**Гадаад эрсдэл**

- Вальютын ханшийн эрсдэл
- Улс төрийн эрсдэл гэх зэрэг
- Зах зээлийн эрсдэл
- Өрсөлдөөний эрсдэл

**Дотоод эрсдэл**

- Хүний нөөцийн эрсдэл
- Техникийн эрсдэл гэх мэт

**Аялал жуулчлалын салбарын эрсдэл**

- Үзвэр үйлчилгээтэй холбоотой гарч болох эрсдэл- Бэлтгэн нийлүүлэгчийн эрсдэл, жуулчдын оролцоотой тэмцээний үеэр жуулчин бэртэж гэмтэх, эвентийн хөтөлбөр жуулчдын сонирхлыг татахгүй байх зэрэг;
- Байрлах хангамжийн асуудал, байрны чанар стандарт, угаалгын өрөөний аюулгүй байдал, ариун цэвэр байдал;
- Тээвэр- Замын дэд бүтцийн хангамжийн асуудал, дотоод тээврийн аюулгүй байдал, жолоочийн хариуцлага
- Хоол- Хоолны чанар,
- Ариун цэвэртэй холбоотой эрсдлүүд;
- Хүний нөөц- Хамтран ажилладаг хувь хүн, албан байгууллагын найдвартай байдал, шаардлага хангаагүй хөтөч, орчуулагч, менежерээс үүсч болох эрсдэл;
- Жуулчин- Эрэлтийн талын эрсдлүүдийг оруулж болно. Сурталчилгаа явуулах, жуулчид татахтай холбоотой эрсдлүүд

**Эвент зохион байгуулахтай холбоотой эрсдэл**

- Орчны
- Зохион байгуулалтын
- Эрэлтийн
- Нийлүүлэлтийн

Дээрх эрсдлүүд болон түүний ангилал дээр тулгуурлан аялал жуулчлалын эвентийн эрсдлийг дараах байдлаар ангиллаа.

### Хүснэгт 3. 1 Аялал жуулчлалын эвентийн эрсдлийн ангилал

| |
|---|
| 1. **Орчны эрсдэл**<br>- Хууль эрх зүй – Аливаа бодлого, шийдвэр, зохицуулалт<br>- Байгаль – ган, зуд болох, гал түймэр, газар хөдлөх<br>- Эдийн засгийн байдал муудах, эдийн засгийн уналт болох<br>- Цаг агаарын байдал, гэнэтийн нөхцөл байдал үүсэх<br>- Нийгмийн мөргөлдөөн, дайн, терроризм<br>- Зам тээвэр, дэд бүтэц<br>- Малын гоц халдварт өвчин гарах<br>- Нийгмийн халдварт өвчин, цар тахал<br>- Гэмт хэрэг – оролцогчид хулгайд эд зүйлээ алдах, өртөх гэх мэт<br>- Хүрээлэн байгаа орчны доройтол, болзошгүй бусад эрсдэл |
| 2. **Үйл ажиллагааны эрсдэл**<br>- Жуулчдыг татах, маркетингийн арга хэмжээ<br>- Эвентийн хөтөлбөртэй холбоотой эрсдэл<br>- Зардал, үр ашгийн тооцоо<br>- Эвентийн зохион байгуулалттай холбоотой эрсдэл<br>- Техник, тоног төхөөрөмжтэй холбоотой эрсдэл<br>- Ажилтнуудын аюулгүй байдал, эрүүл мэндийн эрсдэл<br>- Оролцогчдын аюулгүй байдал, эрүүл мэндийн эрсдэл<br>- Хамтрагч байгууллагын найдвартай байдал<br>- Байрны хангамж, хүрэлцээ<br>- Байрны чанарын шаардлага<br>- Хоолны хангамж, хүрэлцээ<br>- Хоолны чанарын шаардлага<br>- Ариун цэврийн өрөөний асуудал<br>- Хүний нөөцийн бэлэн байдал<br>- Хүний нөөцийн чадвар, чадамж<br>- Худалдаа, арилжаатай холбоотой эрсдэл |

### 3.1.2 Эрсдлийн үнэлгээ хийх

Аливаа эрсдлийг шинжлэх нь эрсдлийн талаарх ойлголтыг нэмэгдүүлж түүнийг хэрхэн удирдаж, болзошгүй эрсдлээс сэргийлж, эрсдэл тохиоход түүнийг хохирол багатай даван гарахад тусалдаг.

Эрсдлийн шинжилгээний зорилго нь эрсдлийн мөн чанар, түүний шинж байдал, эрсдлийн түвшинг тодорхойлж, ойлгоход оршино. Эрсдлийн шинжилгээнд тодорхойгүй байдал, эрсдлийн эх үүсвэр, үр дагавар, болзошгүй тохиолдол, хувилбар, хяналт болон тэдгээрийн үр нөлөөг нарийвчлан авч үзэх шаардлагатай тулгардаг.

Эрсдлийн шинжилгээг зорилго, мэдээллийн хүртээмж, найдвартай байдал, байгаа нөөцөөс хамааран янз бүрийн түвшинд хийж болно. Шинжилгээний арга нь нөхцөл байдал, ашиглах зориулалтаас хамааран чанарын, тоон эсвэл эдгээрийн хослол байж болно.

Эрсдлийн шинжилгээнд дараах хүчин зүйлийг харгалзан үзнэ.

Үүнд:

- Тохиолдлын ба үр дагаврын болзошгүй байдал;
- Үр дагаврын мөн чанар, давтамж;
- Нарийн төвөгтэй байдал болон хоорондын хамаарал;
- Цаг хугацаатай холбоотой хүчин зүйлс, хэлбэлзэл;

- Хэрэгжиж байгаа үйл ажиллагааны үр нөлөө;
- Мэдрэмж ба итгэлтэй байдлын түвшин зэрэг болно.

Эрсдлийн шинжилгээ нь эрсдлийг бууруулах шаардлагатай эсэх, хэрхэн бууруулах оновчтой стратеги, аргуудыг сонгох шийдвэр гаргахад тусална.

- Чанарын үнэлгээ нь үр дагавар, магадлалын хослолоор илэрхийлэгдэх "их", "дунд", "бага" гэсэн тодорхой түвшингээр эрсдлийн түвшин, магадлал, үр дагаврыг тодорхойлж, чанарын шалгуураар эрсдлийн хэмжээг үнэлнэ.
- Тоон шинжилгээний аргаар үр дагавар ба түүний магадлалын бодит хэмжээг тооцоолох ба нөхцөл байдлыг тодорхойлох үед тогтоосон тусгай нэгжээр эрсдлийн түвшинг хэмжинэ. Тоон шинжилгээгээр шинжилж буй тохиолдолд тогтолцоо буюу үйл ажиллагааны талаар хангалттай мэдээлэл, өгөгдөл байхгүй, хүний хүчин зүйлийн нөлөөнөөс болж эсвэл тоон шинжилгээ баталгаагүй, шаардлагагүй зэргээс шалтгаалаад хүссэн үр дүн гарахгүй байж болно.

Эрсдлийн үнэлгээ нь нэмэлт арга хэмжээ шаардлагатай эсэхийг тодорхойлохын тулд эрсдлийн шинжилгээний үр дүнд тогтоосон эрсдлийн шалгуур үзүүлэлтүүдтэй харьцуулахыг хэлнэ.

Энэ нь дараах шийдвэрийг гаргахад хүргэж болно.

Үүнд:

- Цаашид юуг ч хэрэгжүүлэхгүй;
- Эрсдлийг бууруулах сонголтыг авч үзэх;
- Эрсдлийг илүү сайн ойлгохын тулд нэмэлт шинжилгээ хийх;
- Одоо байгаа хяналтыг хадгалах;
- Зорилгоо эргэн харах зэрэг болно.

Эрсдлийг дүгнэх гэдэгт эрсдлийн төрөл ба түвшиний ач холбогдлыг тодорхойлох үүднээс нөхцөл байдлыг үнэлэх үед тогтоосон эрсдлийн шалгууртай эрсдлийн тооцсон түвшинг харьцуулдаг. Эрсдлийг дүгнэхдээ цаашид авах арга хэмжээний дараах шийдвэрүүд гарна:

- Эрсдэлд арга хэмжээ авах шаардлагатай эсэх;
- Нэн чухал арга хэмжээ;
- Үйл ажиллагааг явуулах эсэх;
- Хэд хэдэн арга замыг хэрэгжүүлэх эсэх зэрэг багтана.

Эрсдлийг үнэлсний эцэст дараах 3 бүлэгт хуваадаг:

- Эрсдлийн түвшин үл хүлцэх хэмжээнд байсан ч үйл ажиллагаанаас ямар ч байсан үр ашиг гарна гээд эрсдлийн арга хэмжээ маш чухал гэсэн ***дээд бүлэг***;
- Боломжууд болон зардал, үр ашгийг тооцоод болзошгүй үр дагавартай тэнцэнэ гэж үзэх ***дунд бүлэг***;
- Эрсдлийн түвшин ялихгүй эсвэл маш бага хэмжээнд учир эрсдлийн арга хэмжээ шаардлагагүй гэж үзэх ***доод бүлэг*** гэсэн гурван түвшин байна.

Аялал жуулчлалын эвентийн үйл ажиллагааны эрсдлийг шинжилж, үнэлэлт, дүгнэлт гаргахад зардал үр ашгийн шинжилгээ хийх зайлшгүй шаардлагатай гэж судлаачдын багийн зүгээс үзэж байна. Зардал үр ашгийн шинжилгээ хийх аргачлалыг тухайлан авч үзэх хэрэгтэй.

**Зардал, үр ашгийн шинжилгээ**

Зардал, үр ашгийн шинжилгээг хамгийн сайн, хамгийн ашигтай хувилбарыг сонгохын тулд нийт хүлээгдэж буй зардлын хэмжээг нийт хүлээгдэж буй ашигтай харьцуулж тооцож эрсдлийг дүгнэхэд хэрэглэж болно. Энэ нь эрсдлийг бууруулах зайлшгүй хэсэг юм. Энэ шинжилгээ нь чанарын болон тоон эсвэл тоон ба чанарын хосолсон хэлбэртэй байж болно.

**Зардал, үр ашгийн шинжилгээ** нь зардал, ашиг бий болсон янз бүрийн цаг хугацааны хамрах хүрээнд оролцсон бүх оролцогч талуудын нийт зардал, ашгийг мөнгөн дүнгээр нэгтгэж гаргана.

$$\boldsymbol{NPV} = \sum_{t=1}^{n} \frac{\boldsymbol{R_t}}{(\boldsymbol{1} + \boldsymbol{i})^{t}}$$

NPV-Цэвэр өнөөгийн үнэ цэнэ

$\boldsymbol{R_t}$-t хугацаан дахь цэвэр мөнгөний урсгал (орлого-зардал)

i-Дискаунтын хүү

Аялал жуулчлалын эвентийн үйл ажиллагаатай холбоотой эерэг **өнөөгийн цэвэр өртөг** нь үйл ажиллагаа хэвийн гэдгийг илэрхийлнэ. Өөрөөр хэлбэл ирээдүйд олох өнөөгийн үнэ цэнээр хэмжигдсэн орлогоос өнөөгийн үнэ цэнээр илэрхийлэгдсэн зардлыг хасахад эерэг үр дүн гарч байгаа нь та зөв шийдвэр гаргасныг илэрхийлнэ.

Түүнчлэн ашиг зардлын харьцааг ашиглаж болно. Хэрэв зардал буюу ашгийн түвшингийн талаар тодорхой бус байдал байвал аль нэгийг нь эсвэл хоёуланг нь тэдгээрийн магадлалаар нь хэмжиж болно.

$$\text{BCR}=\frac{PV_{benefit}}{PV_{cost}}$$

BCR- ашиг, зардлын харьцаа

$PV_{benefit}$- Ирээдүйд олох ашгийн өнөөгийн үнэ цэнэ

$PV_{cost}$- - Ирээдүйд гарах нийт зардлын өнөөгийн үнэ цэнэ

Аялал жуулчлалын эвентийн үйл ажиллагааны явцад хүний амь нас эрсдэх, байгаль орчинд хор учруулах зэрэг сөрөг эрсдэл үүсэж болзошгүй тул эрсдлийн шинжилгээ хийх шаардлагатай.

Эрсдлийг гурван бүсэд хуваана: эрсдэл бага, бодит байдалд байх боломжтой гэж үзэх дунд хэсэг, түүний дээд талд онцгой нөхцөл байдалд ч хүлээн зөвшөөрөхгүй хүлцэж үл болох сөрөг эрсдлийн түвшин болон дунд түвшингийн доод талд зөвхөн хяналт тавих шаардлагатай үл ялиг буюу бага эрсдлийн түвшин байна.

Эрсдлийг бага, доогуур түвшинд оруулахын тулд нягт нямбай зардал үр ашгийн шинжилгээ хийж болох боловч эрсдэл нь үл хүлцэх түвшинтэй ойрхон байвал хэрэгжүүлэх арга хэмжээ авах зардал, олох ашиг хоорондын харьцаа их хэмжээний зөрүүтэй байхаас хамаарахгүйгээр арга хэмжээг авна.

Зардал үр ашгийн шинжилгээ нь ашиг хүртэх болон зардалтай хамааралтай байж болох оролцогч талуудыг бас тодорхойлно. Зардал үр ашгийн шинжилгээнд бүх оролцогч талууд оролцоно. Бүх холбогдох оролцогч талуудад хамаарах шууд ба шууд бус ашиг болон зардлыг тодорхойлно.

Шууд ашиг нь үйл ажиллагааны эхнээс шууд гардаг бол шууд бус буюу туслах ашиг нь тохиолдлын чанартай боловч шийдвэрт мэдэгдэхүйц нөлөөтэй байж чадна. Шууд бус ашгийн жишээ бол нэр хүнд дээшлэх, оролцогчдын сэтгэл ханамж нэмэгдэх зэргээр илэрч болох юм.

Шууд зардал нь үйл ажиллагаатай холбогдон шууд гарах зардал юм. Шууд бус зардал нь ашиглалтын алдагдал, менежментийн замбараагүй байдал, бусад боломжтой хөрөнгө оруулалтыг алдсанаас үүссэн хөрөнгийн зөрүү гэх мэт нэмэлт, туслах болон эргэн төлөгдөхгүй зардал юм.

Эрсдлийн арга хэмжээ авах эсэх талаар шийдвэр гаргахад зардал үр ашгийн шинжилгээг хийхдээ эрсдлийг авч үзэх, эрсдлийн арга хэмжээнд хамаарах зардал ба үр ашгийг багтааж тооцох хэрэгтэй.

Хэрвээ богино хугацаа (тухайлбал 1 жилийн дотор)-д зардал гарч, үүнээс хойш урт хугацаанд ашиг олох нөхцөл байдал үүссэн бол ашгийг бууруулж “өнөөдрийн мөнгө”-ний хэмжээнд хүргэх шаардлагатай, тиймээс бодитой харьцуулалтыг хийх хэрэгтэй байдаг. Бүх зардал ба ашгийг өнөөгийн өртгөөр илэрхийлнэ. Бүх зардлын өнөөгийн өртөг болон бүх оролцогч талууд дахь бүх ашгийг нэгтгэж өнөөгийн цэвэр өртгийг гаргана.

Зардал үр ашгийн шинжилгээ нь дараах давуу талтай:

- Нэг хэмжигдэхүүнээр (мөнгө) зардал ба ашгийг харьцуулах боломжтой;
- Шийдвэр гаргалтад ил тод нээлттэй байдлыг бий болгоно;
- Шийдвэрийн бүхий л боломжтой асуудлуудаар нарийвчилсан мэдээлэл цуглуулахыг шаардана. Энэ нь мэдэгдээгүй зүйлийг илрүүлэх түүнчлэн мэдлэг ур чадварыг харилцан солилцоход ач холбогдолтой.

Зардал үр ашгийн шинжилгээ нь дараах хязгаарлалтуудтай:

- Зардал үр ашгийн шинжилгээгээр эдийн засгийн бус ашигт ажиллагаанаас хамаараад илт өөр өөр тоо гарч болно;
- Зарим тохиолдолд ирээдүйн зардал, үр ашгийн хувьд бодитой хөнгөлөлт үзүүлэх хувь хэмжээг тодорхойлоход хүндрэлтэй байна;
- Энэ аргыг зах зээл дээр солилцож болдоггүй бараанд хэрэглэж байгаа тохиолдолд хүн амд оногдох ашгийг нь тооцоход хүндрэлтэй байдаг.

**Аялал жуулчлалын эвентийн эрсдлийг үнэлэх нь**

Судлаачдын багаас эрсдлийн үнэлгээний заавар, шалгуур үзүүлэлт болон эрсдлийн үнэлгээний хуудас *(Үнэлгээний хуудас болон шалгуур үзүүлэлтийг хавсралтаас үзнэ үү)* боловсруулан сонгогдсон 10 эвентийн 9 эвент зохион

байгууллагчтай холбоо тогтоож эрсдлийн үнэлгээний хуудас илгээснээс 7 эвентийн зохион байгуулагчийн үнэлгээний хуудсыг хүлээн авч эрсдлийн үнэлгээг хүснэгт 4.2-т харуулсан эрсдлийн матрицын дагуу хийснийг хүснэгт 4.3-аар харуулав. Ингэхэд нийт дүнгээр эвентийг төлөвлөх үеийн эрсдэл нь зохион байгуулалтын үеийхээс учрах магадлал их. Харин зохион байгуулалтын дараах үед эрсдэл гардаггүй гэсэн хариултыг өгсөн юм.

Судалгаа илгээсэн эвентийн нэрс:

1. Монгол төрийн их наадам
2. Монгол туургатаны язгуур соёлын олон улсын их наадам
3. Улаанбаатарын өвлийн наадам
4. “Хийморь” морьт харваа, морин тулааны фестиваль
5. Хонины найр
6. Талын түмэн адуу
7. Түмэн тэмээний баяр

### Хүснэгт 3. 2 Эрсдлийн матриц

| | | **Үр дагавар** | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | | **Ач холбогдол бага** | **Бага хэмжээний** | **Дундаж хэмжээний** | **Их хэмжээний** | **Аюултай** |
| **Тохиох магадлал** | | 1 | 2 | 3 | 4 | 5 |
| Маш өндөр | 5 | Дундаж | Өндөр | Өндөр | Маш өндөр | Маш өндөр |
| Өндөр | 4 | Дундаж | Дундаж | Өндөр | Өндөр | Маш өндөр |
| Боломжтой | 3 | Бага | Дундаж | Дундаж | Өндөр | Маш өндөр |
| Бага боломжтой | 2 | Бага | Дундаж | Дундаж | Өндөр | Өндөр |
| Маш бага | 1 | Бага | Бага | Дундаж | Дундаж | Өндөр |

*Эх сурвалж: Event risk assesment guidelines, Australia*

Дээрх эрсдлийн матриц дээр үндэслэн эрсдлийн түвшинг тогтоож доорх хүснэгтээр харуулав.

## *Хүснэгт 3. 3* Эвентийн эрсдлийн үнэлгээний үр дүн

| | | | Эрсдэл | 1.Хийморь морьт харваа | 2. УБ өвлийн наадам | 3. Төрийн наадам | 4. Монгол туургатаны язгуур соёлын олон улсын их | 5.Талын түмэн адуу | 6. Түмэн тэмээний баяр | 7. Хонины найр |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| 1 | | | **ТӨЛӨВЛӨЛТИЙН ҮЕ ШАТ** | | | | | | | |
| | 1.1 | | **Орчны эрсдэл** | | | | | | | |
| | | 1 | Хууль эрх зүй- Аливаа бодлого, шийдвэр, зохицуулалт | Дундаж | Өндөр | Өндөр | Бага | Өндөр | Дундаж | Дундаж |
| | | 2 | Байгаль-ган, зуд болох, гал түймэр, газар хөдлөх | Маш бага | Бага | Бага | Бага | Дундаж | Маш өндөр | Өндөр |
| | | 3 | Эдийн засгийн байдал (уналт) | | Дундаж | Дундаж | Бага | Дундаж | Бага | Бага |
| | | 4 | Цаг агаарын байдал | | Өндөр | | Бага | Дундаж | | Өндөр |
| | | 5 | Нийгмийн мөргөлдөөн, дайн, терроризм | | Бага | Дундаж | | | Маш өндөр | Бага |
| | | 6 | Зам тээвэр, дэд бүтэц | Өндөр | Өндөр | Дундаж | Дундаж | Дундаж | | Бага |
| | | 7 | Малын халдварт өвчин | Бага | Бага | Өндөр | | Дундаж | маш өндөр | Маш өндөр |
| | | 8 | Нийгмийн гоц халдварт өвчин | Маш өндөр | Маш өндөр | Өндөр | Өндөр | Өндөр | Маш өндөр | Маш өндөр |
| | | 9 | Гэмт хэрэг- Оролцогчид хулгайд эд зүйлээ алдах г.м | Бага | Бага | | Бага | Дундаж | Бага | Бага |
| | | 10 | Хүрээлэн байгаа орчны доройтолд хүргэж болзошгүй эрсдэл | Бага | Бага | | | Дундаж | | Бага |
| | 2.1 | | **Үйл ажиллагааны эрсдэл** | | | | | | | |
| | | 1 | Жуулчдыг татах, маркетингийн арга хэмжээ | Бага | Бага | Дундаж | Дундаж | Дундаж | | Өндөр |
| | | 2 | Эвентийн хөтөлбөртэй холбоотой эрсдэл | | | Дундаж | | Дундаж | | Дундаж |
| | | 3 | Зардал, үр ашгийн тооцоо | Өндөр | Өндөр | Өндөр | Бага | Дундаж | Дундаж | Дундаж |
| | | 5 | Эвентийн зохион байгуулалттай холбоотой эрсдэл | | | Бага | | Дундаж | Дундаж | Дундаж |
| | | 6 | Техник, тоног төхөөрөмжийн эрсдэл | | Дундаж | Дундаж | Маш өндөр | Дундаж | | Дундаж |
| | | 8 | Ажилтнуудын аюулгүй байдал, эрүүл мэндийн эрсдэл | | Бага | Өндөр | | Бага | Дундаж | Дундаж |
| | | 9 | Оролцогчдын аюулгүй байдал, эрүүл мэндийн эрсдэл | | Бага | Өндөр | | Дундаж | Маш өндөр | Дундаж |
| | | 11 | Хамтрагч байгууллагын найдвартай байдал | | | | | Бага | Дундаж | Бага |
| | | 12 | Байрны хангамж, хүрэлцээ | | | | Өндөр | Дундаж | Дундаж | Дундаж |
| | | 13 | Байрны чанарын шаардлага | | | Дундаж | Бага | Дундаж | | Дундаж |
| | | 14 | Хоолны хангамж, хүрэлцээ | | | Бага | | Бага | Дундаж | Бага |
| | | 15 | Хоолны чанарын шаардлага | | | Бага | | Бага | | Дундаж |
| | | 16 | Ариун цэврийн өрөөний асуудал | | | Бага | Дундаж | Дундаж | Маш өндөр | Өндөр |
| | | 17 | Хүний нөөцийн бэлэн байдал | | | Бага | | Бага | | Дундаж |
| | | 18 | Хүний нөөцийн чанар | | | | | Бага | | Дундаж |
| | | 19 | Худалдаа наймаатай холбоотой эрсдэл | | | | Бага | Дундаж | | Дундаж |
| 2 | | | **ЗОХИОН БАЙГУУЛАЛТЫН ҮЕ ШАТ** | | | | | | | |
| | 2.1 | | **Орчны эрсдэл** | | | | | | | |
| | | 1 | Хууль эрх зүй- Аливаа бодлого, шийдвэр, зохицуулалт | | | Бага | | Дундаж | Дундаж | Бага |
| | | 2 | Байгаль-ган, зуд болох, гал түймэр, газар хөдлөх | Өндөр | Өндөр | Дундаж | | Дундаж | Маш өндөр | Өндөр |
| | | 3 | Эдийн засгийн байдал (уналт) | | | | | Бага | Бага | Бага |
| | | 4 | Цаг агаарын байдал | | Өндөр | Дундаж | Дундаж | Дундаж | | Өндөр |
| | | 5 | Нийгмийн мөргөлдөөн, дайн, терроризм | | | | | | Маш өндөр | Бага |
| | | 6 | Зам тээвэр, дэд бүтэц | | Өндөр | Бага | | Бага | | Бага |
| | | 7 | Малын халдварт өвчин | | | Дундаж | | Дундаж | Маш өндөр | Дундаж |
| | | 8 | Нийгмийн гоц халдварт өвчин | Маш өндөр | Маш өндөр | Дундаж | | Бага | Маш өндөр | Маш өндөр |
| | | 9 | Гэмт хэрэг- Оролцогчид хулгайд эд зүйлээ алдах г.м | | Бага | Дундаж | | Бага | Бага | Дундаж |
| | | 10 | Хүрээлэн байгаа орчны доройтолд хүргэж болзошгүй эрсдэл | | | Дундаж | | Бага | | Бага |
| | 2.2 | | **Үйл ажиллагааны эрсдэл** | | | | | | | |
| | | **1** | Гадаад, дотоодын жуулчдын оролцоо бага байх | Бага | Бага | Дундаж | | Бага | | Дундаж |
| | | 2 | Эвентийн хөтөлбөртэй холбоотой эрсдэл | | | Дундаж | | Бага | | Дундаж |
| | | 3 | Санхүү, зардал үр ашгийн тооцоо | | Бага | Дундаж | | Бага | Дундаж | Бага |
| | | 5 | Эвентийн зохион байгуулалттай холбоотой эрсдэл | | Бага | Бага | Өндөр | Дундаж | Дундаж | Дундаж |
| | | 6 | Техник, тоног төхөөрөмжийн эрсдэл | | Өндөр | | Маш өндөр | Бага | | Өндөр |
| | | 7 | Ажилтнуудын аюулгүй байдал, эрүүл мэндийн эрсдэл | | | Бага | | Бага | Дундаж | Дундаж |
| | | 8 | Оролцогчдын аюулгүй байдал, эрүүл мэндийн эрсдэл | | | Бага | | Дундаж | Маш өндөр | Дундаж |
| | | 9 | Хамтрагч байгууллагын найдвартай байдал | | | | | Дундаж | Дундаж | Дундаж |
| | | 10 | Байрны хангамж, хүрэлцээ | | | Дундаж | | Бага | Дундаж | Дундаж |
| | | 11 | Байрны чанарын шаардлага | | | Дундаж | | Дундаж | | Дундаж |
| | | 12 | Хоолны хангамж, хүрэлцээ | | | | | Бага | Дундаж | Бага |
| | | 13 | Хоолны чанарын шаардлага | | | Өндөр | | Дундаж | | Бага |
| | | 14 | Ариун цэврийн өрөөний асуудал | | | Дундаж | | Дундаж | Маш өндөр | Дундаж |
| | | 15 | Хүний нөөцийн бэлэн байдал | | | | | Бага | | Дундаж |
| | | 16 | Хүний нөөцийн чанар | | | | | Бага | | Дундаж |
| | | 17 | Худалдаа наймаатай холбоотой эрсдэл | | | Дундаж | | Бага | | Дундаж |

*Эх сурвалж: Судалгааны үр дүн*

Төлөвлөлтийн, зохион байгуулалтын 2 үе шатанд эрсдэлүүдийг ямар байдлаар үнэлснийг нийт эвентийн хувьд тоон байдлаар доорх хэсэгт харуулъя. Ингэхдээ тухайн нэг эрсдлийг үнэлэхдээ эвент тус бүрд эрсдлийн тохиолдох магадлалыг түүний үр дагавраар үржүүлж нийт эвентийн арифметик дунджаар гаргаж харуулав.

### Хүснэгт 3. 4 Төлөвлөлтийн үе шатны орчны эрсдэлүүд ба тэдгээрийн үнэлгээ

| | Эрсдлийн бүлэг | Эрсдэл | Эрсдлийн үнэлгээ |
|---|---|---|---|
| 1 | Бага | Хүрээлэн байгаа орчны доройтолд хүргэж болзошгүй эрсдэл | 1.50 |
| 2 | | Гэмт хэрэг- Оролцогчид хулгайд эд зүйлээ алдах г.м | 1.67 |
| 3 | Дунд | Эдийн засгийн байдал (уналт) | 2.50 |
| 4 | | Нийгмийн мөргөлдөөн, дайн, терроризм | 5.00 |
| 5 | | Цаг агаарын байдал | 6.14 |
| 6 | | Зам тээвэр, дэд бүтэц | 6.86 |
| 7 | Их | Хууль эрх зүй- Аливаа бодлого, шийдвэр, зохицуулалт | 8.00 |
| 8 | | Байгаль-ган, зуд болох, гал түймэр, газар хөдлөх | 8.83 |
| 9 | | Малын халдварт өвчин | 9.17 |
| 10 | | Нийгмийн гоц халдварт өвчин | 19.14 |
| | | Нийт | 68.81 |

*Эх сурвалж: Эвентийн эрсдлийн үнэлгээний судалгааны үр дүн*

Хүснэгтээс харахад хамгийн их эрсдэлтэй нь “Нийгмийн гоц халдварт өвчин”, “Малын халдварт өвчин” орсон байна. Харин хамгийн бага оноотой нь “Хүрээлэн байгаа орчны доройтолд хүргэж болзошгүй эрсдэл” орж байгаа нь эдгээр эвентүүд ихэнхи нь байгальд ээлтэйгээр зохион байгуулагдаж байна гэсэн үг юм.

### Хүснэгт 3. 5 Төлөвлөлтийн үе шатны үйл ажиллагааны эрсдэлүүд ба тэдгээрийн үнэлгээ

| | Эрсдлийн бүлэг | Эрсдэл | Эрсдлийн үнэлгээ |
|---|---|---|---|
| 1 | Бага | Хоолны чанарын шаардлага | 1.00 |
| 2 | | Худалдаа наймаатай холбоотой эрсдэл | 1.33 |
| 3 | | Хүний нөөцийн чанар | 1.50 |
| 4 | | Хүний нөөцийн бэлэн байдал | 1.83 |
| 5 | | Хоолны хангамж, хүрэлцээ | 2.00 |
| 6 | | Хамтрагч байгууллагын найдвартай байдал | 2.00 |
| 7 | | Эвентийн хөтөлбөртэй холбоотой эрсдэл | 2.67 |

| | | | |
|---|---|---|---|
| 8 | | Байрны чанарын шаардлага | 3.67 |
| 9 | Дунд | Эвентийн зохион байгуулалттай холбоотой эрсдэл | 3.83 |
| 10 | | Жуулчдыг татах, маркетингийн арга хэмжээ | 4.14 |
| 11 | | Байрны хангамж, хүрэлцээ | 4.14 |
| 12 | | Ажилтнуудын аюулгүй байдал, эрүүл мэндийн эрсдэл | 4.50 |
| 13 | | Техник, тоног төхөөрөмжийн эрсдэл | 7.14 |
| 14 | Их | Ариун цэврийн өрөөний асуудал | 7.67 |
| 15 | | Оролцогчдын аюулгүй байдал, эрүүл мэндийн эрсдэл | 8.33 |
| 16 | | Зардал, үр ашгийн тооцоо | 8.33 |
| | | Нийт | 64.08 |

*Эх сурвалж: Эвентийн эрсдлийн үнэлгээний судалгааны үр дүн*

Төлөвлөлтийн үе шатны үйл ажиллагааны эрсдэлүүдээс хамгийн их анхаарах нь зүйтэй эрсдэл нь “Оролцогчдын аюулгүй байдал, эрүүл мэндийн эрсдэл” ба “Зардал, үр ашгийн тооцоо” орж байна. Харин хамгийн эцэст нь анхаарах эрсдэл нь 1 үнэлгээтэй “Хоолны чанарын шаардлага”, эвент дээр зохион байгуулагдах “худалдаа наймаа”тай холбоотой эрсдэлүүд орж байна. Энэ нь нэг талаар тухайн эрсдэлүүдийг эвент зохион байгуулагчдын ихэнхи нь эрсдэл хуваах тактик ашиглан өөрсөө зохион байгуулдаггүйтэй холбоотой байж болно.

Нийт төлөвлөлтийн үе шатны эрсдэлүүдээс зайлшгүй анхаарч авах шаардлагатай буюу 8 ба түүнээс дээш үнэлгээ авсан эрсдэлүүдийг жагсаавал нэгдүгээрт “Нийгмийн гоц халдварт өвчин”, хоёрдугаарт “Малын халдварт өвчин”, гуравдугаарт “Байгаль-ган, зуд болох, гал түймэр, газар хөдлөх”, дөрөв болон тавдугаарт “Оролцогчдын аюулгүй байдал, эрүүл мэндийн эрсдэл” ба “Зардал, үр ашгийн тооцоо”, зургадугаарт “Хууль эрх зүй- Аливаа бодлого, шийдвэр, зохицуулалт” тус тус багтаж байна.

### Хүснэгт 3. 6 Зохион байгуулалтын үе шатны орчны эрсдэлүүд ба тэдгээрийн үнэлгээ

| | Эрсдлийн бүлэг | Эрсдэл | Эрсдлийн үнэлгээ |
|---|---|---|---|
| 1 | | Эдийн засгийн байдал (уналт) | 0.67 |
| 2 | | Хүрээлэн байгаа орчны доройтолд хүргэж болзошгүй эрсдэл | 1.57 |
| | Бага | | |
| 3 | | Хууль эрх зүй- Аливаа бодлого, шийдвэр, зохицуулалт | 2.43 |
| 4 | | Зам тээвэр, дэд бүтэц | 2.57 |

| | | | |
|---|---|---|---|
| 5 | | Гэмт хэрэг- Оролцогчид хулгайд эд зүйлээ алдах г.м | 3.00 |
| 6 | Дунд | Нийгмийн мөргөлдөөн, дайн, терроризм | 3.71 |
| 7 | | Малын халдварт өвчин | 6.00 |
| 8 | | Цаг агаарын байдал | 6.29 |
| 9 | Их | Байгаль-ган, зуд болох, гал түймэр, газар хөдлөх | 8.57 |
| 10 | | Нийгмийн гоц халдварт өвчин | 14.86 |
| | | Нийт | 49.67 |

*Эх сурвалж: Эвентийн эрсдлийн үнэлгээний судалгааны үр дүн*

Хүснэгтээс харахад зохион байгуулалтын үе шатанд нйигмийн гоц халдварт өвчин, байгалийн үзэгдэлээс бусад орчны эрсдэл харьцангүй бага байна.

### Хүснэгт 3. 7 Зохион байгуулалтын үе шатны үйл ажиллагааны эрсдэлүүд ба тэдгээрийн үнэлгээ

| | Эрсдлийн бүлэг | Эрсдэл | Эрсдлийн үнэлгээ |
|---|---|---|---|
| 1 | | Хүний нөөцийн бэлэн байдал | 1.43 |
| 2 | | Хүний нөөцийн чанар | 1.43 |
| 3 | | Хоолны хангамж, хүрэлцээ | 1.57 |
| 4 | Бага | Худалдаа наймаатай холбоотой эрсдэл | 1.71 |
| 5 | | Хоолны чанарын шаардлага | 1.86 |
| 6 | | Байрны чанарын шаардлага | 2.43 |
| 7 | | Хамтрагч байгууллагын найдвартай байдал | 2.43 |
| 8 | | Гадаад, дотоодын жуулчдын оролцоо бага байх | 2.43 |
| 9 | | Эвентийн хөтөлбөртэй холбоотой эрсдэл | 2.43 |
| 10 | | Санхүү, зардал үр ашгийн тооцоо | 2.83 |
| 11 | | Байрны хангамж, хүрэлцээ | 3.29 |
| 12 | Дунд | Ажилтнуудын аюулгүй байдал, эрүүл мэндийн эрсдэл | 5.57 |
| 13 | | Оролцогчдын аюулгүй байдал, эрүүл мэндийн эрсдэл | 5.57 |
| 14 | | Ариун цэврийн өрөөний асуудал | 6.00 |

| | | | |
|---|---|---|---|
| 15 | | Эвентийн зохион байгуулалттай холбоотой эрсдэл | 6.00 |
| 16 | Их | Техник, тоног төхөөрөмжийн эрсдэл | 9.17 |
| | | Нийт | 56.15 |

*Эх сурвалж: Эвентийн эрсдлийн үнэлгээний судалгааны үр дүн*

Зохион байгуулалтын үеийн үйл ажиллагааны эрсдэлд хамгийн өндөр эрсдэлтэй нь техник, тоног төхөөрөмжийн эрсдэл байгаа бол удаах эрсдлүүдэд ажилтнууд болон оролцогчдын аюулгүй байдал, эрүүл мэндийн эрсдэл, ариун цэврийн өрөөний асуудал, эвент зохион байгуулахтай холбоотой эрсдлүүд орсон байна.

Нийт зохион байгуулалтын үе шатны эрсдлүүдээс зайлшгүй анхаарах шаардлагатай буюу 8 ба түүнээс дээш үнэлгээтэй эрсдлүүдийг жагсаавал нэгдүгээрт "Нийгмийн гоц халдварт өвчин", хоёрдугаарт "Техник, тоног төхөөрөмжийн эрсдэл", гуравдугаарт "Байгаль-ган, зуд болох, гал түймэр, газар хөдлөх" тус тус орж байна.

Төлөвлөлтийн үе шатанд орчны эрсдэл зохион байгуулалтын үеийхээс хамаагүй их байдаг бол үйл ажиллагааны эрсдэл төлөвлөлт болон зохион байгуулалтын үед бараг ижилхэн байгаа нь эрсдлийн үнэлгээний судалгааны үр дүнгээс харагдаж байна.

Одоо харин эвент бүрээр хамгийн өндөр оноо авсан эрсдлүүдийг танилцуулъя. *(8-аас дээш үнэлгээ авсан эрсдлүүдийг оруулсан)*

## Хүснэгт 3. 8 Эвент бүр дээрх хамгийн өндөр үнэлэгдсэн эрсдлүүд

| № | Эвентийн нэр | Төлөвлөлтийн үе шат | | Зохион байгуулалтын үе шат | |
|---|---|---|---|---|---|
| | | **Орчны** | **Үйл ажиллагааны** | **Орчны** | **Үйл ажиллагааны** |
| **1** | **Монгол төрийн их наадам** | • Хууль эрх зүй (12)<br>• Малын халдварт өвчин (12)<br>• Нийгмийн гоц халдварт өвчин (12) | • Ажилтнуудын аюулгүй байдал, эрүүл мэндийн эрсдэл (12)<br>• Оролцогчдын аюулгүй байдал, эрүүл мэндийн эрсдэл (12)<br>• Байрны чанарын шаардлага (9)<br>• Зардал, үр ашгийн тооцоо (8) | • Хүрээлэн байгаа орчны доройтолд хүргэж болзошгүй эрсдэл (9)<br>• Гэмт хэрэг- Оролцогчид хулгайд эд зүйлээ алдах (9) | • Эвентийн хөтөлбөртэй холбоотой эрсдэл (9)<br>• Байрны хангамж, хүрэлцээ (9)<br>• Байрны чанарын шаардлага (9)<br>• Хоолны чанарын шаардлага (8) |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| 2 | **Монгол туургатаны язгуур соёлын олон улсын их наадам** | • Нийгмийн гоц халдварт өвчин (10)<br>• Зам тээвэр, дэд бүтэц (10) | • Техник, тоног төхөөрөмжийн эрсдэл (25)<br>• Байрны хангамж, хүрэлцээ (25) | - | • Техник, тоног төхөөрөмжийн эрсдэл (25)<br>• Эвентийн зохион байгуулалттай холбоотой эрсдэл (12) |
| 3 | **Улаанбаатарын өвлийн наадам** | • Нийгмийн гоц халдварт өвчин (25)<br>• Зам тээвэр, дэд бүтэц (16)<br>• Цаг агаарын байдал (8)<br>• Хууль эрх зүй (8) | • Зардал, үр ашгийн тооцоо (12)<br>• Техник, тоног төхөөрөмжийн эрсдэл (9) | • Нийгмийн гоц халдварт өвчин (25)<br>• Цаг агаарын байдал (16)<br>• Зам тээвэр, дэд бүтэц (12) | • Техник, тоног төхөөрөмжийн эрсдэл (16) |
| 4 | **“Хийморь” морьт харваа, морин тулааны фестиваль** | • Нийгмийн гоц халдварт өвчин (25)<br>• Зам тээвэр, дэд бүтэц (12) | • Зардал, үр ашгийн тооцоо (12) | • Нийгмийн гоц халдварт өвчин (25) | - |
| 5 | **Хонины найр** | • Нийгмийн гоц халдварт өвчин (25)<br>• Малын халдварт өвчин (20)<br>• Цаг агаарын байдал (16)<br>• Байгаль-ган, зуд болох, гал түймэр, газар хөдлөх (16) | • Ариун цэврийн өрөөний асуудал (16)<br>• Жуулчдыг татах, маркетингийн арга хэмжээ (12)<br>• Эвентийн зохион байгуулалттай холбоотой эрсдэл (9)<br>• Оролцогчдын аюулгүй байдал, эрүүл мэндийн эрсдэл (9)<br>• Байрны чанарын шаардлага (9)<br>• Хүний нөөцийн бэлэн байдал (9)<br>• Хүний нөөцийн чанар (8) | • Нийгмийн гоц халдварт өвчин (25)<br>• Байгаль-ган, зуд болох, гал түймэр, газар хөдлөх (16)<br>• Цаг агаарын байдал (16)<br>• Гэмт хэрэг- Оролцогчид хулгайд эд зүйлээ алдах (9)<br>• Малын халдварт өвчин (9) | • Техник, тоног төхөөрөмжийн эрсдэл (12)<br>• Гадаад, дотоодын жуулчдын оролцоо бага байх (9)<br>• Эвентийн зохион байгуулалттай холбоотой эрсдэл (9)<br>• Оролцогчдын аюулгүй байдал, эрүүл мэндийн эрсдэл (9)<br>• Ариун цэврийн өрөөний асуудал (9)<br>• Хүний нөөцийн бэлэн байдал (9) |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| | | | | | • Хүний нөөцийн чанар (9) |
| 6 | **Талын түмэн адуу** | • Хууль эрх зүй (12)<br>• Нийгмийн гоц халдварт өвчин (12)<br>• Байгаль-ган, зуд болох, гал түймэр (9)<br>• Цаг агаарын байдал (9) | - | - | - |
| 7 | **Түмэн тэмээний баяр** | • Байгаль-ган, зуд болох, гал түймэр (25)<br>• Нийгмийн гоц халдварт өвчин (25)<br>• Малын халдварт өвчин (25)<br>• Нийгмийн мөргөлдөөн, дайн терроризм (25)<br>• Хууль эрх зүй (9) | • Оролцогчдын аюулгүй байдал, эрүүл мэндийн эрсдэл (25)<br>• Ариун цэврийн өрөө (25)<br>• Хамтрагч байгууллагын найдвартай байдал (9)<br>• Байрны хангамж, хүрэлцээ (9)<br>• Хоолны хангамж, хүрэлцээ (9)<br>• Зардал үр ашгийн тооцоо<br>• Эвентийн зохион байгуулалттай холбоотой эрсдэл (9)<br>• Ажилтнуудын аюулгүй байдал, эрүүл мэндийн эрсдэл (9) | • Нийгмийн гоц халдварт өвчин (25)<br>• Малын халдварт өвчин (25)<br>• Нийгмийн мөргөлдөөн, дайн, терроризм (25)<br>• Байгаль-ган, зуд болох, гал түймэр, газар хөдлөх (25)<br>• Хууль эрх зүй (9) | • 25 үнэлгээтэй Оролцогчдын аюулгүй байдал, эрүүл мэндийн эрсдэл (25)<br>• Ариун цэврийн өрөөний асуудал (25)<br>• Санхүү, зардал үр ашгийн тооцоо (9)<br>• Эвентийн зохион байгуулалттай холбоотой эрсдэл (9)<br>• Ажилтнуудын аюулгүй байдал, эрүүл мэндийн эрсдэл (9)<br>• Хамтрагч байгууллагын найдвартай байдал (9)<br>• Байрны хангамж, хүрэлцээ (9)<br>• Хоолны хангамж, хүрэлцээ (9) |

*Эх сурвалж: Эвентийн эрсдлийн үнэлгээний судалгааны үр дүн*

### 3.1.3 Эрсдэл бууруулах төлөвлөгөө

Аливаа эрсдлийг удирдахад дараах 4 техник өргөн хэрэглэдэг. Үүнд:

1. Эрсдлээс зайлсхийх
2. Эрсдлийг хуваах/шилжүүлэх

3. Эрсдлийг бууруулах
4. Эрсдлийг хүлээн зөвшөөрөх

**Эрсдлээс зайлсхийх:** Үүнд амжилт олох магадлал өндөртэй боловч зардал өндөртэй  алтернатив хувилбарыг боловсруулах ордог. Хамгийн өргөн хэрэглэгддэг эрсдлээс зайлсхийх техник бол өртөг зардал хэмнэх шинэ технологи нэвтрүүлэхийн оронд нэгэнт туршигдсан, хэрэглээнд нэвтэрсэн технологийг хэрэглэх. Жишээ нь олон улсад өөрийн улс орны дүр төрх нэр хүндийг дээшлүүлэх, дэлхийн аялал жуулчлалын салбарт өөрийн гэсэн байр суурь эзлэх маркетингийн компанит ажил явуулах ажлыг төлбөр өндөр боловч туршлагатай, олон улсын компанид даатгах нь туршлага бага, зардал хямд дотоодын компанид даатгаснаас амжилт олох магадлал өндөртэй, үр дүн богино хугацаанд гарах магадлалтай юм.

**Эрсдлийг хуваах/шилжүүлэх:** Үйл ажиллагаандаа бусад хамтрагч талыг татан оролцуулж эрсдлийг хуваарилах. Даатгалд хамрагдах нь эрсдлийг шилжүүлэх аргын нэг юм. Олон улсын төсөл дээр ажиллаж байгаа олон компаниуд төсөлтэй холбоотой улс төрийн, хуулийн, ажиллах хүчний эрсдлээ бууруулахын тулд дотоодын компанитай хамтарсан үйлдвэр байгуулдаг. Ингэснээр эрсдэл, үр ашгаа хамтран үүрэлцдэг. Үүний нэг жишээ бол төр, хувийн хэвшлийн хамтрал байж болно. Тухайн үйл ажиллагаанд туршлагатай хувийн компаниар төрийн хариуцаж буй төслийг гүйцэтгүүлснээр эрсдлээ хувааж байгаа юм. Эрсдэл хуваарилалтын зарчим нь Эрсдлээс хамгийн сайн сэргийлж чадах талд эрсдлийг хуваарилах ба Ингэснээр тухайн эрсдлийг хариуцсан тал эрсдэл тохиох магадлалыг бууруулахын тулд өөрийн боломж бололцоогоо дайчлах сонирхлыг төрүүлнэ гэж Төр хувийн хэвшлийн түншлэлийн гарын авлагад (2013) дурдсан байна.

**Эрсдлийг бууруулах:** Энэ нь үүсч болзошгүй эрсдлийг бууруулах зорилготой арга хэмжээ авч хэрэгжүүлэхийг хэлнэ. Нэг арга нь хөрөнгө оруулалтын сан юм. Олон улсын төсөл дээр вальютын ханшийн эрсдлийг бууруулахын тулд вальютын ханшийн баталгаа худалдан авдаг. Эвент зохион байгуулах туршлагатай мэргэжилтэн ажиллуулах нь эрсдэл бууруулах бас нэг арга байдаг.

**Эрсдлийг хүлээн зөвшөөрөх**: Үүсэн гарах эрсдлийг мэдэж байгаа ч хэрэгжүүлэхээр шийдэх гэсэн үг юм. Эрсдлийг эвентийн нэр хүндэд нөлөөлөхгүйгээр удирдаж болох үед хэрэглэнэ.

### Хүснэгт 3. 9 Эрсдлийн тохиох магадлал, ү дагаварт харгалзах эрсдэл бууруулах арга хэмжээ

| Эрсдлийн үнэлгээ | Эрсдлийн бууруулах арга хэмжээ |
|---|---|
| **Тохиох магадлал өндөр, бага үр дагавартай** | Эрсдлийг бууруулах |
| **Тохиох магадлал өндөр, өндөр үр дагавартай** | Эрсдлээс зайлсхийх |
| **Тохиох магадлал бага, бага үр дагавартай** | Эрсдлийг хүлээн зөвшөөрөх |

| | |
|---|---|
| **Тохиох магадлал бага, өндөр үр дагавартай** | Эрсдлийг шилжүүлэх |

*Эх сурвалж: Монголбанк, Эрсдэл ба хэрэглэгчийн эрх ашгийн хамгаалалт*

### Хүснэгт 3. 10 Эрсдлийн түвшинд харгалзах эрсдэл бууруулах арга хэмжээ

| Эрсдлийн түвшин | Эрсдлийг бууруулах арга хэмжээ |
|---|---|
| Маш өндөр | Зохион байгуулагчдын зүгээс хариу арга хэмжээ авах нэн шаардлагатай. Эрсдлийг хянах хяналтын арга хэмжээ авч хэрэгжүүлнэ.<br>• Тухайн эрсдлийг үүсэхээс сэргийлж үйл ажиллагаанаасаа хасах<br>• Эрсдлийг дахин үнэлж хүлээж авах түвшинд байгаа эсэх, бууруулах арга  хэмжээ авах эсэх шийдвэр гаргах |
| Өндөр | Эрсдлийг хянах хяналтын арга хэмжээ авч хэрэгжүүлнэ.<br>• Эрсдлийг бууруулах төлөвлөгөөг сайжруулах.<br>• Алтернатив хөтөлбөр, үйл ажиллагаа, арга зүйг заавал боловсруулсан байх |
| Дундаж | Тодорхой эрсдэл бууруулах стратеги хэрэгтэй. Эрсдлийг хянах хяналтын арга хэмжээг авч хэрэгжүүлэх. Оролцогчид болон ажилтнуудын ажлын байрны, эрүүл мэндийн, аюулгүй байдлын талаарх төлөвлөгөөтэй байх. |
| Бага | Үйл ажиллагааны ердийн түвшинд удирдаж болно. Нэмэлт арга хэмжээ хэрэггүй. |

*Эх сурвалж: AICST, Introduction to Risk Management in Tourism*

Аялал жуулчлын эвентийн үйл ажиллагааны эрсдлийг бууруулах зорилго нь эрсдлийг тохиолдох магадлалыг бууруулахад чиглэсэн боломжит хувилбарыг сонгох, хэрэгжүүлэхэд оршино. Эрсдлийг бууруулах арга хэмжээ нь **байнгын, тогтвортой, давтамжтай** хийгдэх шаардлагатай бөгөөд ингэхдээ дараах үйл явцыг хамаарна.

Үүнд:
- Эрсдлийг бууруулах сонголтуудыг боловсруулж, санал болгох;
- Эрсдлийг бууруулах арга хэмжээг төлөвлөх, хэрэгжүүлэх;
- Тухайн эрсдлийг бууруулах арга хэмжээний үр нөлөөг үнэлэх;
- Эрсдлийг хүлээн зөвшөөрч үлдээх эсэхийг шийдэх;
- Хүлээн зөвшөөрөх боломжгүй бол бууруулах, шаардлагатай бол зогсоох, арга хэмжээг үргэлжлүүлэх зэргийг хамарна.

**Эрсдлийг бууруулах төлөвлөгөө боловсруулах үйл явц**

Аялал жуулчлалын эвентийн үйл ажиллагааны үр өгөөжийг нэмэгдүүлэхийн  тулд түүнд учирч болзошгүй эрсдлийг олж тогтоох, түүнийг шинжлэх, үнэлэх, эрсдлийг бууруулах арга техник, төлөвлөгөөтэй байх нь зайлшгүй шаардлагатай юм.

Эрсдлийг бууруулах хамгийн оновчтой хувилбарыг сонгох нь эвентийн зохион байгуулах зардал, хүчин чармайлт, сул талуудыг тэнцвэржүүлэх явдал юм.

Зохион байгуулж буй эвентийн үйл ажиллагаа, санхүү, эдийн засгийн тооцоолол, эвентэд оролцогчдын тоо зэрэг хүлээгдэж байснаас зөрөх тохиолдол учирч болзошгүй гэж үзэн хариу магадлалыг бууруулах арга хэмжээ авахыг эрсдлийг бууруулах төлөвлөгөө гэж нэрлэж болно.

Аялал жуулчлалын эвентийн эрсдлийг бууруулах төлөвлөгөө боловсруулахдаа дараах алхамуудын дагуу гаргасан.

### Зураг 3. 1 Эрсдэл бууруулах төлөвлөгөө боловсруулах алхам[68]




Хамгийн түрүүнд ямар эрсдэл учирч болохыг олж тогтооно. Дараа нь эрсдлийг тохиох магадлал, үзүүлэх нөлөөгөөр нь үнэлнэ. Үүний дараагаар хэрхэн эрсдлийг бууруулж болох талаар эрсдэл бууруулах төлөвлөгөө гаргана.

Аялал жуулчлалын эвентийн эрсдлийг бууруулах арга хэмжээний сонголтыг тухайн үйл ажиллагааны зорилго, шалгуур, боломжит нөөцийн хүрээнд хийх шаардлагатай болно. Ингэхдээ эрсдлийг бууруулах хувилбаруудыг сонгохдоо тухайн эвентийг зохион байгуулагч байгууллага нь оролцогч талуудын үнэ цэнэ, ойлголт, боломжит оролцоо, тэдэнтэй харилцах, зөвлөлдөх хамгийн тохиромжтой арга хэлбэрийг харгалзан үзэх хэрэгтэй.

---
[68] *Эх сурвалж: Gordon Shaw, M. Saayman, A. Saayman (2012)*

Ижил үр дүнтэй зарим эрсдлийг бууруулах арга хэмжээ нь бусад оролцогчдоос илүүтэйгээр зарим оролцогч талуудад илүү тохиромжтой байж болно.

**Эвентийн эрсдлийг бууруулах төлөвлөгөөг хэрэгжүүлэх арга хэмжээ: Шалгах хуудас**

Эвентийн эрсдлийг бууруулах төлөвлөгөөг хэрэгжүүлэх арга хэмжээний шалгах хуудсыг зохион байгуулагч бүр, эвент бүрийн тухайд боловсруулж, хэрэгжүүлэх нь зүйтэй юм.

Эвентийн үйл ажиллагааны эрсдлийг бууруулах төлөвлөгөөнд эрсдлийг бууруулах арга хэмжээг хэрэгжүүлэх дараалдлыг тодорхой зааж өгнө. Эрсдлийг бууруулах төлөвлөгөө, менежмент, хэрэгжүүлэх үйл явцыг зохих оролцогч талуудтай зөвлөлдсөний үндсэн дээр эвентийн үйл ажиллагааг зохион байгуулагч байгууллага нэгтгэн гаргана. Эвентийн эрсдлийг бууруулах төлөвлөгөөг хэрэгжүүлэх арга хэмжээний шалгах хуудсанд дараах байдлаар тусгана.

Үүнд:

- Арга хэмжээний хувилбарыг сонгох үндэслэл, түүний дотор хүлээгдэж буй үр өгөөжийг хэрхэн тооцсоноо гаргах;
- Төлөвлөгөөг баталж, хэрэгжүүлэх үүрэгтэй, хариуцлагатай ажилтныг томилох;
- Санал болгож буй арга хэмжээнүүдийг нэг бүрчлэн бичих;
- Шаардлагатай нөөц, түүний дотор болзошгүй нөхцөл байдлын жагсаалтыг гаргах;
- Гүйцэтгэлийн хэмжүүрүүдийг тогтоох;
- Хязгаарлалтууд юу болохыг гаргах;
- Шаардлагатай тайлан болон мониторинг хийх;
- Арга хэмжээг авч эхлэх ба дуусгах хугацааг товлох зэрэг болно.

### 3.1.4 Эрсдлийг хянах

Эвентийн үйл ажиллагааны эрсдлийг бууруулах арга хэмжээг хэдийгээр сайтар төлөвлөж, хэрэгжүүлсэн ч хүлээж байсан үр дүнд хүрэхгүй эсвэл урьдчилан хараагүй үр дагавар бий болж болзошгүй юм. Арга хэмжээний төрөл бүрийн хэлбэрүүд үр дүнтэй хэвээр байх баталгааг хангахын тулд мониторинг, дүн шинжилгээ нь эрсдлийг бууруулах арга хэмжээний салшгүй хэсэг болдог.

Аялал жуулчлалын эвентийн үйл ажиллагааны эрсдлийг бууруулах арга хэмжээний хүрээнд удирдах шаардлагатай шинэ эрсдлийг илрүүлж болно. Хэрэв бууруулах арга хэмжээний хувилбар байхгүй эсвэл хувилбар нь эрсдлийг хангалттай хэмжээгээр өөрчилж чадахгүй тохиолдолд эрсдлийг бүртгэж, байнгын хяналтад байлгана.

Шийдвэр гаргагч болон бусад оролцогч талууд эвентийн үйл ажиллагааны эрсдлийг бууруулах арга хэмжээний дараа үлдсэн эрсдлийн мөн чанар, цар

хүрээг мэдэж, таньсан байх нь чухал юм. Үлдсэн эрсдэлд мониторинг, дүн шинжилгээ хийж шаардлагатай тохиолдолд бууруулах арга хэмжээнд цаашид хамруулна.

## 3.2. АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН ЭВЕНТИЙГ САЙЖРУУЛАХ ТАЛААР ЗӨВЛӨМЖ

### 3.2.1 Олон улсад эвент зохион байгуулахад тавих шаардлага,стандартууд:

Олон улсад аялал жуулчлалын салбарт мөрдөгддөг хэд хэдэн стандартууд байх боловч эвентэд чиглэсэн гол стандарт бол ISO20121 буюу “Эвентийн тогтвортой удирдлагын тогтолцоо” гэсэн нэртэй стандарт байдаг. Анх Их Британи улс, Лондонгийн олимпийн наадмыг зохион байгуулах эрх авсаны дараа аливаа эвентийг зохион байгуулах тодорхой албан ёсны стандарт гэж байхгүй байна гэж үзээд BS8901 гэсэн стандартаа гаргасан байдаг. Олимпийн дараа ийм төрлийн стандарт Европ, Америк даяар хэрэгцээтэй байсан учраас энэхүү стандартыг үндэслээд ISO20121 буюу “Эвентийн тогтвортой удирдлагын тогтолцоо”-г гаргасан байна.

Энэхүү стандарт нь тухайн эвентийн менежментийн үйл ажиллагаа бүрт тогтвортойгоор хэрэгжүүлэх загвар ба эвентээ төлөвлөхөөс эхлээд алхам бүрт хэрэгжүүлэх боломжтой арга замыг заасан байдаг.[69] Тогтвортой гэдгийг эдийн засгийн үйл ажиллагаа, хүрээлэн буй орчны хариуцлагатай байдал, нийгмийн дэвшил зэргийг тэнцвэржүүлэхийг тогтвортой байдал гэж үзэж байна.

Энэ стандарт нь рок концертоос эхлээд Олимпын наадам хүртэл том, жижиг гэхгүй бүх л эвентэд хэрэглэж болно. Уг стандартыг эвент зохион байгуулагчид, эвент эзэмшигчид, ажиллах хүч, нийлүүлэлтийн сүлжээ, оролцогчид, үзэгчид, зохицуулагч байгууллагууд гэх мэт эвентэд хамааралтай бүхий л оролцогч талуудад хамааралтай. Энэхүү стандартаар эвентийн цар хүрээг тодорхойлохоос эхлээд зорилго, зорилт, үнэ цэнэ, бэрхшээл, боломжийг тодорхойлох, төлөвлөгөө гаргах, үүрэг хариуцлага, талуудын оролцооны талаар ч стандартжуулсан байдаг.

ISO стандарт нэвтрүүлэхийн давуу тал нь эрсдлээ бууруулж, гадаад жуулчдыг татахад ихээхэн нөлөөлнө гэж үзэж байна. Мэдээж тодорхой хэмжээний зардал, мөнгө гаргаж байж уг стандартыг нэвтрүүлнэ.

ISO 20121:2012 нь аливаа төрлийн арга хэмжээ эсвэл эвенттэй холбоотой үйл ажиллагаанд зориулсан эвентийн тогтвортой байдлын удирдлагын тогтолцоонд тавигдах шаардлагуудыг тодорхойлж, эдгээр шаардлагыг биелүүлэх зааварчилгаа өгдөг.

ISO 20121:2012 нь дараах зүйлийг хийхийг хүссэн аливаа байгууллагад хамаарна.[70] Үүнд:

---

[69] https://www.glasgow.gov.uk/CHttpHandler.ashx?id=16655&p=0
[70] https://www.iso.org/standard/54552.html

- Эвентийн тогтвортой байдлын удирдлагын тогтолцоог бий болгох, хэрэгжүүлэх, хадгалах, сайжруулах;
- Өөрийн төлөвлөсөн эвентийг тогтвортой хөгжлийн бодлогод нийцэж байгаа эсэхийг баталгаажуулах;
- ISO 20121:2012 стандартад сайн дурын үндсэн дээр нийцэж буйг
  - Эхний тал (өөрийгөө тодорхойлох, өөрөө мэдүүлэх),
  - Хоёрдогч этгээд (үйлчлүүлэгч гэх мэт байгууллагад ашиг сонирхол бүхий талууд, эсвэл тэдний нэрийн өмнөөс бусад хүмүүс нийцэж байгааг баталгаажуулах) нотлох,
  - Эсвэл бие даасан гуравдагч этгээд (жишээлбэл, баталгаажуулалтын байгууллага) тодорхойлоход хэрэглэх юм.

ISO 20121:2012 нь эвентийн менежментийн бүх мөчлөгийн туршид тогтвортой байдлын менежментийг сайжруулахад зориулагдсан болно.

ISO 20121 нь танаас дараах зүйлийг шаарддаг.

- Эвентийн менежментийн үйл ажиллагаатай холбоотой асуудлаа тодорхойлох:
- Тогтвортой байдлын талаарх амлалтаа тогтвортой байдлын бодлогын хэлбэрээр тодорхойлох;
- Тогтвортой байдалтай холбоотой SMART зорилго, зорилтуудыг боловсруулах;
- Ажилчдаа тогтвортой байдлын талаар сургах;
- Тогтвортой байдлын талаар ханган нийлүүлэгчдээ татан оролцуулах;
- Тогтвортой байдлын харилцааны төлөвлөгөө боловсруулах;
- Амжилтаа хянаж, хэмжих;
- Баримт бичгээ шалгаж, аудит хийлгэх зэрэг болно.

Манай улсын хувьд аялал жуулчлалтай холбоотой цөөн тооны стандарт байх бөгөөд тэдгээр нь байршуулах газрын стандарт гэх мэттэй холбоотой байх бөгөөд тусгайлан эвентийн үйл ажиллагаатай холбоотой стандарт гэж байхгүй байна. Зарим улс орнуудын хувьд улсын, мужийн, нийтийн эзэмшлийн газар, талбай, нөөц, хэрэгсэл ашиглах эсхүл Аялал жуулчлалын байгууллагаас нь гаргах жагсаалтад эвентийн нэрээ оруулахын тулд тодорхой шаардлагуудыг хангасан байх ёстой ба үүний тулд эвентээ хэрхэн зохион байгуулах, юун дээр анхаарах гэх мэт мэдээллүүдийг багтаасан заавар, аргачлал гаргасан байх тохиолдлууд байна.

Тухайлбал, Австрали улсын Чарльз Стурт хот эвент зохион байгуулагчдад зориулсан зааварчилгаа болох “Event information kit”-ийг гаргасан байх ба энэхүү гарын авлагад эрүүл ахуй, орчны аюулгүй байдал, галын аюулгүй байдал, анхны тусламж, хүнсний аюулгүй байдал, 00, тээвэрлэлт, таних тэмдэг, цэвэрлэгээ, хог хаягдал, усны талаар хүртэл мэдээллүүдийг агуулсан байна.

Манай улсын хувьд ийм төрлийн заавар зааварчилгаа зохион байгуулагчид болоод гадаад, дотоодын жуулчдад дутагдаж байдаг.

### 3.2.2 Монгол улсын эвентүүдийн оролцогч талуудын судалгаа

Эвент зохион байгуулах онол, арга зүйн хүрээнд Монгол улсад зохион байгуулагдаж байгаа эвентүүдийг судалсаны үр дүнд дараах оролцогч талуудыг тодорхойлж байна. Үүнд:

1.Төрийн захиргааны байгууллага
2.Орон нутгийн захиргаа
3.Эвент зохион байгуулагч
4.Эвентэд жуулчнаа оролцуулагч буюу хэрэглэгч тур оператор
5.Эвент болох газрын нутгийн иргэд
6.Хамтран зохион байгуулагчид
7.Мэргэжлийн судлаачид
8.Гадаадын жуулчид, дотоодын аялагч

Эдгээр байгууллага, хувь хүмүүсийн эвентэд оролцож буй оролцоогоор нь дараах байдлаар ангилж болохоор байна.

**Хүснэгт 3. 11 Монгол улсын эвентүүлийн зохион байгуулагч талууд**

| № | Оролцогч талууд /Гүйцэтгэх үүргээр/ | Эвентэд гүйцэтгэх үүрэг |
|---|---|---|
| 1 | **Ивээн тэтгэгч** | Эвентийн зардлыг бүтэн болон хэсэгчилж санхүүжүүлсэн боловч зохион байгуулах үйл ажиллагаанд биечлэн оролцдоггүй тал |
| 2 | **Үндсэн зохион байгуулагч** | Эвентийн зардлыг гаргаж, зохион байгуулалтыг хангаж буй тал |
| 3 | **Хамтран зохион байгуулагч** | Эвентийн зардлыг хамтран гаргаж буй, зохион байгуулалтанд хамтран оролцож буй тал |
| 4 | **Гүйцэтгэгч тал** | Эвентийг бүтэн болон хэсэгчилэн зохион байгуулах үйл ажиллагааг хийж тодорхой хөлсөөр гүйцэтгэж буй байгууллага, хувь хүмүүс |
| 5 | **Дэмжигч тал** | Эвентийн зохион байгуулах зардлыг мөнгөөр бус бусад бараа бүтээгдэхүүн, үйлчилгээгээр /бартер/ туслаж буй байгууллага, хувь хүмүүс |
| 6 | **Хэрэглэгч** | Эвентийг зөвхөн үзэх, ажиглах төдийгүй биечлэн оролцож буй байгууллага, хувь хүмүүс үүнд багтана. Дотроо дараах төрлүүдтэй:<br>- Гадаадын жуулчид<br>- Дотоодын аялагчид |

- Нутгийн иргэд, байгууллагууд
- Аялалын хөтөлбөр борлуулагч байгууллага, хүмүүс

Энэхүү төслийн судалгааны ажлын хүрээнд орон нутгийн болоод нийслэлийн аялал жуулчлалын мэргэжилтнүүд, эвент зохион байгуулагч компани, ТББ-уудын дунд нийт 100 эвентийн талаарх мэдээллийг нэгтгэн дүгнэж гаргасан билээ.

### Хүснэгт 3. 12. Монгол улсын эвентүүдийн зохион байгуулагч талуудын төрөл

| Эвент зохион байгуулагчдийн төрөл | | | | | |
|---|---|---|---|---|---|
| БОАЖЯ, АЖХТ, НЗДТГ, НАЖГ | Орон нутгийн захиргаа /ЗДТГ, БОАЖГ/ | ТББ, Холбоод, ОУ-ын байгууллагууд | Жуулчны бааз, амралтын газар | Тур оператор компани | Нутгийн иргэд, байгууллага |
| **8** | **46** | **19** | **14** | **9** | **4** |

Эдгээр эвент зохион байгуулагч талуудын 54% нь төрийн захиргааны байгууллагууд байгаа бөгөөд нийт эвентийн 43%-ийг 2 ба түүнээс дээш оролцогч талууд хамтран зохион байгуулж байна. Эдгээр мэдээллийг графикаар харуулбал дараах байдалтай байна.

### График 3. 1 Монгол улсын эвент зохион байгуулагчдын төрөл




Харин эдгээр эвентүүдийн зохион байгуулагч талууд аялал жуулчлалын улирлын оргил үед /high season/ нийт эвентүүдийг 52%-ийг зохион байгуулсан байна. Иймд дээрх байгууллагуудад аялал жуулчлалын бус улирал /off season/ болон завсарын үеүүдэд /middle season 1, 2/ аль болох эвентүүдээ зохион байгуулбал аялал жуулчлалын улирлыг уртасгах чухал ач холбогдолтой хэмээн судалгааны багаас дүгнэж байна.

**Хүснэгт 3. 13 Эвентүүдийн зохиогдох хугацаа**

| High season | Middle season-1 | Off season | Middle season-2 |
|---|---|---|---|
| **HS**<br>**/6,7,8-р сарууд/** | **MS-1**<br>**/5,9,10-р сарууд/** | **OS**<br>**/12,1,2-р сарууд/** | **MS-2**<br>**/3,4,11-р сарууд/** |
| **52** | **18** | **17** | **13** |

**График 3. 2 Эвентүүдийн зохиогдох хугацаа**




### 3.2.3 Эвент зохион байгуулах, оролцоход үүсч буй хүндрэл, бэрхшээлүүд

Манай судалгааны баг энэхүү судалгааг хийхийн тулд аялал жуулчлалын эвент зохион байгуулдаг, эвентэд жуулчидаа оролцуулдаг аялал жуулчлалын компани, аж ахуйн нэгжүүд болон нийслэл, аймгийн БОАЖГ-ын мэргэжилтнүүдийг оролцуулсан түүвэр судалгааг хийсэн. Энэхүү судалгаагаар эвентэд оролцоход, зохион байгуулахад гардаг түгээмэл хүндрэл бэрхшээл, эвентийн үйл ажиллагааг сайжруулахад юуг анхаарах, ямар төрлийн тусламж, дэмжлэг шаардлагатай байгаа талаар асуултууд тавьж, холбогдох хариултыг авсан.

Түүнчлэн Монголбанкаас 2019 онд “Аялал жуулчлалын өнөөгийн байдал, шийдвэрлэх асуудлууд” сэдэвт түүвэр судалгааг хийсэн ба уг судалгаанд гадны 1500 орчим жуулчин, 34 тур операторуудыг хамруулан салбарын тулгамдсан асуудлуудыг тодорхойлж, бодлого боловсруулагчдад хүргэх зорилготой байсан.

Эдгээр судалгаануудын хүрээнд судалгаанд оролцогчдын хувьд үүссэн хүндрэл, бэрхшээл, мөн бидний судалгааны хүрээнд оролцогчидтой хийсэн

фокус бүлгийн ярилцлагын үеэр дурдагдсан хүндрэл бэрхшээлийн талаар энд тоймлон харуулж байна.

Монголбанкны хийсэн түүвэр судалгаагаар, ерөнхийдөө гадны жуулчид Монголд аяласан сэтгэл ханамж маш сайн байсан гэж судалгаанд оролцогчдын 38 хувь, дунджаас арай дээгүүр буюу дунд зэрэг гэж 56 хувь үлдсэн 6 хувь нь дунджаас доогуур, маш муу байсан гэсэн хариултыг өгсөн байдаг.

Ингэхдээ газрын тээвэр, хоол, байр сууц, үйлчилгээний ажилтан, тур операторын ажлын гүйцэтгэл зэрэгт шүүмжлэлтэй хандсан зүйлүүд байна. [71]

Мөн уг судалгаагаар жуулчид МУ-д ирэхээс өмнө тулгардаг бэрхшээлүүдэд тухайн хэл дээрх мэдээлэл олдоц багатай (ялангуяа БНСУ, БНХАУ, Япон, Герман, Франц зэрэг орны жуулчид ингэж хариулжээ), тийзний үнэ өндөр, мэдээлэл дутмаг байдаг, хариу өгөхгүй уддаг гэх мэт бэрхшээлүүдийг дурдсан байна.

МУ-д аялахад ямар хүндрэл бэрхшээл учирдаг талаар дурдахдаа, нийтийн ариун цэврийн өрөөний бохир, олдоцгүй байдал нь хамгийн хүндрэлтэй, таагүй сэтгэгдэл төрүүлсэн.

Үүний дараагаар зам засвар, замын хөдөлгөөнтэй холбоотой асуудал, интернэт, утсан холбоо дутмаг зэрэг асуудлууд орсон бол аяллын хөтөлбөр, хийсэн зүйлс тааруу гэх хариулт хамгийн бага индекстэй байна гэжээ.

Харин “АФИМ Монголиа” ТББ-ын хийсэн судалгаа нь илүү эвентэд чиглэсэн түүвэр судалгаа бөгөөд яг оролцсон, зохион байгуулсан эвентүүдийнх нь талаар чиглэж асуултууд асуусан.

Судалгаанд оролцогч аж ахуйн нэгжүүд эвентэд оролцоход дараах төрлийн хүндрэлүүд гардаг хэмээн хариулсан байна.

[71] “Аялал жуулчлалын өнөөгийн байдал, шийдвэрлэх асуудлууд”, Монголбанк, 2019

## График 3. 3 Эвентэд оролцоход гардаг түгээмэл хүндрэлүүд[72]




Судалгаанд оролцогчдын хариулсан байдлаас харахад, эвентэд оролцох үнэ, өртөг, зардал хамгийн гол бэрхшээл болохыг 33.3% нь дурджээ. Мөн Монгол Улсын аялал жуулчлалын эрх зүйн орчин, тухайн эвент болох газарт очих дэд бүтэц гол бэрхшээлийн нэг болдогийг судалгаанд оролцогчдын 22.2% болон 25.9% нь тус тус дурдсан болохыг дээрх графикаас харж болно.

Түүнчлэн, хог хаягдлын цэг, ариун цэврийн байгууламж голлох бэрхшээл болохыг энэ удаад ч мөн судалгаанд оролцогчид хариулсан байна. Эвент жил бүр тогтсон хугацаандаа болдоггүй нь хүндрэл бэрхшээл учруулдаг болохыг судалгаанд оролцогчид мөн хариулсан байна. Нөгөө талаас Монголбанкны хийсэн түүвэр судалгаагаар ч эвент батлагдсан хуваарьгүй, найдваргүй байдаг[73] нь саад бэрхшээл болдог болохыг дурдсан байдаг. Харин манай судалгааны багийн хийсэн судалгаанд оролцогч аж ахуйн нэгжүүд эвент зохион байгуулахад дараах төрлийн хүндрэлүүд гардаг хэмээн хариулсан байна.

[72] Түүвэр судалгааны тайлан, “АФИМ Монголиа” ТББ, 2021 он
[73] “Аялал жуулчлалын өнөөгийн байдал, шийдвэрлэх асуудлууд”, 24ху, Монголбанк, 2019

### График 3. 4 Эвентийг зохион байгуулахад гардаг хүндрэл




Дээрх графикаас харахад, судалгаанд оролцогч эвент зохион байгуулагчид аялал жуулчлалын эвент зохион байгуулахад үүсдэг хүндрэлүүдэд санхүүжилт хүрэлцдэггүй, үйлчилгээ тааруу, байрших газрын хүндрэл гол асуудал байдгийг дурдсан байна.

Түүнчлэн, зохион байгуулалт өөрчлөгддөг, зам дэд бүтэц муутай, цаг агаарын гэнэтийн өөрчлөлт ч мөн багагүй хүндрэл үүсгэдэг талаар хариулт өгчээ.

### График 3. 5 Эвентийн түгээмэл хүндрэл бэрхшээлүүд, судалгаанд оролцогч орон нутгийн БОАЖГ-ын мэргэжилтнүүдийн үзэж буйгаар




Судалгаанд оролцогчдын 50-72 хувь нь ариун цэврийн өрөө, байгууламж, хог хаягдлын цэг, үнэ, өртөг зардлын хувьд хамгийн гол бэрхшээл болдогийг

дурдсан байна. Харин хоол унд, тэмдэглэлт арга хэмжээний удирдлага, зохион байгуулалт, МУ-ын аялал жуулчлалын эрх зүйн орчин нь заримдаа бэрхшээл үүсгэдэг гэж ихэнх хувь нь хариулжээ.

Судалгааны хүрээнд гадаадын болон дотоодын жуулчид аялал жуулчлалын эвентийн талаар ямар зүйл дээр сэтгэл ханамжтай харин ямар асуудлууд дээр шүүмжлэлттэй ханддаг талаар асуулга асуухад дараах байдлаар хариулжээ.

Гадаадын жуулчдад байгалийн үзэсгэлэнт газар, өв соёл, нүүдлийн соёл иргэншил, уламжлалт хувцас хэрэгсэл, ахуй соёл таалагддаг талаар судалгаанд оролцогч БОАЖГ-ын мэргэжилтнүүд хариулсан бол 00, ариун цэврийн газар, хог хаягдал, байрлах газар, зохион байгуулалт, дэд бүтцийн асуудал дээр гадаад жуулчид шүүмжлэлттэй ханддагийг дурдсан байна.

**График 3. 6 Эвентийн талаар шүүмжлэлтэй хандсан асуудлууд, орон нутгийн БОАЖГ-ын мэргэжилтнүүдийн үзэж буйгаар**




Харин дотоодын жуулчид байгалийн үзэсгэлэнт газраар аялж, ахуй соёлтойгоо танилцах, өв соёл, уламжлалт соёлоо хадгалж, хамгаалах, нутгийн иргэдийн хувьд брэнд бүтээгдэхүүнээ сурталчлах боломж олгосон тааламжтай талууд байгаа болохыг дурддаг, харин 00 ариун цэвэр, зохион байгуулалт, хог хаягдлыг мөн л дотоодын жуулчид шүүмжлэсэн болохыг байгаль орчин, аялал жуулчлалын мэргэжилтнүүд дурдсан байна.

Мөн манай судалгааны баг энэхүү судалгааг хийх явцдаа хэд хэдэн удаагийн фокус бүлгийн ярилцлага хийсэн ба уг ярилцлагад оролцсон зарим эвент зохион байгуулагчдын хэлж буйгаар аливаа эвентийг зохион байгуулахад тайз засал их хэрэгтэй байх ба эдгээрийг холбох цахилгаан эх үүсвэрийн чадал хүрэлцэхгүй байдаг нь нилээд бэрхшээл учруулах ба энэхүү хүндрэл эвент бүрт байдаг[74] болохыг дурдаж байсан. Мөн зарим эвентүүдийн хувьд гадаад жуулчин ихээр ирлээ гэхэд тэднийг хүлээн авах хүчин чадал муу байгаа[75] нь нилээд хүндрэл учруулдаг гэжээ.

### 3.2.4 Эвент зохион байгуулагчид, оролцогчдоос дэвшүүлсэн саналууд

Манай судалгааны багийн хийсэн түүвэр судалгаанд оролцогч аялал жуулчлалын эвентэд оролцогч, эвент зохион байгуулагч аж ахуйн нэгж,

[74] "Онцын тасархай тур" ХХК-ийн захирал н.Батсүхтэй хийсэн фокус бүлгийн ярилцлагаас
[75] "Гайхамшигт говь" ТББ-ын захирал Н.Ариунсанаатай хийсэн фокус бүлгийн ярилцлагаас

байгууллага, түүнчлэн нийслэл, аймгийн БОАЖГ-ын мэргэжилтнүүдийн аялал жуулчлалын эвентийг сайжруулах талаар хэрхэн хариулсаныг тоймлон харъя.

### График 3. 7 Эвентийн үйл ажиллагааг сайжруулах санал, аж ахуйн нэгжүүдийн хариулсан байдлаар




Эвентийн үйл ажиллагааг цаашид хэрхэн сайжруулах талаар судалгаанд оролцогсдын 33.3 хувь нь зохион байгуулалтаа сайжруулах шаардлагатай байгааг, 24 хувь нь үйлчилгээгээ сайжруулах шаардлагатайг, 22.2 хувь нь дэд бүтцээ сайжруулах шаардлагатайг, харин 20.37 хувь нь үзвэр үйлчилгээний тоог нэмэгдүүлэх шаардлагатай гэж үзжээ.

Эвентүүдэд оролцоход үзвэр үйлчилгээ хангалтгүй байдаг талаар мөн МБ-с хийсэн түүвэр судалгаанд оролцогч гадаадын жуулчид хариулсан[76] байгааг энд дурдах нь зүйтэй болов уу. Нөгөө талаас уг судалгаанд оролцсон гадны жуулчдын зардлаас харахад үзвэр, үйлчилгээнд хамгийн бага зардал зарцуулсан судалгаа байдаг.[77]

### График 3. 8 Жуулчдыг татахын тулд эвентийн хувьд анхаарах зүйлс, БОАЖГ-ын мэргэжилтнүүдийн үзэж буйгаар




Судалгаанд оролцсон БОАЖГ-ын мэргэжилтнүүдийн 55 орчим хувь нь эвентийн зохион байгуулалт, мөн ийм хэмжээгээр тав тухтай орчинг сайжруулах шаардлагатай гэж үзсэн бол, 40 гаруй хувь нь эвентийн маркетингийг сайжруулах, 28 орчим хувь нь дэд бүтцийг сайжруулах хэрэгтэй байгааг онцолсон байгааг дээрх судалгаанд хариулсан байдлаас харж болно.

[76] “Аялал жуулчлалын өнөөгийн байдал, шийдвэрлэх асуудлууд”, Монголбанк, 2019
[77] “Аялал жуулчлалын өнөөгийн байдал, шийдвэрлэх асуудлууд”, Монголбанк, 2019

**График 3. 9 Эвентийг үр дүнтэй зохион байгуудахад төрөөс хэрэгтэй дэмжлэгүүд, орон нутгийн БОАЖГ-ын мэргэжилтнүүдийн үзэж буйгаар**




**График 3. 10 Эвентийг үр дүнтэй зохион байгуупахад олон улсын байгууддага болон мэргэжлийн судлаачдын зүгээс хэрэгтэй дэмжлэгүүд, БОАЖГ-ын мэргэжилтнүүдийн үзэж буйгаар**



**График 3. 11 Эвентийг үр дүнтэй зохион байгуулахад нутгийн иргэд, байгууллагуудын зүгээс хэрэгтэй дэмжлэгүүд, БОАЖГ-ын мэргэжилтнүүдийн үзэж буйгаар**







Дээрх графикуудаас харахад, аялал жуулчлалын эвентийг сайжруулахад, төрөөс болон аймаг, орон нутгийн захиргаанаас санхүүжилт болон зохион байгуулалтын хувьд дэмжлэг илүүтэй хүсч буй бол олон улсын байгууллагууд, ТББ-аас мөн л санхүүжилт, зохион байгуулалтын хувьд дэмжлэг хүсч байгаагаас гадна маркетингийн хувьд дэмжлэг үзүүлбэл илүү хэрэгтэй байгааг дурдсан байна. Харин аялал жуулчлалын мэргэжлийн судлаачдаас үзвэр үйлчилгээний чанар болоод маркетинг сайжруулах талаар судалгаа хийж өгөхийг хүссэн байна. Нутгийн иргэдээс эвентэд илүү оролцоо сайтай байж дэмжлэг үзүүлэхийг хүсдэг бол аялал жуулчлалын байгууллагуудаас харилцаа холбоо, маркетинг, зохион байгуулалт, ажиллах хүчний хувьд туслалцаа үзүүлэн хамтран ажиллахыг хүсчээ.

**График 3. 12 Эвентийн талаар жуулчдын санал хүсэлт, ачлал жуулчлалын компаниудын хариулсан байдлаар**




Судалгаанд оролцогсдын 55 хувь нь эвентэд оролцсон жуулчид оролцсон эвентдээ сэтгэл хангалуун байдаг гэж хариулсан бол 00, ариун цэврийн хувьд хангалтгүй, зам дэд бүтцийн хувьд сайжруулах шаардлагатай, үйлчилгээ хангалтгүй байдаг үзвэр үйлчилгээнийхээ тоог нэмэх шаардлагатай гэх мэт хариултыг өгсөн байна.

### 3.2.5 Судалгааны үр дүн, хэсгийн дүгнэлт

Жуулчид Монгол Улсад ирэхээс өмнө тулгардаг бэрхшээлүүдэд тухайн хэл дээрх мэдээлэл олдоц багатай (ялангуяа БНСУ, БНХАУ, Япон, Герман, Франц зэрэг орны жуулчид ингэж хариулжээ), тийзний үнэ өндөр, мэдээлэл дутмаг байдаг, хариу өгөхгүй уддаг зэрэг бэрхшээлүүд байна.

Жуулчид газрын тээвэр, хоол, байр сууц, үйлчилгээний ажилтан, тур операторын ажлын гүйцэтгэл зэрэгт шүүмжлэлтэй хандсан зүйлүүд байна.

Монгол Улсад аялахад ямар хүндрэл бэрхшээл учирдаг талаар дурдахдаа, нийтийн ариун цэврийн өрөөний бохир, олдоцгүй байдал нь хамгийн хүндрэлтэй, таагүй сэтгэгдэл төрүүлсэн. Үүний дараагаар зам засвар, замын хөдөлгөөнтэй холбоотой асуудал, интернэт, утсан холбоо дутмаг зэрэг асуудлууд орсон бол аяллын хөтөлбөр, хийсэн зүйлс тааруу гэх хариулт хамгийн бага индекстэй байна гэжээ.

Судалгаанд оролцогсдын хариулсан байдлаас харахад, эвентэд оролцох үнэ, өртөг, зардал хамгийн гол бэрхшээл болохыг 33.3 хувь нь дурджээ. Мөн Монгол Улсын аялал жуулчлалын эрх зүйн орчин, тухайн эвент болох газарт очих дэд бүтэц гол бэрхшээлийн нэг болдогийг судалгаанд оролцогсодын 22.22 болон 25.93 хувь нь тус тус дурдсан байна.

Хог хаягдлын цэг, ариун цэврийн байгууламж голлох бэрхшээл болохыг энэ удаад ч мөн судалгаанд оролцогсод хариулсан байна.

Эвент жил бүр тогтсон хугацаандаа болдоггүй нь хүндрэл бэрхшээл учруулдаг болохыг судалгаанд оролцогчид мөн хариулсан байна. Нөгөө талаас Монголбанкны хийсэн түүвэр судалгаагаар ч эвент батлагдсан хуваарьгүй, найдваргүй байдаг[78] нь саад бэрхшээл болдог болохыг дурдсан байдаг.

Судалгаанд оролцогч эвент зохион байгуулагчид аялал жуулчлалын эвент зохион байгуулахад үүсдэг хүндрэлүүдэд санхүүжилт хүрэлцдэггүй, үйлчилгээ тааруу, байрших газрын хүндрэл гол асуудал байдаг тухай дурдсан байна. Түүнчлэн, зохион байгуулалт өөрчлөгддөг, зам дэд бүтэц муутай, цаг агаарын гэнэтийн өөрчлөлт ч мөн нилээдгүй хүндрэл үүсгэдэг болох талаар хариулт өгчээ.

Судалгаанд оролцогчдын 50-72 хувь нь ариун цэврийн өрөө, байгууламж, хог хаягдлын цэг, үнэ, өртөг зардлын хувьд хамгийн гол бэрхшээл болдог тухай дурдсан байна. Харин хоол унд, тэмдэглэлт арга хэмжээний удирдлага, зохион байгуулалт, Монгол Улсын аялал жуулчлалын эрх зүйн орчин нь заримдаа бэрхшээл үүсгэдэг гэж багагүй хувь нь хариулжээ.

Судалгааны хүрээнд гадаадын болон дотоодын жуулчид аялал жуулчлалын эвентийн талаар ямар зүйл дээр сэтгэл ханамжтай харин ямар асуудлууд дээр шүүмжлэлттэй ханддаг талаар асуулга асуухад гадаадын жуулчдад байгалийн үзэсгэлэнт газар, өв соёл, нүүдлийн соёл иргэншил, уламжлалт хувцас хэрэгсэл, ахуй соёл таалагддаг талаар судалгаанд оролцогч БОАЖГ-ын мэргэжилтнүүд хариулсан бол 00, ариун цэврийн газар, хог хаягдал, байрлах газар, зохион

[78] "Аялал жуулчлалын өнөөгийн байдал, шийдвэрлэх асуудлууд", 24-р хуудас, Монголбанк, 2019

байгуулалт, дэд бүтцийн асуудал дээр гадаад жуулчид шүүмжлэлттэй ханддагийг дурдсан байна.

Эвент зохион байгуулах газруудад цахилгаан эх үүсвэр хангалтгүй, жуулчдыг хүлээн авах хүчин чадлын хувьд хязгаарлагдмал байдаг нь бэрхшээл учруулдаг байна.

Эвентийн үйл ажиллагааг цаашид хэрхэн сайжруулах талаар судалгаанд оролцогсдын 33.3 хувь нь зохион байгуулалтаа сайжруулах шаардлагатай байгааг, 24 хувь нь үйлчилгээгээ сайжруулах шаардлагатайг, 22.2 хувь нь дэд бүтцээ сайжруулах шаардлагатайг, харин 20.37 хувь нь үзвэр үйлчилгээний тоог нэмэгдүүлэх шаардлагатай гэж үзжээ. Эвентүүдэд оролцоход үзвэр үйлчилгээ хангалтгүй байдаг талаар мөн МБ-аас хийсэн түүвэр судалгаанд оролцогч гадаадын жуулчид хариулсан[79] байдагийг энд дурдах нь зүйтэй болов уу. Нөгөө талаас уг судалгаанд оролцсон гадны жуулчдын зардлаас харахад үзвэр, үйлчилгээнд хамгийн бага зардал зарцуулсан судалгаа байдаг.

Судалгаанд оролцсон БОАЖГ-ын мэргэжилтнүүдийн 55 орчим хувь нь эвентийн зохион байгуулалт, мөн ийм хэмжээгээр тав тухтай орчинг сайжруулах шаардлагатай гэж үзсэн бол, 40 гаруй хувь нь эвентийн маркетингийг сайжруулах, 28 орчим хувь нь дэд бүтцийг сайжруулах хэрэгтэй байгааг онцолсон байгааг дээрх судалгаанд хариулсан байдлаас харж болно.

Аялал жуулчлалын эвентийг сайжруулахад, төрөөс болон аймаг, орон нутгийн захиргаанаас санхүүжилт болон зохион байгуулалтын хувьд дэмжлэг илүүтэй хүсч буй бол олон улсын байгууллагууд, ТББ-аас мөн л санхүүжилт, зохион байгуулалтын хувьд дэмжлэг хүсч байгаагаас гадна маркетингийн хувьд дэмжлэг үзүүлбэл илүү хэрэгтэй байгааг дурдсан байна. Харин аялал жуулчлалын мэргэжлийн судлаачдаас үзвэр үйлчилгээний чанар болоод маркетинг сайжруулах талаар судалгаа хийж өгөхийг хүссэн байна. Нутгийн иргэдээс эвентэд илүү оролцоо сайтай байж дэмжлэг үзүүлэхийг хүсдэг бол аялал жуулчлалын байгууллагуудаас харилцаа холбоо, маркетинг, зохион байгуулалт, ажиллах хүчний хувьд туслалцаа үзүүлэн хамтран ажиллахыг хүсчээ.

Олон улсад аялал жуулчлалын салбарт мөрдөгддөг хэд хэдэн стандартууд байх боловч эвентэд чиглэсэн гол стандарт бол ISO20121 буюу “Эвентийн тогтвортой удирдлагын тогтолцоо” гэж байдаг. Манай улсын хувьд байршуулах газрын стандарт гэх мэт цөөн тооны стандарт байх боловч эвентэд чиглэсэн стандарт байхгүй.

### 3.2.6 Эвентийн үйл ажиллагааг сайжруулах зөвлөмж

Дээрх судалгаа болон оролцогч талуудтай хийсэн ярилцлагын үндсэн дээр оролцогч тал тус бүрд дараах зөвлөмжийг өгч байна.

**Эвент зохион байгуулагч төрийн захиргааны төв байгууллага болон орон нутгийн захиргааны байгууллагуудад өгөх зөвлөмж:**

---

[79] “Аялал жуулчлалын өнөөгийн байдал, шийдвэрлэх асуудлууд”, Монголбанк, 2019

Монгол улсын үзэсгэлэнт байгаль, өв уламжлал, ёс заншилыг дэлхийд сурталчилах нэгдсэн марктингийн бодлогыг БОАЖЯ, Соёлын яам, ГХЯ хамтран төлөвлөж хэрэгжүүлэх;

Эвент аялал жуулчлалыг хөгжүүлэх хууль эрх зүйн орчинг боловсронгуй болгох /мэдээллийн сан бүрдүүлэх журам гэх мэт;

Эвентийн талаар олон улсын стандарт нэвтрүүлэх, эвент зохион байгуулагч аж ахуйн нэгжүүдэд энэ чиглэлээр тусламж, дэмжлэг үзүүлэх, олон улсын стандарт нэвтрүүлэхийн зэрэгцээ Монгол улс эвент зохион байгуулахтай холбоотойгоор тусгайлсан стандарт гаргах;

Эвентүүд голлон зохиогддог бүс нутаг, газар оронд дэд бүтэц хөгжүүлж, түр амрах, отоглох цэгүүдийг байгуулж амрах орчинг бүрдүүлэх;

Аймаг орон нутагт өөрийн гэсэн тур оператор байгуулахыг дэмжих;

Эвентийн үндсэн зохион байгуулагч болон хамтран зохион байгуулагч талуудад аялал жуулчлал, зочлох үйлчилгээ, эвент менежментийн чиглэлээр сургалт зохион байгуулах, гэрчилгээжүүлэх;

Улсын төсөв болон орон нутгийн төсвөөс эвентийг дэмжих чиглэлээр гаргах санхүүжилтийн дэмжлэгийг нэмэгдүүлэх, зарцуулалтыг тодорхой чиглэлийн үйл ажиллагаанд зарцуулах талаар хяналт, дүн шинжилгээ хийдэг байх;

Аймаг, бүс нутаг тус бүрийн онцлогт уялдуулан эвентүүдийг төрөлжүүлэх, багцалж бүтээгдэхүүн болгох, эвент бүрийн онцлог дүр төрхийг бүрдүүлэх чиглэлээр төр захиргааны байгууллагууд бодлого боловсруулж, хэрэгжүүлэх;

Төрийн захиргааны байгууллагын зүгээс аялал жуулчлалын мэргэжлийн судлаачдаар орон нутгийн онцлогт тохирсон, жуулчдын сонирхлыг татах арга хэмжээ, үйл явцын судалгааг хийлгэж, эвентийн агуулгыг баяжуулах;

Эвент зохион байгуулагчдаас тодорхой гаргасан загвар, маягтын дагуу эвент бүрийн тайланг авч нэгтгэн жил бүрийн эцэст үр дүнг олон нийтэд тайлагнадаг байх;

Эвент зохион байгуулагчдад зориулсан гарын авлага, сургалт арга зүйгээр хангах;

Монгол улсад хэрэгжиж буй хөрөнгө оруулалт, бүтээн байгуулалт, аялал жуулчлалын төсөл хөтөлбөрүүдтэй эвентүүдийн харилцан хамтын ажиллагаа, уялдаа холбоог харгалзан үзэх;

Эвентүүдэд БОАЖЯ болоод орон нутгийн ЗДТГ-аас санхүүжилт олгохдоо тодорхой шалгууруудыг харгалзан үзэж олгох. Тухайлбал, эвент зохион байгуулах өдөр тогтвортой байгаа эсэх, эвентийн үйл ажиллагааг хэрхэн төлөвлөсөн, төлөвлөгөөний дагуу өмнө нь зохион байгуулж байсан эсэх, мониторинг хийсэн тайлан зэрэгт үндэслэн олгох. Мөн эвентийн дараа гадаад, дотоодын жуулчдаас санал асуулга бөглүүлж, шаардлагатай мэдээллүүдийг цуглуулсны дараа эдгээрийг мониторингийн тайландаа тусгах гэх мэт.

Эрэмбийн дагуу орон нутагт зохиогддог зарим томоохон эвентүүд рүү дотоодын иргэний агаарын тээвэрлэгч компаниудтай хамтран тусгай нислэг үйлддэг байх талаар төрөөс дэмжлэг үзүүлэх;

Нүүдлийн соёлын аялал жуулчлалын гадаадын эвентүүд, Монгол угсаатнуудын зохион байгуулдаг эвентүүдтэй дотоодын эвентүүдээ холбох, хорших, хамтран ажиллах боломж, гарцыг хэрэгжүүлэх;

Эвентийн мэдээллийн нэгдсэн платформыг хөгжүүлэх, дэмжих;

БОАЖЯ болон орон нутгийн төсвөөс ач холбогдол өндөртэй, гадны жуулчид ихээр татаж, улс орны эдийн засагт нөлөө их үзүүлэх эвентийг бий болгож үүнд томоохон хөрөнгө оруулалт хийх талаар илүү дэмжих зэрэг болно.

**Эвент зохион байгуулагч оператор, жуулчны бааз болон орон нутгийн бусад байгууллагуудад өгөх зөвлөмж:**

Эвентийн нэрийг тогтсон, албан ёсны нэршилээр батлаж төрийн захиргааны төв байгууллагад мэдэгдэн урьдчилсан мэдээлэл, сурталчилгаанд оруулах хэрэгтэй эвентийн нэрийг огт солихгүй байх шаардлагатайг анхаарах;

Зохион байгуултыг сайжруулж, эвент бүрийн болох цаг хугацаа, байршлыг жилийн өмнөөс тодорхой болгож, тогтмол нэг хугацаа, газартаа зохион байгуулах;

Эвентийн үеэр үзвэр үйлчилгээний чанар, нэр төрлийг нэмэгдүүлэх;

Эвент болох газар нутаг, талбайд мэдээлэх, анхааруулах тэмдэг тэмдэглэгээ, самбаруудыг урьдчилан сайтар тооцож байршуулсан байх;

Эвентүүдийн мэдээллийг дотоодын аялагч, гадаадын жуулчид, тур оператор байгууллагуудад хүргэх ажлыг сайн зохион байгуулах;

Ариун цэврийн байгууламжийн асуудлыг шийдвэрлэх, нийтийн ариун цэврийн байгууламж байгуулах, мобайл кэмпинг, мобайл 00-ын талаар судлан нэвтрүүлэх тал дээр анхаарч ажиллах хэрэгтэй.. Ийм төрлийн үйлчилгээ үзүүлдэг байгууллагуудтай хамтран ажиллах;

Эвент бүрийн онцлогт тохирсон гадаад жуулчдын зах зээлийг тодорхойлж /target segment/ маркетингийн идэвхижүүлэлт хийх;

Хогийн цэгийг эвент болох газар урьдчилан төлөвлөж бэлтгэх. Мэдээлэх самбаруудыг бэлтгэж тавьсан байх;

Эвентийн хүрээнд зохион байгуулах үйл ажиллагаанд аль болох нутгийн иргэд, байгууллагуудыг түлхүү оролцуулж орон нутагт эдийн засгийн үр өгөөж үлдээхийг эрмэлзэх;

Эвент зохион байгуулдаг мэргэшсэн туршлагатай менежментийн баг бүрдүүлэх, эсвэл хамтран ажиллах байдлаар тухайн эвентийн менежментийг сайжруулах;

Олон улсын байгууллагууд, төрийн бус байгууллагуудтай хамтран ажиллаж гадаад харилцаа, мэдээлэл сурталчилгааг сайжруулах;

Аялал жуулчлалын мэргэжлийн судалгааны байгууллага, судлаачидтай хамтран ажиллаж хэрэглэгчдийн сэтгэл ханамж, эвентийн үр өгөөж, нөлөөллийн асуудлыг тогтмол судлаж, тайлан гаргаж байх;

Тур операторуудтай хамтын ажиллагаагаа сайжруулж эвент наадмын талаарх мэдээллийг хэрэглэгчдэд түргэн шуурхай хүргэх;

Гадаадын жуулчдын оролцоог хангасан тэмцээн, уралдааныг эвентийн хөтөлбөрт заавал оруулах хэрэгтэй ба зохион байгуулалтыг сайтар төлөвлөх /орчуулга, аюулгүй байдал, тоног хэрэгсэл гэх мэт/;

Эвентийн маркетинг, найруулга тал дээр мэргэжлийн байгууллагатай хамтран ажиллах, зохион байгуулалтын бүхий л шатанд төлөвлөлтийг сайн хийж, хамтын ажиллагааг уялдуулах;

Эвентийн талаар холбогдох мэдээллийг Англи болон бусад жуулчид их ирдэг орон тухайлбал Солонгос, Япон, Хятад хэл дээр бэлтгэн түгээх тал дээр анхаарах;

Эвентийн мэдээллийг зөвхөн тур операторын веб сайт бус жуулчид ихээр ханддаг мэдээллийн сайтуудад байршуулах тал дээр анхаарах;

Эвент зохион байгуулах газраа сонгохдоо дэд бүтэц сайтай, зам харилцаа хөгжсөн, цахилгаан эрчим хүчд холбогдсон, байрших газрын хүчин чадал гэх мэтийг анхаарч шийдвэрээ гаргах зэрэг болно.

**Эвентэд оролцогч туслан гүйцэтгэгч нутгийн иргэд, байгууллагуудад өгөх зөвлөмж:**

Эвентийн зохион байгуулалтанд нутгийн иргэд нөхөрлөл байгуулах замаар албан ёсоор байгууллагын түвшинд хамтран ажиллахыг эрмэлзэх;

Жуулчдын улирлын хамаарлыг бууруулах зорилгоор хавар, намар ихэнхдээ зохион байгуулдаг тул хүйтэн салхи шороо ихтэй байгалийн үзэгдэл тогтвортой байдлыг сануулах хэрэгтэй;

Эвент зохион байгуулагчдын заасан, товлосон хогийн цэгт хог хаягдалаа хаях;

НИТАЖ хөгжүүлэхэд хувь нэмэр оруулж, аялагчдад аялах нөхцөл бүрдүүлэх

Эвентийг зохион байгуулах хүний нөөцийн сургалт, бэлтгэл ажилд идэвхитэй хамрагдаж гэрчилгээ авах;

Нутгийн бренд бүтээгдхүүнийг сурталчилах, эсвэл шинээр бий болгох замаар бүтээгдхүүний чанарыг сайжруулах, орлого олох;

Эвент зохион байгуулж буй аялал жуулчлалын бус байгууллагууд /Жишээ нь шашны байгууллага, хувь хүмүүс/ орон нутгийн захиргаа, аялал жуулчлалын мэргэжлийн байгууллагуудтай заавал хамтран ажиллах шаардлагатай бөгөөд эвент менежментийн зохих шаардлага, стандартыг хангах хэрэгтэй;

Нутгийн брэнд аялал жуулчлалын бэлэг дурсгалын зүйлсийг бий болгож эвентийн үеэр зарж борлуулах;

Хоол ундны үйлчилгээг ихэвчлэн орон нутгийн байгууллагууд, бизнес эрхлэгчид хариуцдаг тул амт чанар, тэжээллэг байдал, гадаадын жуулчдын хэрэгцээнд нийцэх эсэх дээр тогтмол анхаарч ажилладаг байх зэрэг болно.

**Эвентэд оролцогч буюу дотоод, гадаадын жуулчдад өгөх зөвлөмж:**

Эвент зохион байгуулагчдын заасан, товлосон хогийн цэгт хог хаягдалаа хаях;

Зохион байгуулагдаж байгаа арга хэмжээнд идэвхтэй, хариуцлагатай ухамсартай оролцох;

Монгол ахуй соёл, зан заншил, уламжлалт өв соёлоо сурталчлах;

Нутгийн иргэд нь Монгол аялагчид болон гадаадын жуулчдыг хүндлэх, найрсаг харьцах шаардлагатай ба өөрсдийн санал шүүмжийг зөвөөр илэрхийлэх хэрэгтэй;

Эвентийн үеэр зохиогдох төрөл бүрийн тэмцээн, уралдаан, арга хэмжээнд идэвхтэй оролцох;

Эвент зохиогдох бүс нутгийн иргэд малын гоц халдварт өвчин гарахаас онцгой сэргийлж ажиллах хэрэгтэй ба мал эмнэлэг, онцгой байдлын албатай хамтрах хэрэгтэй;

Нутгийн иргэд эвентийн үеэр зочид гийчдийн аюулгүй байдал, тав тухад анхаарч эвент зохион байгуулагч нарт туслах, мэдээлэх үүрэгтэй;

Эвентийн үеэр архи, тамхины зохисгүй хэрэглээ, галын аюулгүй байдал алдагдах зэрэг аливаа эрсдлээс урьдчилан сэргийлж холбогдох албаны хүмүүсийг дэмжих, туслах зэргийг онцолж байна.

# ДӨРӨВ. БОЛОМЖИТ, ШИЛДЭГ 10 ЭВЕНТИЙН СТРАТЕГИ ТӨЛӨВЛӨГӨӨ

## 4.1. ЭВЕНТҮҮДИЙН ЗАХ ЗЭЭЛИЙН БАЙР СУУРЬ

### 4.1.1 Аялал жуулчлалын эвентийн шинжилгээ хийх арга зүй

Монгол улсын аялал жуулчлалын сонгогдсон боломжит, шилдэг 10 эвентийн шинжилгээг хийхдээ өмнөх тайланд тодорхойлон авч үзсэн эвентүүдийн хувьд тухайн зах зээл дээр хэдэн хувийг эзэлж байгааг гадаад оролцогчид болон нийт оролцогчдын тоогоор тооцож, эрэмбэлэв. Дараа нь стратеги төлөвлөгөө боловсруулахад нийтлэг ашиглагддаг СВОТ шинжилгээний аргыг ашиглан эвент бүрээр шинжилгээ хийлээ. Үүнд үндэслэн нэгдсэн байдлаар Монгол улсын аялал жуулчлалын эвентийн СВОТ шинжилгээг хийснээр энэ бүлгийг дүгнэж байна.

**СВОТ шинжилгээ**[80]:

СВОТ (SWOT) шинжилгээний арга нь аливаа бизнесийн үйл ажиллагаа, стратегийн шийдвэр гаргахдаа өнгөрсөн болон одоогийн нөхцөл байдалд дүн шинжилгээ хийх эсвэл стратеги төлөвлөгөө гаргахын өмнө болон стратеги төлөвлөгөө боловсруулахдаа хийдэг суурь шинжилгээний арга юм (Gurel & Merba, 2017). Альберт Хамфигээр удирдуулсан Стэнфорд их сургуулийн судлаачдын баг 1960 онд тус аргыг анхлан ашигласан түүхтэй.

СВОТ шинжилгээний арга нь 4 үе шаттай.

1. Эхний алхам бол Strength буюу тухайн бүтээгдэхүүний давуу талыг тодорхойлно. Тухайн бүтээгдэхүүний давуу тал бол бусад бүтээгдэхүүнээс ялгарах онцлог, мөн чанарыг тодорхойлох;
2. Хоёр дахь алхам бол Weakness буюу өөрийн сул талаа тодорхойлох. Свот шинжилгээний аргыг нэг талаараа тухайн бүтээгдэхүүнийг сайжруулах зорилгоор хийдэг. Иймээс бүтээгдэхүүнийг сайжруулах хамгийн шилдэг арга бол сул талуудаа олж мэдэх;
3. Дараагийн алхам бол Opportunity буюу боломжуудаа тодорхойлох;
4. Сүүлийн алхам бол Threat буюу аюул заналыг тодорхойлох. Энэ тухайн бүтээгдэхүүнтэй ямар бүтээгдэхүүнүүд өрсөлдөж болохыг тодорхойлох юм.

[80] Emet GÜREL, SWOT Analysis: A Theoretical Review, 2017, Journal of International Social Research 10(51):994-1006

### 4.1.2 Монгол улсын шилдэг 10 эвентийн зах зээлд эзлэх хувь хэмжээ

**Хүснэгт 4. 1 Аялал жуулчлалын боломжит 10 эвентийн ангилал**

| № | Аялал жуулчлалын боломжит 10 эвент | Дотоод жуулчдын тоо | Гадаад жуулчдын тоо | Нийт жуулчид | Эвентийн ангилал | Зорилтот зах зээл (одоогийн байдлаар) |
|---|---|---|---|---|---|---|
| 1 | Алтан бүргэд-бүргэдийн баяр | 2,000 | 1,000 | 3,000 | Бүс нутаг | Дотоод, Гадаад |
| 2 | Монгол төрийн их наадам | 32,000 | 3,000 | 35,000 | Олон улсын | Дотоод |
| 3 | Монгол туургатны язгуур соёлын олон улсын их наадам | 1800 | 200 | 2,000 | Бүс нутгийн | Гадаад |
| 4 | Плэйтайм олон улсын хөгжмийн наадам | 31,550 | 450 | 32,000 | Олон улсын | Гадаад |
| 5 | Талын түмэн адуу | 1,500 | 320 | 1,820 | Бүс нутгийн | Дотоод |
| 6 | Түмэн тэмээний баяр | 620 | 156 | 776 | Бүс нутгийн | Дотоод |
| 7 | Улаанбаатарын өвлийн наадам | 8,800 | 200 | 9,000 | Бүс нутгийн | Дотоод, гадаад |
| 8 | “Хийморь” морьт харваа, морин тулааны фестиваль | 2,550 | 450 | 3,000 | Бүс нутгийн | Гадаад |
| 9 | Хонины найр | 120 | 10 | 130 | Орон нутгийн | Дотоод |
| 10 | Хөх сувд - Хөвсгөлийн мөсний баяр | 30,000 | 120 | 30,120 | Бүс нутгийн | Дотоод |

*Эх үүсвэр:Оролцогч талуудаас цуглуулсан мэдээлэлд үндэслэн гаргасан судлаачийн тооцоо*

Дээрх хүснэгтэд аялал жуулчлалын 10 эвентийг цагаан толгойн үсгийн дараалаар байршуулж, дараах ангиллын дагуу ангилж, зорилтот зах зээлийг тодорхойлов. Зорилтот зах зээлийг тодорхойлохдоо тухайн эвентийн зорилго, ирсэн жуулчдын бүтэц, фокус бүлгийн ярилцлага дээр үндэслэв.

**Хүснэгт 4. 2 Эвентийн ангилал**

| Мега эвент[81] | Олон улсын эвент[82] | Бүс нутгийн эвент[83] | Орон нутгийн эвент[84] |
|---|---|---|---|
| • Оролцогч болон үзэгчид нь дэлхий нийтийг хамарсан | • Олон улсын үзэгчид, оролцогчидтой | • Ихэнхи оролцогчид нь дотоодын жуулчид байдаг. | • Голлон нутгийн иргэд, дотоодын үзэгчдэд зориулан зохиодог болovч |

[81] Introduction to Tourism and Hospitality in BC – 2nd Edition (2021)
[82] OECD, Tourism paper Major events as catalysts for tourism, 2017/2, OECD Publishing, Paris
[83] Donald Getz, Stephen J, Progress and prospects for event tourism research, Tourism Management 52 (2016) 593e631
[84] Introduction to Tourism and Hospitality in BC – 2nd Edition (2021)

| | | | |
|---|---|---|---|
| • Эзэн орон/хот зохион байгуулдаг<br>• Асар их хэмжээний зардал гарч ажлын байр нэмэгддэг<br>• Заавал үзэх ёстой гэсэн шинж чанартай<br>• 1 сая гаруй жуулчин хамрагддаг. | • Төр засгаас нь бүхэлд нь болон хэсэгчилж санхүүжүүлдэг<br>• Тухайн эвентийн хажуугаар олон төрлийн бүтээгдэхүүн үйлчилгээг бий болгож ашиг олдог<br>• Гадаад жуулчдын тоо 500-аас дээш, Нийт жуулчдын тоог 10,000-аас дээш[85] | • Нутгийн эдийн засгийг нэмэгдүүлдэг.<br>• Гадаад жуулчдад нээлттэй.<br>• Гадаад жуулчдын тоо 100-500 хүртэл, Нийт жуулчдын тоог 1000-10,000 хүртэл[86] | гадаад жуулчдад нээлттэй.<br>• Гадаад жуулчдын эрэлт бага, оролцоо бага<br>• Зорилтот үзэгчидтэй.<br>• Ихэвчлэн сум, орон нутгийн эвентүүд орно.<br>• Гадаад жуулчдын тоо 100 хүртэл, Нийт жуулчдын тоог 1000 хүртэл[87] |

### Хүснэгт 4. 3 Эвентийн дотоодын зах зээлд эзлэх хувь хэмжээ

| № | Аялал жуулчлалын боломжит 10 эвент | Зохион байгуулагддаг зах зээл | Гадаад жуулчдын тоо | Нийт жуулчдын тоо | Зах зээлд эзлэх хувь хэмжээ, гадаад жуулчдаар | Зах зээлд эзлэх хувь хэмжээ, нийт оролцогчдын тоогоор |
|---|---|---|---|---|---|---|
| 1 | Монгол төрийн их наадам | УБ | 3,000 | 35,000 | 50.8% | 30.0% |
| 2 | Алтан бүргэд- бүргэдийн баяр | Баян Өлгий | 1,000 | 3,000 | 16.9% | 2.6% |
| 3 | Плэйтайм олон улсын хөгжмийн наадам | УБ | 450 | 32,000 | 7.6% | 27.4% |
| 4 | “Хийморь” морьт харваа, морин тулааны фестиваль | УБ | 450 | 3,000 | 7.6% | 2.6% |
| 5 | Талын түмэн адуу | Хэнтий | 320 | 1,820 | 5.4% | 1.6% |
| 6 | Улаанбаатарын өвлийн наадам | УБ | 200 | 9,000 | 3.4% | 7.7% |
| 7 | Монгол туургатны язгуур соёлын олон улсын их наадам | Увс | 200 | 2,000 | 3.4% | 1.7% |
| 8 | Түмэн тэмээний баяр | Өмнөговь | 156 | 776 | 2.6% | 0.7% |
| 9 | Хөх сувд - Хөвсгөлийн мөсний баяр | Хөвсгөл | 120 | 30,120 | 2.0% | 25.8% |
| 10 | Хонины найр | Төв | 10 | 130 | 0.2% | 0.1% |

*Эх сурвалж: Судлаачдын асуумжаар цуглуулсан тоон мэдээ*

---

85 Судлаачдын багийн гаргасан шалгуур үзүүлэлт
86 Судлаачдын багийн гаргасан шалгуур үзүүлэлт
87 Судлаачдын багийн гаргасан шалгуур үзүүлэлт

Дээрх хүснэгтэд Монгол улсын аялал жуулчлалын сонгогдсон шилдэг 10 эвентийг гадаад жуулчид болон нийт оролцогчдоор нь зах зээлд эзлэх хувь хэмжээг нь тооцож, эрэмбэлж харуулсан. Монгол төрийн их наадам нийт оролцогчдын тоо болон оролцсон гадаад жуулчдын тоогоороо дотоодын зах зээлд хамгийн их хувь эзэлж байна. Плэйтайм олон улсын хөгжмийн наадам оролцогчдын нийт тоогоороо зах зээлд 27.4% эзэлж буй ч гадаад оролцогчдын тоогоор 7.6% эзэлснээр 3 дугаар байрт эрэмбэлэгдэв. Алтан бүргэдийн баяр нийт оролцогчдын тоо бага боловч гадаад жуулчдын тоо өндөр учир зах зээлд 16.9% эзэлснээр хоёрдугаар байранд оржээ. Түүнчлэн Хөх сувд мөсний баяр нийт оролцогчдын тоогоор тооцож үзэхэд нийт зах зээлийн 25.8 хувийг эзэлж нийт оролцогчдын тоогоороо 3-рт байгааг дурдах нь зүйтэй болов уу.

Харин эдгээр эвентүүд олон улсын тэр тусмаа нүүдлийн соёлын Улаанбаатар хотоос 5 цагийн нислэгийн зайд байгаа орнуудын эвентүүдтэй харьцуулахад ямар байр суурьтай байсныг өмнөх гуравдугаар тайлангийн Хүснэгт 2-т харуулсан тул дэлгэрэнгүй мэдээллийг тэндээс харна уу. Энэхүү тооцооллоор нийт зах зээлийн 92.49 хувийг Киргиз улсад зохион байгуулагддаг “Дэлхийн нүүдэлчдийн наадам” /World Nomad Games/ - Азийн орнуудын угсаатнуудын фестиваль дангаараа эзэлж байсан. Тус судалгаанд сонгон авсан Монголын 10 эвентийн хувьд нийт зах зээлийн 7 орчим хувийг эзэлж байсныг харж болно. Тухайлбал, Плэйтайм эвентийг нүүдэлчний соёлын эвент гэж шууд үзэхгүй ч тухайн арга хэмжээний хүрээнд нүүдлийн хэв шинж, соёлыг агуулсан хамтлаг, дуучид оролцдог мөн тус эвентийн сонирхол, оролцоо өндөр байсан тул сонгосон болно.

Улаанбаатар хотоос 5 цагийн нислэгийн зайд зохион байгуулагддаг нүүдэлчдийн соёлын эвентээс зах зээлд эзлэх хувь хамгийн өндөр 4 эвентийг дор харуулав. Үүнд:

1. “Дэлхийн нүүдэлчдийн наадам” /World Nomad Games/ - Азийн орнуудын угсаатануудын фестиваль. Киргиз улс-**92.49 хувь**;
2. Монгол төрийн их наадам-**3.67 хувь**;
3. Алтан бүргэд - Бүргэдчдийн баяр-**1.01 хувь**;
4. “Хийморь” морьт харваа, морин тулааны фестиваль-**0.57** хувь тус тус байна.

Дээрх 4 эвентийн төвлөрлийн харьцааны нийлбэрийг тооцвол:

$CR_4 = \sum_{i=1}^{4} \quad s_i$=92.49+3.67+1.01+0.57=**97.74%**

буюу энэ зах зээлийн төвлөрлийн түвшин өндөр буюу хангалттай тооны өрсөлдөгч байхгүй байна гэсэн байсныг энд тоймлон дахин харуулж байна.

### 4.1.3 Монгол улсын боломжит, шилдэг 10 эвентийн свот шинжилгээ

**Хүснэгт 4. 4 "Монгол төрийн их наадам"-ын свот шинжилгээ**

| | | |
|---|---|---|
| SWOT анализ | **Strengths: Давуу тал** | - Гадаад жуулчдын сонирхлыг татдаг, зорин очдог үндэсний хэмжээний уламжлал, соёлын хамгийн том эвент<br>- Аялал жуулчлалын идэвхтэй үед зохион байгуулагддаг<br>- Нийслэл Улаанбаатар хотод болдог тул олон жуулчдыг - оролцуулах бүрэн боломжтой.<br>- Улс, орон нутгийн төсвөөс 100% санхүүжүүлдэг бөгөөд санхүүжилтийн боломж харьцангуй сайн.<br>- Аялал жуулчлалын тур оператор компаниуд бүгд "Наадам"-ыг эвент болгон сурталчилж борлуулдаг тул сурталчилгаанд их төсөв зарцуулах шаардлагагүй. |
| | **Weaknesses: Сул тал** | - "Төрийн наадам"-ыг зөвхөн Монголчуудын баяр гэж иргэд ойлгодог тул аялал жуулчлалын эвент болгож жуулчдыг илүү татах, оролцуулах, төсөвт орлого оруулах боломж гэдэг ойлголт сул байдаг<br>- Гадаа зохион байгуулагддаг учир цаг агаарын нөхцөлөөс хамааралтай.<br>- Хоол, ариун цэврийн өрөөний хүрэлцээ, стандарт чанар дээр анхаарах шаардлагатай.<br>- Цэнгэлдэх хүрээлэнгийн даац хүрдэггүй учраас шийдвэрлэх шаардлагатай. |
| | **Opportunities: Боломж** | - Олон улсад танигдсан байдал дээрээ тулгуурлан олон улсын жуулчдын тоог нэмэгдүүлэх боломжтой.<br>- Нүүдэлчдийн олон улсын наадам, соёлын эвентүүдтэй хамтран ажиллах, нэгдсэн маршрут гаргах зэргээр хорших боломжтой<br>- Зөвхөн Монгол улсын төдийгүй дэлхийн нүүдэлчин ард түмний нэгдэн тэмдэглэдэг их баяр, наадам болгож эвентийн ялгарлыг нэмэгдүүлэх |
| | **Threats: Аюул** | - Киргизийн "Дэлхийн нүүдэлчдийн наадам" аль хэдийн зах зээлийн 90 гаруй хувийг эзэлж байр сууриа бэхжүүлж байна.<br>- Нүүдлийн соёл иргэншлийн язгуур соёл хадгалагдаж үлдсэн улс бол Монгол орон гэдгийг олон улсын жуулчид эргэлзэх, Киргиз, Казахстан, Бутан улсуудруу хандах аюултай. |
| **Товч танилцуулга** | | Монгол төрийн их баяр наадам нь Монгол улсын уламжлалт эрийн гурван наадмыг төр ёсны баяр болгон тэмдэглэдэг бөгөөд Монгол Улсын хамгийн том эвент наадам юм. Жил бүрийн 7 дугаар сарын 11,12,13-ны өдрүүдэд төв цэнгэлдэх хүрээлэнд, зохион байгуулах баяр наадмын түр комиссоос зохион байгуулдаг.<br>1922 онд Буянт-Ухаад улсын чанартай наадмыг анх Цэргийн наадам нэртэй тэмдэглэсэн. Тэр цагаас хойш Ардын хувьсгалын ойн баяр наадам болгон жил бүр тэмдэглэж иржээ. |
| **Эвентийн онцлог** | | Олон улсын жуулчдын сонирхлыг татдаг Монгол улсын уламжлал, соёлын томоохон эвент юм. Жуулчид Монгол улсын үндэсний их баяр наадмын үеэр болдог бусад эвентүүдэд оролцох боломж их байдаг. Эвентийн зорилтот зах зээлийн хувьд дотоод, гадаадын жуулчид аль аль нь боловч дотоодын жуулчдад илүү чиглэгддэг. |

*Эх үүсвэр: Судлаачийн тооцоо*

### Хүснэгт 4. 5 “Улаанбаатар өвлийн наадам”-ын свот шинжилгээ

| | | |
|---|---|---|
| SWOT анализ | **Strengths: Давуу тал** | - Үйлчилгээний хүчин чадал өндөр газар буюу Нийслэл Улаанбаатар хотод болдог давуу талтай<br>- Аялал жуулчлалын улирлыг уртасгах, өвлийн аялал жуулчлалыг дэмжихээр зохиогддог<br>- Төрийн дэмжлэг, ялангуяа Нийслэлийн ЗДТГ, НАЖГ-ын шууд хариуцан зохион байгуулдаг эвент тул албан байгууллагуудын оролцоо, идэвх өндөр байдаг |
| | **Weaknesses: Сул тал** | - Мөсөн сур, мөсөн шагайн зориулалтын талбайтай болох шаардлагатай.<br>- Олон улсын тамирчдын оролцоо бага байгааг нэмэгдүүлэх шаардлагатай.<br>- Бусад гадаад улсуудын цас, мөсний баяруудаас ялгарах зүйл, онцлох имидж бага байдал |
| | **Opportunities: Боломж** | - Олон улсын өвлийн спортын наадмуудын туршлага судлан хөгжүүлэх боломжтой.<br>- Олон улсын эвентийн холбоонд нэгдсэнээр өвлийн АЖ-ыг хөгжүүлэхэд дэмжлэг олох боломжтой |
| | **Threats: Аюул** | - Харбин, Манжуур зэрэг хотуудад өвлийн наадам, цас мөсний баяр олон үзэгч, нэр хүндтэй зохион байгуулагдаж байгаа байдал |
| **Товч танилцуулга** | | Нийслэлийн аялал жуулчлалын газар, мэргэжлийн холбоод хамтран 2010 оноос хойш жил бүрийн 2-р сард Улаанбаатар хотод зохион байгуулж ирсэн.<br>Уг арга хэмжээ нь тусгай сонирхлын аялал жуулчлалыг хөгжүүлэх, жуулчны улирлын хугацааг уртасгах, өвлийн улирлын уламжлалт болон орчин үеийн экстрим спортыг түгээн дэлгэрүүлэх, өвлийн улиралд Улаанбаатар хотод ирэх жуулчдын тоог нэмэгдүүлэх зорилготой.<br>Энэхүү эвент нь оролцогчдын тоогоор дээгүүрт орж буй бөгөөд 2019 оны арга хэмжээнд нийт 9000 гаруй хүн оролцсоноос 200 гаруй нь гадаадын жуулчид байсан. |
| **Эвентийн онцлог** | | Эвентийн зорилтот зах зээл нь дотоод, гадаадын жуулчид аль аль нь болно. |

*Эх үүсвэр: Судлаачийн тооцоо*

### Хүснэгт 4. 6 “PLAYTIME хөгжмийн наадам”-ын свот шинжилгээ

| | | |
|---|---|---|
| SWOT анализ | **Strengths: Давуу тал** | - Орчин үеийн хөгжмийн урлагийг үндэсний урлагтай хослуулан шинэ эвентийг бий болгож байгаагаараа давуу талтай.<br>- Монгол улсын хэмжээнд хамгийн том хөгжмийн наадам болж гадаадын оролцогчид олныг татаж байна.<br>- Монгол улсаас дэлхийд танигдсан “ХҮ Хамтлаг” зэрэг хүчтэй оролцогч нар гарч ирсэн |
| | **Weaknesses: Сул тал** | - Үндэсний язгуур урлагийн төрөл, жанрыг бага агуулдаг.<br>- Гадаадын оролцогчид цөөн улс орнуудаас ихэвчлэн ирдэг. |
| | **Opportunities: Боломж** | - Азийн болон олон улсын хөгжмийн бусад наадмууд хамтран ажиллах, тодорхой хуваарийн дагуу зохион байгуулалттай хийгдэж буй байдал<br>- Орчин үеийн амьд хөгжмийн урсгалыг сонирхогч залуусын тоо дэлхийн хэмжээнд тогтмол өсөн нэмэгдэж байгаа байдал |

| | | |
|---|---|---|
| | **Threats: Аюул** | - К-Поп зэрэг урлагийн урсгал, чиглэл залуусын дунд хүчтэй байгаа<br>- Зүүн хойд Азийн амьд хөгжмийн наадмууд ялгарал, давуу талаа тогтмол сайжруулж байгаа. |
| **Товч танилцуулга** | | Энэхүү наадам нь орчин үеийн хөгжмийн урлагаар дамжуулан Улаанбаатар хотыг Азийн тэргүүлэх хөгжмийн аялал жуулчлалын хот болгох зорилготой юм. Уг арга хэмжээ нь 2002 оноос хойш зохион байгуулагдаж байгаа бөгөөд нийт 100 гаруй хамтлаг, уран бүтээлчид өөрсдийн уран бүтээлээ 30,000 гаруй үзэгчдэд 3 хоногийн турш хүргэдэг. |
| **Эвентийн онцлог** | | Эвентийн зорилтот зах зээл нь олон улсын жуулчид болон дотоодын залуу үеийнхэн юм. |

*Эх үүсвэр: Судлаачийн тооцоо*

### Хүснэгт 4. 7 "Хийморь морьт харваа" фестивалийн свот шинжилгээ

| | | |
|---|---|---|
| **SWOT анализ** | **Strengths: Давуу тал** | - Монголчууд морьт харвааны маш эртний түүхтэй.<br>- Морь унаж, нум сум харвах уламжлалыг хадгалан үлдээх клуб, дугуйлан хичээллүүлж уг эвентэд оролцогчдын тоо тогтмол нэмэгдэж байгаа<br>- Олон орны морьт харваачид нэг дор цугларан туршлага солилцох давуу талтай |
| | **Weaknesses: Сул тал** | - Эвент зохион байгуулагддаг талбайг шинэчлэн сайжруулах шаардлагатай<br>- Зохион байгуулагдаад удаагүй учир цөөн гадаад жуулчид ирдэг |
| | **Opportunities: Боломж** | - Олон улсад морьт харвааны спорт маш хурдацтай хөгжиж байна. Тэр хэрээр сонирхон ирэх гадаад оролцогчид, жуулчдын тоо нэмэгдэх боломжтой.<br>-Олон улсын эвентийн холбоонд мэдээлэл, сурталчилгаагаа хүргэж хамтран ажилласнаар гадаад жуулчдын тоог нэмэгдүүлэх боломжтой<br>- Дэлхийн морин спорт, морин аяллын байгууллагуудтай хамтран ажиллах боломжтой<br>-Олон улсын морьт харвааны ДАШТ-ийг 2022 онд Монгол улсад зохион байгуулахаар болсон нь энэхүү эвентийн хувьд олон улсад хурдан хугацаанд танигдах боломж нээж байна. |
| | **Threats: Аюул** | - Казакстан улсад морьт харвааны томоохон тэмцээн зохион байгуулагддаг<br>- Адууны ханиад зэрэг малын гоц халдварт өвчний гаралт нэмэгдэх болсон |
| **Товч танилцуулга** | | Монгол морийг дэлхийд сурталчлан таниулах, морь унаж, нум сум харвах уламжлалыг Монголчууддаа өвлүүлэн үлдээх зорилгоор 2019 оноос Хан Монгол морьтны холбооноос бусад холбоодтой хамтран зохион байгуулж байна. |
| **Эвентийн онцлог** | | Эвентийн зорилтот зах зээл нь дотоод болон гадаадын жуулчид. Богино хугацаанд дотоод жуулчид, урт хугацаанд гадаад жуулчдын тоог нэмэгдүүлэх зорилготой. |

*Эх үүсвэр: Судлаачийн тооцоо*

### Хүснэгт 4. 8 “Алтан бүргэд” бүргэдийн баярын свот шинжилгээ

| | | |
|---|---|---|
| SWOT анализ | **Strengths: Давуу тал** | - Бүргэдээр ан хийлгэх зан үйл Дэлхийн өвд бүртгэгдсэн соёлын өв<br>- Эвентийн үеэр зөвхөн Казах түмний соёл уламжлалаас гадна Урианхай, Торгууд, Захчин, Дөрвөд зэрэг олон ястны соёлын өвтэй танилцах боломжтой |
| | **Weaknesses: Сул тал** | - Эвент зохион байгуулагддаг орчин, талбай бага, үйлчилгээний байгууллагын хүчин чадал сул.<br>- Бүргэдийн тэмцээн насны ангилалгүй явагддагаас тэмцээний дараа маргаан гардаг сул талтай |
| | **Opportunities: Боломж** | - Төрийн болон төрийн бус байгууллага нэгдэж “Казах шувуулахуйн холбоо” байгуулж Олон улсад сурталчлах зорилго тавьж байгаа.<br>- Хил орчмын аялал жуулчлалыг хөгжүүлэх боломжтой. ОХУ-аас жуулчид ирж оролцох боломжтой<br>- “Алтайн алтан цагираг” ОУ-ын аялал жуулчлалын маршрут идэвхжих хандлагатай байгаа |
| | **Threats: Аюул** | - Казах үндэстний бүргэдээр ан хийлгэх зан заншил, соёлын өвийг ашиглан Казакстан, Киргиз улсууд олон улсыг хамруулсан том эвентүүд зохион байгуулж байгаа.<br>- Бүргэдээр ан хийлгэх зан үйлийг Дэлхий соёлын өвд бүртгэхдээ Ази, Европ, Арабын 18 улсын дунд бүртгэсэн тул эдгээр орнуудын аль нь ч томоохон бүргэдийн баяр зохиох магадлалтай |
| **Товч танилцуулга** | | 1999 онд буюу анх удаа зохиогдсон Бүргэдийн баярт 30 жуулчин ирж байсан бол 2019 онд нийт 1000-3000 жуулчин ирсэн байна.<br>Уг арга хэмжээний үеэр Көкбар, Кыз хуар, Тенге илүү, Сур харваа зэрэг тэмцээнүүдийг зохион байгуулдаг ба жуулчдад зориулсан тэмцээн уралдаан ч явагддаг.<br>Зохион байгуулалтын үеэр 13 бааз, зочид буудал нийлээд өдөртөө 1044 хүнд үйлчлэх хүчин чадалтай. |
| **Эвентийн онцлог** | | Эвентийн зорилтот зах зээл нь дотоод, гадаадын жуулчид аль аль нь юм. |

*Эх үүсвэр: Судлаачийн тооцоо*

### Хүснэгт 4. 9 “Хөх сувд” Хөвсгөлийн мөсний баярын свот шинжилгээ

| | | |
|---|---|---|
| SWOT анализ | **Strengths: Давуу тал** | - Үзэсгэлэнт Хөвсгөл нуурын эрэгт, байгалийн сайханд зохион байгуулдаг давуу талтай<br>- Дэд бүтцийн хувьд давуу талтай<br>- Өвлийн аялал жуулчлалын бүтээгдэхүүн хөгжүүлэх, аялал жуулчлалын улирал сунгах давуу талтай.<br>- Мөсний баярт хүрэлцэн ирсэн гадаадын жуулчид хөтөлбөрт орсон уралдаан тэмцээнүүдэд нээлттэй оролцох боломжтой бөгөөд 2019 оноос эхлэн жуулчдад зориулсан “Competition for tourists” арга хэмжээг зохион байгуулж байгаа<br>- Морин чарганы соёлыг давуу талаа болгон сурталчилдаг |
| | **Weaknesses: Сул тал** | - Хөвсгөл далайн мөсөн дээр зохион байгуулагддаг учраас хүрээлэн буй орчныг бохирдуулж болзошгүй.<br>- Өвөл ажилладаг аялал жуулчны баазууд цөөн байдаг тул эвентэд оролцогчдыг байраар хангахад даац хүрэлцэхгүй байх хүндрэлтэй.<br>- Нийслэл хотоос буюу олон улсын нисэх буудлаас хол газар болдог тул дотоодын нислэггүй байх нь сул тал болдог |

| | | |
|---|---|---|
| | **Opportunities: Боломж** | - Өвөл болдог 3 эвентийг нэгтгэж “Дэлхийн нүүдэлчдийн өвөл” гэдэг нэг эвент зохион байгуулах боломжтой<br>- Ханх сумаар дамжин ирэх Орос жуулчдын тоог нэмэгдүүлэх<br>- ОХУ-ын Буриад улсад болдог өвлийн аялал жуулчлалын эвентүүдтэй хамтран маршрут, хөтөлбөр хэрэгжүүлэх боломжтой |
| | **Threats: Аюул** | - Хөвсгөл далайн мөсийг шалгах, мөс цөмрөх аюулаас урьдчилан сэргийлэх арга хэмжээ авах шаардлагатай байдаг. Цаг агаарын нөхцөл байдал чухал байдаг.<br>- Өвлийн улиралд болдог эвент тул гадаадын жуулчдын тоо бага байх аюултай |
| **Товч танилцуулга** | | Хөх сувд мөсний баяр нь 2000 оноос хойш жил бүр 3-р сарын эхний өдрүүдэд зохион байгуулагддаг. Мөсний баяр анх зохион байгуулагдсанаасаа эхлэн гадаад, дотоодын жуулчдын сонирхлыг татаж жил бүр оролцогчдын тоо нэмэгдэж ирсэн. Анхны жил нутгийн 70 гаруй дотоодын иргэд оролцож байсан бол 2013 онд 10 мянга, 2019 онд 30 мянган дотоодын оролцогчид, гадаадын 15 орны 120 орчим жуулчин хүрэлцэн ирсэн байна. |
| **Эвентийн онцлог** | | Эвентийн зорилтот зах зээл нь дотоодын жуулчид юм. Жилдээ 100-200 гадаад жуулчид ирдэг. |

*Эх үүсвэр: Судлаачийн тооцоо*

### Хүснэгт 4. 10 “Монгол туургатны язгуур соёслын олон улсын их наадам”-ын свот шинжилгээ

| | | |
|---|---|---|
| **SWOT анализ** | **Strengths: Давуу тал** | - Олон улсын жуулчдад Монголын язгуур урлаг, ёс заншлыг танилцуулдаг Монгол туургатны соёлын солилцоо явагддаг олон улсын шинж чанартай томоохон эвент юм.<br>- Язгуур урлаг дотроо чиглэл чиглэлээр нь ангилж нарийвчлан тэмцээн зохиодог.<br>- Олон улсаас наадамд оролцохоор ирсэн оролцогчдыг хил дээрээс тосч авах, эвентийн дараа богино хугацааны аялал зохион байгуулж өгөх зэрэг үйлчилгээ үзүүлдэг.<br>- Жил болгон тогтсон өдрөө тогтмол зохион байгуулагддаг. |
| | **Weaknesses: Сул тал** | - Санхүүжилтийн хувьд нэг жуулчны баазаас гардаг учраас хүндрэлтэй байдаг.<br>- Урлагийн наадам болохоор техник хэрэгслийн бэлэн байдал, чанар дээр анхаарах шаардлагатай болдог<br>- Алс баруун хязгаарт болдог тул ирж буй гадаадын жуулчдын тээвэр, ялангуяа дотоодын нислэгийн хувьд ихээхэн хүндрэл үүсдэг<br>- Өвөр Монгол оролцогчдын тоо цөөн байгаа нь нийт Монгол туургатан улсуудыг бүрэн хамруулахад сул тал болж байна |
| | **Opportunities: Боломж** | - Олон улсад суугаа Монгол туургатнуудыг “Өвгөдийн нутгаар аялуулах” аялал жуулчлалын шинэ бүтээгдэхүүн, маршрут гаргах боломж байна.<br>- Хятадын өмнөд хэсэг, Тайвань, Япон, Солонгост байгаа Монгол угсаатныг оролцуулах боломж байгаа. |

| | | |
|---|---|---|
| | | - Хил орчмын аялал жуулчлалыг хөгжүүлэх боломжтой.<br>- Ази, Европын ардын урлагийн наадмуудтай хамтарч ажиллах, туршлага солилцох боломж бий. |
| | **Threats: Аюул** | - Цаг үеийн шаардлагаар хөтөлбөрөө баяжуулж модерн, этник урлагийн үзүүлбэр нэмж байгаа<br>- Бусад Монгол туургатан ард түмэн язгуур соёл, урлагийн эвентүүд бий болгох, олон улсад сурталчлах |
| **Товч танилцуулга** | | Уг наадмыг “Онцын тасархай тур” ХХК нь 2006 оноос хойш жил болгоны 8 дугаар сарын 04-ний өдөр тасралтгүй зохион байгуулж ирсэн. Онцын тасархай жуулчны баазаас бүх зохион байгуулалт, зардлыг гаргадаг. Зохион байгуулагчид цаашид уг арга хэмжээг түшиглэн аялал жуулчлалын өөр эвентүүд зохион байгуулахаар төлөвлөж байна. Язгуур урлагийн наадмаас гадна нүүдэлчдийн соёлыг эвентээрээ дамжуулан үзүүлж нүүдэл, ачлага, гэр барих, эсгий хийх, ноос цохих зэрэг Монгол ахуйг сурталчлах үзүүлбэрүүд гаргадаг. |
| **Эвентийн онцлог** | | Эвентийн зорилтот зах зээл нь гадаад жуулчид тэр дундаа халимаг, Тува, БНХАУ-ын ӨМӨЗО-ны Ордос юм. Жуулчид, наадмын оролцогчдыг татахын тулд зорилтот зах зээлд ТВ сувгуудаар (ОРТ1, Ордос ТВ г.м) сурталчилгаа цацах, тур операторуудтай найдвартай түншлэл үүсгэж ажилладаг. |

*Эх үүсвэр: Судлаачийн тооцоо*

### Хүснэгт 4. 11 “Талын түмэн адуу” эвентийн свот шинжилгээ

| | | |
|---|---|---|
| **SWOT анализ** | **Strengths: Давуу тал** | - Монголын уламжлалт адуу дагасан соёлыг хадгалж, хамгаалах зорилгыг эвентийн давуу талаа болгодог<br>- Батноров сумын онцлог шингэсэн, уламжлалт адуун соёл, адууны эдлэл хэрэглэлийн үзүүлэн, музейг оролцогчдод дэлгэн үзүүлдэг гэдгээрээ дахин давтагдашгүй онцлог, давуу талтай<br>- Сүүлийн жилүүдэд зохион байгуулалтын шинэчлэлт хийж мэргэжлийн баг хөлсөлж ажиллуулдаг болсон.<br>- Цаашид ч гэсэн зохион байгуулалтаа мэргэжлийн түвшинд аваачих менежментийн шинэчлэлт хийх төлөвлөгөөтэй<br>- Зохион байгуулалтын дараа үйл ажиллагааны тайланг тогтмол бэлтгэж санхүүжилт олгосон газруудад илгээдэг. |
| | **Weaknesses: Сул тал** | - Эдийн засгийн үр өгөөж өндөртэй жуулчдыг татаж чадахгүй байгаа нь хамгийн том сул тал болж байна.<br>- Уг арга хэмжээг 3 өдөр зохион байгуулдаг боловч зохион байгуулж буй газарт байршуулах хэрэгслийн дутагдалтай (30 ор хоног) байдаг учраас холын жуулчдыг оролцох боломжийг хааж байна. Ингэснээр тухайн эвентийг орон нутгийн хэмжээний оролцогчдын түвшинтэй болгож байна. Явуулын кемп ажиллуулж үзсэн боловч зардал өндөр байсан. |
| | **Opportunities: Боломж** | - Ижил төрлийн эвент зохион байгуулдаг эвент зохион байгуулагч нар хамтарч ажиллах боломжтой. Ингэснээр зардал хэмнэж, үр ашгаа өндөрсгөх, эрсдлээ хувааж үүрэх, оролцогчдоо тарамдуулахгүй байх боломжтой. |

| | | |
|---|---|---|
| | | - Олон улсад Америк ковбой адуучидтай хамтарч ажиллах, тэдгээрийг урих, Монгол адуучдаа явуулж туршлага судлах боломжтой |
| | **Threats: Аюул** | - Эвентийн утга агуулга ижил, цаг хугацааны хувьд ойролцоо зохион байгуулагдаж буй эвентүүд оролцогчдын тоог бууруулах магадлалтай байна.<br>- Малын өвчин, цаг агаарын нөхцөл байдал их нөлөөтэй. Тэмцээнд оролцогчдын аюулгүй байдал чухал байна. |
| **Товч танилцуулга** | | "Мөнх харилцаа" ТББ-аас жил бүр зохион байгуулдаг "Талын түмэн адуу" эвент нь 2013 оноос хойш жил бүр Хэнтий аймгийн Батноров суманд зохион байгуулагддаг, адууны соёлыг сурталчлах үзүүлбэр, тэмцээн уралдаан, урлаг соёлын арга хэмжээг хослуулсан 3 өдрийн эвент юм. Эвентээ хөгжүүлэхэд анхаарч 2019 онд бүтээгдэхүүн хөгжүүлэлт, зах зээлийн судалгаар 20 сая төгрөгөөр хийлгэж байсан туршлагатай эвент байна. Эвентээ цаашид хөгжүүлэхэд анхаарч 2019 онд бүтээгдэхүүн хөгжүүлэлт, зах зээлийн судалгаар 20 сая төгрөгөөр хийлгэж байсан туршлагатай. Уг тайлангаар Хэнтий аймагт 100 сая төгрөгийн эдийн засгийн үр өгөөж үлдсэн хэмээн тооцоолжээ.[88] |
| **Эвентийн онцлог** | | Эвентийн зорилтот зах зээл нь 90% дотоодын жуулчид, 10% гадаадын жуулчид. Орон нутгийн хэмжээний эвент. |

*Эх үүсвэр: Судлаачийн тооцоо*

### Хүснэгт 4. 12 "Түмэн тэмээний баяр" эвентийн свот шинжилгээ

| | | |
|---|---|---|
| **SWOT анализ** | **Strengths: Давуу тал** | - Дэлхийд ховорхон хоёр бөхт тэмээний сүргийн цөм болох бүс нутагт зохион байгуулагддаг.<br>- Мэргэжлийн тэмээний хөтөч, сургагч үзүүлбэр үзүүлдгээрээ давуу талтай.<br>- Тэмээний баярын эвентээс гадна говь нутгийн байгаль, ард түмний ахуй амьдрал, палеонтологийн олдворт газруудаар аялал хийх боломжийг олгодог |
| | **Weaknesses: Сул тал** | - Дотоодын нислэг, ариун цэврийн өрөө, зардал,<br>- Голлох хүндрэл бэрхшээл бол зохион байгуулалт, түүний уялдаа холбоог сайжруулах явдал<br>- Өвлийн улиралд зохиогддог тул үйлчилгээний байгууллагын хүчин чадал бага байдаг<br>- Шүлхий зэрэг малын гаралтай гоц халдварт өвчин шууд нөлөөлдөг |
| | **Opportunities: Боломж** | - Азийн тэмээн холбооноос зохион байгуулдаг өвлийн "Nomadic game"-ийн хэсгийн тоглолтуудыг Монголд зохион байгуулах боломжтой.<br>- Тэмээгээ түшиглэж гадаад харилцаагаа хөгжүүлэх, олонд танигдах боломжтой. |
| | **Threats: Аюул** | - БНХАУ, ӨМӨЗО, Киргиз улсад тэмээний баяр хийж эхэлж байна.<br>- Нийгмийг хамарсан цар тахал, малын гаралтай гоц халдварт өвчин |
| **Товч танилцуулга** | | "Гайхамшигт говь аялал жуулчлалын холбоо" ТББ-аас Өмнөговь аймгийн Булган сумын ЗДТГ-тай хамтран 1997 оноос хойш жил бүр зохион байгуулж байна. Тус эвент нь дэлхийд ховорхон хоёр бөхт тэмээн сүргийг хайрлан хамгаалах, тэмээнд олон нийтийн |

[88] Талын түмэн адуу эвентийн 2021 оны тайлан

| | |
|---|---|
| | анхаарлыг хандуулах, тэмээчин ардын хөдөлмөрийг үнэлэх, тэмээний амьдын үнэлэмжийг нэмэгдүүлэх, аялал жуулчлалаас ард иргэдийн ашиг орлогыг нэмэгдүүлэх зорилготой. |
| **Эвентийн онцлог** | Эвентийн зорилтот зах зээл нь дотоодын оролцогчид юм. |

*Эх үүсвэр: Судлаачийн тооцоо*

### Хүснэгт 4. 13 "Хонины найр" эвентийн свот шинжилгээ

| | | |
|---|---|---|
| **SWOT анализ** | **Strengths: Давуу тал** | - Хустайн нуруу аялал жуулчлалын баазыг түшиглэн зохион байгуулдаг тул, хоол, байр, үйлчилгээний хувьд давуу талтай.<br>- Улаанбаатар хотоос холгүй тул хотод буусан жуулчид ирж оролцоход давуу талтай.<br>- Хамгийн гол давуу тал нь малын бэлчээр дээр нүүдэлчин ахуй соёлыг шууд харуулдаг нь гол давуу тал юм.<br>- Эвент зохион байгуулагчид нь шууд малчид өөрсдөө байдаг давуу талтай |
| | **Weaknesses: Сул тал** | - Нэг өдрийн арга хэмжээ бөгөөд хязгаарлагдмал хүрээг хамарч байна.<br>- Зохион байгуулалт сайжруулах, хүн хүч нэмэх шаардлагатай.<br>- Эвентэд туслан гүйцэтгэгчээр оролцдог нутгийн иргэдэд сургалт оруулах, аялал жуулчлалын үйлчилгээний талаарх чадавхыг бэхжүүлэх шаардлагатай байгаа. |
| | **Opportunities: Боломж** | - Дотоодын аялагч нарт уламжлалт ахуйн соёлоо таньж мэдэх, сэргээн санах, уламжлалт идээгээ өдөр тутамдаа хэрэглэх санал сэдэл өгөх зорилгоор дотоодын аялагчдад түлхүү анхаарах боломжтой.<br>- Зохион байгуулалтын хувьд тогтсон цаашид өргөжин тэлэх, хөгжүүлэх боломжтой.<br>- "Угуул иргэдийн холбоо" зэрэг олон улсын байгууллагуудтай хамтран ажиллаж тус эвентийг дэлхийд таниулах боломжтой |
| | **Threats: Аюул** | - Малын халдварт өвчин, цаг агаарын нөхцөл |
| **Товч танилцуулга** | | Төв аймаг Алтанбулаг сумын "Баянсонгинот" малчдын бүлэг 2014 оноос хойш жил болгон 7 дугаар сард Монголчуудын уламжлалт зан үйл, ахуй соёлыг жуулчид болон дотоодын аялагчдад сурталчлан таниулах зорилгоор зохион байгуулдаг. Морь унуулах, нум сум харвуулах зэрэг үйлчилгээ, цагаан идээний үзэсгэлэн худалдаа зохион байгуулдаг. Мөн сайхан хонь шалгаруулах, хонь уралдуулах, аргал түүх тэмцээн насанд хүрэгчдийн дунд, шагай шүүрэх, шагай няслах уралдааныг хүүхдүүдийн дунд зохион байгуулдаг. Төв аймгийн Монгол туургатан театрын уран бүтээлчид урлагийн тоглолт үзүүлдэг байна. |
| **Эвентийн онцлог** | | Эсгий хийх болон бусад үзүүлбэрүүдэд жуулчдыг оролцуулдгаараа онцлог.<br>Эвентийн зорилтот зах зээл нь дотоодын аялагчид тэр тусмаа залуу үеийнхэн байна. |

*Эх үүсвэр: Судлаачийн тооцоо*

### Хүснэгт 4. 14 Нэгдсэн свот шинжилгээ

| | | |
|---|---|---|
| **SWOT анализ** | **Strengths: Давуу тал** | - Монгол улс нь өөрийн гэсэн давтагдашгүй соёл, уламжлал, түүх, ахуйтай ард түмэн юм. Эдгээр онцлог шинжийг агуулсан аялал жуулчлалын эвентүүд байгаа нь цаашид хөгжүүлэх, жуулчдын сонирхлыг татах давуу тал болно. |

| | | |
|---|---|---|
| | | -Цаг уурын нөхцөл байдлаас шалтгаалан өвлийн эвент, тэр дундаа өвлийн спортын эвент хөгжүүлэх давуу талтай.<br>-Сонгогдсон эвентүүд нь бүгд хоорондоо өөр өөрийн гэсэн ялгарах онцлогтой. Тэр онцлог дээрээ тулгуурлан цаашид хөгжих боломжтой эвентүүд юм. Тухайлбал хоёр бөхт тэмээ, адуу хонь зэрэг.<br>-Эвент зохион байгуулагчид мэргэжлийн багуудыг эвентийн зохион байгуулалтад оруулах нь чухал байгааг илэрхийлж байна. |
| | **Weaknesses: Сул тал** | - Монгол улс нь гадаад жуулчдын зорин очдог, эрэлт өндөртэй, аялал жуулчлалаараа дэлхийд танигдсан улс биш юм.<br>-Агаарын нислэг, зам дэд бүтэц, стандарт шаардлага хангасан байршуулах хэрэгсэл, ариун цэврийн өрөө зэрэг материаллаг дэд бүтэц хангалтгүй хөгжсөн.<br>-Аялал жуулчлалын тааламжтай хугацаа богино<br>-Маркетинг, сурталчилгаа муу. Зардлын ихэнх хувийг зохион байгуулалтын зардал эзэлдэг.<br>-Ихэнх эвентүүд өөрсдийн гэсэн цахим хуудасгүй.<br>-Аялал жуулчлалын эдийн засгийн ач холбогдлыг орон нутгийн иргэдэд ойлгуулах<br>-Эвент зохион байгуулагч нарын чадавхыг хөгжүүлэх, мэргэшүүлэх шаардлагатай. Олон улсын эвентийн менежментийн богино, урт хугацааны сургалтууд, тухайн газар нутагт очиж туршлага судлах, олон улсын эвент зохион байгуулагч нарыг урьж авчирч туршлага судлах  зэрэг олон арга хэлбэр байж болно. |
| | **Opportunities: Боломж** | - Дотоодын хамтрал: Аялал жуулчлалын төстэй агуулга бүхий эвентүүдийг нэгтгэн хамтран зохион байгуулах, нөөцөө нэгтгэх<br>-Гадаад хамтрал: Олон улсын хэмжээний эвентүүдтэй хамтран ажиллах, туршлага солилцох, өөрсдийн соёлоо тус эвентүүд дээр сурталчлах<br>-Мэргэжлийн холбоодод элсэх, үйл ажиллагаанд нь идэвхтэй оролцсоноор бусдад танигдах, холбооноос дэмжлэг авах<br>-ЮНЕСКО-ийн ивээл дор[89] үйл ажиллагаа зохиох эрх авснаар олон улсад нэр хүндээ өсгөх<br>-Эвентийн зохион байгуулалтад дотоод, гадаадын мэргэшсэн багийг оруулж ажиллуулах. Ингэснээр эвентээ чанаржуулах, хамгийн гол нь мэргэшсэн багаас олон зүйлийг сурч үлдэх боломжтой.<br>-Хөгжмийн фестивалийн хувьд Монгол үндэсний хөгжмийг рок хөгжмийн урсгалтай хослуулан Монгол рок урсгалыг гаргаж ирж дэлхийд алдаршсан “The Hu” хамтлагийг түшиглэн сурталчлах боломжтой. |
| | **Threats: Аюул** | -Монголчуудтай адил нүүдлийн соёл иргэншилтэй Казакстан, Киргиз зэрэг улсууд олонд танигдсан, олон улсын хэмжээний, оролцогч ихтэй спортын, соёлын, урлагийн наадмуудыг хийдэг.<br>- Малын халдварт өвчин<br>-Хулгайн гэмт хэрэг<br>-Дэлхийн аялал жуулчлалын өрсөлдөх чадварын индексээр 140 улсаас 93-т жагссан үзүүлэлттэй. |
| | **Онцлог** | Монгол улсын сонгогдсон 10 эвентийн зохион байгуулагчидтай хийсэн фокус бүлгийн ярилцлага болон эвентийн зорилт, ирдэг жуулчдын бүтцээс харахад ихэнх нь бүс нутгийн эвентүүд байна. Голчлон дотоод жуулчиддаа төвлөрч, тэдний эрэлт хэрэгцээнд таарсан үйлчилгээ үзүүлдэг. |

*Эх үүсвэр: Судлаачийн тооцоо*

[89] https://ich.unesco.org/en/8-steps-for-patronage-00402

Эвентийг шинжилж үзэхэд дараах нийтлэг зүйлс байна. Үүнд:

Эвентийн зохион байгуулалтын талаар дотоод бичиг баримт байхгүй. Бичиг, баримттай болсноор зохион байгуулалтын алдаа гарахаас сэргийлнэ, хамтрагч байгууллага, хувь хүмүүстэй харилцах харилцаа, үнэ тариф тодорхой байснаар хамтын ажиллагаа, уялдаа сайжирна;

Эвентийн эдийн засгийн үр ашигтай байдлыг анхаардаггүй;

Эвентүүд маркетингийн зардалдаа хамгийн бага мөнгө зарцуулдаг. Эвент зохион байгуулагдахаас богино хугацааны өмнө сошиалаар төлбөртэй пост тавьдаг. Маркетинг явуулах хугацаа бага байгаа учраас хэрэглэгчид хүргэх ялангуяа орон нутгийн хэмжээний эвентүүд бүс нутгийн, улсын хэмжээний эвент болохын тулд үйл ажиллагааны тайлан болон эвентээ таниулах ажлуудыг тогтмол хийдэг байх шаардлагатай байна. Тухайн эвентийн танилцуулга, тайлан, хөтөлбөр зэргийг олонд түгээдэг сувагтай болох, өөрийн цахим хуудас хөгжүүлж хөтлөх;

Тэмцээн уралдаан бүхий эвентүүд оролцогчдыг сайн татдаг. Эргүүлээд зохион байгуулагчид ч нийт зардлынхаа 50% орчмыг шагналын санд төсөвлөдөг;

Эвент зохион байгуулагчдын хувьд хангамжаа дагаж зохион байгуулалтаа хийвэл үр ашигтай байдаг. Тийм учраас жуулчны бааз, сумын төв зэрэг цахилгаан, ус, байршуулах хэрэгсэл, ариун цэврийн өрөөний асуудлыг тодорхой хэмжээнд шийдсэн газрыг түшиглэх;

Эвент зохион байгуулагчид хоорондоо хамтарч ажиллах сонирхолтой бөгөөд төрийн байгууллага нь санхүүжилт хуваарилж, бодлогоор дэмждэгийнхээ хувьд хувийн хэвшил хоорондын хамтын ажиллагааны гүүр болж ажиллавал сайн байх талаар саналаа хэлж байсан. Үүнийг салбарын зохицуулалт, санхүүжилт олгох журмаар шийдвэрлэж болно гэж үзэж байна;

Эвентийн одоогийн санхүүжилтийг 2-3 дахин нэмэгдүүлснээр үйл ажиллагааг чанаржуулна гэж дийлэнх эвентийн зохион байгуулагчид үзэж байна;

Санал болгож буй 10 эвентийг хөтөлбөрийн хувь хоорондын ялгаатай байдлыг улам тодотгох шаардлагатай байна;

Эвент зохион байгуулах мэргэжлийн баг, найруулагч, контент бэлтгэгчдийн оруулах сонирхолтой байдаг боловч зардлын хувьд хүндрэлтэй байдаг. Улсын төсөв, орон нутгаас өгч буй санхүүжилтийг маркетинг эсвэл мэргэжлийн зөвлөх үйлчилгээнд өгдөг байдлаар зохицуулах эсвэл 10 эвентийг маркетингийг нэгдсэн байдлаар олон улсад маркетинг хийх;

Эвентэд туслан гүйцэтгэгч, хамтрагч хувь хүн, компаниудын аялал жуулчлалын үйлчилгээний талаарх чадавхыг сайжруулах, сургалтад хамруулах шаардлагатай;

Төрөөс зам, дэд бүтэц зэрэгт хөрөнгө оруулалт хийж сайжруулснаар аялал жуулчлалыг дэмжих нь зүйтэй байна.

## 4.2 МОНГОЛ УЛСЫН БОЛОМЖИТ, ШИЛДЭГ 10 ЭВЕНТИЙН ЗОРИЛТОТ ЗАХ ЗЭЭЛ

### 4.2.1 Эвентийн зорилтот зах зээлийг сонгох арга зүй[90]

Маркетерууд сегментчилэлийн үндэс болгон янз бүрийн шалгуурыг ашигладаг. Хэрэглэгчийн зах зээлийг сегментчилэх шалгуурууд нь хүн ам зүйн (нас, хүйс, гэр бүлийн байдал, орлого), газарзүйн байдал, зан үйлийн (ашиг тус, хэрэглээний давтамж, үнэнч байдал) болон сэтгэлзүйн (амьдралын хэв маяг, хувийн шинж чанар) байдал юм. Дотоодын зах зээлийн сегментчилэлээс гадна олон улсын зах зээлийн сегментчилэл хэрэглэгддэг. Өөрөөр хэлбэл газарзүйн байршил (жишээлбэл, улс орнуудыг бүсээр нь бүлэглэх), эдийн засаг, улс төр, хууль эрх зүй, соёлын хүчин зүйлс зэрэг сегментчилэлийн шалгуурт үндэслэн олон улсын ялгаатай сегментүүдийг тодорхойлох шаардлагатай.

Аялал жуулчлалын бүтээгдэхүүн нь зөвхөн дотоодын зах зээлээ төдийгүй олон улсын зах зээлд чиглэсэн байдаг тул олон улсын зах зээлийн сегментчилэлийг ашигладаг. Тиймээс аялал жуулчлалын газар нь тодорхой улс орнуудын (жишээлбэл, Герман ба/эсвэл Францын хэрэглэгчид) эсвэл бүс нутгийн (жишээлбэл, Ойрх Дорнодын хэрэглэгчид) хэрэглэгчдэд чиглэж болно. Зарим олон улсын компаниудын хэрэглэж буй өөр нэг арга бол зах зээлийн сегментчилэл юм (Котлер & Армстронг, 2008, х. 193).

Энэ тохиолдолд компаниуд өөр өөр орноос жуулчид ирдэг ч ижил төстэй хэрэгцээ, худалдан авалтын зан үйл бүхий хэрэглэгчдийн сегментийг хөгжүүлдэг. Жишээлбэл аялал жуулчлалын хувьд экстрим спортыг хөгжүүлэхэд анхаарлаа хандуулдаг газрууд дэлхийн өнцөг булан бүрээс экстримийг мэдрэх сонирхолтой жуулчдыг татах зорилготой байдаг.

**Эвентийн зорилтот зах зээл**

**Хүснэгт 4. 15 Боломжит 10 эвентийн зорилтот зах зээл сонголт**

| № | Эвентийн нэрс | Богино хугацааны зорилтот зах зээл /2022-2026/ | | Урт хугацааны зорилтот зах зээл /2030 он хүртэл/ | |
|---|---|---|---|---|---|
| | | Улс орон | Онцлог /мэргэжил, нас, хэрэгцээ, сонирхол/ | Улс орон | Онцлог /мэргэжил, нас, хэрэгцээ, сонирхол/ |
| 1 | “Алтан бүргэд” бүргэдийн баяр | Монгол, Казахстан, ОХУ, Киргиз | Хэрэглэгч: Соёлын жуулчид буюу 40-с дээш насны, орлого өндөр, аялалд их мөнгө зарцуулдаг гадаадын жуулчид, Монгол аялагчид<br>Оролцогч: Монгол, Казахстан, | Казахстан, ОХУ, Киргиз, Япон, Арабын улсууд, АНУ-ын жуулчид | Хэрэглэгч: Соёлын жуулчид буюу 40-с дээш насны, орлого өндөр, аялалд их мөнгө зарцуулдаг жуулчид<br>Оролцогч: Монгол, |

[90] Rodoula H. Tsiotsou, Target Marketing and Its Application to Tourism, 2012

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| | | | Киргизийн бүргэдчид<br><br>Хэрэглэгч: Хөгжим сонирхогч, ихэвчлэн 35 хүртэлх насны Монгол, гадаад залуучууд<br>Оролцогч: Монгол улсын ба 20 гаруй орнуудын хөгжмийн 9 төрлийн хамтлагууд | | Казахстан, Киргизийн бүргэдчид<br>Хэрэглэгч: Хөгжим сонирхогч бүхийл насны Монгол, гадаад жуулчид<br>Оролцогч: Монгол улсын ба 30 гаруй орнуудын хөгжмийн бүх төрлийн хамтлагууд |
| 2 | Плэйтайм олон улсын хөгжмийн наадам | Монгол, Мексик, АНУ, БНСУ, Тайланд, Филиппин, Япон | | ОХУ, БНХАУ, БНСУ, АНУ, Мексик, Япон болон Зүүн өмнөд Азийн орнууд | |
| 3 | Монгол төрийн их наадам | Монгол, Ази тивийн Нүүдлийн соёл иргэншлийн уламжлалтай орнууд, ба бусад | Монгол, ОХУ-ын Буриад улс, БНХАУ-ын ӨМӨЗО, Киргиз, Казахстан, Балба, Бутан, Төвд ба МУ-ын тэргүүлэх зах зээлийн орнууд /АНУ, Япон, Солонгос, Герман/ | Нүүдлийн соёл иргэншлийн уламжлалтай дэлхийн улс орнууд, ба бусад | Монгол, ОХУ-ын Буриад улс, БНХАУ-ын ӨМӨЗО, Киргиз, Казахстан, Балба, Бутан, Төвд, Кени, Иран, Энэтхэг, Сомали, Алжир, Турк ба МУ-ын тэргүүлэх зах зээлийн орнууд /АНУ, Япон, Солонгос, Герман/ |
| 4 | Хонины найр | Монгол, МУ-ын голлох зах зээлийн орнууд ба Америк тив, Ази тивийн уугуул иргэдийн төлөөлөл | Хэрэглэгч: Соёлын жуулчид болон МУ-ын тэргүүлэх зах зээлийн орнууд /АНУ, Япон, Солонгос, Герман г.м/<br>Оролцогч: Монгол, АНУ-ын уугуул индианууд, Өмнөд Америкийн уугуул иргэд, Япон улсын уугуул иргэд г.м | МУ-ын голлох зах зээлийн орнууд ба дэлхийн нийт уугуул иргэдийн төлөөллийг бүрэн хамруулах | Хэрэглэгч: Соёлын жуулчид болон МУ-ын тэргүүлэх зах зээлийн орнууд /АНУ, Япон, Солонгос, Герман г.м/<br>Оролцогч: Монгол, АНУ-ын уугуул индианууд, Өмнөд Америкийн уугуул иргэд, Япон улсын уугуул иргэд г.м |
| 5 | Талын түмэн адуу | Монгол, АНУ, ОХУ, БНХАУ, Япон, Казахстан, Киргиз | Хэрэглэгч: Адуу сонирхогч, адууны соёлтой улс орнууд, МУ-ын тэргүүлэх зах зээлийн орнууд /АНУ, Япон, Солонгос, Герман г.м/<br>Оролцогч: Монгол, | Нүүдлийн соёл иргэншлийн уламжлалтай дэлхийн улс орнууд, ба бусад | Хэрэглэгч: Адуу сонирхогч, адууны соёлтой улс орнууд болон МУ-ын тэргүүлэх зах зээлийн орнууд /АНУ, Япон, Солонгос, Герман г.м/ |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| | | | АНУ-ын уугуул индианууд, Өмнөд Америкийн уугуул иргэд, Какахстан, Киргиз | | Оролцогч: Монгол, АНУ-ын уугуул индианууд, Өмнөд Америкийн уугуул иргэд, г.м |
| 6 | Түмэн тэмээний баяр | Монгол, ОХУ, БНХАУ, Япон, Казахстан, Киргиз | Хэрэглэгч: Тэмээ сонирхогч, тэмээний соёлтой улс орнууд, МУ-ын тэргүүлэх зах зээлийн орнууд /АНУ, Япон, Солонгос, Герман г.м/ Оролцогч: Монгол, Казахстан, Киргиз | Нүүдлийн соёл иргэншлийн уламжлалтай дэлхийн улс, Арабын улс орнууд, Энэтхэг ба бусад | Хэрэглэгч: Тэмээ сонирхогч жуулчид МУ-ын тэргүүлэх зах зээлийн орнууд /АНУ, Япон, Солонгос, Герман г.м/ Оролцогч: Монгол, Казахстан, Киргиз |
| 7 | Улаанбаатарын өвлийн наадам | Монгол, ОХУ, БНХАУ, Япон, Казахстан, Киргиз | Хэрэглэгч: спорт эвент тэр дундаа өвлийн спорт эвент сонирхогч улс орнууд, МУ-ын тэргүүлэх зах зээлийн орнууд /АНУ, Япон, Солонгос, Герман г.м/ Оролцогч: Монгол, АНУ-ын уугуул индианууд, Өмнөд Америкийн уугуул иргэд | Нүүдлийн соёл иргэншлийн уламжлалтай дэлхийн улс орнууд, ба бусад | Монгол, ОХУ-ын Буриад улс, БНХАУ-ын ӨМӨЗО, Киргиз, Казахстан, Балба, Бутан, Төвд, Кени, Иран, Энэтхэг, Сомали, Алжир ба МУ-ын тэргүүлэх зах зээлийн орнууд /АНУ, Япон, Солонгос, Герман/ |
| 8 | “Хийморь” морьт харваа, морин тулааны фестиваль | Монгол, ОХУ, БНХАУ, Япон, Казахстан, Киргиз, Турк, БНСУ | Хэрэглэгч: Адуу сонирхогч, морь харвааны спорт сонирхогч улс орнууд, МУ-ын тэргүүлэх зах зээлийн орнууд /АНУ, Япон, Солонгос, Герман г.м/ Оролцогч: Монгол, АНУ-ын уугуул индианууд, Өмнөд Америкийн уугуул иргэд, | Нүүдлийн соёл иргэншлийн уламжлалтай дэлхийн улс орнууд, ба бусад | Монгол, ОХУ-ын Буриад улс, БНХАУ-ын ӨМӨЗО, Киргиз, Казахстан, Балба, Бутан, Төвд, Кени, Иран, Энэтхэг, Сомали, Алжир ба МУ-ын тэргүүлэх зах зээлийн орнууд /АНУ, Япон, Солонгос, Герман/ |
| 9 | Монгол туургатны язгуур соёлын ОУ-ын Их наадам | Монгол, Тува, Халимаг, БНХАУ-ын ӨМӨЗО | Хэрэглэгч: Нүүдэлчин ард түмний ахуй соёл, язгуур урлаг сонирхогчид, МУ-ын тэргүүлэх зах зээлийн орнууд /АНУ, Япон, | Монгол туургатан улс орнууд, АНУ, Герман, Япон, Солонгос, | Хэрэглэгч: Соёлын жуулчид, нүүдэлчин ард түмний язгуур урлаг сонирхогч болон МУ-ын тэргүүлэх зах |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| | | | Солонгос, Герман г.м/ Оролцогч:Монгол, ОХУ, БНХАУ | | зээлийн орнууд /АНУ, Япон, Солонгос, Герман г.м/ Оролцогч: Монгол, ОХУ, БНХАУ болон дэлхийгээр таран суугаа Монгол туургатан улс орнууд |
| 10 | Хөх сувд - Хөвсгөлийн мөсний баяр | Монгол, БНХАУ, ОХУ, БНСУ, Япон, Герман | Хэрэглэгч: Өвлийн наадам сонирхогч улс орнууд, МУ-ын тэргүүлэх зах зээлийн орнууд /АНУ, Япон, Солонгос, Герман г.м/ | орнууд, ба бусад | Монгол, ОХУ-ын Буриад улс, БНХАУ-ын ӨМӨЗО, Киргиз, Казахстан, Балба, Бутан, Төвд, Кени, Иран, Энэтхэг, Сомали, Алжир ба МУ-ын тэргүүлэх зах зээлийн орнууд /АНУ, Япон, Солонгос, Герман/ |

## 4.3. ЭВЕНТИЙН СТРАТЕГИЙН ЗОРИЛТ, ҮР ДҮНТЭЙ ХЭРЭГЖҮҮЛЭХ ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТҮҮД, ОРОЛЦОГЧ ТАЛУУДЫН ҮҮРЭГ

### 4.3.1 Эвентийн стратегийн зорилт, шалгуур үзүүлэлтийг тодорхойлоход хэрэглэгдэх арга зүй

Эвентээ амжилттай болгохын тулд тухайн эвентийн зорилго, зорилт нь зорилтот зах зээл болон бусад холбогдох талуудын хэрэгцээ шаардлагад нийцсэн тодорхой бөгөөд бат бөх үзэл баримтлал шаардлагатай.

Энэхүү бүлгийн стратегийн зорилтуудыг дэвшүүлэхдээ дараах арга зүйг харгалзан үзсэн. Үүнд:

1. Зорилтууд SMART шинж чанарыг хангасан байх;
2. Бусад бодлогын баримт бичгүүдийн зорилго, зорилтуудтай нийцсэн байх;
3. Тогтвортой хөгжлийн үзэл баримтлалтай нийцсэн байх.

**5W арга:**

Эвентийг төлөвлөх, зохиох үйл явцын нэг хэсэг болгон 5В /W/-ийг асуултад хариулах арга зүйг ашиглаж болно.[91] Үүнд:

[91] www.visitmonmouthshire.com/events-management/aims.aspx

- What – юу? /Эвентийн төрөл, хамрах хүрээ юу вэ?/
- Why – яагаад? /Эвентийг яагаад, ямар үр дүнд хүрэхээр хийх вэ?/
- Who – хэн? /Эвентийн үзэгч, оролцогчид хэн байхаар төлөвлөх вэ?/
- Where – хаана? /Байршил, газрыг хэрхэн төлөвлөсөн бэ?/

Marketing – Зорилтот хэрэглэгчдийн хэрэгцээнд хэрхэн нийцэх
Functional – Хүчин чадал, зохион байгуулалтыг төлөвлөх
Operational – Ус, эрчим хүч, зогсоол, тайз, талбайг харгалзах
Risk management – Аюулгүй байдал, хяналт, онцгой байдлыг харгалзах
Financial – Санхүүжилт, төсвийн хувьд биелэгдэх боломжтой байх
Aesthetic – Хэрэглэгчийн сэтгэл татах байдал ба бусад үзмэртэй хорших

- When – хэзээ? /Огноог зорилтот зах зээлд нийцүүлсэн эсэх?/

**SMART арга:**

**S – SPECIFIC –тодорхой, нарийвчилсан**
Эвент болох газар, орон нутгийг тодорхой төлөвлөсөн байх
**M – MEASURABLE – хэмжигдэхүйц**
Эвентийн зорилгыг тоон хэмжээсээр төлөвлөсөн байх
**A – ATTAINABLE – хүрч чадахуйц /**Achievable/
Эвентийн зорилго нь биелэгдэхүйц, бодит үр дүнг төлөвлөсөн байх
**R – RELEVANT – чухал /**Realistic/
Эвентийн зорилго нь бусад бодлогын баримт бичгүүдэд нийсэн байх
**T – TIME-BOUND - хугацаа хязгаартай**
Эвентийн зорилго нь тодорхой цаг хугацаанд хэрэгжүүлэхээр төлөвлөх

**TOWS матриц:**

Дотоод болон гадаад орчны нөхцөл байдлын дүн шинжилгээг SWOT анализын аргаар хийсний үр дүнд үндэслэн боломж, давуу талаа хэрхэн ашиглаж сул талаа засах, эрсдлээс сэргийлэх стратегийн зорилтууд, түүний хүрээнд хийгдэх ажлуудыг сонгох аргачлалыг TOWS матриц буюу хослолын арга гэж нэрлэдэг[92].

**Хүснэгт 4. 16 TOWS матриц ашиглан стратеги тодорхойлох**

| ***SO - “Maxi-maxi” стратеги*** | ***ST - “Maxi-mini” стратеги*** |
|---|---|
| Давуу тал дээрээ тулгуурлан боломжоо ашиглах стратеги | Давуу талаа ашиглан аюулаас зайлсхийх стратеги |
| ***WO - “Mini-maxi” стратеги*** | **WT - “Mini-mini” стратеги** |
| Боломжоо ашиглан сул талаа бууруулах стратеги | Сул талаа бууруулан аюулаас зайлсхийх стратеги |

[92] “Strategy development using TOWS matrix for international project risk management based on prioritization of risk categories”. Rahul Vishwanath Dandage and others. 22 March 2019 . *“International Journal of Managing Projects in Business”. ISSN: 1753-8378.*

*II.*

### 4.3.2 Монгол улсын эвент аялал жуулчлал хөгжүүлэх зорилго, зорилтуудад хийсэн дүн шинжилгээ

Эвентүүдийн стратегийн зорилго, зорилтыг дэвшүүлэхдээ макро түвшинд буюу улс орны хэмжээнд микро түвшинд буюу эвент бүрийн зорилт хэмээн ялгаж үзлээ. Үүнд:

I. Монгол улсын аялал жуулчлалын эвентийг хөгжүүлэх стратегийн зорилго, зорилтууд

II. Боломжит 10 эвентийн стратегийн зорилго, зорилтууд

**Монгол улсын аялал жуулчлалын эвентийг хөгжүүлэх стратегийн зорилго, зорилтууд**

Монгол улсад аялал жуулчлалын 100 гаруй эвентүүд нийслэл болон хөдөө орон нутагт зохион байгуулагдаж байгаа талаар өмнөх бүлэгт дурдсан билээ. Эдгээр эвентүүдийг нэгтгэн нэг бодлого, чиглэлд зангидах зорилгоор энэхүү төлөвлөлтийг хийж байна.

Монгол улсад аялал жуулчлалын эвентийг **хөгжүүлэх зорилго** нь эвентээс улс, орон нутгийн хэмжээнд үлдэх эдийн засгийн үр өгөөжийг нэмэгдүүлэх улмаар дэлхийн түвшинд өрсөлдөх “Монгол мега эвент” бий болгох явдал юм.

Монгол улсын эвентийн **стратегийн зорилгууд**:

1. Эвентийн удирдлага, сургалтын тогтолцоо, мэдээллийн санг бүрдүүлэх
2. Эвентээс орон нутагт үлдэх эдийн засгийн үр өгөөжийг нэмэгдүүлэх
3. Оролцогч талуудын оролцоо, нөлөөллийг нэмэгдүүлэх
4. Эвентэд оролцогч, үзэгчдийн тоог нэмэгдүүлэх, ялангуяа гадаадын жуулчдын тоог өсгөх.

**Боломжит 10 эвентийн стратегийн зорилго, зорилтууд**

Боломжит, шилдэг 10 эвентийн богино хугацааны зорилтуудыг зах зээл, хэрэглэгчээ нэмэгдүүлэх, маркетинг сурталчилгаагаа сайжруулах, зохион байгуулалт, менежментээ сайжруулах, санхүүжилт нөөцөө нэмэгдүүлэх, хамтын ажиллагаагаа сайжруулах гэсэн 5 үндсэн чиглэлээр тодорхойлсон. Учир нь цахим болон биечилсэн уулзалт ярилцлага болон түүвэр судалгааны үр дүнгээс үзэхэд эвент зохион байгуулагчдын хувьд одоогоор дотоодын зах зээлд түлхүү анхаарч байгаа бөгөөд санхүүжилтийн хувьд хүндрэлтэй байгаа нь ажиглагдсан билээ.

Иймд манай судалгааны багийн зүгээс эвентүүдийн стратегийн зорилтыг тодорхойлохдоо бүтээгдэхүүний ялгарал буюу эвентийн онцлог шинжийг хэрхэн бүрдүүлж гадаадын жуулчдын тоог ямар хэмжээтэй нэмэгдүүлэх, үүний тулд гадаад, дотоодын байгууллагуудтай хэрхэн хамтран ажиллах вэ гэдгийг онцолсон.

**Бусад бодлогын баримт бичгүүдийн зорилго, зорилтуудад хийсэн дүн шинжилгээ:**

Боломжит, шилдэг 10 эвентийн стратеги зорилтуудыг тодорхойлохын тулд бусад бодлогын баримт бичгүүдтэй уялдсан байх нь нэн чухал. Иймээс энэхүү судалгааны хүрээнд аялал жуулчлалын эвентийг хөгжүүлэх талаар тусгагдсан бодлогын баримт бичгийн уялдаа холбоог судлан дараах хүснэгтэд харуулж байна.

**Хүснэгт 4. 17 Монгол улсад эвент аялал жуулчлалыг хөгжүүлэх зорилго, зорилтуудыг тодорхойлоход харгалзан үзэх бусад бодлогын баримт бичгийн уялдаа холбоо**

| № | Эвент хөгжүүлэх зорилтууд / Баримт бичгүүд | Эвентийн удирдлага, сургалтын тогтолцоо, мэдээллийн санг бүрдүүлэх | Эвентээс орон нутагт үлдэх эдийн засгийн үр өгөөжийг нэмэгдүүлэх | Эвентүүдийн оролцогч талуудын оролцоо, нөлөөллийг нэмэгдүүлэх | Эвентэд оролцогч, үзэгчдийн тоог нэмэгдүүлэх, ялангуяа гадаадын жуулчдын тоог өсгөх | Нийт | Нийцсэн хувь (шууд уялдсан) |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | **Зорилт 1** | **Зорилт 2** | **Зорилт 3** | **Зорилт 4** | **43** | **11; 26%** |
| 1. | МУ-ын “Алсын хараа 2050” | 4.2.47.Монгол улсын соёл, аялал жуулчлалын төвүүдийг зорилтот зах зээлийн орнуудад байгуулж, гадаад сурталчилгааг сайжруулан, аялал жуулчлалын томоохон төв, паркуудыг байгуулж, шашин, соёл, спорт, адал явдалт аялал зэрэг улирлын хамаарал багатай аялал жуулчлалыг хөгжүүлнэ.<br>4.2.45.Аялал жуулчлалын үйлчилгээний стандартуудыг олон улсын жишигт нийцүүлэн мөрдүүлнэ. | 4.2.1.Нэмүү өртөг шингээсэн уул уурхай, стратегийн мега төслүүд, боловсруулах аж үйлдвэр, хөдөө аж ахуй, эрчим хүч, тээвэр, логистик, төрөлжсөн аялал жуулчлал, түүнийг дагасан үйлчилгээ, жижиг, дунд үйлдвэрлэл, мэдлэгжсэн бүтээлч үйлдвэрлэлийг эдийн засгийн тэргүүлэх салбар болгон хөгжүүлнэ.<br>4.2.43.Аялал жуулчлалын салбарыг эдийн засгийн тогтвортой хөгжлийн салбар болгон хөгжүүлнэ. | 1.5.3.Дэлхийд танигдсан оюуны болон соёлын өвийг бүтээгч хувь хүн, баг, хамт олныг дэмжиж алдаршуулах, залгамж халааг бэлтгэхэд төрөөс дэмжлэг үзүүлнэ. Оюуны болон соёлын, биет бус өвийн бүтээлүүдийг дагасан уламжлал, ёс заншил, үндэсний онцлог бүхий брэнд үйлдвэрлэлийг хөгжүүлж экспортлох боломжийг нэмэгдүүлнэ.<br>8.3.11.Малчдын ахуй амьдралд түшиглэн нүүдлийн соёл, иргэншил, уламжлал бүхий аялал жуулчлалыг хөгжүүлж, орлого, ашгийг нь өсгөнө. | 4.2.44.Аялал жуулчлалын гадаад сурталчилгаа, маркетингийн үйл ажиллагааг эрчимжүүлж, олон улсын аялал жуулчлалын сүлжээнд нэгдэнэ.<br>**8.2.**Эдийн засгийн тэргүүлэх салбарууд болон байршлын давуу талд тулгуурлан бүс, орон нутагт аялал жуулчлалыг хөгжүүлнэ.<br>Шалгуур 4.10.Хүлээн авах гадаад жуулчдын тоог 2030 онд 2 сая, 2040 онд 4 сая, 2050 онд 6 саяд хүргэнэ. | *9* | 3; 33% |
| | *Үнэлгээ* | *Шууд тусгагдсан-1* | *Агуулгын хувьд уялдсан* | *Шууд тусгагдсан-1* | *Шууд тусгагдсан-1* | *3* | |
| 2. | МУ-ын “АЖ-ын тухай” хууль | 3.1.4."аялал жуулчлалын бүтээгдэхүүн" гэж аялал жуулчлалын байгууллагаас үзүүлж байгаа жуулчдын | 11.3. Энэ хуулийн 14.1.1-д заасны дагуу байгуулсан аялал жуулчлалын бүс нутгийг хөгжүүлэх зорилгоор | 11.1. Төрөөс экспортын үйлдвэрлэлд үзүүлэх дэмжлэг, хөнгөлөлтөд аялал жуулчлалын байгууллага, | - | *3* | 1; 33% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| 3. | | сонирхлыг татах, тэдний аялах тав тухтай нөхцөлийг хангасан төлбөрт үйлчилгээг; | зарласан уралдаанд төсөл нь шалгарсан этгээдэд төслөө хэрэгжүүлэхэд зориулж төрөөс зохих санхүүжилтийг гэрээний үндсэн дээр олгож болно. | зочид буудлын гадаадын жуулчдад үзүүлсэн үйлчилгээ нэг адил хамаарна. | | | |
| | *Үнэлгээ* | *Шууд тусгасан-1* | *Агуулгын хувьд уялдсан* | *Агуулгын хувьд уялдсан* | *Байхгүй* | *1* | |
| 3. | Аялал жуулчлалын Үндэсний Хөтөлбөр | 4.1.5. жуулчдын зорин очих дуртай газруудын төлөвлөлт, менежментийг сайжруулах, дэд бүтцийн асуудлыг байгаль орчинд ээлтэй технологиор шийдвэрлэх.<br>4.2.5. зочид буудал, жуулчны бааз, үйлчилгээний байгууллагуудад зэрэглэл тогтоох стандартыг олон улсын жишигт нийцүүлэн боловсронгуй болгох;<br>4.3.1. аялал жуулчлалын мэдээллийн сүлжээг хөгжүүлж, салбарын мэдээллийн нэгдсэн санг бий болгох; | 4.2.7. аялал жуулчлалын бүтээгдэхүүний төрлийг нэмэгдүүлж, улирлын хамаарлыг бууруулахад чиглэгдсэн арга хэмжээг зохион байгуулж хэрэгжүүлэх.<br>4.5.1. гадаад орнууд болон Дэлхийн аялал жуулчлалын байгууллага, олон улсын байгууллагуудтай хамтын ажиллагааг өргөжүүлэх;<br>4.6.2. тусгай хамгаалалттай болон соёлын өвийн бүс нутгуудад аялал жуулчлалыг хөгжүүлэх; | 4.2.1. аялал жуулчлалыг Монгол орны байгаль, түүх, соёлын үнэт өв, нүүдэлчин ахуй, уламжлалт зан заншлыг тусгасан өөр өөрийн онцлог бүхий бүтээгдэхүүн, үйлчилгээний ялгаатайгаар бүсчлэн хөгжүүлэх;<br>4.2.2. аялал жуулчлалын бүтээгдэхүүн, үйлчилгээний хөгжлийг дэмжиж, аялал жуулчлалын бүтээгдэхүүнийг тухайн бүс нутгийн онцлогт тулгуурлан бий болгох; | 6.1.1.2. жуулчин тээвэрлэх, хүлээн авах хүчин чадлыг нэмэгдүүлэх замаар Монгол Улсад ирэх жуулчдын тоог 2 сая хүргэнэ; | *9* | 1; 11% |
| | *Үнэлгээ* | *Агуулгын хувьд уялдсан* | *Агуулгын хувьд уялдсан* | *Агуулгын хувьд уялдсан* | *Шууд тусгагдсан-1* | *1* | |
| 4. | Төрөөс аялал жуулчлалыг хөгжүүлэх талаар баримтлах бодлого | 2.1.2. Тогтвортой аялал жуулчлалын шалгуур үзүүлэлтүүдийг боловсруулж, батлуулан, ногоон гэрчилгээжүүлэлт, ногоон зээл олгох эрх зүйн орчинг бүрдүүлэх<br>3.2.4.5. Аялал жуулчлалын эвент арга хэмжээнүүдийг бүсийн хэмжээнд харилцан уялдаатай тогтоож, зохион | 2.1. Алсын хараа: Монгол улс Нүүдлийн соёлын аялал жуулчлалын олон улсын төв болно.<br>4.3. Аялал жуулчлалын салбарын жилийн орлогыг 2022 онд 1,2 тэрбум ам.долларт, 2026 онд 1,8 тэрбум ам.долларт хүргэсэн байна. | 4.4.1.1. Аялал жуулчлалын идэвх багатай 9-5 дугаар сарууддад зохион байгуулагдаж буй аялал жуулчлалын эвент арга хэмжээний цар хүрээг нэмэгдүүлэх, зохион байгуулалтыг сайжруулахад дэмжлэг үзүүлэх<br>4.5. Аялал жуулчлалын салбар дахь ажлын байрны тоог 2022 онд 85 мянга, 2026 | 2.2.4. Газарзүйн байрлал, байгаль, түүх, соёлын өвд тулгуурласан харилцан ялгарал бүхий аялал жуулчлалын бүс нутгуудыг хөгжүүлж, бүтээгдэхүүний хөгжлийг эрчимжүүлэх, үйлчилгээний чанарыг сайжруулах, ажлын байрыг нэмэгдүүлэх<br>4.2. 1 жил Монгол улсад аялах гадаадын жуулчдын | *10* | 3; 33% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | байгуулах ажлыг тогтмолжуулах<br>2.4.12. Аялал жуулчлалын үйлчилгээний стандартуудыг олон улсын жишигт нийцүүлэн шинэчлэн батлуулах, мөрдүүлэх | | онд 125 мянгад хүргэсэн байна.<br>1.4.4. Түүх, соёлын өвийг хадгалах, хамгаалах, өвлүүлэх, сурталчлах; | тоог 2022 онд 1,2 сая, 2026 онд 1,7 саяд хүргэсэн байна. | | |
| | *Үнэлгээ* | *Шууд тусгагдсан-1* | *Агуулгын хувьд уялдсан* | *Шууд тусгагдсан-1* | *Шууд тусгагдсан-1* | *3* | |
| 5. | МУ-ын тогтвортой хөгжлийн үзэл баримтлал | 2.1.2.Аялал жуулчлалын салбар. Зорилт 1.Монгол улс нүүдлийн соёл, аялал жуулчлалын олон улсын төв болно.<br>II үе шат: "...үйлчилгээний чанарыг сайжруулах, байгаль орчин, эрүүл ахуйн шаардлага хангасан эко аялал жуулчлалын бүсүүд, бүтээгдэхүүн, үйлчилгээг хөгжүүлэх, аялал жуулчлалын олон төрөл, улирлын чанартай аялал жуулчлалыг хөгжүүлэх, Монголын нүүдлийн соёл, аялал жуулчлалын олон улсын сурталчилгааг тасралтгүй сайжруулах..." | III үе шат: "Байгаль орчин, эрүүл ахуйн шаардлага хангасан эко аялал жуулчлалын бүсүүд, бүтээгдэхүүн, үйлчилгээг хөгжүүлж, нүүдлийн соёл, аялал жуулчлалын Монгол брэндийг дэлхийд сурталчлан, аялал жуулчлалаас орох орлогыг нэмэгдүүлэх..." | I үе шат: "Байгаль, соёлын өвийн үйлдвэрлэл, үзмэрүүдийн голлох төвүүдэд жуулчлалын дэд бүтэц, үйлчилгээний чанарыг сайжруулах, олон улсын тавцанд Монголын аялал жуулчлалын онцлог дүр төрхийг бүрдүүлэх, байгаль орчин, эрүүл ахуйн шаардлага хангасан эко аялал жуулчлалын бүсүүд, бүтээгдэхүүн, үйлчилгээг хөгжүүлэх..." | 2.1.2. Зорилт 1. 2016-2020 онд 1 сая жуулчин, 2021-2025 онд 1,5 сая жуулчин, 2026-2030 онд 2 сая гадаадын жуулчин хүлээн авч үйлчилнэ. | *5* | 3; 20% |
| | *Үнэлгээ* | *Агуулгын хувьд уялдсан* | *Агуулгын хувьд уялдсан* | *Агуулгын хувьд уялдсан* | *Шууд тусгагдсан-1* | *1* | |
| 6. | МУ-ын ногоон хөгжлийн бодлого | 3.1.7.байгаль орчин, эрүүл ахуйн шаардлага хангасан эко аялал жуулчлалын бүтээгдэхүүн, үйлчилгээг хөгжүүлэх; | Стратегийн зорилт 3. Ногоон эдийн засгийг дэмжих санхүүжилт, татвар, зээл, урамшууллын оновчтой хөшүүргийг нэвтрүүлж, байгаль хамгаалал, хүний хөгжил, цэвэр технологийг | 3.2.2. байгалийн нөөцийн үндэсний парк, байгаль, соёлын өвийн дурсгалт газарт уул уурхай, хүнд үйлдвэрлэлийн үйл ажиллагаа эрхлэхийг хязгаарлан, ногоон хөгжлийн жишиг нутаг болгон эко аялал жуулчлал, | - | *3* | 0; 0% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | дэмжих хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлнэ. | уламжлалт мал аж ахуйг хөгжүүлэх; | | | |
| | *Үнэлгээ* | *Агуулгын хувьд уялдсан* | *Агуулгын хувьд уялдсан* | *Агуулгын хувьд уялдсан* | *Байхгүй* | *0* | |
| 7. | МУ-ын ЗГ-ын үйл ажиллагааны хөтөлбөр | 3.4.5.Монголын нүүдлийн соёлын онцлогт тохирсон үндэсний шинэлэг, сор бүтээл, брэнд бүтээгдэхүүн үйлдвэрлэж, аялал жуулчлалыг дэмжинэ. | 4.5.3.Гадаадын хөрөнгө оруулагчдын эрх ашгийг тууштай хамгаалж, дэд бүтэц, уул уурхай, эрчим хүч, хүнс, хөдөө аж ахуй, аялал жуулчлал зэрэг эдийн засгийн тэргүүлэх салбар, мега төслүүдэд гадаадын хөрөнгө оруулалт татах, хөнгөлөлттэй зээл, буцалтгүй тусламж авахад дэмжлэг үзүүлнэ. | **3.4.Байгаль, түүх, соёлын өвд түшиглэсэн тогтвортой аялал жуулчлалыг хөгжүүлнэ.** | 3.4.4.Аялал жуулчлалын бүтээгдэхүүн, үйлчилгээ, чанар, стандартыг сайжруулж, өрсөлдөх чадварыг дээшлүүлэн, иргэд, жуулчдын тоог нэг саяд хүргэнэ. | *4* | 0; 0% |
| | *Үнэлгээ* | *Агуулгын хувьд уялдсан* | *Агуулгын хувьд уялдсан* | *Агуулгын хувьд уялдсан* | *Агуулгын хувьд уялдсан* | 0 | |

*Эх үүсвэр:Судлаачийн тооцоо*

Бодлогын баримт бичгүүдэд аялал жуулчлалын бүтээгдэхүүн хөгжүүлэх, гадаад жуулчдын тоог нэмэгдүүлэхтэй холбоотой тусгасан зүйл заалт нийт 43 байгаагаас эвент аялал жуулчлалын агуулгыг шууд тусгасан зүйл 11 буюу нийт заалтуудын 26%-ийг эзэлж байна. Гэхдээ Монгол улсын эвент аялал жуулчлалын гол нөөц болох нүүдлийн соёл, өв уламжлал, түүх болоод түүхийн дурсгалт зүйлсийг аялал жуулчлалын бүтээгдэхүүн болгох, үйлчилгээний чанарыг сайжруулах чиглэлээр агуулгын хувьд багтаасан дээрх 43 зүйлийг үндэслэл болгон эвент аялал жуулчлалыг хөгжүүлэх бүрэн боломж байна.

Харин “Эвент” гэж онцгойлон тусгасан эрхзүйн баримт бичиг нь “Төрөөс аялал жуулчлалыг хөгжүүлэх талаар баримтлах бодлого” бөгөөд 2 зүйлийг нэр цохон дурджээ. Үүнд:

1. “Төрөөс аялал жуулчлалыг хөгжүүлэх талаар баримтлах бодлого”-ын 3.2.4.6-д “Аялал жуулчлалын эвент арга хэмжээнүүдийг бүсийн хэмжээнд харилцан уялдаатай тогтоож, зохион байгуулах ажлыг тогтмолжуулах”;
2. “Төрөөс аялал жуулчлалыг хөгжүүлэх талаар баримтлах бодлого”-ын 4.5.1.1-д “Аялал жуулчлалын идэвх багатай 9-5 дугаар саруудад зохион байгуулагдаж буй аялал жуулчлалын эвент арга хэмжээний цар хүрээг нэмэгдүүлэх, зохион байгуулалтыг сайжруулахад дэмжлэг үзүүлэх” байна.

### 4.3.3 Боломжит 10 эвентийн стратегийн зорилго, зорилт, шалгуур үзүүлэлт, талуудын оролцоо

**Хүснэгт 4. 18 Эвентийн зорилго, зорилт, шалгуур үзүүлэлт, талуудын оролцоо**

| Эрхэм зорилго | Урт хугацааны стратеги зорилго | Зорилтот зах зээл | Богино хугацааны зорилтууд | Шалгуур үзүүлэлт | Хэмжих нэгж | Хүрэх үр дүн | | Хэрэгжүүлэх байгууллага | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | Богино хугацаа (2022-2026) | Урт хугацаа (2022-2030) | Үндсэн | Хамтран |
| **Нэг. Монгол төрийн их наадам** | | | | | | | | | |
| Эртнээс уламжилж ирсэн “Эрийн гурван наадам”-аа Монголчууд тэмдэглэж бахархах, баярлахын зэрэгцээ нүүдэлчин ард түмний түүх соёл, ёс заншил, дэг жаягийг өвлөн үлдээх, дэлхий дахинд сурталчлан таниулах зорилготой | Нүүдлийн соёл уламжлал, түүх заншилтай улс орнуудын эв нэгдлийн бэлэг тэмдэг болсон олон улсын тэмдэглэлт баяр болж 2030 оны наадмын нээлтийг гадаадын 100,000 жуулчдад шууд үзүүлэх | Дотоодын иргэд, Монгол туургатан, нүүдлийн соёл иргэншилтэй улсууд, нүүдлийн соёл иргэншилтэй бус дэлхийн бусад улсын иргэд, жуулчид | Гадаадын жуулчид, тэр дундаа Нүүдлийн соёл уламжлалтай орнуудын жуулчдын тоог нэмэгдүүлэх (үзэгчдийн хувьд биетээр болон онлайнаар төлбөр төлж үзэх байдлаар зохион байгуулах) | Гадаадын жуулчдын тоо | Тоо | 45000 | 100000 | ҮИБНЗБХороо, НЗДТГ, Нийслэлийн БОАЖГ | БОАЖЯ, ГХЯ, ЗТЯ |
| | | | “Нүүдэлчдийн Их Баяр Наадам” хэмээн гадаад зах зээл дээр сурталчлах | Сурталчилгааны тоо, сурталчилгаа үзэгчдийн тоо | Ширхэг | 5/1000000 | 10/10000000 | НЗДТГ, Нийслэлийн БОАЖГ | БОАЖЯ,СоЯ, ГХЯ |
| | | | Монголчуудад зориулсан, Олон улсад зориулсан 2 удаагийн нээлт хийх байдлаар хөтөлбөрөө шинэчлэх | Нээлтийн арга хэмжээний тоо | Ширхэг | 2 | 2 | ҮИБНЗБХороо,СоЯ | Нийслэлийн БОАЖГ, БОАЖЯ, ГХЯ |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | Төрийн наадмыг зохион байгуулах төсвийг 5-9 тэрбумд хүргэж, энэ зардлыг гадаад жуулчдаас олох тасалбарын орлогоор нөхөх зарчим руу шилжих | Нийт төсөвт төрөөс даах зардлын эзлэх хувь | Хувиар | 80 | 60 | ҮИБНЗБХороо, Нийслэлийн БОАЖГ | СоЯ, СЯ |
| | | | Нүүдэлчдийн бусад наадам, тэмцээнүүдтэй хамтран аяллын багц хөтөлбөр гаргах | Багцын тоо | *Ширхэг* | 3 | 10 | ҮИБНЗБХороо, Нийслэлийн БОАЖГ | СоЯ,ГХЯ, ЗТЯ |
| **Хоёр. Плэйтайм олон улсын хөгжмийн наадам** | | | | | | | | | |
| Орчин үеийн хөгжмийн урлагаар дамжуулан Улаанбаатар хотыг Азийн тэргүүлэх хөгжмийн аялал жуулчлалын хот болгох болон бүтээлч үйлдвэрлэлийн салбарыг хөгжүүлэх замаар Монгол улсын тогтвортой хөгжилд хувь | 2027 он гэхэд Азийн шилдэг 5, 2030 онд Азийн хамгийн шилдэг 3 хөгжмийн фестивалийн нэг болох, гадаадын оролцогчдын тоог 1500 болгох | Богино хугацаанд Монгол, Мексик, АНУ, БНСУ, Тайланд, Филипин, Япон орны хөгжим сонирхогч, ихэвчлэн 35 хүртэлх насны Монгол, гадаад залуучууд, урт хугацаанд дотоодын болон ОХУ, БНХАУ, БНСУ, АНУ, Мексик, Япон болон Зүүн өмнөд Азийн орнуудын хөгжим сонирхогч бүхий л насныхан | Азийн орнуудын оролцогчдын тоог нэмэгдүүлж шилдэг хөгжмийн фестивалийн нэг болох | Азийн хөгжмийн фестивальд эзлэх байр | эрэмбэ, тоогоор | 5 | 3 | Зохион байгуулагч | СоЯ, ГХЯ |
| | | | Азийн орнуудын хөгжмийн урлагийн байгууллагуудаар дамжуулан сурталчлах | Сурталчилгааны тоо, сурталчилгаа үзэгчдийн тоо | Ширхэг | 5/500000 | 10/5000000 | Зохион байгуулагч | СоЯ, ГХЯ |
| | | | Монгол улсаас “ХҮ” хамтлаг, бусад улсаас мөн дэлхийн хэмжээний шилдэг хамтлаг, уран бүтээлчдийг хамруулах | Дэлхийн хэмжээний хамтлаг, дуучдын тоо | Тоо | 3 | 10 | Зохион байгуулагч | СоЯ, ГХЯ |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| нэмэр оруулах эрхэм зорилготой | | | Хөгжмийн наадмын төсвийг нэмэгдүүлж тасалбарын орлогоор санхүүжих боломжийг нэмэгдүүлэх | Ашгийн хувь | Хувиар | 10 | 15 | Зохион байгуулагч | СоЯ, БОАЖЯ,Нийслэлийн БОАЖГ |
| | | | Азийн улсуудын соёл урлагийн төрийн болон төрийн бус байгууллагууд, мэргэшсэн энтертаймент шоу бизнес эрхлэгчидтэй хамтрах | Хамтран гаргасан шоу, фестивалийн тоо | Тоо | 3 | 7 | Зохион байгуулагч | СоЯ, БОАЖЯ, бусад хамтран ажиллах байгууллагууд, ,Нийслэлийн БОАЖГ |
| **Гурав.Хөх сувд - Хөвсгөлийн мөсний баяр** | | | | | | | | | |
| Монгол оронд өвлийн аялал жуулчлалыг хөгжүүлэх, аялал жуулчлалын улирлын хугацааг уртасгах, Азийн цэвэр усны томоохон нөөц Хөвсгөл далай, түүний орчмын нутгийн үзэсгэлэнт байгалийг | 2030 он гэхэд “Олон улсын цас, мөсний баяр” болж гадаадын 1000 жуулчид оролцдог болсон байх | Өвлийн наадам сонирхогч улс орнууд, МУ-ын тэргүүлэх зах зээлийн орнууд /АНУ, Япон, Солонгос, Герман г.м/ | Нийт гадаадын жуулчдын тоог нэмэгдүүлэх, ялангуяа Ханх сумаар дамжин ирэх Орос жуулчдын тоог өсгөх | Гадаадын жуулчдын тоо | Тоо | 400 | 1000 | Хөвсгөл аймгийн ЗДТГ, зохион байгуулагчид | БОАЖЯ, ГХЯ, ЗТЯ |
| | | | Өвлийн спорт, мөсөн урлалыг нүүдлийн соёлтой хослуулсан өвөрмөц эвент гэдэг дүр төрхийг сурталчлах | Сурталчилгааны тоо, сурталчилгаа үзэгчдийн тоо | Ширхэг | 2/100000 | 10/1000000 | Хөвсгөл аймгийн ЗДТГ, зохион байгуулагчид | СоЯ, БОАЖЯ, ГХЯ |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| хамгаалах, байгаль орчиндоо эвсэг, хариуцлагатай аялал жуулчлалыг дэмжин, орон нутгийнханд өвөл орлого олох боломжийг нэмэгдүүлэх зорилготой | | | Морин чарганы аяллын 2-3 хоногийн маршрутыг төлөвлөж сурталчлах | Сурталчилгааны тоо, сурталчилгаа үзэгчдийн тоо | Ширхэг | 2/100000 | 10/1000000 | Хөвсгөл аймгийн ЗДТГ, зохион байгуулагчид | СоЯ, БОАЖЯ, ГХЯ |
| | | | Мөсний баярын санхүүжилтийг өсгөж талбайг томруулах, мөсөн урлалын үзэсгэлэнг өргөжүүлэх | Санхүүжилтийн хэмжээ өссөн хувиар, талбайн хэмжээний өсөлт, мөсөн урлалын тооны өсөлт | Хувиар | 150/20/50 | 1000/100/200 | Хөвсгөл аймгийн ЗДТГ, зохион байгуулагчид | СоЯ, БОАЖЯ, |
| | | | Мөс, цасны баяр тэмдэглэдэг улс орнуудтай хамтран ажиллах, дотоодын нислэгийн авиа компаниудын дэмжлэгийг авах | Хамтран ажилласан улсын тоо | Ширхэг | 2 | 5 | Хөвсгөл аймгийн ЗДТГ, зохион байгуулагчид | СоЯ, БОАЖЯ, ЗТЯ, МИАТ |

| Дөрөв. Монгол туургатны язгуур соёлын ОУ-ын Их наадам | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| Язгуур урлаг, өв соёлоо сэргээн хөгжүүлэх, хойч үедээ өвлүүлэн үлдээх, Монгол туургатнуудаа нэгтгэн соёлын солилцоо хийх зорилготой | Монгол Туургатан ард түмэн хуран цугларч язгуур өв соёлын уламжлалаараа уралдаж, бахархаж, сурталчилдаг олон улсын эвент болон 2030 он гэхэд гадаадын 2000 жуулчид ирж үзэж, оролцдог болгох | Богино хугацаанд нүүдэлчин ард түмний ахуй соёл, язгуур урлаг сонирхогчид, МУ-ын тэргүүлэх зах зээлийн орнууд /АНУ, Япон, Солонгос, Герман г.м/, Монгол, ОХУ, БНХАУ оролцогчид, урт хугацаанд соёлын жуулчид, нүүдэлчин ард түмний язгуур урлаг сонирхогч болон МУ-ын тэргүүлэх зах зээлийн орнууд /АНУ, Япон, Солонгос, Герман г.м/, Монгол, ОХУ, БНХАУ болон дэлхийгээр таран суугаа Монгол туургатан улс орнуудын оролцогчид | Монгол туургатан ард түмнээс оролцогчдын тоог нэмэгдүүлэх | Оролцогчдын тоо | Тоо | 200 | 2000 | Зохион байгуулагчид | Увс аймгийн ЗДТГ, СоЯ, БОАЖЯ |
| | | | Монгол угсаатнууд амьдардаг улс орнуудад эвентээ сурталчлах | Сурталчилгааны тоо, сурталчилгаа үзэгчдийн тоо | Ширхэг | 2/100000 | 10/1000000 | Зохион байгуулагчид | Увс аймгийн ЗДТГ, СоЯ, БОАЖЯ |
| | | | Зөвхөн эвент төдийгүй 14-с дээш хоногийн тойрон аяллын маршрут хөтөлбөр гарган борлуулах | Маршрут хөтөлбөрийн тоо | Ширхэг | 2 | 5 | Зохион байгуулагчид | Увс аймгийн ЗДТГ, СоЯ, БОАЖЯ |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | Улсын төсөв, орон нутгийг төсвөөс санхүүжүүлэх төсвийг нэмэгдүүлэх, эвентийн тасалбар борлуулах | Нийт төсөвт төрөөс даах зардлын эзлэх хувь | Хувиар | 20 | 40 | СоЯ, БОАЖЯ, ЗДТГ | Зохион байгуулагч |
| | | | Монгол угсаатнууд амьдардаг улс орнуудын Соёлын байгууллагуудтай хамтран ажиллах | Идэвхтэй хамтран ажилладаг байгууллагын тоо | Тоо | 10 | 20 | Зохион байгуулагч | СоЯ, БОАЖЯ, ЗДТГ, ГХЯ |
| **Тав.“Хийморь” морьт харваа, морин тулааны фестиваль** | | | | | | | | | |
| Тусгай сонирхлын аялал жуулчлалыг хөгжүүлэх, Монгол морь, Монгол түмний уламжлалт зан заншлыг дэлхийд сурталчлан таниулах, өв уламжлалыг хойч үедээ өвлүүлэн үлдээх зорилготой | 2030 онд “Морьт харвааны спорт”-ыг олон улсын хэмжээний тэмцээн, их наадам болгон хөгжүүлж гадаадын үзэгч жуулчдын тоог 3000, гадаад тамирчдын тоог 200-д хүргэх | Богино хугацаанд адуу сонирхогч, морь харвааны спорт сонирхогч улс орнууд, МУ-ын тэргүүлэх зах зээлийн орнууд /АНУ, Япон, Солонгос, Герман г.м/, урт хугацаанд Монгол, ОХУ-ын Буриад улс, БНХАУ-ын ӨМӨЗО, Киргизстан, Казахстан, Балба, Бутан, Төвд, Кени, Иран, Энэтхэг, Сомали, Алжир ба МУ-ын тэргүүлэх зах зээлийн орнууд /АНУ, Япон, Солонгос, Герман/ | Гадаад жуулчдын тоо, оролцоог нэмэгдүүлэх, гадаад тамирчдыг оролцуулдаг болох | гадаадын жуулчдын тоо, оролцргчдын тоо | Тоо | 300/10 | 3000/200 | Зохион байгуулагч | СоЯ, БОАЖЯ, ЗДТГ, ГХЯ |
| | | | ОУ-ын эвентийн холбооны гишүүн болж сурталчилгаагаа нэмэгдүүлэх | Сурталчилгааны тоо, сурталчилгаа үзэгчдийн тоо | Ширхэг | 2/100000 | 5/1000000 | Зохион байгуулагчид | СоЯ, ЗДТГ, ГХЯ, ЦХХХЯам |
| | | | Байршлаа өөрчилж том талбайд зохион байгуулах | Талбайн хэмжээний өсөлт | Хувиар | 50 | 100 | Зохион байгуулагчид | ЗДТГ |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | “Хийморь”наадмын төсвийг нэмэгдүүлж, ашигтай ажиллах боломжийг бүрдүүлэх | Нийт төсөвт төрөөс даах зардлын эзлэх хувь | Хувиар | 20 | 30 | Зохион байгуулагчид | ЗДТГ, БОАЖЯ, ЗГХЭГ |
| | | | Казахстан, Киргиз зэрэг улсын нүүдлийн соёлын наадмуудтай хамтрах | Хамтран ажилласан наадмын тоо | Тоо | 1 | 3 | Зохион байгуулагчид | ЗДТГ, БОАЖЯ, ГХЯ |
| **Зургаа. “Алтан бүргэд” бүргэдийн баяр** | | | | | | | | | |
| Казак ард түмний ёс заншлыг дэлхий нийтэд сурталчлах | 2030 он гэхэд дэлхий даяар байх Казах түмний нэгдэн цугларч тэмдэглэдэг “Казах шувуулахуй”-н олон улсын баяр болж, оролцогч бүргэдчдийн тоог 200, гадаад жуулчдын тоог 10,000-д хүргэх | Богино хугацаанд соёлын жуулчид буюу 40-с дээш насны, орлого өндөр, аялалд их мөнгө зарцуулдаг гадаадын жуулчид, Монгол аялагчидОролцогч: Монгол, Казахстан, Киргизийн бүргэдчид, урт хугацаанд, Соёлын жуулчид буюу 40-с дээш насны, орлого өндөр, аялалд их мөнгө зарцуулдаг жуулчидОролцогч: Монгол, Казахстан, | Казахстан, Киргиз улсын бүргэдчдийн оролцоог нэмэгдүүлэх | Оролцсон бүргэдчдийн тоо,жуулчдын тоо | Тоо | 50/5000 | 200/10000 | Зохион байгуулагчид, ЗДТГ | СоЯ, БОАЖЯ, ГХЯ |
| | | | Казахстан улсын нүүдлийн соёлын эвентүүдэд оролцож сурталчлах | Сурталчилгааны тоо, сурталчилгаа үзэгчдийн тоо | Тоо | 2/10000 | 5/200000 | зохион байгуулагчид | СоЯ, БОАЖЯ, ЦХХХЯ, ГХЯ |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | Киргизийн бүргэдчид | Зохион байгуулах газрын байршил, талбайн сонголтыг байршуулах хэрэгсэлтэй ойртуулан зохиох | Хэрэглэгчийн сэтгэл ханамжийн судалгаан дахь дэд бүтцийн талаарх эерэг сэтгэл ханамж | Хувиар | 40 | 80 | зохион байгуулагчид | ЗДТГ |
| | | | Эвентэд оролцогч бүргэдчдийн урамшуулал болон шагналын санг нэмэгдүүлэх | Шагналын сангийн хэмжээ, өссөн дүнгээр | Хувиар | 100 | 200 | зохион байгуулагчид | ЗДТГ |
| | | | Казах шувуулахуйн соёл уламжлагдан ирсэн орнуудтай хамтран ажиллах | Идэвхтэй хамтран ажилладаг байгууллагын тоо | Тоо | 2 | 5 | зохион байгуулагчид | ЗДТГ |
| **Долоо.Хонины найр** | | | | | | | | | |
| Нүүдэлчдийн соёл, ахуй амьдрал болон нутаг орныхоо талаар сурталчлах, таниулах зорилготой | “Нутгийн уугуул иргэд”-ийн олон улсын соёлын их наадам болж НИТАЖ-ын жишиг эвент болон 2030 он гэхэд гадаадын 300, дотоодын | Богино хугацаанд соёлын жуулчид болон МУ-ын тэргүүлэх зах зээлийн орнууд /АНУ, Япон, Солонгос, Герман г.м/ Оролцогч: Монгол, | Дотоодын аялагч хүүхэд, залуус, гэр бүлийн амрагчид болон гадаадын жуулчдыг тоог нэмэгдүүлэх | Гадаад, дотоод жуулчдын тоо | Тоо | 100/400 | 300/1000 | Зохион байгуулагчид | ЗДТГ, ЗТЯ, СоЯ, БОАЖЯ |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | 1000 үзэгчтэй болсон байх | АНУ-ын уугуул индианууд, Өмнөд Америкийн уугуул иргэд, Япон улсын уугуул иргэд г.м, урт хугацаанд Соёлын жуулчид болон МУ-ын тэргүүлэх зах зээлийн орнууд /АНУ, Япон, Солонгос, Герман г.м/ Оролцогч: Монгол, АНУ-ын уугуул индианууд, Өмнөд Америкийн уугуул иргэд, Япон улсын уугуул иргэд г.м | Хустай пэйж дээр нэмж тусдаа вэб сайттай болж сурталчилгаа, мэдээлэл тогтмол хийх | сурталчилгаа үзсэн үзэгчдийн тоо | Тоо | 10000 | 100000 | Зохион байгуулагчид | ЗДТГ, ЦХХХЯ, СоЯ, БОАЖЯ |
| | | | Малчдын бүлгийн үйлчилгээний соёлыг сайжруулах сургалт хийх, эвент менежментийн зөвлөх үйлчилгээний багтай хамтрах | Сургалтанд хамрагдагсадын тоо, малчдын бүлгийн гишүүддэд эзлэх хувиар | Хувиар | 50 | 100 | Зохион байгуулагчид | ХХААХҮЯ, БОАЖЯ |
| | | | Малчдын нөхөрлөлийн бизнесийг дэмжих, худалдан авалт болон тасалбарын орлогоос санхүүжилтээ бүрдүүлэх | Нийт төсөвт төрөөс даах зардлын эзлэх хувь | Хувиар | 30 | 15 | Зохион байгуулагчид | ХХААХҮЯ, БОАЖЯ |
| | | | Аялал жуулчлалын тур оператор байгууллагууд болон Нийслэлийн ЕБС-иудтай хамтран ажиллах гэрээ байгуулах | Идэвхтэй хамтран ажиллах гэрээтэй байгууллагын тоо | Тоо | 15 | 60 | Зохион байгуулагчид | БОАЖЯ, ЗДТГ |

| Найм.Талын түмэн адуу | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| Монгол адуу, адуучны өв соёлыг хэвээр хадгалан авч үлдэх, сурталчлах зорилготой | Адуу маллах соёл, уламжлал бүхий улс орнуудын нэгдэн цуглардаг Олон улсын их наадам болж 2030 онд дотоодын үзэгч 3000, гадаадын жуулчид 1200-г хүлээн авдаг болох | Адуу сонирхогч, адууны соёлтой улс орнууд, МУ-ын тэргүүлэх зах зээлийн орнууд /АНУ, Япон, Солонгос, Герман г.м/ Оролцогч: Монгол, АНУ-ын уугуул индианууд, Өмнөд Америкийн уугуул иргэд, Какахстан, Киргиз | Перу улсын болон АНУ-ын Техасын ковбойчуудыг оролцуулах | Гадаад жуулчдын тоо | Тоо | 500 | 1200 | Зохион байгуулагчид, ЗДТГ | БОАЖЯ, ГХЯ,ЦХХХЯ |
| | | | Эвентийн шторк, промюшн бичлэгийг контент болгох | Контентийн тоо | Тоо | 5 | 10 | Зохион байгуулагчид, ЗДТГ | БОАЖЯ, ГХЯ,ЦХХХЯ |
| | | | Нэг удирдлага доорх бие даасан зохион байгуулалтын багууд болгон өргөжүүлж, мэргэшүүлэх | Хэрэглэгчийн сэтгэл ханамж өссөн хувиар | Хувиар | 40 | 100 | Зохион байгуулагчид | ЗДТГ |
| | | | Эвентийн төсөв, санхүүжилтийг нэмэгдүүлж оролцогч адуучдыг урамшуулах, иргэдийн бизнесийг дэмжих | Нийт (төрөөс, зохион байгуулагч даас, хөрөнгө оруулагчид, хандив тусламж гэх мэт бүгд) санхүүжилтийн хэмжээ, өссөн дүнгээр | Хувиар | 100 | 300 | Зохион байгуулагчид, | ЗДТГ, БОАЖЯ, СоЯ |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | Адууны соёл уламжилж ирсэн орнуудтай хамтран ажиллах | Хамтран ажилласан улсын тоо | Тоо | 2 | 5 | Зохион байгуулагчид, | ЗДТГ, БОАЖЯ, СоЯ |
| **Ес.Түмэн тэмээний баяр** | | | | | | | | | |
| Говь нутгийн сүрлэг сайхан тэмээн сүргийг өсгөн хамгаалах, тэмээний амьдын үнэлэмжийг дээшлүүлэх зорилготой | Тэмээ маллах соёл, уламжлалыг сурталчлан таниулж 2030 онд тус эвентийг үзэх гадаадын жуулчдын тоог 1500, дотоодын аялагчдын тоог 5000-д хүргэх | Богино хугацаанд Тэмээ сонирхогч, тэмээний соёлтой улс орнууд, МУ-ын тэргүүлэх зах зээлийн орнууд /АНУ, Япон, Солонгос, Герман г.м/ Оролцогч: Монгол, Казахстан, Киргиз, урт хугацаанд Тэмээ сонирхогч жуулчид МУ-ын тэргүүлэх зах зээлийн орнууд /АНУ, Япон, Солонгос, Герман г.м/ Оролцогч: Монгол, Казахстан, Киргиз | Эвентийг зорин ирж үзэх гадаадын жуулчдын тоог нэмэгдүүлэх | Гадаадын жуулчдын тоо | Тоо | 300 | 1500 | Зохион байгуулагчид, ЗДТГ | БОАЖЯ, ЦХХХЯ, ГХЯ |
| | | | Олон улсад гаргах сурталчилгааны контентууд хийлгэх | Контентийн тоо | Тоо | 1 | 3 | Зохион байгуулагчид, ЗДТГ | БОАЖЯ, ЦХХХЯ, ГХЯ |
| | | | Эвентийн үйл ажиллагааг өргөжүүлэх, нарийвчлах | Нийт оролцогсодын тоо | Тоо | 1500 | 6500 | Зохион байгуулагчид, ЗДТГ | БОАЖЯ, ЦХХХЯ, ГХЯ |
| | | | Улсын төсвөөс одоогийн санхүүжилтийг 3 дахин нэмэх (үр дүнтэй уялдуулах зарчимд үндэслэн) | Санхүүжилтийн хэмжээ өссөн хувиар | Хувиар | 50 | 300 | Зохион байгуулагчид, ЗДТГ | БОАЖЯ |
| | | | Өвлийн улиралд болдог гадаадын эвентүүдтэй хамтран ажиллах | Хамтран ажилласан гадаад эвентийн тоо | Тоо | 1 | 3 | Зохион байгуулагчид, ЗДТГ | БОАЖЯ, ЦХХХЯ, ГХЯ |

| Арав.Улаанбаатарын өвлийн наадам | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| Говь нутгийн сүрлэг сайхан тэмээн сүргийг өсгөн хамгаалах, тэмээний амьдын үнэлэмжийг дээшлүүлэх зорилготой | 2030 онд Зүүн хойд Азийн орнуудын өвлийн спортын их наадам болох ба үүнээс Монгол туургатан ард түмний оролцогчдын тоог 2000-д хүргэх | Богино хугацаанд спорт эвент тэр дундаа өвлийн спорт эвент сонирхогч улс орнууд, МУ-ын тэргүүлэх зах зээлийн орнууд /АНУ, Япон, Солонгос, Герман г.м/Оролцогч: Монгол, АНУ-ын уугуул индианууд, Өмнөд Америкийн уугуул иргэд, урт хугацаанд Монгол, ОХУ-ын Буриад улс, БНХАУ-ын ӨМӨЗО, Киргизстан, Казахстан, Балба, Бутан, Төвд, Кени, Иран, Энэтхэг, Сомали, Алжир ба МУ-ын тэргүүлэх зах зээлийн орнууд /АНУ, Япон, Солонгос, Герман/ | ОУ-ын тамирчид, жуулчдын тоог нэмэгдүүлэх | Жуулчдын тоо | тоо | 500 | 2000 | Зохион байгуулагчид | ЗГХЭГ, ГХЯ, ЦХХХЯ, ЗТЯ |
| | | | ОУ-ын эвентийн холбооны гишүүн болж дэлхийд эвентээ сурталчлах | Сурталчилгааны тоо, сурталчилгаа үзэгчдийн тоо | тоо | 1/100000 | 3/1000000 | Зохион байгуулагчид | ЗГХЭГ, ГХЯ, ЦХХХЯ |
| | | | Мөсөн шагайн болон мөсөн сурын зориулалтын талбайтай болж сайжруулах | Зориулалтын талбайн тоо | тоо | 1 | 2 | Зохион байгуулагчид | ЗГХЭГ |
| | | | Санхүүгийн нөөцийг нэмэгдүүлэх, тасалбарын борлуулалтаас тодорхой төсвийг бүрдүүлэх | Нийт төсөвт төрөөс даах зардлын эзлэх хувь | хувиар | 70 | 40 | Зохион байгуулагчид | БОАЖЯ |
| | | | Өвлийн спорт, аялал жуулчлалын жишиг болсон эвентүүдийн туршлага судлах | Хэрэгжүүлсэн туршлагын тоо | тоо | 3 | 10 | Зохион байгуулагчид | БОАЖЯ |

Стратегийн зорилгуудыг дэвшүүлэхдээ 2030 он хүртэлх буюу 8 жилийн хугацаатай стратегийн зорилтуудыг дэвшүүлсэн бөгөөд эдгээр зорилтууд бүрэн биелэгдэнэ гэж үзвэл суурь үзүүлэлтийн хугацаа /2019 он/-ны үеийн үзүүлэлтээс 3-10 дахин нэмэгдсэн байхаар үр дүнгийн хүлээлэлттэй байна. Хүснэгт-19 болон График-1-с харна уу.

### Хүснэгт 4. 19 Эвентүүдэд оролцох гадаад жуулчдын тоо,хүлээгдэж буй дүнгээр

| № | Эвентийн нэрс | Гадаадын жуулчдын тооны өөрчлөлт /зорилт/ | |
|---|---|---|---|
| | | **2019 он** | **2030 он** |
| ***1*** | “Алтан бүргэд” бүргэдийн баяр | *1 000* | *10 000* |
| ***2*** | Плэйтайм олон улсын хөгжийн наадам | *450* | *1 500* |
| ***3*** | Монгол төрийн их наадам /нээлтийн тасалбар/ | *3 000* | *100 000* |
| ***4*** | Хонины найр | *10* | *300* |
| ***5*** | Талын түмэн адуу | *320* | *1 200* |
| ***6*** | Түмэн тэмээний баяр | *156* | *1 500* |
| ***7*** | Улаанбаатарын өвлийн наадам | *200* | *2 000* |
| ***8*** | “Хийморь” морьт харваа, морин тулааны фестиваль | *450* | *3 000* |
| ***9*** | Монгол туургатны язгуур соёлын ОУ-ын Их наадам | *200* | *2 000* |
| ***10*** | Хөх сувд - Хөвсгөлийн мөсний баяр | *120* | *1 000* |
| | НИЙТ | *5 906* | *122 500* |

*Эх сурвалж:Судлаачийн тооцоо*

Үр дүнгийн таамаглалыг графикаар үзүүлбэл дараах байдалтай байна.

**График 4. 1 Эвентийн оролцох гадаад жуулчдын тоо, хүлээгдэж байгаа байдлаар**




*Эх сурвалж:Судлаачийн тооцоо*

**Хүснэгт 4. 20 Боломжит 10 эвентийн стратегийн зорилтуудыг хэрэгжүүлэх үйл ажиллагааны чиглэлийн TOWS матриц**

| № | Эвентийн нэрс | SO - “Maxi-maxi” стратеги /Давуу тал дээрээ тулгуурлан боломжоо ашиглах стратеги/ | ST - “Maxi-mini” стратеги /Давуу талаа ашиглан аюулаас зайлсхийх стратеги/ | WO - “Mini-maxi” стратеги /Боломжоо ашиглан сул талаа бууруулах стратеги/ | WT - “Mini-mini” стратеги /Сул талаа бууруулан аюулаас зайлсхийх стратеги/ |
|---|---|---|---|---|---|
| 1 | “Алтан бүргэд” бүргэдийн баяр | *Дэлхийн соёлын өвд бүртгэгдсэн бүргэдээр ан хийх зан үйлийг олон улсын эвентийн холбооны гишүүний хувиар дамжуулан сурталчлах* | *Тус эвентийн үеэр зөвхөн Казах шувуулахуйн зан заншлаас гадна Урианхай ястан болон бусад олон ястны өв соёлтой нэгэн зэрэг танилцах боломжтой гэдэг давуу талаа ашиглан Киргизийн “Дэлхийн нүүдэлчдийн наадам”-аас ялгарах* | *Төрийн дэмжлэг болон дэлхийн соёлын өв гэдэг утгаар нь санхүүжилт, зохион байгуулалтаа мэргэжлийн менежментийн зөвлөх багтай хамтран зохион байгуулалтаа сайжруулах* | *Эвентийн зохион байгуулалт, менежментийг сайжруулан санхүүжилтийг нэмэгдүүлснээр “Дэлхийн нүүдэлчдийн наадам”, “Нүүдэлчдийн ертөнц” зэрэг эвентүүдээс ялгарах, зарим талаар хоршиж хамтрах* |
| 2 | Плэйтайм олон улсын хөгжийн наадам | *Орчин үеийн хөгжмийн урсгалыг сонирхогч залуусын тоо дэлхийн хэмжээнд тогтмол өсөн нэмэгдэж байгааг ашиглаж үндэсний хөгжмийн урлагийг сурталчлах* | *Зүүн хойд Азийн амьд хөгжмийн наадмуудаас ялгарах онцлогийг бий болгож “The Hu” хамтлагтай хамтран эвент зохион байгуулах* | *Азийн болон олон улсын хөгжмийн бусад наадмууд хамтран ажиллах, тоглолтын хуваарьт эвентээ багтааж олон улсын залуучуудын оролцоог нэмэгдүүлэх* | *К-Поп урлаг, амьд хөгжмийн тоглолтуудтай хамтран ажиллах* |
| 3 | Монгол төрийн их наадам | *Олон улсад “Наадам” нэрээрээ танигдсан нэр хүнд, нийслэл Улаанбаатар хотын үйлчилгээний хүчин чадлын боломж, төрийн дэмжлэгийг ашиглан “Нүүдлийн соёл иргэншил”-ийн олон улсын их наадам болж* | *Киргизийн нүүдэлчдийн наадам нь “Нүүдэлчдийн олимп” буюу гадаадын оролцогчид нь тамирчид болж нүүдэлчдийн спортоор өрсөлдөх үзэл баримтлалтай бол “Монгол төрийн их наадам” нь язгуурын нүүдэлчин ахуйгаа хадгалж үлдсэн давуу талаа* | *Төрийн дэмжлэг, санхүүжилтийг нэмэгдүүлэх, зөв зарцуулах замаар шинэ цэнгэлдэх хүрээлэн байгуулах, жуулчдад зориулсан наадмын нээлт хийх зэргээр даац, үйлчилгээний хүчин чадлаа нэмэгдүүлэх* | *Төрийн наадмыг үзэх жуулчдын тоог нэмж, хүчин чадлаа нэмэгдүүлснээр нүүдлийн соёл уламжлалтай улс орнуудын төлөөллийг наадмын хөтөлбөрийн нэг хэсэгт оруулж Киргизийн эвентээс илүү давуу талыг бий болгох. Дэлхийн нүүдэлчдийн өв соёлыг* |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| | | *“Мега” эвент болох* | *ашиглан ялгарал үүсгэх* | | *Монгол наадмын үеэр мэдрэх боломжийг амлах.* |
| 4 | Хонины найр | *Хустайн нуруу аялал жуулчлалын баазыг түшиглэн зохион байгуулдаг тул, хоол, байр, үйлчилгээний хувьд давуу талаа ашиглан дотоодын аялагчид, хүүхэд багачуудыг оролцуулах* | *Эвент зохион байгуулагчид нь шууд малчид өөрсдөө байдаг давуу талаа ашиглан малын халдварт өвчин, цаг агаарын нөхцөл зэрэг гэнэтийн хүчин зүйлийн нөлөөллөөс сэргийлж ажиллах* | *“Уугуул иргэдийн холбоо” зэрэг олон улсын байгууллагуудтай хамтран ажиллаж тус эвентийн богино хугацаатай, хязгаарлагдмал хүрээг хамарч байгаа сул талыг засаж сайжруулах* | *Эвентэд туслан гүйцэтгэгчээр оролцдог нутгийн иргэдэд сургалт оруулах, аялал жуулчлалын үйлчилгээний талаарх чадавхыг бэхжүүлэх байдлаар үйлчилгээний сул талаа засаж аливаа эрсдлээс сэргийлэх* |
| 5 | Талын түмэн адуу | *Ижил төрлийн эвент зохион байгуулдаг эвент зохион байгуулагч нартай хамтарч ажиллах. Ингэхдээ мэргэжлийн баг, хүмүүстэй хамтрах* | Эвентийн утга агуулга ижил, цаг хугацааны хувьд ойролцоо зохион байгуулагдаж буй эвентүүдээс Батноров сумын онцлог шингэсэн, уламжлалт адуун соёл, адууны эдлэл хэрэглэлийн үзүүлэн, музейг оролцогчдод дэлгэн үзүүлдэг гэдэг давуу талаа ашиглан ялгарах | *Олон улсад Америк ковбой адуучидтай хамтарч ажиллах, тэдгээрийг урих, Монгол адуучдаа явуулж туршлага судлах боломжийг ашиглан эдийн засгийн үр өгөөж өндөртэй жуулчдыг татаж чадахгүй байгаа нь хамгийн том сул талаа засах* | *Уг арга хэмжээг 3 өдөр зохион байгуулдаг болович зохион байгуулж буй газарт байршуулах хэрэгслийн дутагдалтай байдаг сул талыг зассанаар утга агуулга ижил, цаг хугацааны хувьд ойролцоо зохион байгуулагдаж буй эвентүүдээс ялгарах* |
| 6 | Түмэн тэмээний баяр | Дэлхийд ховорхон хоёр бөхт тэмээний сүргийн цөм болох бүс нутагт зохион байгуулдаг давуу талаа ашиглан гадаад харилцаагаа хөгжүүлэх, олонд танигдах боломжтой. | БНХАУ, ӨМӨЗО, Киргиз улсад тэмээний баяр хийж эхэлж байгаа аюулаас сэргийлэхийн тулд Азийн тэмээн холбооноос зохион байгуулдаг өвлийн “Nomadic game”-ийн хэсгийн тоглолтуудыг Монголд зохион байгуулах | Азийн тэмээн холбооноос зохион байгуулдаг өвлийн “Nomadic game”-ийн хэсгийн тоглолтуудыг Монголд зохион байгуулж голлох хүндрэл бэрхшээл болох зохион байгуулалт, түүний уялдаа холбоог сайжруулах | *Нийгмийг хамарсан цар тахал, малын гаралтай гоц халдварт өвчнөөс сэргийлж малчидтайгаа хамтран ажиллах* |
| 7 | Улаанбаатарын өвлийн наадам | *Үйлчилгээний хүчин чадал өндөр газар буюу Нийслэл Улаанбаатар хотод болдог давуу* | *Төрийн дэмжлэг, ялангуяа Нийслэлийн ЗДТГ, НАЖГ-ын шууд хариуцан зохион байгуулдаг эвент тул албан* | *Олон улсын эвентийн холбоонд нэгдсэнээр өвлийн АЖ-ыг хөгжүүлэхэд дэмжлэг авч олон улсын* | *Бусад гадаад улсуудын цас, мөсний баяруудаас ялгарахын тулд эвентээ “Нүүдэлчдийн өвлийн мөсний* |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| | | *талаа ашиглан олон улсын өвлийн спортын наадмуудын туршлага судлан хөгжүүлэх* | *байгууллагуудын оролцоо, идэвх өндөр байдаг давуу талаа ашиглан мөсөн сур, мөсөн шагайн зориулалтын талбайтай болох* | *тамирчдын оролцоо бага байгаа сул талаа сайжруулах* | *баяр" хэмээн нэрлээд "Дэлхийн Нүүдэлчдийн өвөл" нэгдсэн маршруттай холбосноор Харбин, Манжуурын цас, мөсний баяраас үзэгчдийг татах* |
| *8* | "Хийморь" морьт харваа, морин тулааны фестиваль | *Дэлхийн морин спорт, морин аяллын байгууллагуудтай хамтран ажиллах боломжоо ашиглан олон орны морьт харваачид нэг дор цугларан туршлага солилцох* | Монголчууд морь маллах, адуулах нүүдэлчдийн их өв соёл, уламжлалыг бий болгож чадсан давуу талаа ашиглан Казакстан улсад морьт харвааны тэмцээнээс ялгарах | *Олон улсын эвентийн холбоонд мэдээлэл, сурталчилгаагаа хүргэж хамтран ажилласнаар гадаад жуулчдын тоог нэмэгдүүлэх* | *Эвент зохион байгуулагддаг талбай, газар орныг шинэчлэн сайжруулж, малын гаралтай* |
| *9* | Монгол туургатны язгуур соёлын ОУ-ын их наадам | Олон улсаас наадамд оролцохоор ирсэн оролцогчдыг хил дээрээс тосч авах, эвентийн дараа богино хугацааны аялал зохион байгуулдаг давуу талаа ашиглан хил орчмын аялал жуулчлалыг хөгжүүлэх | Язгуур урлаг дотроо чиглэл чиглэлээр нь ангилж нарийвчлан тэмцээн зохиодог давуу талаа ашиглан модерн, этник урлагийн үзүүлбэрийг нэмж харуулах | *Хятадын өмнөд хэсэг, Тайвань, Япон, Солонгост байгаа Монгол угсаатныг оролцуулах боломжоо ашиглан гадаадын жуулчдын тоог нэмэгдүүлэх, дотоодын нислэг явуулах* | *Урлагийн наадмын техник хэрэгслийн бэлэн байдал, чанар дээр анхаарч, санхүүжилтийг нэмэгдүүлснээр бусад Монгол туургатан ард түмэн язгуур соёл, урлагийн эвентүүдээс ялгарах* |
| 10 | Хөх сувд - Хөвсгөлийн мөсний баяр | Гадаадын жуулчид нээлттэй оролцох "Competition for tourists" арга хэмжээнд Ханх сумаар дамжин ирэх Орос жуулчдыг оролцуулж сурталчлах | Үзэсгэлэнт Хөвсгөл нуурын эрэгт, байгалийн сайханд морин чарганы соёлыг сурталчилж гадаадын жуулчдын тоог нэмэгдүүлэх | Өвөл болдог эвентүүдийг нэгтгэж "Дэлхийн нүүдэлчдийн өвөл" гэдэг нэг эвент болгон жуулчны бааз, амралтын газруудыг эвентийн хугацаанд түр нээж ажиллуулах | Хөвсгөл далайн мөсийг шалгах, мөс цөмрөх аюулаас урьдчилан сэргийлж автомашины хөдөлгөөн, парклах ажлыг эрэг дээр хийснээр байгаль орчныг бохирдуулахаас сэргийлэх |

Хүснэгт 24-т боломжит, шилдэг 10 эвентийн стратегийн зорилтуудыг хэрэгжүүлэх үйл ажиллагааны чиглэлийг өмнөх бүлэгт дурдсан SWOT анализ дээр үндэслэн TOWS матриц үүсгэн төлөвлөлт хийлээ. Үүнд:

- Давуу тал дээрээ тулгуурлан боломжоо ашиглах стратеги
- Давуу талаа ашиглан аюулаас зайлсхийх стратеги
- Боломжоо ашиглан сул талаа бууруулах стратеги
- Сул талаа бууруулан аюулаас зайлсхийх стратеги

“Боломжит, шилдэг 10 эвент”-ийн хувьд тус бүр өөр өөрийн гэсэн давуу тал, онцлогууд байгаа бөгөөд үүн дээр үндэслэн дотоод сул талаа засах, гадаад боломжуудаа ашиглах шаардлагатай. Үүнийг нэгтгэн дүгнэж үзвэл:

- Улаанбаатар хотод болдог эвентүүд өвөл, зун гэлтгүй байршлын хувьд давуу тал, дэд бүтцийн давуу тал, хэрэглэгчийн зах зээлийг татах боломжууд, гадаад жуулчдад хүргэх боломжууд бусдаас илүү байна.
- Өвөл болдог эвентүүд хугацааны хувьд хэдийгээр жуулчны улирлыг уртасгах сайн талтай боловч нөгөө талаас гадаад жуулчид хүрэлцэн ирж оролцоход цаг агаарын хувьд хүндрэлтэй, онгоцны нислэг цөөн үе таардаг зэрэг сул талууд нийтлэг байна.
- Ийм учраас өвлийн эвентүүдийг дэмжихийн тулд хугацааны хувьд багцлан бүлэглэх, олон улсын нислэгийг тухайн багцын үеэр нэмэгдүүлэх, мөн энэ үеэр дотоодын нислэгийг нэмэгдүүлэх шаардлагатай байна. Мэдээж энэ захиалгыг таамгаар бус тухайн үеийн жуулчдын захиалгыг тур оператор компаниудаас урьдчилан авах байдлаар тогтоох бөгөөд өвлийн багц эвентүүдээс 1-3 сарын өмнө /намар/ аль хэдийн тов гарсан байхаар зохион байгуулах нь чухал юм.
- Өвлийн эвент зохион байгуулагчдын санаачилж буй “Нүүдэлчдийн өвөл” багц эвентийг манай судалгааны баг мөн дэмжиж байгаа бөгөөд зохион байгуулалтын хувьд сайжруулан 1 сарын хугацаанд явагдахаар төлөвлөж болох юм. Ложистикийн хувьд дотоодын нислэг, авто замаар холбож болох ба заавал томоохон бүх эвентүүдэд биш зарим том эвент ба дунд нь жижиг эвентүүдтэй холбосон “Эвент аяллын маршрут” гаргаж борлуулалт хийх нь оновчтой гэж үзэж байна. Тухайлбал:

II сараас III сар хүртэл хугацаанд “Нүүдэлчдийн өвөл” багц эвентүүд

- Хөх сувд мөсний баяр
- Түмэн тэмээний баяр
- Улаанбаатарын өвлийн наадам

VII сараас VIII сар дуустал хугацаанд “Нүүдэлчдийн наадам” багц эвент

- Төрийн их наадам
- Хонины найр
- Монгол туургатны язгуур соёлын олон улсын их наадам
- Плэйтайм олон улсын хөгжмийн наадам

IX сараас X сар дуустал хугацаанд “Нүүдэлчдийн өв” багц эвент

- Алтан бүргэдийн баяр
- Талын түмэн адуу
- Хийморь морь харваань наадам

## 4.4. ДҮГНЭЛТ

Сонгогдсон 10 эвентийн зах зээлд эзлэх хувь хэмжээг тооцож, эрэмбэлэхэд Монгол төрийн их наадам нийт оролцогчдын тоо болон оролцсон гадаад жуулчдын тоогоороо дотоодын зах зээлд хамгийн их хувь эзэлж байна. Плэйтайм олон улсын хөгжмийн наадам оролцогчдын нийт тоогоороо зах зээлд 27.4% эзэлж буй ч гадаад оролцогчдын тоогоор 7.6% эзэлснээр 3 дугаар байрт, Алтан бүргэдийн баяр нийт оролцогчдын тоо бага боловч гадаад жуулчдын тоо өндөр учир зах зээлд 16.9% эзэлснээр хоёрдугаар байранд орсон. Түүнчлэн Хөх сувд мөсний баяр нийт оролцогчдын тоогоор тооцож үзэхэд нийт зах зээлийн 25.8 хувийг эзэлж нийт оролцогчдын тоогоороо 3-рт байна.

Нүүдлийн соёлын, Улаанбаатар хотоос 5 цагийн нислэгийн зайд байгаа орнуудын эвентүүдтэй харьцуулахад нийт зах зээлийн 92.49 хувийг Киргиз улсад зохион байгуулагддаг “Дэлхийн нүүдэлчдийн наадам” /World Nomad Games/ - Азийн орнуудын угсаатнуудын фестиваль дангаараа эзэлж байсан. Тус судалгаанд сонгон авсан Монголын 10 эвентийн хувьд хамтдаа нийт зах зээлийн 7 орчим хувийг эзэлж байна.

Эвент бүрийн зорилтот зах зээлийг тухайн эвентийн зорилго, ирсэн жуулчдын бүтэц, фокус бүлгийн ярилцлага дээр үндэслэн тодорхойлоход ихэнх нь дотоодын жуулчдад чиглэгдсэн байна. Олон улсын ангиллын дагуу сонгогдсон 10 эвентийг ангилахад ихэнх нь бүс нутгийн эвентүүд байна. Цаашид эдийн засгийн үр нөлөөг нэмэгдүүлэх үүднээс гадаадын жуулчид, гадны хэрэглэгчдэд зорилтот зах зээлээ чиглүүлэх шаардлагатай.

Бодлогын баримт бичгүүдэд аялал жуулчлалын бүтээгдэхүүн хөгжүүлэх, гадаад жуулчдын тоог нэмэгдүүлэхтэй холбоотой тусгасан зүйл заалт нийт 43 байгаагаас эвент аялал жуулчлалын агуулгыг шууд тусгасан зүйл 11 буюу нийт заалтуудын 26%-ийг эзэлж байна. Гэхдээ Монгол улсын эвент аялал жуулчлалын гол нөөц болох нүүдлийн соёл, өв уламжлал, түүх болоод түүхийн дурсгалт зүйлсийг аялал жуулчлалын бүтээгдэхүүн болгох, үйлчилгээний чанарыг сайжруулах чиглэлээр агуулгын хувьд багтаасан дээрх 43 зүйлийг үндэслэл болгон эвент аялал жуулчлалыг хөгжүүлэх бүрэн боломж байна.

Харин “Эвент” гэж онцгойлон тусгасан эрхзүйн баримт бичиг нь “Төрөөс аялал жуулчлалыг хөгжүүлэх талаар баримтлах бодлого” бөгөөд 2 зүйлийг нэр цохон дурджээ.

Стратегийн зорилгуудыг дэвшүүлэхдээ 2030 он хүртэлх буюу 8 жилийн хугацаатай стратегийн зорилтуудыг дэвшүүлсэн бөгөөд эдгээр зорилтууд бүрэн биелэгдэнэ гэж үзвэл суурь үзүүлэлтийн хугацаа /2019 он/-ны үеийн үзүүлэлтээс 3-10 дахин нэмэгдсэн байхаар үр дүнгийн хүлээлэлттэй байна.

Боломжит, шилдэг 10 эвентийн богино хугацааны зорилтуудыг зах зээл, хэрэглэгчээ нэмэгдүүлэх, маркетинг сурталчилгаагаа сайжруулах, зохион байгуулалт, менежментээ сайжруулах, санхүүжилт нөөцөө нэмэгдүүлэх, хамтын ажиллагаагаа сайжруулах гэсэн 5 үндсэн чиглэлээр тодорхойлсон. Учир нь цахим

болон биечилсэн уулзалт ярилцлага болон түүвэр судалгааны үр дүнгээс үзэхэд эвент зохион байгуулагчдын хувьд одоогоор дотоодын зах зээлд түлхүү анхаарч байгаа бөгөөд санхүүжилтийн хувьд хүндрэлтэй байгаа нь ажиглагдсан билээ.

Иймд манай судалгааны багийн зүгээс эвентүүдийн стратегийн зорилтыг тодорхойлохдоо бүтээгдэхүүний ялгарал буюу эвентийн онцлог шинжийг хэрхэн бүрдүүлж гадаадын жуулчдын тоог ямар хэмжээтэй нэмэгдүүлэх, үүний тулд гадаад, дотоодын байгууллагуудтай хэрхэн хамтран ажиллах вэ гэдгийг онцолсон.

Эвентүүдийн хувьд санхүүжилтийн хувьд хангалтгүй учраас үйл ажиллагаагаа өргөжүүлж чаддаггүй, 46% нь улсын болон орон нутгийн төсвөөс шууд хамааралтай, 33% нь улсын төсвөөс ямар нэгэн хэмжээгээр татаас авдаг /2019 оны байдлаар нийт эвентүүдийн хувьд/ нийтлэг сул талууд ажиглагдаж байна.

Өвлийн болон аялал жуулчлалын бус улиралд зохиогддог эвентүүдийг жуулчны улирал уртасгах сайн талтай гэх боловч тусгайлан үзүүлэх хөнгөлөлт, урамшуулал, дэмжлэг байдаггүй. Гэтэл гадаадын жуулчид багатай үед зохиогддог тул одоогоор дотоодын аялагчдыг татах тал дээр анхаарч ажиллаж байна. Мөн энэ шалтгаанаар ихэнх буюу эвентүүдийн 52% нь жуулчид их ирдэг 6,7,8 саруудад зохиогдож байна. Иймд өвлийн болон намрын эвентүүдэд тодорхой санхүүгийн илүү дэмжлэг хэрэгтэй байна.

Манай улсын цаашдын зорилго нь хамгийн том эвент болох “Төрийн их наадам”-ыг “Мега эвент” буюу олон зуун мянган хүн зорьж ирдэг, эдийн засгийн том нөлөө бүхий эвент болгож бусад томоохон эвентүүдээ “Холлмарк эвент” буюу олон улсын эвент болгох явдал юм. Үүнд хүрэхийн тулд TOWS матриц дээр дурдсаны дагуу маркетинг, зохион байгуулалтын менежмент, санхүүжилт, хамтын ажиллагааны олон арга хэмжээг хэрэгжүүлэх хэрэгтэй байна.

Аялал жуулчлалын эвентүүдийг олон хүн хамруулсан өргөн хүрээтэй болгохын тулд зөвхөн эвентийн үеийн хэдхэн хоногоор хязгаарлаж үл болох бөгөөд хугацааны хувьд ойрхон, байршлын хувьд ойролцоо бусад эвентүүд, аяллын үзмэрүүд, байршлын хэрэгсэлүүдтэй хэрхэн багцалж, хоршиж бүтээгдэхүүн болохыг төрөөс бодлогын хувьд нарийн төлөвлөх шаардлагатай байна. Иймд судалгааны багийн зүгээс эвентүүдийг багцлан дараах 3 хэсэгт хуваан нэгдсэн аяллын маршрут, хэсэгчилсэн маршрутуудыг төлөвлөх санал гаргаж байна. Үүнд:

а/ II сараас III сар хүртэл хугацаанд “Нүүдэлчдийн өвөл” багц эвентүүд
б/ VII сараас VIII сар дуустал хугацаанд “Нүүдэлчдийн наадам” багц эвент
в/ IX сараас X сар дуустал хугацаанд “Нүүдэлчдийн өв” багц эвент

Энэ 3 багцад нийт эвентийн 89% нь багтаж байгаа юм.

# ХАВСРАЛТ

## ХАВСРАЛТ 1. МОНГОЛ УЛСЫН АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН ЭВЕНТҮҮД

| | | |
|---|---|---|
| | 18 | Улаанбаатарын бүс |
| | 15 | Баруун бүс |
| | 28 | Хангайн бүс |
| | 27 | Төвийн бүс |
| | 12 | Зүүн бүс |
| | **100** | |

| | |
|---|---|
| High season | 52 |
| Middle season-1 | 18 |
| Off season | 17 |
| Middle season-2 | 13 |
| **Total** | **100** |

| Шалгуур / Эвентийн код | Эвентийн нэрс | Бүс нутаг |
|---|---|---|
| А-1 | Агтана хүрээт хүлэгч эрсийн наадам, олон улсын гэрэл зурагчдын уралдаан | Зүүн бүс |
| А-2 | "Агуу их цайны зам" ОУ-ын хүүхдийн наадам | Улаанбаатарын бүс |
| А-3 | Адуучдын баяр /Орхоны хөндий -Цайдам бааз/ | Хангайн бүс |
| А-4 | Адуучин, айрагны баяр /Дундговь-Хотод ойрхон говь эвентэд/ | Төвийн бүс |
| А-5 | Адуучин шоу-Адуучны нэг өдөр /МНТ жуулчны бааз/ | Төвийн бүс |
| А-6 | Айрагны баяр /Булганы ЗДТГ-с Улаанбаатар хотод/ | Хангайн бүс |
| А-7 | Айс чаллэнж /Ice Challenge Mongolia/ байршил өөрчлөгддөг | Улаанбаатарын бүс |
| А-8 | Алтан бүргэд - Бүргэдчидийн баяр | Баруун бүс |
| А-9 | Алтай eagle festival /Алтайн нүүдэлчдийн баяр-???/ | Баруун бүс |
| А-10 | Алтайн Урианхайн мөсний баяр, мөсөн сур харваа | Баруун бүс |
| Б-11 | Баруун Монгол ардын язгуур урлагийн наадам /Монгол туургатаны язгуур соёлын олон улсын их наадам/ | Баруун бүс |
| Б-12 | Боржигон өв соёлын их наадам /Төвийн бүсийн их хурд/ | Төвийн бүс |
| Б-13 | Булган уулын түмэн зул | Хангайн бүс |
| Г-14 | Галшарын хурдан адууны баяр | Зүүн бүс |
| Г-15 | Ганга нуурын чуулга | Зүүн бүс |
| Г-16 | Говийн ардын чуулган-Домгийн чуулган /Өмнөговь, Булган/ | Төвийн бүс |
| Г-17 | Говийн олон улсын марафон гүйлт /Монгол говь бааз/ | Төвийн бүс |
| Г-18 | "Говь Марч" олон улсын марафон гүйлтийн уралдаан /Элсэн тасархай/ | Хангайн бүс |
| Г-19 | Гонгорын бумбаны тахилга /Амарбаясгалант хийд/ | Төвийн бүс |
| Г-20 | Дархан хотын баяр | Төвийн бүс |
| Г-21 | "Дархан хайрханы тахилга" бэсрэг наадам | Төвийн бүс |
| Д-22 | Даян дээрхийн шагайн тойром /Хөвсгөл, Цагаан-Үүр/ | Хангайн бүс |
| Д-23 | Дээлтэй Монгол - наадам | Улаанбаатарын бүс |
| Д-24 | Дэлгэрхаан уулын тахилга-Цагаан адууны баяр, Дархад хурд | Хангайн бүс |
| Е-25 | Ерэн есөн бяцхан баатарын аялал - наадам /Цайдам бааз/ | Хангайн бүс |

| | | |
|---|---|---|
| Ё-26 | Ёохор наадам /Хэнтий, Батширээт/ | Зүүн бүс |
| З-27 | “Заг-Байдрагийн хүрэн бэлчир” Монгол туургатны харвуул их наадам | Хангайн бүс |
| З-28 | Заяын хүрээний өвлийн бэсрэг наадам /Урд Тамирын гол/ | Хангайн бүс |
| И-29 | Их хотын өдөр /Эрдэнэт/ | Хангайн бүс |
| И-30 | Их говийн тэмээ-Цагаансуварга /Хотод ойрхон говь эвентэд/ | Төвийн бүс |
| И-31 | Их говийн тэмээний баяр /Тэмээний их баяр/ | Баруун бүс |
| К-32 | “Karakorum Ice Festivale” мөсөнд авиралтын УАШТ | Хангайн бүс |
| М-33 | “Малчны баяр” арга хэмжээ /“Онгийн хийд”-Хотод ойрхон говь эвентэд/ | Төвийн бүс |
| М-34 | Мөнгөлөг шагшуурга - цас мөсний баяр /Хар-Ус нуур/ | Баруун бүс |
| М-35 | Мөсний баяр-Баян-Өлгий | Баруун бүс |
| М-36 | Мөсний шагай /Мөнгөн өвлийн жингэнээ/ | Хангайн бүс |
| М-37 | Монгол төрийн их наадам /Төв цэнгэлдэх/ | Улаанбаатарын бүс |
| М-38 | Монголиа байк чэллэнж /Mongolia bike challenge/ | Төвийн бүс |
| М-39 | Монгол наадам /Чингисийн хүрээ/ | Улаанбаатарын бүс |
| М-40 | Монгол сарлаг | Хангайн бүс |
| М-41 | Монгол туургатны соёл, спортын их наадам | Улаанбаатарын бүс |
| М-42 | Монголын говь-225км хэт холын ОУ-ын марафон гүйлт /Архангай-БОАЖГ/ | Төвийн бүс |
| М-43 | Монголын нүүдэлчдийн нэг өдөр | Төвийн бүс |
| Н-44 | Наадам найт | Улаанбаатарын бүс |
| Н-45 | Наурызын баяр | Баруун бүс |
| Н-46 | Наурызын бүргэдийн баяр | Баруун бүс |
| Н-47 | Нүүдэлчдийн өвөл - Цагаан сарын баяр | Төвийн бүс |
| Н-48 | Нүүдэлчин наадам-Монгол нүүдэлчин /Mongolia nomadic/ | Төвийн бүс |
| Н-49 | Нүүдэлчдийн соёлын наадам /Улаагчны хар нуур/ | Баруун бүс |
| О-50 | Онгийн Улаан нуурын мөсний баяр | Төвийн бүс |
| П-51 | Плэйтайм /Playtime/ хөгжмийн наадам | Улаанбаатарын бүс |
| С-52 | Сайханы сарлаг - наадам (Өмнөговь) | Төвийн бүс |
| С-53 | Санрайз, Сансэт /Хөвсгөл, Хатгал/ | Хангайн бүс |
| С-54 | Сарлагийн баяр (Өвөрхангай) | Хангайн бүс |
| С-55 | Сарлагийн наадгай (Баянхонгор) байршил сум өөрчлөгддөг | Хангайн бүс |
| С-56 | Сарлагийн наадам (Хөвсгөл, Хатгал) | Хангайн бүс |
| С-57 | Соёлын наадам /Хүй 7 худаг/ | Улаанбаатарын бүс |
| С-58 | Соёлын биет бус өвийн их наадам /Хүй 7 худаг/“Нүүдэлчин-Монгол" | Улаанбаатарын бүс |
| Т-59 | Талын түмэн адуу | Зүүн бүс |
| Т-60 | Тал нутгийн соёл /Халх, Буриад, Барга, Үзэмчин ястаны отог/ | Зүүн бүс |
| Т-61 | Талын нар шинэ оны нар харах аялал /Сүхбаатар-Талын наран/ | Зүүн бүс |
| Т-62 | "Талын салхи” Олон улсын мото наадам | Улаанбаатарын бүс |

| | | |
|---|---|---|
| Т-63 | Талын тайга нохойны үзүүлбэр | Зүүн бүс |
| Т-64 | Тогорууны баяр | Зүүн бүс |
| Т-65 | Торгоны зам - Хархорин хот | Хангайн бүс |
| Т-66 | Төв-Түмний цэнгэл | Төвийн бүс |
| Т-67 | Түмэн тэмээний баяр | Төвийн бүс |
| Т-68 | Түйн голын жавар /Түйн голын Огтонотой булаг/ | Хангайн бүс |
| Т-69 | Тэмээ тэнгэрийн амьтан | Хангайн бүс |
| Т-70 | Тэмээ-мөс-загасчлал | Баруун бүс |
| У-71 | Улаанбаатар марафон - Олон улсын гүйлт | Улаанбаатарын бүс |
| У-72 | Улаанбаатарын өвлийн наадам | Улаанбаатарын бүс |
| У-73 | “Улаанбаатар” Олон Улсын явган аяллын фестиваль | Улаанбаатарын бүс |
| У-74 | Уяхан замбуу тивийн наран | Төвийн бүс |
| Ү-75 | Үндэсний тоглоомын баяр /Говь Мираж бааз/ | Төвийн бүс |
| Х-76 | Хаврын Бүргэдийн баяр /Чингисийн хүрээ бааз/ | Улаанбаатарын бүс |
| Х-77 | Хангинахын Шагайн тойром /Гуртын гүүр/ | Хангайн бүс |
| Х-78 | Хансонар бүргэдийн баяр | Баруун бүс |
| Х-79 | "Хийморь" Олон улсын морьт харвааны тэмцээн /Чингисийн хүрээ бааз/ | Улаанбаатарын бүс |
| Х-80 | Хонины найр | Төвийн бүс |
| Х-81 | Хонгорын хурд /Хонгорын элс/ | Төвийн бүс |
| Х-82 | Хөвсгөл нуурын дэлгэр их тахилга | Хангайн бүс |
| Х-83 | Хөх сувд - Хөвсгөлийн мөсний баяр | Хангайн бүс |
| Х-84 | Хөрш зэргэлдээ 3 улсын АЖ-ын өдөр | Зүүн бүс |
| Х-85 | Хуралдай наадам-Шонхорын баяр /Чингисийн хүрээ бааз/ | Улаанбаатарын бүс |
| Х-86 | Хүрээ цам-Даншиг наадам /Төв цэнгэлдэх/ | Улаанбаатарын бүс |
| Х-87 | "Хүүхэд-Эрдэнэ" бэсрэг наадам /Их Бурхант/ | Зүүн бүс |
| Ц-88 | Цаатан наадам-фестиваль /Далай тур бааз/ | Хангайн бүс |
| Ц-89 | Цаатны наадам-2000 цааны баяр | Хангайн бүс |
| Ц-90 | Цайны зам өв соёлын наадам | Баруун бүс |
| Ц-91 | Цасны наадам /Хөвсгөл, Рэнчинлхүмбэ/ | Хангайн бүс |
| Ч-92 | Чингис фестиваль хүүхдийн наадам | Зүүн бүс |
| Ш-93 | “Шамбалын их ерөөл хурах ёслол” /Хамрын хийд/-Зулын ерөөл | Төвийн бүс |
| Э-94 | Ээж мод - ханш нээх өдөр /Сэлэнгэ/ | Төвийн бүс |
| Э-95 | Элсний фестиваль /Эрээн нуур бааз ба Гүн нуур-өөрчлөгддөг/ | Баруун бүс |
| Э-96 | Эр бор харцага - эртний Монгол наадам /13-р зуун/ | Төвийн бүс |
| Э-97 | Эсгий урлалын баяр /Монгол эсгийний баяр/ | Хангайн бүс |
| Э-98 | Элсэн манханы баяр /Хонгорын элс/ | Төвийн бүс |
| Э-99 | Ээж уулын элбэрэл /Ээж хайрхан уул/ | Баруун бүс |
| Э-100 | Эв модны наадам-Бага Алтаргана | Хангайн бүс |

## ХАВСРАЛТ 2. ҮНЭЛГЭЭНИЙ ДЭЛГЭРЭНГҮЙ ХУУДАС

| Шалгуур Эвентийн код | Хэрэглэгч-дийн тоо | Тогтмолж-сон байдал | Тэнцвэржүү-лэх байдал | Өв тээгч байдал | Өвөрмөц байдал | Цогц байдал | НИЙТ |
|---|---|---|---|---|---|---|---|
| А-1 | 1 | 3 | 4 | 3 | 4 | 2 | 2.8 |
| А-2 | 5 | 1 | 4 | 5 | 5 | 5 | 4.2 |
| А-3 | 1 | 5 | 1 | 3 | 4 | 5 | 3.2 |
| А-4 | 2 | 2 | 3 | 4 | 5 | 3 | 3.2 |
| А-5 | 3 | 5 | 1 | 3 | 4 | 4 | 3.3 |
| А-6 | 1 | 3 | 3 | 4 | 2 | 5 | 3 |
| А-7 | 1 | 3 | 4 | 1 | 1 | 5 | 2.5 |
| А-8 | 5 | 5 | 3 | 5 | 5 | 3 | 4.3 |
| А-9 | 5 | 3 | 5 | 5 | 5 | 3 | 4.3 |
| А-10 | 5 | 5 | 4 | 4 | 5 | 3 | 4.3 |
| Б-11 | 3 | 5 | 1 | 5 | 5 | 5 | 4 |
| Б-12 | 4 | 5 | 1 | 5 | 5 | 2 | 3.7 |
| Б-13 | 0 | 5 | 4 | 4 | 4 | 4 | 3.5 |
| Г-14 | 0 | 5 | 1 | 5 | 4 | 3 | 3 |
| Г-15 | 0 | 3 | 3 | 4 | 4 | 3 | 2.8 |
| Г-16 | 1 | 1 | 3 | 4 | 3 | 3 | 2.5 |
| Г-17 | 3 | 5 | 3 | 2 | 1 | 3 | 2.8 |
| Г-18 | 3 | 2 | 2 | 1 | 1 | 3 | 2 |
| Г-19 | 1 | 5 | 1 | 3 | 2 | 2 | 2.3 |
| Д-20 | 1 | 5 | 3 | 1 | 1 | 3 | 2.3 |
| Д-21 | 1 | 5 | 2 | 3 | 2 | 1 | 2.3 |
| Д-22 | 1 | 3 | 2 | 4 | 2 | 2 | 2.3 |
| Д-23 | 5 | 5 | 1 | 5 | 5 | 5 | 4.3 |
| Д-24 | 0 | 1 | 3 | 4 | 2 | 2 | 2 |
| Е-25 | 1 | 5 | 1 | 3 | 3 | 3 | 2.7 |
| Ё-26 | 3 | 4 | 1 | 4 | 4 | 4 | 3.3 |
| З-27 | 2 | 3 | 1 | 3 | 5 | 3 | 2.8 |
| З-28 | 1 | 3 | 4 | 5 | 3 | 4 | 3.3 |
| И-29 | 1 | 3 | 4 | 2 | 1 | 2 | 2.2 |
| И-30 | 3 | 1 | 3 | 4 | 5 | 3 | 3.2 |
| И-31 | 1 | 3 | 4 | 4 | 5 | 2 | 3.2 |
| К-32 | 0 | 4 | 4 | 1 | 1 | 4 | 2.3 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| М-33 | 4 | 4 | 3 | 5 | 5 | 3 | 4 |
| М-34 | 1 | 5 | 4 | 4 | 4 | 2 | 3.3 |
| М-35 | 0 | 5 | 5 | 3 | 4 | 3 | 3.3 |
| М-36 | 0 | 2 | 5 | 4 | 3 | 3 | 2.8 |
| М-37 | 5 | 5 | 1 | 5 | 5 | 5 | 4.3 |
| М-38 | 4 | 5 | 3 | 1 | 1 | 4 | 3 |
| М-39 | 2 | 5 | 1 | 5 | 5 | 5 | 3.8 |
| М-40 | 3 | 4 | 2 | 5 | 3 | 5 | 3.7 |
| М-41 | 0 | 5 | 2 | 1 | 1 | 4 | 2.2 |
| М-42 | 2 | 1 | 1 | 5 | 5 | 3 | 2.8 |
| М-43 | 1 | 3 | 1 | 3 | 4 | 5 | 2.8 |
| Н-44 | 5 | 1 | 1 | 5 | 5 | 5 | 3.7 |
| Н-45 | 5 | 5 | 4 | 4 | 4 | 4 | 4.3 |
| Н-46 | 5 | 5 | 4 | 5 | 5 | 4 | 4.7 |
| Н-47 | 1 | 5 | 5 | 3 | 4 | 4 | 3.7 |
| Н-48 | 3 | 5 | 1 | 5 | 5 | 5 | 4 |
| Н-49 | 3 | 1 | 1 | 5 | 5 | 3 | 3 |
| О-50 | 0 | 1 | 4 | 4 | 5 | 3 | 2.8 |
| П-51 | 4 | 5 | 1 | 4 | 5 | 5 | 4 |
| С-52 | 1 | 2 | 3 | 5 | 4 | 5 | 3.3 |
| С-53 | 2 | 3 | 1 | 2 | 2 | 5 | 2.5 |
| С-54 | 4 | 5 | 1 | 3 | 4 | 4 | 3.5 |
| С-55 | 2 | 4 | 1 | 3 | 4 | 3 | 2.8 |
| С-56 | 0 | 5 | 1 | 4 | 4 | 5 | 3.2 |
| С-57 | 4 | 5 | 1 | 5 | 5 | 5 | 4.2 |
| С-58 | 2 | 1 | 1 | 5 | 5 | 5 | 3.2 |
| Т-59 | 4 | 5 | 4 | 5 | 5 | 3 | 4.3 |
| Т-60 | 0 | 1 | 1 | 4 | 4 | 2 | 2 |
| Т-61 | 0 | 5 | 4 | 1 | 1 | 2 | 2.2 |
| Т-62 | 3 | 5 | 2 | 1 | 3 | 5 | 3.2 |
| Т-63 | 0 | 3 | 1 | 4 | 5 | 3 | 2.7 |
| Т-64 | 0 | 5 | 2 | 1 | 2 | 3 | 2.2 |
| Т-65 | 5 | 2 | 1 | 5 | 5 | 5 | 3.8 |
| Т-66 | 0 | 1 | 1 | 5 | 5 | 3 | 2.5 |
| Т-67 | 3 | 5 | 4 | 5 | 4 | 5 | 4.3 |
| Т-68 | 1 | 3 | 5 | 4 | 2 | 2 | 2.8 |
| Т-69 | 0 | 5 | 4 | 4 | 3 | 2 | 3 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| Т-70 | 2 | 2 | 4 | 4 | 2 | 3 | 2.8 |
| У-71 | 4 | 5 | 2 | 1 | 2 | 5 | 3.2 |
| У-72 | 3 | 5 | 5 | 2 | 4 | 5 | 4 |
| У-73 | 4 | 5 | 2 | 1 | 3 | 5 | 3.3 |
| У-74 | 2 | 4 | 1 | 5 | 4 | 3 | 3.2 |
| Ү-75 | 0 | 2 | 1 | 5 | 5 | 4 | 2.8 |
| Х-76 | 3 | 2 | 4 | 5 | 4 | 5 | 3.8 |
| Х-77 | 0 | 4 | 2 | 5 | 5 | 3 | 3.2 |
| Х-78 | 5 | 5 | 3 | 5 | 5 | 4 | 4.5 |
| Х-79 | 5 | 2 | 3 | 5 | 5 | 5 | 4.2 |
| Х-80 | 3 | 5 | 1 | 5 | 5 | 5 | 4 |
| Х-81 | 5 | 1 | 1 | 5 | 5 | 4 | 3.5 |
| Х-82 | 0 | 1 | 2 | 5 | 4 | 4 | 2.7 |
| Х-83 | 3 | 5 | 4 | 4 | 3 | 5 | 4 |
| Х-84 | 0 | 5 | 3 | 2 | 2 | 2 | 2.3 |
| Х-85 | 3 | 2 | 1 | 5 | 5 | 5 | 3.5 |
| Х-86 | 3 | 5 | 3 | 5 | 5 | 5 | 4.3 |
| Х-87 | 0 | 1 | 1 | 5 | 3 | 2 | 2 |
| Ц-88 | 5 | 4 | 1 | 4 | 2 | 5 | 3.5 |
| Ц-89 | 4 | 1 | 1 | 4 | 3 | 5 | 3 |
| Ц-90 | 0 | 2 | 3 | 5 | 5 | 3 | 3 |
| Ц-91 | 5 | 1 | 5 | 3 | 3 | 3 | 3.3 |
| Ч-92 | 1 | 3 | 1 | 2 | 4 | 3 | 2.3 |
| Ш-93 | 0 | 5 | 3 | 3 | 3 | 1 | 2.5 |
| Э-94 | 1 | 2 | 4 | 4 | 2 | 2 | 2.5 |
| Э-95 | 1 | 5 | 1 | 2 | 3 | 2 | 2.3 |
| Э-96 | 2 | 2 | 1 | 5 | 5 | 3 | 3 |
| Э-97 | 2 | 5 | 1 | 5 | 5 | 4 | 3.7 |
| Э-98 | 3 | 3 | 3 | 2 | 2 | 4 | 2.8 |
| Э-99 | 0 | 4 | 3 | 2 | 1 | 3 | 2.2 |
| Э-100 | 0 | 1 | 2 | 4 | 4 | 3 | 2.3 |

## ХАВСРАЛТ 3. ФОКУС БҮЛГИЙН ЯРИЛЦЛАГЫН ТЭМДЭГЛЭЛ

**Монгол улсын аялал жуулчлалын эвентийн эдийн засгийн нөлөөлөл**

**Зохион байгуулагч:** БОАЖЯ, Афим Монголиа ТББ

**Зорилго:** Аялал жуулчлалын эвентүүдийг эдийн засгийн нөлөөлөлөөр нь эрэмбэлж, үнэлэх арга зүйн талаар аялал жуулчлалын багш, судлаачдын дунд хэлэлцүүлэг хийж цаашид эвентийн ач холбогдлыг нэмэгдүүлэх боломжийн талаар ярилцах

**Оролцогч талууд:**

- БОАЖЯ-ны ахлах мэргэжилтэн Болормаа
- Афим Монголиа ТББ-ын эдийн засаг, маркетингийн судлаачид
- Аялал жуулчлалын боловсрол хөгжлийн нийгэмлэгийн судлаачид

**Хугацаа:**

2021 оны 08-р сарын 25-ны өдрийн 15:30 цагаас 17:30 цаг хүртэл

**Хөтөлбөр:**

- Төслийн товч танилцуулга
- Үнэлгээний арга зүйн танилцуулга
- Эвентүүдийг эрэмбэлэх үндсэн арга зүйн талаарх санал асуулга
- Эдийн засгийн 5 бүсийг төлөөлөх эвентүүдийн талаарх хэлэлцүүлэг

**ХУРЛААС ГАРСАН ГОЛ САНАЛ, ЗӨВЛӨМЖҮҮД**

| № | САНАЛ ЗӨВЛӨМЖ |
|---|---|
| 1 | Олон улсын аялал жуулчлалын салбарын өрсөлдөх чадварын индексийг тооцдог аргачлалыг судалж, цаашдын тайланд тусгах |
| 2 | Эвентийг өргөн хүрээнд авч үзэж, төрөл, хамрах хүрээгээр нь ангилах. Бусад салбарын яамдуудтай хамтарч ажиллах, саналыг нь авах. |
| 3 | Хайлтын систем дээр гарч ирж байгаа илэрцээр эвентийг үнэлдэг арга зүй байдгийг ашиглах. “Монгол” гэдэг үгтэй хамт гарч ирж байгаа түлхүүр үгнүүдийг анхааралдаа авах, судалгааны ажилдаа тусгах. НҮБ-ийн 6 хэлээр хайхад мэдээллийн олдоц хэр байгааг судлах |
| 4 | Эвентийг бүтээгдэхүүн гэдэг өнцгөөс харж, сэтгэл ханамжийн судалгаа, ямар хүлээлттэй ирсэн зэрэг дээр үндэслэж эвентийг хөгжүүлдэг байх |
| 5 | Эвентийг үнэлэх шалгуур үзүүлэлтээ дэлгэрүүлж дэлгэрэнгүй үнэлгээний хуудас гаргах. |
| 6 | “Алсан хараа 2050”-д заасан бүсчлэлийн 6 бүсийг ашиглах. |

**Оролцсон судлаачид:**

1. Д.Мөнхтөмөр /АЖБХН-ийн УЗ-ийн гишүүн. Манзушир төслийн гишүүн, “Хаппи сити групп” ХХК-ны Аялал жуулчлалын захирал/

2. Б.Мөнхбадрал /АЖБХН-ийн УЗ-ийн гишүүн. Соёлын АЖ-ын эвент чиглэлийн судлаач, СУИС-ийн багш, Ph.D/
3. Ч.Мөнхжаргал /АЖБХН-ийн Хүндэт гишүүн. Монголыг төлөөлөх САЖ-ын бүтээгдэхүүний судалгаа чиглэлээр мэргэшсэн судлаач/
4. Э.Хишигбаяр /АЖБХН-ийн УЗ-ийн гишүүн. “1000 унаганы баяр” эвентийн зохион байгуулагч/
5. Б.Ербахыт /Жинхэнэ гишүүн. АЖ-ын эдийн засгийн нөлөөллийн судалгаа/
6. Д.Гансүх /АЖБХН-ийн Хүндэт гишүүн. Тогтвортой АЖ-ын судалгаагаар мэргэшсэн. “Аялал жуулчлалын сургалт, судалгааны төв”-ийн тэргүүн/
7. Ч.Болорхүү /АЖБХН-ийн Жинхэнэ гишүүн. АЖ-ын эвентийн судалгаагаар мэргэшсэн. МАЖХ-ны ерөнхий менежер асан/
8. Э.Цоморлиг /“Монголын эвентийн холбоо”-ны УЗ, “Аяллын андууд компаний захирал, “Join me” төслийн удирдагч /



# ХАВСРАЛТ 4. БОАЖЯ-НЫ АЛБАН ТООТ

МОНГОЛ УЛСЫН
БАЙГАЛЬ ОРЧИН,
АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН ЯАМ

15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг,
Нэгдсэн Үндэстний гудамж 5/2, Засгийн газрын II байр,
Утас: 26 19 66, Факс: (976-51) 26 61 71,
И-мэйл: contact@mne.gov.mn, Вэбсайт: www.mne.mn

2021.08.20. № 03/3786

танай ____________-ны №____________-т

АЙМГУУДЫН БАЙГАЛЬ ОРЧИН,
АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН ГАЗРЫН
ДАРГА НАРТ

Хамтран ажиллах тухай

Алсын хараа-2050 Монгол Улсын урт хугацааны бодлогын баримт бичигт "Үндэсний онцлог, бүхий аялал жуулчлалыг хөгжүүлж, олон улсын аялал жуулчлалын зах зээлд өрсөлдөх чадвараа дээшлүүлэх", Монгол Улсын Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн 3.4.5-д "Монголын нүүдлийн соёлын онцлогт тохирсон үндэсний шинэлэг, сор бүтээл, брэнд бүтээгдэхүүн үйлдвэрлэж, аялал жуулчлалыг дэмжих" гэсэн зорилтуудын хүрээнд Дэлхийн банкны Экспортыг дэмжих төслийн дэмжлэгтэйгээр "Монгол Улсын аялал жуулчлалын эвентийн стратеги төлөвлөгөө, бүтээгдэхүүн хөгжлийн дүн шинжилгээ, зөвлөмж боловсруулах" төслийг хэрэгжүүлж байна.

Төслийн судалгааны ажилд шаардлагатай хавсралтад тусгагдсан мэдээллийг судалгааны багт ирүүлж хамтран ажиллана уу.

Жич: Аялал жуулчлалын бодлого, зохицуулалтын газрын мэргэжилтэн Н.Болормаа /51-264848, n.bolormaa@mne.gov.mn/ судалгааны багийн гишүүн С.Бямбасүрэн /91996665, afimongolia@gmail.com/ нартай холбогдоно уу.

ТӨРИЙН НАРИЙН БИЧГИЙН
ДАРГА Д.ГАНБОЛД

Байгаль орчин, аялал жуулчлалын яамны
2021 оны ... дугаар сарын .. .-ний өдрийн
.... дугаар албан бичгийн хавсралт

# СУДАЛГААНЫ АЖИЛД ШААРДАГДАХ МЭДЭЭЛЛИЙН ЖАГСААЛТ

Аймаг орон нутгийн БОАЖГ-ын Аялал жуулчлалын мэргэжилтнүүдээс авах мэдээллийн жагсаалт:

1. Тухайн орон нутагт 2016 оноос хойш зохион байгуулагдсан эвентүүдийн жагсаалт, зохион байгуулагдсан газар, огноогоор, голлон зохион байгуулсан байгууллагын мэдээлэл
2. Эвентүүдийн үндсэн онцлог, ялгарах имидж, үнэт зүйлийн талаарх мэдээлэл
3. Тухайн аймагт 2016 оноос хойш зохион байгуулагдсан эвентүүдийн нийт зардлын мэдээлэл, эвент бүрээр, үүнээс санхүүжүүлсэн эх үүсвэрүүдийн зардлын хэмжээ /орон нутаг, улсын төсөв, компани г.м/
4. Эвентүүдийн орлогын мэдээлэл, шууд ба шууд бусаар
5. Эвентүүдийн оролцогсодын тоо /дотоодын аялагч, гадаадын жуулчид, үзэгч иргэд/
6. Эвентүүдэд ажилласан ажиллагсадын тоо
7. Эвент бүрийн хувьд зохион байгуулахад учирч байсан хүндрэлүүд, шийдэх арга зам, сайжруулах ажлын талаар дүгнэлт шинжилгээ
8. Эвент бүрийн хувьд гаргасан тайлан мэдээ

## ХАВСРАЛТ 5. ЗАРИМ НҮҮДЛИЙН СОЁЛЫН ЭВЕНТҮҮД

### ДЭЛХИЙН НҮҮДЭЛЧДИЙН НААДАМ






2014 - Төв азийн нүүдэлчин 20 улс орны 400 тамирчин 10 төрлөөр
2016 - Дэлхийн 62 улсын 1200 гаруй тамирчид
2018 – 77 улсын 3000 тамирчид

- морин дээрээс нум сумаар харвах,
- нохой болон бүргэдээр ан агнах,
- морин поло,
- шагайн харваа,
- хүчит бөхийн барилдаан,
- амь өрссөн жадтай тулаан гэх мэт 25 төрлөөр АНУ, ОХУ, Энэтхэг зэрэг улсыг урилгаар оролцуулж хүрээгээ тэлсэн байна.
- Наадамлаж буй нүүдэлчид Иссык-Куль нуурыг тойрсон 20 орчим отог үүсгэсэн бөгөөд 300 орчим гэр барьж отоглон буужээ.
-

### “NOMADS’ WORLD FESTIVAL”

Казахстан улс 2018 оны 06-р сарын 30-наас 7-р сарын 1-ны өдрүүдэд “Нүүдэлчдийн ертөнц” этно фестивалийг зохион байгуулсан бөгөөд 2021 онд Этно олимпийг өөрийн улсдаа зохион байгуулах хүсэлтийг ЮНЕСКО-д гаргасан байна. 2021 оны Этно-олимпийг зохион байгуулахаар Казахстан, Турк, Канад, Өмнөд Солонгос зэрэг 4 улс өрсөлдөж байгаа бөгөөд энэ олимп нь Киргизийн Дэлхийн нүүдэлчдийн наадамтай утга агуулгын хувьд их төстэй.

Казахстан улс сүүлийн жилүүдэд нүүдэлчин соёл, үндэсний хувцас, уламжлалт тоглоом наадгайг түлхүү сурталчилж байгаа. Үүнээс гадна этник хөгжмийн урсгалыг хүчтэй хөгжүүлж, шинэ хамтлаг дуучдыг олноор бэлдэж гаргажээ. Өөрөөр хэлбэл нүүдэлчдийн этник дуу хөгжим, үндэсний фестивалиараа улс орноо сурталчилж байна.[93]

[93] https://www.azattyq.org/a/29270045.html

Дөрөв дэх Koshpendiler Alemi буюу “World of Nomads festival” нь 2019 оны 6-р сарын 28-аас 30-ны өдрүүдэд нийслэлийн Этноауыл үндэсний соёлын цогцолборт болов.[94]

Хүннү, Кангжу, Массагета, Сака, Скиф, Сармат, Тиграхауда, Усун нарын эрин үеийн хувцасны үзүүлбэрийг толилуулав. Уг хөтөлбөрт угсаатны хөгжмийн концертыг багтаасан болно. Азербайджан, Болгар, Иран, Киргиз, Монгол, Өмнөд Солонгос, Турк, Узбекстаны 22 оролцогчтой байв.

## “ЭТНО АУЫЛ” АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН ЦОГЦОЛБОР, КАЗАКСТАН УЛС

АСТАНА-EXPO-2017 үзэсгэлэнгийн бүтээн байгуулалтын хүрээнд “Этно ауыл” (энэ нь Ethno Village гэсэн үг) буюу нүүдэлчдийн хотхоныг байгуулсан. Үүнд:

- 2500 м.кв талбайг хамарсан 40 гэр, 8 хэсгээс бүрдэх цогцолбор
- дархчуулын хэсэг,
- үндэсний зоог,
- урлаг соёлын нэгдсэн тайз,
- уламжлалт ан агнах ёсыг харуулсан хэсэг,
- нүүдэлчдийн уламжлалт тоглоом, наадгай зэрэг 8 хэсгээс бүрдэх бөгөөд хэсэг тус бүрдээ казах түмний нүүдэлчин соёлын янз бүрийн үзүүлбэртэй.

Энэ хотхон нээгдсэн эхний 2 өдөрт нийт 18 мянган зочин хүрэлцэн иржээ. Нийслэлийн захын хороололд нээгдсэн уг хотхонд зохион байгуулагчид зочдыг казах ард түмний баялаг түүх, урлаг, уламжлал, зан заншил, үндэсний хоолтой танилцуулж, нүүдэлчдийн амьдрал хэрхэн өрнөдгийг мэдрүүлэхээр зорьж байна.

Экспо дуусмагц Ethno Village нь улирлын чанартай үндэсний болон соёлын төв хэлбэрээр үргэлжлүүлэн ажиллаж байгаа юм. Үндэсний хамгийн тод арга хэмжээнүүд жил бүр зохион байгуулагдах төлөвлөгөөтэй.

**“Этно ауыл” аялал жуулчлалын цогцолборын зураг:**



[94] https://astanatimes.com/2019/07/world-of-nomads-festival-presents-ancient-traditions-martial-arts-competitions/

## “КАЗАХ ЕРТӨНЦ” НҮҮДЭЛЧДИЙН ЦЭЦЭРЛЭГТ ХҮРЭЭЛЭН

"Эртний Тараз" археологийн цэцэрлэгт хүрээлэн нь 20 га талбайг эзэлдэг бөгөөд үүдний нуман хаалга, харуулын цамхаг, Найрамдлын ордон, Конгрессын танхимтай угсаатны соёлын төв, угсаатны зүйн музей гэх зэргээс бүрддэг байна.

Тараз бол Казахстаны хамгийн эртний хотуудын нэг юм. Энэ нь XIII-р зуунд Монголын цэргүүдэд устгагдах хүртэл Торгоны замын дагуу зогсоол болон цэцэглэн хөгжсөн эртний Тараз хотын суурин дээр байгуулагдсан хот тул археологийн олдвор бүхий чухал газар нутаг юм.

“Эртний Тараз” төсөл нь эртний дурсгалт зүйл бүхий өвөрмөц, нээлттэй задгай музей хэлбэрээр хөгжүүлэх зорилготой юм байна.

Төслийг орон нутгийн төсвөөс санхүүжүүлсэн. Археологчид VI-XII зуунд хамаарах 40 мянга орчим эд өлгийн зүйл, дундад зууны үеийн цайз, сүм хийд (VII-IX зууны үе), медресе, зиндан (шорон), эртний барилгуудын суурь зэргийг олж илрүүлжээ.

## ХАВСРАЛТ 6. ЮНЕСКО-ИЙН СОЁЛЫН БИЕТ БУС ӨВИЙН КОНВЕНЦ: Яаралтай хамгаалах шаардлагатай болон Төлөөллийн жагсаалт

- Морин хуур хөгжмийн уламжлалт урлаг (2008)
- Монгол ардын уртын дуу (2008)
- Монгол бий биелгээ, уламжлалт бүжгийн урлаг (2009)
- Монгол тууль (2009)
- Монгол цуур хөгжмийн уламжлалт урлаг (2009)
- Монголын уламжлалт Хөөмэйн урлаг (2010)
- Шувуучлахуй буюу Бүргэдээр ан хийх зан үйл (Ази, Европ, Арабын 18 улстай хамтран) (2010)
- Монгол баяр наадам (2010)
- Монгол лимбэчдийн уртын дуу тоглох уламжлалт арга барил – битүү амьсгаа (2011)
- Монгол уран бичлэг (2013)
- Монгол гэрийн уламжлалт урлал, зан үйл (2013)
- Монгол шагайн харваа (2014)
- Ботго авахуулах зан үйл (2015)
- Уул овоо тахих Монгол зан үйл (2017)
- Хөхүүрийн айраг исгэх уламжлал, холбогдох зан үйл (2019)

# ХАВСРАЛТ 7. НЭГ ХҮНД НОГДОХ ДНБ, АЙМГУУДЫН ӨРСӨЛДӨХ ЧАДВАР

Нэг хүнд ногдох ДНБ

| Зах зээл | Нэг хүнд ногдох ДНБ | | | | |
|---|---|---|---|---|---|
| | **Бүлэг** | **Дүн** | **Эзлэх байр** | **Харгалзах оноо** | **Өгсөн оноо** |
| Улаанбаатар | 1 | 17,327 | 1 | 7 | 7 |
| Өмнөговь | 2 | 12,113 | 2 | 6 | 6 |
| Төв | 3 | 6,677 | 3 | 5 | 4.5 |
| Хэнтий | 3 | 6,137 | 4 | 4 | 4.5 |
| Хөвсгөл | 4 | 5,263 | 5 | 3 | 2.5 |
| Увс | 4 | 4,760 | 6 | 2 | 2.5 |
| Баян-Өлгий | 5 | 4,099 | 7 | 1 | 1 |

Аймгуудын өрсөлдөх чадварын индекс

| Зах зээл | Өрсөлдөх чадварын индекс | | | | |
|---|---|---|---|---|---|
| | **Бүлэг** | **Дүн** | **Эзлэх байр** | **Харгалзах оноо** | **Өгсөн оноо** |
| Улаанбаатар | 1 | 100 | 1 | 7 | 6.5 |
| Өмнөговь | 1 | 98 | 2 | 6 | 6.5 |
| Увс | 2 | 72 | 3 | 5 | 4.5 |
| Хэнтий | 2 | 71 | 4 | 4 | 4.5 |
| Төв | 3 | 68 | 5 | 3 | 3 |
| Баян-Өлгий | 4 | 60 | 6 | 2 | 1.5 |
| Хөвсгөл | 4 | 57 | 7 | 1 | 1.5 |

Байршуулах хэрэгслийн хүчин чадал

| Зах зээл | Байршуулах хэрэгслийн хүчин чадал | | | | |
|---|---|---|---|---|---|
| | **Бүлэг** | **Дүн** | **Эзлэх байр** | **Харгалзах оноо** | **Өгсөн оноо** |
| Төв | 1 | 7,465 | 1 | 7 | 6.5 |
| Улаанбаатар | 1 | 7,402 | 2 | 6 | 6.5 |
| Хөвсгөл | 2 | 6,766 | 3 | 5 | 5 |
| Өмнөговь | 3 | 4,201 | 4 | 4 | 4 |
| Хэнтий | 4 | 3,673 | 5 | 3 | 3 |
| Увс | 5 | 1,572 | 6 | 2 | 1.5 |
| Баян-Өлгий | 5 | 1,549 | 7 | 1 | 1.5 |

Тухайн газар нутгийг зорин очсон жуулчдын тоо

| Зах зээл | Тухайн газар нутгийг зорин очсон жуулчдын тоо | | | | |
|---|---|---|---|---|---|
| | **Бүлэг** | **Дүн** | **Эзлэх байр** | **Харгалзах оноо** | **Өгсөн оноо** |
| Улаанбаатар | 1 | 577,262 | 1 | 7 | 7 |
| Төв | 2 | 72,000 | 2 | 6 | 6 |
| Увс | 3 | 45,104 | 3 | 5 | 4.5 |
| Өмнөговь | 3 | 42,132 | 4 | 4 | 4.5 |
| Хөвсгөл | 4 | 26,137 | 5 | 3 | 3 |
| Хэнтий | 5 | 6,150 | 6 | 2 | 1.5 |
| Баян-Өлгий | 5 | 6,000 | 7 | 1 | 1.5 |

## ХАВСРАЛТ 8. ТҮҮВЭР СУДАЛГАА, АРГАЧЛАЛ

**Судалгаа зорилго:** "Монгол Улсын аялал жуулчлалын эвентийн стратеги төлөвлөгөө, бүтээгдэхүүн хөгжлийн дүн шинжилгээ, зөвлөмж боловсруулах" зөвлөх үйлчилгээний хүрээнд эвентүүдийн эдийн засгийн нөлөөллийн үнэлгээ хийх, эрсдлийн болон стратеги төлөвлөгөө боловсруулах, бүтээгдэхүүн хөгжлийн дүн шинжилгээ хийхийн тулд эвентийг зохион байгуулагчид, аялал жуулчлалын тур операторууд, болон нийслэл, аймгуудын БОАЖГ-ын мэргэжилтнүүдээс зохион байгуулж буй эвентийн талаар тоо мэдээ, цуглуулах, зохион байгуулахад гарах хүндрэл бэрхшээл, тэдгээрийг даван туулахтай холбоотой мэдээлэл цуглуулахад энэхүү түүвэр судалгааны зорилго оршино.

**Түүврийн оновчтой хэмжээ, түүвэр**: түүврийн хэмжээг тогтоохдоо энгийн санамсаргүй түүврийн аргачлалаар түүврийн хэмжээг сонгосон ба томьёог доор үзүүлэв. Ингэхдээ эх олонлогийг хэвийн тархалттай гэж таамагласан болно.

$$n = \frac{t^2 * w(1-w) * N}{N * \Delta_p^2 + t^2 * w * (1-w)}$$

n-Түүврийн оновчтой хэмжээ

t-Стьюдентийн t тархалтын критик утга

w-Түүврийн тодорхой асуултанд хариулах магадлал буюу зорилтот бүлгийн эх олонлогт эзлэх хувь (Судалгаа хийхээс өмнө энэ үзүүлэлт мэдэгдэхгүй бол 0.5 гэсэн тогтмол тоог ашигладаг)

N-Эх олонлогийн хэмжээ

$\Delta$-алдааны хязгаар

**Ашигласан тоон өгөгдөл**:

| Өгөгдөл | Утга |
|---|---|
| T | 1.96 (95%-ийн итгэх магадлалын түвшин) |
| W | 0.5 (тогтмол утга) |
| N | 120[95] ( Монгол Улсад идэвхитэй үйл ажиллагаа явуулж буй тур операторын тоо) |
| $\Delta$ | 0.05 |
| N | 91.4 |

Ийнхүү 95 хувийн итгэх түвшинтэй, 0.05 -ийн алдааны хязгаартайгаар түүврийн оновчтой хэмжээг тодорхойлоход 91.4 гэж гарсан. Үүн дээр үндэслээд нийт 91 аж ахуй эрхлэгчээс түүвэр судалгаа авлаа.

[95] АЖХ-ны мэдээлснээр, 2019 оны байдлаар, идэвхитэй үйл ажиллагаа явуулж буй 120 тур оператор байна.

Харин нийслэл, аймгийн БОАЖГ-ын мэргэжилтнүүдээс 100 хувь судалгаа авсан. Өөрөөр хэлбэл тус судалгаанд бүх аймаг, хотын мэргэжилтнүүд хамрагдсан болно.

## ХАВСРАЛТ 9: ААН, КОМПАНИУДААС АВСАН СУДАЛГААНЫ ҮР ДҮН

Судалгаанд нийт 91 компани оролцсон ба тэдгээрийн 50 орчим хувь нь 10-аас дээш жил аялал жуулчлал эрхэлсэн бол, 46.3 хувь 5 хүртэлх жил аялал жуулчлалын эвентэд оролцсон байна. Энэ талаар дэлгэрэнгүй мэдээллийг дараах графикаас харна уу.

**Судалгаанд оролцсон компаниудын аялал жуулчлал эрхэлсэн болон эвентэд оролцсон хугацаа**




Судалгаанд оролцсон тур оператур компаниуд давхардсан тоогоор 49 эвентийг дангаараа болон хамтран зохион байгуулсан ба жуулчдаа оролцуулдаг болохыг дурдсан байна. Судалгаанаас харахад Мөсний баяр, Түмэн тэмээний баяр,Бүргэдийн баяр,Алтан намар бэсрэг наадамд хамгийн олон аж ахуй эрхлэгч оролцсон болохоо дурдсан байна.

**Эвентүүдийн онцлог, имидж**




Судалгаанд хамрагдсан тур оператур эвент зохион байгуулагч аж ахуйн нэгжүүдийн 34 хувь нь тэдний аймаг, орон нутагт зохион байгуулагдсан эвентүүд таван хошуу мал, нүүдлийн соёлд түшиглэсэнээрээ онцлог гэсэн бол 11 хувь нь спортын арга хэмжээнд түшиглэдэг, 8 хувь нь байгалийн сайханд түшиглэдэг, 6 хувь нь түүхэн газар нутагт зохион байгуулагддагаараа онцлог гэж хариулсан байна.

Судалгаанд оролцогсод эвент зохион байгуулахад гардаг түгээмэл хүндрэлүүдийг дараах байдлаар үнэлжээ.

### Эвентэд оролцоход гардаг түгээмэл хүндрэлүүд




Судалгаанд оролцогсдын хариулсан байдлаас харахад, эвентэд оролцох үнэ, өртөг, зардал хамгийн гол бэрхшээл болохыг 33.3 хувь нь дурджээ. Мөн Монгол Улсын аялал жуулчлалын эрх зүйн орчин, тухайн эвент болох газарт очих дэд бүтэц гол бэрхшээлийн нэг болдогийг судалгаанд оролцогсодын 22.22 болон 25.93 хувь нь тус тус дурдсан болохыг дээрх графикаас харж болно. Түүнчлэн, хог хаягдлын цэг, ариун цэврийн байгууламж голлох бэрхшээл болохыг энэ удаад ч мөн судалгаанд оролцогсод хариулсан байна. Харин хоол ундны хувьд бэрхшээл хүндрэл бараг гардаггүй болохыг судалгаанд оролцогсдын дийлэнх нь дурджээ.

**Эвентийг зохион байгуулахад гардаг хүндрэл**




Дээрх графикаас харахад, судалгаанд оролцогч эвент зохион байгуулагчид аялал жуулчлалын эвент зохион байгуулахад үүсдэг хүндрэлүүдэд санхүүжилт хүрэлцдэггүй, үйлчилгээ тааруу, байрших газрын хүндрэл гол асуудал байдгийг дурдсан байна. Түүнчлэн, зохион байгуулалт өөрчлөгддөг, зам дэд бүтэц муутай, цаг агаарын гэнэтийн өөрчлөлт ч мөн нилээдгүй хүндрэл үүсгэдэг болох талаар хариулт өгчээ.

**Аялал жуулчлалын эвент зохион байгуулахад гарах эрсдэл**




Цаг агаарын хүчин зүйл бол эвент зохион байгуулахад гардаг хамгийн том эрсдэл болохыг судалгаанд оролцогсдын 62.96 хувь нь хариулсан байна.

Түүнчлэн хамтран зохион байгуулагчдын уялдаа холбоо муу байдаг (судалгаанд оролцогсдын 37.04 хувь), гаргасан зардлаа нөхөж чадахгүй байдаг (судалгаанд оролцогсдын 31.48 хувь) нь мөн эрсдэл үүсгэдэг гэжээ.

**Эвентийн үйл ажиллагааг сайжруулах санал**




Эвентийн үйл ажиллагааг цаашид хэрхэн сайжруулах талаар судалгаанд оролцогсдын 33.3 хувь нь зохион байгуулалтаа сайжруулах шаардлагатай байгааг, 24 хувь нь үйлчилгээгээ сайжруулах шаардлагатайг, 22.2 хувь нь дэд бүтцээ сайжруулах шаардлагатайг, харин 20.37 хувь нь үзвэр үйлчилгээний тоог нэмэгдүүлэх шаардлагатай гэж үзжээ.

**Эвентийн талаар жуулчдын санал хүсэлт, аялал жуулчлалын компаниудын хариулсан байдлаар**




Судалгаанд оролцогсдын 55 хувь нь эвентэд оролцсон жуулчид оролцсон эвентдээ сэтгэл хангалуун байдаг гэж хариулсан бол 00, ариун цэврийн хувьд хангалтгүй, зам дэд бүтцийн хувьд сайжруулах шаардлагатай, үйлчилгээ хангалтгүй байдаг үзвэр үйлчилгээнийхээ тоог нэмэх шаардлагатай гэх мэт хариултыг өгсөн байна.

**Эвентийн нийгэм эдийн засагт үзүүлэх нөлөөлөл:**

Түүвэр судалгаанд аялал жуулчлалын компаниудын хариулсан байдлаас харахад нийт эвентүүдийн хувьд дундаж орлого нь 36.14 сая төгрөг, харин дундаж зардал нь 27.56 сая төгрөг буюу судалгаанд дурдагдсан эвентүүдийн хувьд дундаж орлого нь дундаж зардлаасаа 8.58 сая төгрөгөөр өндөр байгааг харж болно. Мөн судалгаанд хамрагдсан нийт эвентүүдийн хувьд хамгийн багадаа 350 мянга, хамгийн ихдээ 350 сая төгрөг зарцуулсан бол хамгийн багадаа 114 мянган төгрөг, хамгийн ихдээ 300 сая төгрөгийн орлого олсон эвентүүд байна.

Судалгааны тоон мэдээлэлд регрессийн шинжилгээ хийв. Ингэхдээ эвент зохион байгуулахад гарсан зардал болоод олсон орлогын хооронд хамаарал байгаа эсэх, ямар хамаарал байгааг үнэлсэн болно. Дараах тэгшитгэлийг үнэллээ. Үүнд:

| Model | | Unstandardized Coefficients | | Standardized Coefficients | T | Sig. | Correlations | | | Collinearity Statistics | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | B | Std. Error | Beta | | | Zero-order | Partial | Part | Tolerance | VIF |
| 1 | (Constant) | 2.688 | 1.514 | | 1.776 | 0.085 | | | | | |
| | ln(зардал) | 0.855 | 0.094 | 0.849 | 9.086 | <.001 | 0.849 | 0.849 | 0.849 | 1 | 1 |

**a. Dependent Variable: ln(орлого)**

Log (орлого)=b0+b1* Log (зардал)

Lg(Y)=2.688+0.855*Lg(X)

Y-орлого

X-Зардал

Зардал 1 хувиар өсөхөд, орлого 0.85 хувиар өснө гэсэн үр дүн гарч байна. Өөрөөр хэлбэл, эвентийг зохион байгуулах зардлын хэмжээ өсөх нь тур оператур компаниудын олох орлогод шууд нөлөөтэй болох нь харагдаж байна.

**Жуулчдын тоо, аялал жуулчлалын компаниудын хариулсан байдлаар**




Судалгаанд оролцсон эвентүүдийн хувьд, 1000-с их жуулчин (гадаад болон дотоод) татсан эвент нийт эвентийн 25 хувь, 100-1000 жуулчин татсан 37.5 хувь, 100 хүртэлх жуулчидтай 37.5 хувь байна. Харин 1000-с их гадаадын жуулчин татсан эвент нийт эвентийн 8.3 хувийг эзэлж байна. 100 хүртэлх гадаадын жуулчинтай эвент нийт эвентийн 58.3 хувийг эзэлж байгааг дээрх графикаас харж болно.

**Эвентийн эдийн засгийн үр ашиг, судалгаанд оролцогсдын үзэж буйгаар**




Судалгаанд оролцогчид аялал жуулчлалын эвентийн эдийн засгийн гол үр ашиг бол нутгийн иргэдийн ашиг орлого өссөн, жуулчдыг татсан, орон нутгийн сурталчилгаа, нүүр царай болдог, өв соёлыг сурталчлах, хадгалах үр ашигтай болохыг дурдсан байна.

# ХАВСРАЛТ 10. НИЙСЛЭЛ, АЙМАГ ОРОН НУТГИЙН БОАЖГ-ЫН МЭРГЭЖИЛТНҮҮДЭЭС АВСАН СУДАЛГААНЫ ҮР ДҮН

**Эвентийн үр дүн, судалгаанд оролцогч нийслэл, аймгийн БОАЖГ-ын мэргэжилтнүүдийн үзэж буйгаар**




Судалгаанд оролцогсдын үзэж буйгаар зохион байгуулсан аялал жуулчлалын эвентүүд нь нутгийн малчдад, нутгийн жижиг бизнес эрхлэгчдэд, уламжлалт ахуй соёлоо хадгалахад маш их эерэгээр нөлөөлсөн байна. Харин байгаль орчинд бага зэрэг сөрөг нөлөө үзүүлсэн талаар судалгаанд оролцогсдын 5.56 хувь хариулжээ.

**Зохион байгуулж буй эвентүүдэд оролцсон гадаад жуулчдын мэдээллийн эх сурвалж, БОАЖГ-ын мэргэжилтнүүдийн үзэж буйгаар**




БОАЖГ-ын мэргэжилтнүүдийн үзэж буйгаар тэдний зохион байгуулсан эвентүүдэд оролцсон гадаадын жуулчид эвентийн талаар мэдээллийг тур операторуудын веб сайт, болоод Фэйсбүүк гэх мэт сошиал сувгуудаас ихэнхдээ авдаг болохыг судалгаанд оролцогчид дурджээ.

**Эвентийн түгээмэл хүндрэл бэрхшээлүүд, судалгаанд оролцогч БОАЖГ-ын мэргэжилтнүүдийн үзэж буйгаар**




Судалгаанд оролцогчдын 50-72 хувь нь ариун цэврийн өрөө, байгууламж, хог хаягдлын цэг, үнэ,өртөг зардлын хувьд хамгийн гол бэрхшээл болдогийг дурдсан байна. Харин хоол унд, тэмдэглэлт арга хэмжээний удирдлага, зохион байгуулалт, МУ-ын аялал жуулчлалын эрх зүйн орчин нь заримдаа бэрхшээл үүсгэдэг гэж нилээд хувь нь хариулжээ.

Судалгааны хүрээнд гадаадын болон дотоодын жуулчид аялал жуулчлалын эвентийн талаар ямар зүйл дээр сэтгэл ханамжтай харин ямар асуудлууд дээр шүүмжлэлттэй ханддаг талаар асуулга асуухад дараах байдлаар хариулжээ. Гадаадын жуулчдад байгалийн үзэсгэлэнт газар, өв соёл, нүүдлийн соёл иргэншил, уламжлалт хувцас хэрэгсэл, ахуй соёл таалагддаг талаар судалгаанд оролцогч БОАЖГ-ын мэргэжилтнүүд хариулсан бол 00, ариун цэврийн газар, хог хаягдал, байрлах газар, зохион байгуулалт, дэд бүтцийн асуудал дээр гадаад жуулчид шүүмжлэлттэй ханддагийг дурдсан байна.

**Эвентийн талаар шүүмжлэлтэй хандсан асуудлууд, БОАЖГ-ын мэргэжилтнүүдийн үзэж буйгаар**




Харин дотоодын жуулчид байгалийн үзэсгэлэнт газраар аялж, ахуй соёлтойгоо танилцах, өв соёл, уламжлалт соёлоо хадгалж, хамгаалах, нутгийн иргэдийн хувьд брэнд бүтээгдэхүүнээ сурталчлах боломж олгосон талаамжтай талууд байгаа болохыг дурддаг талаар, харин 00 ариун цэвэр, зохион байгуулалт, хог хаягдлыг мөн л дотоодын жуулчид шүүмжлэсэн болохыг байгаль орчин, аялал жуулчлалын мэргэжилтнүүд дурдсан байна.

**Жуулчдыг татахын тулд эвентийн хувьд анхаарах зүйлс, БОАЖГ-ын мэргэжилтнүүдийн үзэж буйгаар**




Судалгаанд оролцсон БОАЖГ-ын мэргэжилтнүүдийн 55 орчим хувь нь эвентийн зохион байгуулалт, мөн ийм хэмжээгээр тав тухтай орчинг сайжруулах шаардлагатай гэж үзсэн бол, 40 гаруй хувь нь эвентийн маркетингийг

сайжруулах, 28 орчим хувь нь дэд бүтцийг сайжруулах хэрэгтэй байгааг онцолсон байгааг дээрх судалгаанд хариулсан байдлаас харж болно.

**Эвентийг үр дүнтэй зохион байгуулахад хэрэгтэй дэмжлэгүүд, БОАЖГ-ын мэргэжилтнүүдийн үзэж буйгаар**


















Дээрх графикуудаас харахад, аялал жуулчлалын эвентийг сайжруулахад, төрөөс болон аймаг, орон нутгийн захиргаанаас санхүүжилт болон зохион байгуулалтын хувьд дэмжлэг илүүтэй хүсч буй бол олон улсын байгууллагууд, ТББ-аас мөн л санхүүжилт, зохион байгуулалтын хувьд дэмжлэг хүсч байгаагаас гадна маркетингийн хувьд дэмжлэг үзүүлбэл илүү хэрэгтэй байгааг дурдсан байна. Харин аялал жуулчлалын мэргэжлийн судлаачдаас үзвэр үйлчилгээний чанар болоод маркетинг сайжруулах талаар судалгаа хийж өгөхийг хүссэн байна. Нутгийн иргэдээс эвентэд илүү оролцоо сайтай байж дэмжлэг үзүүлэхийг хүсдэг бол аялал жуулчлалын байгууллагуудаас харилцаа холбоо, маркетинг, зохион байгуулалт, ажиллах хүчний хувьд туслалцаа үзүүлэн хамтран ажиллахыг хүсчээ.

**Эвентийн эдийн засгийн үр нөлөөг, БОАЖГ-ын мэргэжилтнүүдийн ирүүлсэн мэдээллээр:**

Түүвэр судалгаанд БОАЖГ-ын мэргэжилтнүүдийн хариулсан байдлаас харахад нийт эвентүүдийн дундаж орлого нь 120.1 сая төгрөг, харин дундаж зардал нь 28.03 сая төгрөг буюу судалгаанд дурдагдсан эвентүүдийн хувьд дундаж орлого нь дундаж зардлаасаа даруй 92 сая төгрөгөөр өндөр байна. Нийт эвентийн хувьд хамгийн багадаа 1 сая, хамгийн ихдээ 200 сая төгрөг зарцуулсан бол хамгийн багадаа 4 төгрөг, хамгийн ихдээ 2 тэрбум төгрөгийн орлого олсон эвентүүд байна. Түүнчлэн БОАЖЯ-наас гаргасан зардлын хувьд дунджаар эвентүүдэд 15 сая төгрөг зарцуулсан ба хамгийн багадаа 1 сая, хамгийн ихдээ 100 сая төгрөг байна. Харин аймаг, орон нутгийн захиргаанаас дунджаар 6.7 сая, хамгийн багадаа 1 сая, хамгийн ихдээ 70 сая төгрөг зарцуулсан байна. Аж ахуйн нэгж, байгууллагын зардал, хандив тусламжийн хувьд дунджаар 12.8 сая төгрөг, хамгийн багадаа 0 төгрөг, хамгийн ихдээ 170 сая төгрөгийн зардал гаргасан гэсэн байна.

**Жуулчдын тоо, БОАЖГ-ын мэргэжилтнүүдийн хариулсан байдлаар**




Судалгаанд оролцсон БОАЖГ-ын мэргэжилтнүүдийн үзэж буйгаар 1000-аас их жуулчин (гадаад болон дотоод) татсан эвент нийт эвентийн 54.7 хувь, 100-1000 жуулчин татсан 43.4 хувь, 100 хүртэлх жуулчидтай 1.9 хувь байна. Харин 1000-аас их гадаадын жуулчин татсан эвент нийт эвентийн 1.9 хувийг эзэлж байна. 100 хүртэлх гадаадын жуулчидтай эвент нийт эвентийн 66 хувийг эзэлж байгааг дээрх графикаас харж болно.

## ХАВСРАЛТ 11. ТҮҮВЭР СУДАЛГАА, ДҮГНЭЛТ

Судалгаанд оролцсон эвент зохион байгуулагч аж ахуйн нэгжүүдийн 34 хувь нь тэдний аймаг, орон нутагт зохион байгуулагдсан эвентүүд таван хошуу мал, нүүдлийн соёлд түшиглэсэнээрээ онцлог гэсэн бол 11 хувь нь спортын арга хэмжээнд түшиглэдэг, 8 хувь нь байгалийн сайханд түшиглэдэг, 6 хувь нь түүхэн газар нутагт зохион байгуулагддагаараа онцлог гэж үзжээ.

Цаг агаарын хүчин зүйл бол эвент зохион байгуулахад гарах хамгийн том эрсдэл болохыг судалгаанд оролцогчдын 62.96 хувь нь хариулсан байна. Түүнчлэн хамтран зохион байгуулагчдын уялдаа холбоо муу байх (судалгаанд оролцогчдын 37.04 хувь), гаргасан зардлаа нөхөж чадахгүй байх (судалгаанд оролцогчдын 31.48 хувь) нь мөн эрсдэл үүсгэдэг байна.

Түүвэр судалгаанд хамрагдсан аялал жуулчлалын компаниудын хариулсан байдлаас харахад, дундаж орлого нь 36.14 сая төгрөг, харин дундаж зардал нь 27.56 сая төгрөг буюу судалгаанд дурдагдсан эвентүүдийн хувьд дундаж орлого нь дундаж зардлаасаа 8.58 сая төгрөгөөр өндөр байгаа бол, БОАЖГ-ын мэргэжилтнүүдийн хариулсан байдлаас харахад нийт эвентүүдийн хувьд дундаж орлого нь 120.1 сая төгрөг, харин дундаж зардал нь 28.03 сая төгрөг буюу судалгаанд дурдагдсан эвентүүдийн хувьд дундаж орлого нь дундаж зардлаасаа даруй 92 сая төгрөгөөр өндөр байсан. Нөгөө талаас харахад, эвентүүдийн дундаж орлогын мэдээлэл харьцангуй зөрүүтэй байгаа ба үүнээс улбаалан орлого, зарлагын зөрүү ихээхэн ялгаатай байна. Энэ нь судалгаанд оролцсон аж

ахуйн нэгжүүдийн зохион байгуулсан болоод БОАЖГ-ын мэргэжилтнүүдийн судалгаанд дурдсан эвентүүд өөр өөр байгаатай холбоотойгоор ийм зөрүүтэй байж болох ба нөгөө талаас энэ салбарт мэдээллийн зөрүүтэй байдал их байгааг мөн харуулж байна.

Судалгаанд хамрагдсан нийт эвентүүдийн хувьд БОАЖЯ-наас дунджаар эвентүүдэд 15 сая төгрөг, аймаг, орон нутгийн захиргаанаас дунджаар 6.7 сая, аж ахуйн нэгж, байгууллагын зардал, хандив тусламжийн хувьд дунджаар 12.8 сая төгрөг зарцуулсан байна.

Судалгааны тоон мэдээлэлд үндэслэн регрессийн шинжилгээ хийж үзэхэд, зардал 1 хувиар өсөхөд, орлого 0.85 хувиар өснө гэсэн үр дүн гарч байна.

Судалгаанд оролцсон аж ахуйн нэгж, байгууллагын хариулсан байдлаас харахад,

- 1000-аас их жуулчин (гадаад болон дотоод) татсан эвент нийт эвентийн 25 хувь,
- 100-1000 жуулчин татсан 37.5 хувь,
- 100 хүртэлх жуулчидтай 37.5 хувь байна.
- Харин 1000-аас их гадаадын жуулчин татсан эвент нийт эвентийн 8.3 хувийг эзэлж байна.
- 100 хүртэлх гадаадын жуулчидтай эвент нийт эвентийн 58.3 хувийг эзэлж байсан.

Харин судалгаанд оролцсон БОАЖГ-ын мэргэжилтнүүдийн үзэж байгаагаар,

- 1000-аас их жуулчин (гадаад болон дотоод) татсан эвент нийт эвентийн 54.7 хувь,
- 100-1000 жуулчин татсан 43.4 хувь,
- 100 хүртэлх жуулчидтай 1.9 хувь байна.
- Харин 1000-с их гадаадын жуулчин татсан эвент нийт эвентийн 1.9 хувийг эзэлж байна.
- 100 хүртэлх гадаадын жуулчидтай эвент нийт эвентийн 66 хувийг эзэлж байна.

Эвентүүдийн нийт болон гадаад, дотоод жуулчдын тоо салбарын аж ахуйн нэгжүүд болоод БОАЖГ-ын мэргэжилтнүүдийн үзэж байгаагаар ийнхүү ялгаатай байгаа нь судалгаанд дурдсан эвентүүд өөр өөр байгаатай холбоотой байж болох ба нөгөө талаас энэ салбарт мэдээллийн зөрүүтэй байдал их байгааг мөн харуулж байна.

Судалгаанд оролцогч эвент зохион байгуулагчид аялал жуулчлалын эвент зохион байгуулахад үүсдэг хүндрэлүүдэд санхүүжилт хүрэлцдэггүй, үйлчилгээ тааруу, байрших газрын хүндрэл гол хүндрэл үүсгэдэгийг дурдсан байна. Түүнчлэн, зохион байгуулалт өөрчлөгддөг, зам дэд бүтэц муутай, цаг агаарын гэнэтийн өөрчлөлт ч мөн нилээдгүй хүндрэл үүсгэдэг талаар хариулжээ. Аймаг,

орон нутгийн БОАЖГ-ын мэргэжилтнүүдийн үзэж буйгаар ариун цэврийн өрөө, байгууламж, хог хаягдлын цэг, үнэ, өртөг зардлын хувьд хамгийн гол бэрхшээл болдогийг дурдсан байна.

Эвентийн үйл ажиллагааг цаашид хэрхэн сайжруулах талаар судалгаанд оролцогч аж ахуйн нэгжүүд зохион байгуулалт, үйлчилгээ, дэд бүтцээ сайжруулах, үзвэр үйлчилгээний тоог нэмэгдүүлэх шаардлагатай гэж үзсэн байна. Харин судалгаанд оролцсон БОАЖГ-ын мэргэжилтнүүдийн хувьд, эвентийн зохион байгуулалт, тав тухтай орчин, эвентийн маркетинг, дэд бүтцийг сайжруулах хэрэгтэй байгааг онцолсон байна.

Аялал жуулчлалын компаниудын хариулсан байдлаас харахад, тэдгээрийн 55 хувь нь эвентэд оролцсон жуулчид оролцсон эвентдээ сэтгэл хангалуун байдаг гэж хариулсан бол 00, ариун цэврийн хувьд хангалтгүй, зам дэд бүтцийн хувьд сайжруулах шаардлагатай, үйлчилгээ хангалтгүй байдаг үзвэр үйлчилгээнийхээ тоог нэмэх шаардлагатай гэж үзжээ.

Судалгаанд оролцогсдын үзэж байгаагаар, аялал жуулчлалын эвентүүд нь нутгийн иргэд, жижиг бизнес эрхлэгчдэд, өв соёлыг сурталчлах, хадгалахад эерэг нөлөөтэй бол байгаль орчинд бага зэрэг сөрөг нөлөө үзүүлсэн гэж үзэж байна.

Зохион байгуулсан эвентүүдэд оролцсон гадаадын жуулчид эвентийн талаарх мэдээллийг тур операторуудын веб сайт, болоод Фэйсбүүк гэх мэт сошиал сувгуудаас ихэнхдээ авдаг болохыг судалгаанд оролцогчид дурджээ.

Гадаадын жуулчдад байгалийн үзэсгэлэнт газар, өв соёл, нүүдлийн соёл иргэншил, уламжлалт хувцас хэрэгсэл, ахуй соёл таалагддаг бол 00, ариун цэврийн газар, хог хаягдал, байрлах газар, зохион байгуулалт, дэд бүтцийн асуудал дээр шүүмжлэлттэй ханддагийг дурдсан байна.

Аялал жуулчлалын эвентийг сайжруулахад, төрөөс болон аймаг орон нутгийн захиргаанаас санхүүжилт болон зохион байгуулалтын хувьд дэмжлэг илүүтэй хүсч буй бол олон улсын байгууллагууд, ТББ-аас мөн л санхүүжилт, зохион байгуулалтын хувьд дэмжлэг хүсч байгаагаас гадна маркетингийн хувьд дэмжлэг үзүүлбэл илүү хэрэгтэй байгааг дурдсан байна. Нутгийн иргэдээс эвентэд илүү оролцоо сайтай байж дэмжлэг үзүүлэхийг хүсдэг бол аялал жуулчлалын байгууллагуудаас харилцаа холбоо, маркетинг, зохион байгуулалт, ажиллах хүчний хувьд туслалцаа үзүүлэн хамтран ажиллахыг хүссэн байна.

# ХАВСРАЛТ 12. ЭРСДЛИЙН ҮНЭЛГЭЭНИЙ ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТ, ЗААВАРЧИЛГАА

### Эрсдлийн үнэлгээний шалгуур үзүүлэлт, зааварчилгаа

| Тохиох магадлал | Оноо | Үр дагавар | Шалгуур үзүүлэлт | Оноо |
|---|---|---|---|---|
| Маш өндөр | 5 | Аюултай | Үр дагавар нь эвент болон түүний зохион байгуулалтанд ноцтой хүндрэл учруулах. Жишээ нь амь эрсдэх, санхүүгийн хүнд гарз хохирол, эвентийн нэр хүндэд их хэмжээний хохирол учруулах, олон нийтийн сүлжээнд бухимдал үүсгэх г.м | 5 |
| Өндөр | 4 | Их хэмжээний | Эвентийн тасралтгүй үйл ажиллагаад хүндрэл учруулах. Үүнд олон нийтийн анхааралд орох, санхүүгийн томоохон алдагдал, үндэсний хэвлэл мэдээллээр гарах г.м | 4 |
| Боломжтой | 3 | Дундаж хэмжээний | Эвентийн үйл ажиллагаанд хүндрэл учруулах. Жишээ нь бэртэж гэмтсэн хүнийг эмнэлэгт хэвтүүлэх, олон нийтийн анхаарлыг дундаж хэмжээгээр татах, санхүүгийн хохирол, орон нутгийн хэвлэл мэдээллээр гарах г.м | 3 |
| Бага боломжтой | 2 | Бага хэмжээний | Эвентийн үр ашигтай байдалд хүндрэл учруулахгүй. Дотооддоо зохицуулж болох үр дагавартай эрсдэл багтана. Санхүүгийн бага гарз хохирол, анхан шатны эмнэлэгийн тусламж үйлчилгээ үзүүлэх зэрэг. | 2 |
| Маш бага | 1 | Ач холбогдол бага | Үр дагаврыг ердийн үйл ажиллагаагаар зохицуулж болно. Ямар нэг бэртэл гэмтэл, санхүүгийн гарз байхгүй. Нэр хүндэд бага хэмжээгээр нөлөөлөх эрсдлүүд орно. | 1 |

Хэрэв тухайн эрсдэл нь эвентийн үйл ажиллагаатай хамаарахгүй бол 0 оноо өгнө үү

Хэрэв асуумжид тусгагдаагүй эрсдлүүд байвал та нэмж бичнэ үү

# Эрсдлийн үнэлгээний хуудас

| | | Эрсдлийн ангилал | Эрсдэл | Эрсдэл тохиох магадлал | Эрсдлийн үр дагавар |
|---|---|---|---|---|---|
| 1 | | **ТӨЛӨВЛӨЛТИЙН ҮЕ ШАТ** | | | |
| | 1 | **Орчны эрсдэл** | | | |
| | | 1 | Хууль эрх зүй- Аливаа бодлого, шийдвэр, зохицуулалт | | |
| | | 2 | Байгаль-ган, зуд болох, гал түймэр, газар хөдлөх | | |
| | | 3 | Эдийн засгийн байдал (уналт) | | |
| | | 4 | Цаг агаарын байдал | | |
| | | 5 | Нийгмийн мөргөлдөөн, дайн, терроризм | | |
| | | 6 | Зам тээвэр, дэд бүтэц | | |
| | | 7 | Малын халдварт өвчин | | |
| | | 8 | Нийгмийн гоц халдварт өвчин | | |
| | | 9 | Гэмт хэрэг- Оролцогчид хулгайд эд зүйлээ алдах г.м | | |
| | | 10 | Хүрээлэн байгаа орчны доройтолд хүргэж болзошгүй эрсдэл | | |
| | 2 | **Үйл ажиллагааны эрсдэл** | | | |
| | | 1 | Жуулчдыг татах, маркетингийн арга хэмжээ | | |
| | | 2 | Эвентийн хөтөлбөртэй холбоотой эрсдэл | | |
| | | 3 | Зардал, үр ашгийн тооцоо | | |
| | | 5 | Эвентийн зохион байгуулалттай холбоотой эрсдэл | | |
| | | 6 | Техник, тоног төхөөрөмжийн эрсдэл | | |
| | | 8 | Ажилтнуудын аюулгүй байдал, эрүүл мэндийн эрсдэл | | |
| | | 9 | Оролцогчдын аюулгүй байдал, эрүүл мэндийн эрсдэл | | |
| | | 11 | Хамтрагч байгууллагын найдвартай байдал | | |
| | | 12 | Байрны хангамж, хүрэлцээ | | |
| | | 13 | Байрны чанарын шаардлага | | |
| | | 14 | Хоолны хангамж, хүрэлцээ | | |
| | | 15 | Хоолны чанарын шаардлага | | |
| | | 16 | Ариун цэврийн өрөөний асуудал | | |
| | | 17 | Хүний нөөцийн бэлэн байдал | | |
| | | 18 | Хүний нөөцийн чанар | | |
| | | 19 | Худалдаа наймаатай холбоотой эрсдэл | | |
| 2 | | **ЗОХИОН БАЙГУУЛАЛТЫН ҮЕ ШАТ** | | | |
| | 1 | **Орчны эрсдэл** | | | |
| | | 1 | Хууль эрх зүй- Аливаа бодлого, шийдвэр, зохицуулалт | | |
| | | 2 | Байгаль-ган, зуд болох, гал түймэр, газар хөдлөх | | |
| | | 3 | Эдийн засгийн байдал (уналт) | | |
| | | 4 | Цаг агаарын байдал | | |
| | | 5 | Нийгмийн мөргөлдөөн, дайн, терроризм | | |
| | | 6 | Зам тээвэр, дэд бүтэц | | |
| | | 7 | Малын халдварт өвчин | | |
| | | 8 | Нийгмийн гоц халдварт өвчин | | |
| | | 9 | Гэмт хэрэг- Оролцогчид хулгайд эд зүйлээ алдах г.м | | |
| | | 10 | Хүрээлэн байгаа орчны доройтолд хүргэж болзошгүй эрсдэл | | |
| | 2 | **Үйл ажиллагааны эрсдэл** | | | |
| | | 1 | Гадаад, дотоодын жуулчдын оролцоо бага байх | | |
| | | 2 | Эвентийн хөтөлбөртэй холбоотой эрсдэл | | |
| | | 3 | Санхүү, зардал үр ашгийн тооцоо | | |
| | | 5 | Эвентийн зохион байгуулалттай холбоотой эрсдэл | | |
| | | 6 | Техник, тоног төхөөрөмжийн эрсдэл | | |
| | | 7 | Ажилтнуудын аюулгүй байдал, эрүүл мэндийн эрсдэл | | |
| | | 8 | Оролцогчдын аюулгүй байдал, эрүүл мэндийн эрсдэл | | |
| | | 9 | Хамтрагч байгууллагын найдвартай байдал | | |
| | | 10 | Байрны хангамж, хүрэлцээ | | |
| | | 11 | Байрны чанарын шаардлага | | |
| | | 12 | Хоолны хангамж, хүрэлцээ | | |
| | | 13 | Хоолны чанарын шаардлага | | |
| | | 14 | Ариун цэврийн өрөөний асуудал | | |
| | | 15 | Хүний нөөцийн бэлэн байдал | | |
| | | 16 | Хүний нөөцийн чанар | | |
| | | 17 | Худалдаа наймаатай холбоотой эрсдэл | | |
| 3 | | **ЗОХИОН БАЙГУУЛАЛТЫН ДАРААХ ҮЕ ШАТ** | | | |
| | | Энэ үе шатанд гарч болзошгүй аливаа эрсдэл байвал та бөглөнө үү. Дээрх эрсдлийн төрлийн хүрээнд эсвэл танай эвентийн үйл ажиллагааны онцлогоос хамаарсан байж болно | | | |
| | | | | | |
| | | | | | |
| | | | | | |

# ХАВСРАЛТ 13. ЭВЕНТИЙН ЭРСДЛИЙГ БУУРУУЛАХ ТӨЛӨВЛӨГӨӨ

## Эвентийн эрсдэл бууруулах төлөвлөгөө: ХОНИНЫ НАЙР ЭВЕНТ

| | | | Эрсдэл | Эрсдэл тохиох магадлал | Эрсдлийн үр дагавар | Эрсдэлийн түвшин | Эрдэл бууруулах тактик | Эрсдэл бууруулах арга хэмжээ | Хариуцагч эзэн | Хийж гүйцэтгэх хугацаа |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| 1 | | | **ТӨЛӨВЛӨЛТИЙН ҮЕ ШАТ** | | | | | | | |
| | 1 | | **Орчны эрсдэл** | | | | | | | |
| | | 1 | Хууль эрх зүй- Аливаа бодлого, шийдвэр, зохицуулалт | 1 | 3 | Дундаж | Эрсдэлийг хүлээн зөвшөөрөх | Төлөвлөлтийн шатанд хууль эрх зүй, бодлого зохицуулалтын талаарх судалгааг хийх, мэдээлэл авах | Ерөнхий зохион байгуулагч | 5.01 |
| | | 2 | Байгаль-гаң, зуд болох, гал түймэр, газар хөдлөх | 4 | 4 | Өндөр | Эрдэлээс зайлсхийх | Зохион байгуулах өдрийг өөрчлөх | Ерөнхий зохион байгуулагч | 5.01 |
| | | 3 | Эдийн засгийн байдал (уналт) | 1 | 1 | Бага | Эрсдэлийг хүлээн зөвшөөрөх | Эрсдэлийг хүлээн зөвшөөрнө | Ерөнхий зохион байгуулагч | 5.01 |
| | | 4 | Цаг агаарын байдал | 4 | 4 | Өндөр | Эрсдэлийг бууруулах төлөвлөгөөг сайжруулах. Алтернатив хөтөлбөр, үйл ажиллагаа, арга зүйг заавал боловсруулсан байх | Цаг агаар муудахаар бол зохион байгуулах өдрийг өөрчлөх, дотор зохион байгуулах боломжтой хөтөлбөрүүдийг гаргах, том өсөр бэлдэж болно. Зочдод цаг агаарын талаар урьдчилж анхааруулга өгөх | Ерөнхий зохион байгуулагч | 5.01 |
| | | 5 | Нийгмийн мөргөлдөөн, дайн, терроризм | 1 | 1 | Бага | Эрсдэлийг хүлээн зөвшөөрөх | Хариу арга хэмжээ шаардлагагүй | Ерөнхий зохион байгуулагч | 5.01 |
| | | 6 | Зам тээвэр, дэд бүтэц | 1 | 1 | Бага | Эрсдэлийг хүлээн зөвшөөрөх | Хариу арга хэмжээ шаардлагагүй | Ерөнхий зохион байгуулагч | 5.01 |
| | | 7 | Малын халдварт өвчин | 5 | 4 | Маш өндөр | Эрсдэлээс зайлсхийх | Сүүлийн жилүүдэд шүлхий зэрэг малын халдварт өвчний гаралт нэмэгдэж өргөн хүрээг хамарч байгаа. Иймд тухайн зохион байгуулагдах жилд малын халдварт өвчний гаралт их бол эвентэд оруулах мал амьтныг урьдчилж тусгаарлаж болно. | Ерөнхий зохион байгуулагч | 5.01 |
| | | 8 | Нийгмийн гоц халдварт өвчин | 5 | 5 | Маш өндөр | Эрсдэлээс зайлсхийх | Эвентийг цуцлах хүртэл хариу арга хэмжээ авах | Ерөнхий зохион байгуулагч | 5.01 |
| | | 9 | Гэмт хэрэг- Оролцогчид хулгайд эд зүйлээ алдах г.м | 1 | 1 | Бага | Үйл ажиллагааны ердийн түвшинд удирдаж болно. | Хариу арга хэмжээ шаардлагагүй. | Ерөнхий зохион байгуулагч | 5.01 |
| | | 10 | Хүрээлэн байгаа орчны доройтолд хүргэж болзошгүй эрсдэл | 1 | 1 | Бага | Үйл ажиллагааны ердийн түвшинд удирдаж болно. | Хариу арга хэмжээ шаардлагагүй | Ерөнхий зохион байгуулагч | 5.01 |
| | 2 | | **Үйл ажиллагааны эрсдэл** | | | | | | | |
| | | 1 | Жуулчдыг татах, маркетингийн арга хэмжээ | 3 | 4 | Өндөр | Эрсдэлийг бууруулах төлөвлөгөөг сайжруулах. Алтернатив хөтөлбөр, үйл ажиллагаа, арга зүйг заавал боловсруулсан байх | Маркетинг, сурталчилгааны ажлыг жил тойрон хийх. Ингэхдээ эвентийн тусдаа цахим хуудастай болох, аялал жуулчлалын түр агентуудтай холбоо харилцаагаа сайжруулах. Холбогдох яам, олон улсын байгууллага зэрэгт эвентийн танилцуулгыг илгээдэг байх зэрэг олон арга хэмжээ байж болно. | Зохион байгуулах баг | 5.01 |
| | | 2 | Эвентийн хөтөлбөртэй холбоотой эрсдэл | 2 | 2 | Дундаж | Эрсдэлийг бууруулах төлөвлөгөөг сайжруулах. Алтернатив хөтөлбөр, үйл ажиллагаа, арга зүйг заавал боловсруулсан байх | Эвентийн хөтөлбөрийг өмнөх жилүүдийн зохион байгуулалтын үр дүн дээр тулгуурлан гаргах, шинэчилж байх | Зохион байгуулах баг | 5.01 |
| | | 3 | Зардал, үр ашгийн тооцоо | 2 | 3 | Дундаж | Эрсдэлийг бууруулах төлөвлөгөөг сайжруулах. Алтернатив хөтөлбөр, үйл ажиллагаа, арга зүйг заавал боловсруулсан байх | Зардал үр ашгийн тооцоог сайн хийх, хамтран ажилладаг хувь хүн байгууллагтай гэрээ хийх. Мэргэжлийн хуульч ажиллуулах. | Зохион байгуулах баг | 5.01 |
| | | 5 | Эвентийн зохион байгуулалттай холбоотой эрсдэл | 3 | 3 | Дундаж | Эрсдэлийг бууруулах төлөвлөгөөг сайжруулах. Алтернатив хөтөлбөр, үйл ажиллагаа, арга зүйг заавал боловсруулсан байх | Эвентийн зохион байгуулалттай холбоотой эрсдэлийг бууруулахыг тулд эвент зохион байгуулах төлөвлөгөөг нарийвчлан гаргаж, хариуцах эзэнг тодорхойлж өгөх, ажил үүргийг хуваарилах | Зохион байгуулах баг | 5.01 |
| | | 6 | Техник, тоног төхөөрөмжийн эрсдэл | 2 | 3 | Дундаж | Эрсдэлийг бууруулах төлөвлөгөөг сайжруулах. Алтернатив хөтөлбөр, үйл ажиллагаа, арга зүйг заавал боловсруулсан байх | Урлагийн тоглолтын техникийн бэлэн байдлыг нэг хүнд хариуцуулах. Тухайн хариуцагч үйл ажиллагаа болохоос өмнөх өдөр тоног төхөөрөмжийн бэлэн байдлыг хангасан байх. Урлагийн тоглолт болохоос өмнө дахин шалгасан байх. Цахилгааны тасалдалаас сэргийлэхийн тулд нэмэлт цахилгаан үүсгүүр бэлдэх. | Зохион байгуулах баг | 5.01 |
| | | 8 | Ажилтнуудын аюулгүй байдал, эрүүл мэндийн эрсдэл | 2 | 2 | Дундаж | Тодорхой эрсдэл бууруулах стратеги хэрэгтэй. Эрсдэлийг хянах хяналтын арга хэмжээг авч хэрэгжүүлэх. Оролцогчид болон ажилтнуудын ажлын байрны, эрүүл мэндийн, аюулгүй байдлын талаарх төлөвлөгөөтэй байх. | Хөдөлмөр аюулгүй байдал эрүүл ахуйн дүрэм зааврыг баталж эвент зохион байгуулах үеэр ажиллах ажилтнууд болон зохион байгуулах багт урьдчилан танилцуулж, гарын үсэг зуруулсан байх. Анхан шатны тусламжын хайрцаг бэлэн байлгах. Зохион байгуулалтын үед эмч ажиллуулах | Зохион байгуулах баг | 5.01 |
| | | 9 | Оролцогчдын аюулгүй байдал, эрүүл мэндийн эрсдэл | 3 | 3 | Дундаж | Тодорхой эрсдэл бууруулах стратеги хэрэгтэй. Эрсдэлийг хянах хяналтын арга хэмжээг авч хэрэгжүүлэх. Оролцогчид болон ажилтнуудын ажлын байрны, эрүүл мэндийн, аюулгүй байдлын талаарх төлөвлөгөөтэй байх. | Оролцогчдын эрүүл, аюулгүй байдлыг хангаж зохион байгуулалт хийх. Ялангуяа үзэгчдийг оролцуулсан хөтөлбөр дээр анхаарах. Анхан шатны тусламжын хайрцаг бэлэн байлгах. Зохион байгуулалтын үед эмч ажиллуулах. Хэрэв жуулчин гэмтсэн тохиолдолд хэн хариуцаж эмнэлэгийн тусламж үйлчилгээ үзүүлэхэд туслахыг урьдчилан тодорхойлсон байна. | Зохион байгуулах баг | 5.01 |
| | | 11 | Хамтрагч байгууллагын найдвартай байдал | 1 | 1 | Бага | Үйл ажиллагааны ердийн түвшинд удирдаж болно. | Хариу арга хэмжээ шаардлагагүй | Зохион байгуулах баг | 5.01 |
| | | 12 | Байрны хангамж, хүрэлцээ | 3 | 2 | Дундаж | Эрсдэлийг бууруулах төлөвлөгөөг сайжруулах. Алтернатив хөтөлбөр, үйл ажиллагаа, арга зүйг заавал боловсруулсан байх | Тухайн эвентэд жуулчид такс төлж оролцдог учир байрны хангамжийн асуудлыг урьдчилж зохицуулах боломжтой. Даац хүрэлцэхээргүй бол хөдөлгөөнт кэмп ажиллуулах зэрэг арга хэмжээ авах | Зохион байгуулах баг | 5.01 |
| | | 13 | Байрны чанарын шаардлага | 3 | 3 | Дундаж | Эрсдэлийг бууруулах төлөвлөгөөг сайжруулах. Алтернатив хөтөлбөр, үйл ажиллагаа, арга зүйг заавал боловсруулсан байх | Хустайн жуулчны бааз болон жуулчин хүлээж авдаг айлуудтай стандарт, шаардлагаа урьдчилж тохирох | Зохион байгуулах баг | 5.01 |
| | | 14 | Хоолны хангамж, хүрэлцээ | 1 | 1 | Бага | Үйл ажиллагааны ердийн түвшинд удирдаж болно. | Хариу арга хэмжээ шаардлагагүй | Зохион байгуулах баг | 5.01 |
| | | 15 | Хоолны чанарын шаардлага | 2 | 2 | Дундаж | Эрсдэлийг бууруулах төлөвлөгөөг сайжруулах. Алтернатив хөтөлбөр, үйл ажиллагаа, арга зүйг заавал боловсруулсан байх | Хустайн жуулчны бааз болон жуулчин хүлээж авдаг айлуудтай стандарт, шаардлагаа урьдчилж тохирох | Зохион байгуулах баг | 5.01 |
| | | 16 | Ариун цэврийн өрөөний асуудал | 4 | 4 | Өндөр | | | Зохион байгуулах баг | 5.01 |
| | | 17 | Хүний нөөцийн бэлэн байдал | 3 | 3 | Дундаж | Эрсдэлийг бууруулах төлөвлөгөөг сайжруулах. Алтернатив хөтөлбөр, үйл ажиллагаа, арга зүйг заавал боловсруулсан байх | Эвент зохион байгуулалтын үеэр ажиллах ажилтнуудын сан үүсгэх, боломжит хүмүүстэй гэрээ хийх, сургалтанд хамруулах. Сургалтын гэрээ хийж болно. Ингэснээр хэрэв сургалт авчихаад эвентийн зохион байгуулалтад ажиллахгүй болбол сургалтын төлбөрийг тухайн хүнээр төлүүлдэг. | Зохион байгуулах баг | 5.01 |
| | | 18 | Хүний нөөцийн чанар | 4 | 2 | Дундаж | Эрсдэлийг бууруулах төлөвлөгөөг сайжруулах. Алтернатив хөтөлбөр, үйл ажиллагаа, арга зүйг заавал боловсруулсан байх | Мэргэжлийн байгууллагуудтай хамтарч сургалт авах. Зохион байгуулалтан дээр мэргэжлийн баг оруулж ажиллуулах | Зохион байгуулах баг | 5.01 |
| | | 19 | Худалдаа наймаатай холбоотой эрсдэл | 2 | 2 | Дундаж | Эрсдэлийг бууруулах төлөвлөгөөг сайжруулах. Алтернатив хөтөлбөр, үйл ажиллагаа, арга зүйг заавал боловсруулсан байх | Эвент дээр худалдаа наймаа хийж байгаа иргэд, албан байгууллагатай гэрээ хийх, шаардлагаа урьдчилж тодорхойлох. | Зохион байгуулах баг | 5.01 |

| | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| 2 | | | **ЗОХИОН БАЙГУУЛАЛТЫН ҮЕ ШАТ** | | | | | | | |
| | 1 | **Орчны эрсдэл** | | | | | | | | |
| | | 1 | Хууль эрх зүй- Аливаа бодлого, шийдвэр, зохицуулалт | 1 | 2 | Бага | Үйл ажиллагааны ердийн түвшинд удирдаж болно. | Хариу арга хэмжээ шаардлагагүй | Зохион байгуулах баг | 7.01 |
| | | 2 | Байгаль-гап, зуд болох, гал түймэр, газар хөдлөх | 4 | 4 | Өндөр | Эрсдэлээс зайлсхийх | Эвентийг цуцлах хүртэл хариу арга хэмжээ авах | Зохион байгуулах баг | 7.01 |
| | | 3 | Эдийн засгийн байдал (уналт) | 1 | 1 | Бага | Үйл ажиллагааны ердийн түвшинд удирдаж болно. | Хариу арга хэмжээ шаардлагагүй | Зохион байгуулах баг | 7.01 |
| | | 4 | Цаг агаарын байдал | 4 | 4 | Өндөр | Эрсдэлээс зайлсхийх | Төлөвлөлтийн шатанд бэлдсэн арга хэрэгслүүдийг ашиглах. Зарим арга хэмжээг дотор зохион байгуулах, эсвэл том асар бэлдэх, оролцогчдод урьдчилж сануулах. | Зохион байгуулах баг | 7.01 |
| | | 5 | Нийгмийн мөргөлдөөн, дайн, терроризм | 1 | 1 | Бага | Үйл ажиллагааны ердийн түвшинд удирдаж болно. | Хариу арга хэмжээ шаардлагагүй | Зохион байгуулах баг | 7.01 |
| | | 6 | Зам тээвэр, дэд бүтэц | 1 | 1 | Бага | Үйл ажиллагааны ердийн түвшинд удирдаж болно. | Хариу арга хэмжээ шаардлагагүй | Зохион байгуулах баг | 7.01 |
| | | 7 | Малын халдварт өвчин | 3 | 3 | Дундаж | | | Зохион байгуулах баг | 7.01 |
| | | 8 | Нийгмийн гоц халдварт өвчин | 5 | 5 | Маш өндөр | Эрсдэлээс зайлсхийх | Эвентийг цуцлах хүртэл хариу арга хэмжээ авах | Зохион байгуулах баг | 7.01 |
| | | 9 | Гэмт хэрэг- Оролцогчид хулгайд эд зүйлээ алдах г.м | 3 | 3 | Дундаж | Эрсдэлийг бууруулах төлөвлөгөөг сайжруулах. Алтернатив хөтөлбөр, үйл ажиллагаа, арга зүйг заавал боловсруулсан байх | Орон нутгийн цагдаагийн албан хаагчдыг ажиллуулах. Зохион байгуулагчдын зүгээс жуулчдад анхаарал тавих. Эвентийн үеэр камер суурилуулах зэрэг. | Зохион байгуулах баг | 7.01 |
| | | 10 | Хүрээлэн байгаа орчны доройтолд хүргэж болзошгүй эрсдэл | 1 | 1 | Бага | Үйл ажиллагааны ердийн түвшинд удирдаж болно. | Хариу арга хэмжээ шаардлагагүй | Зохион байгуулах баг | 7.01 |
| | 2 | **Үйл ажиллагааны эрсдэл** | | | | | | | | |
| | | **1** | Гадаад, дотоодын жуулчдын оролцоо бага байх | 3 | 3 | Дундаж | Эрсдэлийг бууруулах төлөвлөгөөг сайжруулах. Алтернатив хөтөлбөр, үйл ажиллагаа, арга зүйг заавал боловсруулсан байх | Төлөвлөлтийн үе шатанд такс авсан оролцогчид бага байвал харгалзах зардалыг бууруулах, үйл ажиллагааны зохион байгуулалтыг цомхон болгох зэрэг арга хэмжээ авч болно. | Зохион байгуулах баг | 7.25 |
| | | 2 | Эвентийн хөтөлбөртэй холбоотой эрсдэл | 3 | 2 | Дундаж | Эрсдэлийг бууруулах төлөвлөгөөг сайжруулах. Алтернатив хөтөлбөр, үйл ажиллагаа, арга зүйг заавал боловсруулсан байх | Төлөвлөлтийн шатанд эвентийн хөтөлбөрийг чамбай боловсруулсан бол эвентийн хөтөлбөр цаг хугацааны дагуу явагдаж байгаад анхаарал тавих, холбох зохион байгуулалтыг хариуцсан хүмүүс сайн зохион байгуулах | Зохион байгуулах баг | 7.25 |
| | | 3 | Санхүү, зардал үр ашгийн тооцоо | 1 | 1 | Бага | Үйл ажиллагааны ердийн түвшинд удирдаж болно. | Хариу арга хэмжээ шаардлагагүй | Зохион байгуулах баг | 7.25 |
| | | 5 | Эвентийн зохион байгуулалттай холбоотой эрсдэл | 3 | 3 | Дундаж | Эрсдэлийг бууруулах төлөвлөгөөг сайжруулах. Алтернатив хөтөлбөр, үйл ажиллагаа, арга зүйг заавал боловсруулсан байх | Ажил үүргийн хуваарийн дагуу ажилтнууд хариуцсан үйл ажиллагаагаа хийж байгаа эсэхэд ерөнхий зохион байгуулагч хяналт тавих. | Зохион байгуулах баг | 7.25 |
| | | 6 | Техник, тоног төхөөрөмжийн эрсдэл | 3 | 4 | Өндөр | Эрсдэлээс зайлсхийх | Төлөвлөлтийн шатанд бэлдсэн арга хэмжээг хэрэгжүүлэх, тэдгээр аргаар шийдэж болохгүй бол хөтөлбөрийн дараалалд бага хэмжээний өөрчлөлт оруулж цаг хожих. | Зохион байгуулах баг | 7.25 |
| | | 7 | Ажилтнуудын аюулгүй байдал, эрүүл мэндийн эрсдэл | 2 | 2 | Дундаж | Эрсдэлийг бууруулах төлөвлөгөөг сайжруулах. Алтернатив хөтөлбөр, үйл ажиллагаа, арга зүйг заавал боловсруулсан байх | Хөдөлмөр аюулгүй байдал эрүүл ахуйн дүрэм зааврыг баталж эвент зохион байгуулах үеэр ажиллах ажилтнууд болон зохион байгуулах багт урьдчилан танилцуулж, мөрдөж ажиллаж байгаад хяналт тавих. Анхан шатны тусламжын хайрцаг бэлэн байлгах. Зохион байгуулалтын үед эмч ажиллуулах | Ерөнхий зохион байгуулагч | 7.25 |
| | | 8 | Оролцогчдын аюулгүй байдал, эрүүл мэндийн эрсдэл | 3 | 3 | Дундаж | Эрсдэлийг бууруулах төлөвлөгөөг сайжруулах. Алтернатив хөтөлбөр, үйл ажиллагаа, арга зүйг заавал боловсруулсан байх | Оролцогчдын эрүүл, аюулгүй байдлыг хангаж зохион байгуулалт хийх. Ялангуяа үзэгчдийг оролцуулсан хөтөлбөр дээр анхаарах. Анхан шатны тусламжын хайрцаг бэлэн байлгах. Зохион байгуулалтын үед эмч ажиллуулах. Хэрэв жуулчин гэмтсэн тохиолдолд хэн хариуцаж эмнэлэгийн тусламж үйлчилгээ үзүүлэхэд туслахыг урьдчилан тодорхойлсон байна. | Ерөнхий зохион байгуулагч | 7.25 |
| | | 9 | Хамтрагч байгууллагын найдвартай байдал | 2 | 2 | Дундаж | Эрсдэлийг бууруулах төлөвлөгөөг сайжруулах. Алтернатив хөтөлбөр, үйл ажиллагаа, арга зүйг заавал боловсруулсан байх | Хамтрагч иргэн байгууллага хариуцахаар нэг хүнийг томилж хамтран ажиллах, хяналт тавих. Гэрээгээр заасан үүргээ биелүүлэхийг шаардах | Зохион байгуулах баг | 7.25 |
| | | 10 | Байрны хангамж, хүрэлцээ | 2 | 2 | Дундаж | Эрсдэлийг бууруулах төлөвлөгөөг сайжруулах. Алтернатив хөтөлбөр, үйл ажиллагаа, арга зүйг заавал боловсруулсан байх | Уг эвент 1 өдрийн эвент учир зочдыг хоноглуулахаар бол урьдчилж мэдэх, хоноглохгүй бол хүрэлцэхүйц хэмжээний асар, майхан, гэр бэлдэх | Зохион байгуулах баг | 7.15 |
| | | 11 | Байрны чанарын шаардлага | 2 | 2 | Дундаж | Эрсдэлийг бууруулах төлөвлөгөөг сайжруулах. Алтернатив хөтөлбөр, үйл ажиллагаа, арга зүйг заавал боловсруулсан байх | Эвентийн зохион байгуулах өдрөөс өмнө байршуулах хэрэгслийн чанар, стандарт дээр хяналт тавьсан байх | Зохион байгуулах баг | 7.15 |
| | | 12 | Хоолны хангамж, хүрэлцээ | 1 | 1 | Бага | Үйл ажиллагааны ердийн түвшинд удирдаж болно. | Хариу арга хэмжээ шаардлагагүй | Зохион байгуулах баг | 7.25 |
| | | 13 | Хоолны чанарын шаардлага | 1 | 1 | Бага | Үйл ажиллагааны ердийн түвшинд удирдаж болно. | Хариу арга хэмжээ шаардлагагүй | Зохион байгуулах баг | 7.25 |
| | | 14 | Ариун цэврийн өрөөний асуудал | 3 | 3 | Дундаж | Эрсдэлийг бууруулах төлөвлөгөөг сайжруулах. Алтернатив хөтөлбөр, үйл ажиллагаа, арга зүйг заавал боловсруулсан байх | Эвентийн үеэр зөөврийн ариун цэврийн өрөө бэлдэж болно. | Зохион байгуулах баг | 7.25 |
| | | 15 | Хүний нөөцийн бэлэн байдал | 3 | 3 | Дундаж | Эрсдэлийг бууруулах төлөвлөгөөг сайжруулах. Алтернатив хөтөлбөр, үйл ажиллагаа, арга зүйг заавал боловсруулсан байх | Төлөвлөлтийн шатанд бэлтгэж, гэрээ байгуулах. Хэрэв тухайн газар нутгаас ажиллах хүн хангалттай олдохгүй бол бусад газраас ажилтан авахаар тохирох | Зохион байгуулах баг | 7.25 |
| | | 16 | Хүний нөөцийн чанар | 3 | 3 | Дундаж | Эрсдэлийг бууруулах төлөвлөгөөг сайжруулах. Алтернатив хөтөлбөр, үйл ажиллагаа, арга зүйг заавал боловсруулсан байх | Төлөвлөлтийн шатанд эвентэд ажиллах хүмүүст сургалт орох. Өмнөх жил нь зохион байгуулалтад оролцсон хүмүүсийг үргэлжлүүлэн ажиллуулах | Зохион байгуулах баг | 7.25 |
| | | 17 | Худалдаа наймаатай холбоотой эрсдэл | 2 | 2 | Дундаж | Эрсдэлийг бууруулах төлөвлөгөөг сайжруулах. Алтернатив хөтөлбөр, үйл ажиллагаа, арга зүйг заавал боловсруулсан байх | зохион байгуулагчид эвентийн үеэр хяналт тавих | Зохион байгуулах баг | 7.25 |

## ХАВСРАЛТ 14. ЭВЕНТ ЗОХИОН БАЙГУУЛАХ ГАРЫН АВЛАГА

**Эвент зохион байгуулагчдад зориулсан гарын авлага**

**Агуулга**


**Танилцуулга ......................................................................................................223**

**Төлөвлөлт..........................................................................................................223**

**Зорилго ...............................................................................................................223**

**Эрсдлийн менежмент .......................................................................................223**

**Байршил..............................................................................................................224**

**Гадна талбайд зохион байгуулагдах эвент.....................................................224**

**Тухайн орон нутгийн ЗДТГ-т хүсэлт гаргах ......................................................224**

**Эвентийг цуцлах ................................................................................................224**

**Зөвшөөрөгдөөгүй эвент....................................................................................224**

**Даатгал ...............................................................................................................225**

**Хөдөлмөрийн эрүүл, аюулгүй байдал/Нийтийн аюулгүй байдал ...............225**

**Галын аюулгүй байдал .......................................................................................225**

**Анхны тусламж ..................................................................................................226**

**Хүртээмжтэй байдал..........................................................................................226**

**Хүнсний аюулгүй байдал ..................................................................................226**

**Утаат тамхи.........................................................................................................227**

**Эрх бүхий байгууллагаас эвент зохион байгуулахыг зөвшөөрсөн талбай ..........................................................................................................................227**

**Талбайн хуваарилалт, зохион байгуулалт .....................................................227**

**Согтууруулах ундаа – Согтууруулах ундаа хориглох бүс ............................227**

**Аюулгүй байдал .................................................................................................228**

**Байгууламж, үзвэр үйлчилгээ, зугаа цэнгэл ....................................................228**

**Ариун цэврийн байгууламж...............................................................................228**

**Тээвэр...................................................................................................................229**

**Тээврийн хэрэгслийн зорчих хөдөлгөөнийг түр хаах ....................................229**

**Түр зогсоолын хяналт (TPC) .............................................................................230**

**Нэвтрэх тээврийн хэрэгсэл ...............................................................................230**

**Дуу чимээний хязгаарлалт ................................................................................230**

**Тухайн орон нутгийн засаг захиргааны эрх бүхий байгууллагад мэдэгдэх нь ..........................................................................................................................231**

**Баннер ба тэмдэг ...............................................................................................231**

**Хөдөлгөөнт буюу явуулын худалдаа эрхлэгчид ............................................232**

**Гэмт хэрэг, гэнэтийн халдлагын үеийн удирдамж, зааварчилгаа .............232**
**Салют ба галын наадам ....................................................................232**
**Зохиогчийн эрхтэй контент ашиглах ..................................................232**
**Цахилгаан эрчим хүч ........................................................................232**
**Цэвэрлэгээ ба хог хаягдлын менежмент..............................................232**
**Ус, мөсөн дээрх эвент .......................................................................232**

**Танилцуулга**

Эвент зохион байгуулах болон төлөвлөхөд байгууллага, хувь хүмүүс болон олон нийтийн бүлгүүдэд туслах зорилгоор энэхүү гарын авлагыг бэлтгэлээ. Энэхүү гарын авлагад эвент төлөвлөх гол үйл явц болон заримдаа анзаарагдалгүй орхигдож болох чухал хүчин зүйлсүүд, захиргааны байгууллагуудын шаардлага, журмыг хэрэгжүүлэхэд туслах зөвлөмжүүдийг тусгасан. Гэвч эвент бүр өөрийн гэсэн хэрэгцээтэй, тусгай шаардлагатай тул энэхүү зөвлөмж нь эцсийн хувилбар биш, ерөнхий зөвлөмж гэдгийг анхаарах хэрэгтэй.

**Төлөвлөлт:**

Эвентийг амжилттай зохион байгуулах нь зөв төлөвлөлтөөс хамаарна. Үүний тулд эвентийн зохион байгуулагчийг тодорхойлж, үндсэн ажлуудыг хугацаа тогтоон хуваарилаж, ажлын хэсэг байгуулах хэрэгтэй. Биелүүлэх ажлын жагсаалтыг гаргах ёстой. Зөвшөөрөл шаардах ажлуудыг тодорхойлж, зөвшөөрлийг урьдчилан авах нь чухал.

Төсөв, хөтөлбөр боловсруулж, эвентийн ажилтнууд, гол оролцогч талуудтай үр дүнтэй харилцах, логистикийн шаардлагыг дагаж мөрдөх нь чухал юм.

Амжилттай эвентийн төлөвлөгөөнд анхаарах зүйл:

- Урьдчилсан төлөвлөлт
- Нарийвчилсан төлөвлөгөөнд анхаарах
- Урьдчилан тооцоолоогүй, үүсч болохуйц гэнэтийн нөхцөл байдлыг тооцох

**Зорилго**

Эвент нь уьдчилан тодорхойлогдсон эрэлт хэрэгцээг хамгийн сайнаар хангах эсэхийг тодорхойлох нь чухал юм. Үүнд анхаарах шаардлагатай зүйлүүд нь:

- Эвент хийх үндэслэл
- Оролцогч талууд
- Зорилго
- Эрсдэл
- Үргэлжлэх хугацаа
- Зардалууд

Эвентийн зорилго, зорилт, үр дүнг тодорхойлж, тухайн эвент, эвентийн багаас эцсийн хариуцах хүнийг тодорхойлох нь чухал юм. Зорилтот зах зээл буюу

хэрэглэгч-үзэгчдийг тодорхойлж, ямар тэмцээн, үзүүлбэр, уралдаан энэ үзэгчдэд хамгийн сайн хүрэхийг судлах хэрэгтэй.

**Эрсдлийн менежмент**

Аливаа эвенттэй холбоотой эрсдэлүүд байдаг. Бид эвентийг зохион байгуулахтай холбоотой тодорхой хууль эрх зүйн болон ёс суртахууны үүрэг хариуцлага хүлээдэг. Ялангуяа цалинтай болон цалингүй ажилчдад анхаарал тавих, оролцож буй хүмүүсийн эрүүл мэнд, аюулгүй байдлын асуудлыг шийдвэрлэх үүрэгтэй. Үүсч болохуйц эрсдлээ төлөвлөх нь эрсдлийг багасгах боловч ямар нэг зүйл буруу болвол стратегийг авч үзэх шаардлагатай. Эрсдэл төлөвлөлтийн хамгийн ашигтай арга бол “Эрсдлийн менежментийн төлөвлөгөө” боловсруулах явдал юм.

**Байршил**

Эвентийг түр кэмп эсвэл суурин газарт тулгуурлан дотор болон гадаа талбайг ашиглах байдлаар зохион байгуулах бөгөөд нэг удаагийн эсвэл тогтмол байдлаар зохион байгуулж болдог. Хамгийн чухал нь эвент зохион байгуулагдах талбай нь эвентэд оролцох хүмүүсийн тоонд тохирсон байх нь чухал.

Байршил нь үйл явдлын мөн чанартай уялдсан байх ёстой. Анхаарах ёстой зарим зүйл бол тухайн газрын түрээсийн зардал, дүр төрх, уур амьсгал, нийтийн хоолоор хангадаг эсэх, эсвэл ханган нийлүүлэгчдэд шаардлагатай зохицуулалтыг хийх боломжтой эсэх, дуу чимээний хязгаарлалт болон хөгжлийн бэрхшээлтэй хүмүүст хүртээмжтэй байгаа эсэх юм.

**Гадна талбайд зохион байгуулагдах эвент**

Эвент зохион байгуулагчдын зорилго бол бүх оролцогч талуудын аюулгүй байдлыг хангах, нийтийн эзэмшлийн талбайн тохижилтыг хангахын зэрэгцээ эвент, баяр наадмыг зохион байгуулах явдал юм.

Хэрэв эвентийг гадаа зохион байгуулах гэж байгаа бол та халуун цаг агаар, хур тунадас, салхины эрч зэргээс урьдчилан сэргийлж, төлөвлөгөө боловсруулах шаардлагатай. Эвент болох байршил нь сүүдрэвч эсвэл хоргодох газартэй эсэх, тав тухтай байдал, хөгжлийн бэрхшээлтэй хүмүүст нэвтрэх боломжтой эсэхийг шалгаарай.

**Тухайн орон нутгийн ЗДТГ-т хүсэлт гаргах**

Эвентийг орон нутагт зохион байгуулахын тулд тухайн сумын ЗДТГ-аас зөвшөөрөл авах шаардлагатай болдог. Үүний тулд ашиглах гэж буй газраа урьдчилсан захиалга өгөх хэрэгтэй. Хэрэв УТХГН болон орон нутгийн тусгай хамгаалалттай газар эвент зохиох бол эвент болохоос дор хаяж 3 сарын өмнө зөвшөөрөл авах шаардлагатай болно.

**Эвентийг цуцлах**

Та батлагдсан эвентийг цуцлах шаардлагатай болвол цуцлах тухай мэдэгдлийг орон нутгийн захиргаанд тодорхой хугацааны өмнө мэдэгдсэн байх ёстой бөгөөд цуцлах нөхцөлийн талаар урьдчилан лавлах хэрэгтэй. Хэрэв эвент товлосон өдрөөс 14-с доош хоногийн өмнө цуцлагдсан бол түрээсийн төлбөрийг эргүүлэн олгохгүй байх үндэслэл үүсч, төлсөн төлбөрийг хурааж болно.

**Зөвшөөрөгдөөгүй эвент**

ЗДТГ нь өөрийн үзэмжээр орон нутгийн аль нэг нөөц газар, эрэг орчмын газрыг түрээслэхээс татгалзах эрхтэй. Дараах нөхцөл байдал зөвшөөрөхгүй байх үндэслэл болно. Гэхдээ үүгээр хязгаарлагдахгүй.

• Өргөдлийг үнэлэхэд хангалтгүй мэдээлэлтэй эсвэл хугацааг тусгаагүй бол
• Олон нийт, орон нутгийн иргэд, аж ахуйн нэгжүүдэд таагүй нөлөөлөл үзүүлэх, хүндрэл учруулж болзошгүй бол
• Өргөдөл гаргагч/Эвент зохион байгуулагчид үйл ажиллагааг зохих ёсоор удирдах нөөц, шаардлагатай туршлага байхгүй гэж ЗДТГ-ийн эвентийн зохицуулагчид үзвэл
• Санал болгож буй эвент нь урьдчилан таамаглах боломжгүй, тодорхой бус баййх
• Тухайн бүсэд хэдийн зөвшөөрөгдсөн бусад эвенттэй зөрчилдөх гэх мэт.

**Даатгал**

Эвентэд оролцож буй бүх оролцогч талууд (гуравдагч этгээдүүд) өөрсдийн нийтийн хариуцлагын даатгалд хамрагдах ёстой: интэртаймент, зугаа цэнгэл, нийтийн хоолны газар, сайн дурын бүлгүүд, тайзны техникч гэх мэт.

Санал болгож буй бусад даатгал бол хувийн осол, цаг агаарын таагүй байдлын даатгал юм. Таны төлөвлөж буй арга хэмжээнд хамгийн тохиромжтой даатгалыг тодорхойлохын тулд даатгагчтайгаа зөвлөлдөнө үү.

**Хөдөлмөрийн эрүүл, аюулгүй байдал/Нийтийн аюулгүй байдал**

Монгол улсад хөдөлмөрийн эрүүл мэнд, аюулгүй байдалтай холбоотой олон тооны хууль, эрхзүйн баримтууд байдаг. ЗДТГ нь эвентийг зохион байгуулагчдаас эвент болох хүртэлх хугацаанд хөдөлмөрийн эрүүл мэнд, аюулгүй байдлын бүх журмыг дагаж мөрдөхийг шаардах болно.

Эвент зохион байгуулагч ажилтнууд өөрсдийгөө, эсвэл зочдыг хамгаалах үүрэг хүлээдэг ч хэрэв үйлчлүүлэгч эсвэл зочин гэмтэж, нөхөн төлбөр авах хүсэлт гаргавал энэ нь олон нийтийн хариуцлагын нэхэмжлэл болно гэдгийг ойлгох хэрэгтэй.

Эвент зохион байгуулагчид үйл ажиллагаандаа Хөдөлмөрийн аюулгүй байдал эрүүл ахуйн талаар төрөөс баримтлах бүх бодлого, зарчмуудыг авч үзэх ёстой.

- Машин механизм тоног төхөөрөмжид тавих шаардлага. Эвентэд ашигласан бүх тоног төхөөрөмж аюулгүй байдлын шалгалтанд хамрагдсан эсэхийг шалгана.
- Өргөх, зөөх, тээвэрлэх механизмд тавих шаардлага
- Галын аюулгүй байдалд тавих шаардлагыг хангасан эсэх
- Оролцох худалдаачид/гүйцэтгэгчид тусгай зөвшөөрөлтэй эсэх, эрүүл мэндийн үзлэгт хамрагдсан эсэх
- Архи согтууруулах ундаагаар үйлчлэх тусгай зөвшөөрөл зэрэгт хариуцлагатай хяналт тавих
- Олон түмний аюулгүй байдлыг хангах (жишээ нь хамгаалалтын ажилтнууд)
- Хүнсний бүтээгдэхүүнтэй харьцах аюулгүй арга барил бий.

Хэрэв та ХАБЭА-н үүргийнхээ талаар эргэлзэж байгаа эсвэл зөвлөгөө авах шаардлагатай бол ХАБЭА-н мэргэжилтнүүдийн холбоо болон сургагч багш нараас зөвөлгөө авч холбогдоно уу.

**Галын аюулгүй байдал**

Ямар ч тохиолдолд гал түймрээс урьдчилан сэргийлэх нь чухал юм. Эвентийн зохион байгуулагчид цахилгаан тоног төхөөрөмж, ялангуяа нийтийн хоолны газрууд зэрэг зохих газруудад тохирох гал унтраагуураар хангагдсан байх ёстой. Янз бүрийн хэрэглээнд (жишээлбэл, CO2, химийн бодис, ус) гал унтраагуурын зөв төрлийг хангах нь чухал юм. Эвентийн бүх ажилтнууд гал унтраах хэрэгслийг ашиглах талаар сурсан байх ёстой.

Мөн шатамхай материалыг гал асаах эх үүсвэрээс хол байлгах нь зайлшгүй чухал юм. Гал гарсан тохиолдолд эвентийн талбайн зохион байгуулалтад яаралтай тусламжийн үйлчилгээ үзүүлэх хангалттай өрөө, нэвтрэх цэгүүдийг багтаасан эсэхийг шалгаарай.

Эвент зохион байгуулагч нь аймаг, нийслэлийн Онцгой байдлын албатай холбогдож эвентүүдийн галын аюулгүй байдлын талаар зөвлөгөө авах, бүх ажилтнууд болон сайн дурын ажилтнуудад галын аюулгүй байдлын ерөнхий зарчмуудын талаар мэдээлэл өгөхийг зөвлөж байна.

**Анхны тусламж**

Таны эвентийн мөн чанар болон хүлээгдэж буй цугларалтын тоо нь мэргэжлийн анхны тусламжийн ажилтан эсвэл сайн дурын ажилтнууд таны эвентэд оролцох эсэхийг тодорхойлно. Анхны тусламжийн постуудыг олон нийтэд хялбархан олохын тулд тодорхой ялгах боломжтой байлгах ёстой.

Эвентүүдэд эмнэлгийн болон анхны тусламж үзүүлэх гэрээт, эмч сувилагч, түргэн тусламжийн ажилтан ажиллах болсон.

*Иймээс анхны тусламж, эмнэлгийн үйлчилгээ үзүүлэгчийг захиалахын өмнө анхаарах ёстой чухал зүйлс.*

- Тэд шаардлагатай тохиолдолд тэд бэлэн байж чадах уу?
- Тэд туршлагатай түргэн тусламж, сувилагч, эмч мөн үү?
- Тэд тоноглогдсон уу?
- Тэд яаралтай эм авч явах зөвшөөрөлтэй юу?
- Тэд анхны тусламжийн гэрчилгээ, мэргэжлийн үнэмлэхтэй эсэхийг шалгана уу.

**Хүртээмжтэй байдал**

Эвент зохион байгуулагчид нь хүний эрхийг зөрчих, ялгаварлан гадуурхахаас зайлсхийх, уг зөрчил гарсан тохиолдолд хуулийн дагуу хариуцлага хүлээнэ. Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн хэрэгцээ шаардлагыг аль болох хангахуйц байхыг эвент бүр анхаарах хэрэгтэй.

Эдгээр үүргээ биелүүлэхийн тулд эвентийг төлөвлөх эхний үе шатанд хүртээмжтэй байдлын талаар нарийн судалж, үйл ажиллагаандаа хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийг хамруулах, орон нутгийн засаг захиргаа болон сайн дурын байгууллагуудтай холбогдож мэдээлэл, зөвлөгөөг урьдчилан авах нь зүйтэй юм.

**Хүнсний аюулгүй байдал**

Эвентийн үеэр хүнсний зүйлс, хоол зарах хүсэлтэй бүх бизнес эрхлэгчид үйл ажиллагаа явуулахаас 14-с доошгүй хоногийн өмнө ЗДТГ-т мэдэгдэх ёстой. Мөн оролцох хүсэлтэй хүнсний лангуу эзэмшигч бүр "Эвентийн үеийн хоол хүнсний мэдэгдлийн маягт"-ыг бөглөж, эвентийн зохион байгуулагчид ирүүлэх үүрэгтэй бөгөөд түүнд бизнесийн нэр, холбоо барих хаягийг дэлгэрэнгүй бичсэн байна.

Үүний дараа оролцогч талууд нь хүлээн авсан баримт, мэдээллийг нэгтгэн хүнсний аюулгүй байдал, эрүүл ахуйн чухал шаардлагуудын дагуу нарийвчлан хэлэлцэхийг зөвлөж байна.

Эвентийн зохицуулагчид нь “Эвентийн үеийн хоол хүнсний мэдэгдлийн маягт”-ын хуулбарыг шаардлагатай тохиолдолд бүх хүнсний лангуу эзэмшигчдэд болон ЗДТГ-т хүргүүлэх боломжтой байлгах хэрэгтэй.

Хүнсний бүтээгдэхүүнтэй харьцаж буй хүн бүр Хүнсний тухай хууль болон Хүнсний аюулгүй байдлыг хангах зарчимыг дагаж мөрдөх үүрэгтэй. Үүний тулд эвентийн зохицуулагчид нь хүнсний лангуу эзэмшигчдийг зарим шаардлагатай тоног төхөөрөмжөөр хангаж болох юм.

Хэрэв эвент давтан зохион байгуулагдаж байгаа бол (жишээ нь жил бүр) эвент зохион байгуулагч нь "Эвентийн үеийн хоолны мэдэгдлийн маягт"-ыг мөн давтан ирүүлэх ёстой хэдий ч тогтмол оролцдог хүнсний лангуу эзэмшигчидийн хувьд зөвхөн холбогдох хүмүүсийн хаягийн мэдээллийг ирүүлж болохоор зохицуулах боломжтой.

Хүнсний бизнес нь зөвхөн нэг удаагийн хоол хүнстэй харьцах, худалдах эсэхээс үл хамааран арилжааны, буяны болон олон нийтийн шинж чанартай хүнсний борлуулалттай холбоотой аливаа аж ахуйн нэгжийн бизнесийн үйл ажиллагаа юм.

**Утаат тамхи**

Та эвентээ утаагүй болгох талаар бодож үзсэн үү? Дам тамхидалт нь хүний эрүүл мэндэд муугаар нөлөөлдөг гэдгийг бид мэднэ. Тиймээс эвент дээр тамхи татахыг хязгаарлах, эсвэл тамхи татах цэгийг тусгайлан гаргахад анхаарах шаардлагатай. Үүний тулд ойлгомжтой таних тэмдэгийг байрлуулах нь чухал.

**Эрх бүхий байгууллагаас эвент зохион байгуулахыг зөвшөөрсөн талбай**

Хэрэв хашаа, боргоцой, хаалт, бие засах газар, хогийн цэг гэх мэт зүйлс таны эвентэд ашиглагдах шаардлагатай бол үүнийгээ ЗДТГ-т гаргах хүсэлтэд тодорхой зааж ирүүлэх шаардлагатай ба дараах мэдээллийг агуулсан байх ёстой.

• Байршлыг харуулсан сайтын төлөвлөгөө

•Тухайн газрыг эзлэх огноо, үргэлжлэх хугацаа зэрэг үйл явдлын дэлгэрэнгүй мэдээлэл

• Бусад

(Зөвшөөрөл авах хүсэлтийн маягтыг үзнэ үү)

Хэрэв та хог хаягдлыг зайлуулах гэх мэт эвентийнхээ хүрээнд ЗДТГ-ын газар дээр хогийн сав, тээвэрлэлтийн чингэлэг байрлуулахыг шаардвал ЗДТГ-ын газар дээр зөвшөөрөл авах-Алгасах сав/тээвэрлэлтийн чингэлэг авах өргөдлийг бөглөж, ЗДТГ болон холбогдох бүх байгууллагад хүргүүлэх ёстой. төлбөр төлсөн.

**Талбайн хуваарилалт, зохион байгуулалт**

Эвент зохион байгуулагдах газрын хуваарилалть зохион байгуулалтыг эвент болохоос дор хаяж 4 долоо хоногийн өмнө ЗДТГ-т ирүүлэх ёстой. Энэ нь төлөвлөлт нь эвентэд багтах бүх зүйлийг агуулсан байх ёстой;

• Эвентийн бүх орох/гарах цэгүүд
• Яаралтай тусламжийн үйлчилгээнд нэвтрэх, гарах гарц
• Байнгын нийтийн үйлчилгээний газруудын байршил
• Хоолны лангуу/зугаа цэнгэл/ үйл ажиллагаа гэх мэт
• Алдагдсан хүүхдүүд/эд хөрөнгө
• Marquees – жишээлбэл Бүртгэл, хоол хүнс, суудал гэх мэт

• Анхны тусламжийн хэсэг
• Тайзны байршил
• Архи согтууруулах ундааны хэрэглэж болох цэгүүд
• Түр / зөөврийн нийтийн үйлчилгээний газруудын байршил
• Хамгаалалтын хяналт/байрлуулалт гэх мэт
• Машины зогсоол

**Согтууруулах ундаа – Согтууруулах ундаа хориглох бүс**

Хэрэв та эвент дээрээ согтууруулах ундаа зарах эсвэл нийлүүлэх гэж байгаа бол архи согтууруулах ундааны зөвшөөрөл авах шаардлагатай.Согтууруулах ундаа хэрэглэхийг хориглодог бүсэд зарим тохиолдолд архины түр зөвшөөрөл авах хүсэлтэй бол ЗДТГ мэдэгдсэнээр дэмжигдэж болно. Эхний ээлжинд ЗДТГ-т хандана уу.

Хязгаарлагдмал лицензийг зөвхөн хэд хэдэн онцгой тохиолдлуудад олгож болно.

ЗДТГ-т илгээх зөвшөөрлийн хүсэлтэд байх ёстой зүйл:
• Танай байгууллагын нэр
• Таны эвентийн огноо, байршил
• Архи согтууруулах ундаа худалдах хугацаа
• Согтууруудах ундаа хориглох бүсийн дэлгэрэнгүй мэдээлэл
• Оролцогчдын тоог урьдчилан тооцоолох
• Үйл явдлын тайлбар
• Үйл ажиллагааны аюулгүй байдлын дэлгэрэнгүй мэдээлэл
• Тусгай зөвшөөрөл шаардлагатай онцолсон газрын төлөвлөгөө
• Хариуцлагын дэлгэрэнгүй мэдээлэл
• Багтаасан ариун цэврийн байгууламжийн тоо
• Зугаа цэнгэлийн төрөл хэлбэр

**Аюулгүй байдал**

Эвентэд оролцох хүний тоо нь аюулгүй байдал шаардлагатай эсэхийг тодорхойлно. Хамгаалалтын ажилтнуудын үүрэг хариуцлагад цугласан олныг чиглүүлэх, эд хөрөнгийг хамгаалах, төөрсөн хүүхдүүдийг харах, алдагдсан эд зүйлсийг хадгалах зэрэг багтана.

**Байгууламж, үзвэр үйлчилгээ, зугаа цэнгэл**

Байгууламж

Эвент нь суудал, лангуу, тайз, том талбай, зугаа цэнгэлийн гэх мэт байгууламжуудтай байж болно. Бүх байгууламж, үзвэр, үйлчилгээ нь хууль тогтоомжийн шаардлагад нийцэж байгаа эсэхийг эвент зохион байгуулагч хариуцна.

Хэрэв байгууламж нь эвентийн бүрэлдэхүүн хэсэг бол эвент зохион байгуулагч нь эвент болохоос дор хаяж 12 долоо хоногийн өмнө ЗДТГ-т өгөх хүсэлтдээ тодорхой тусгасан байх шаардлагатай.

Хэрэв шаардлагатай бол угсралтын ажил эхлэхээс өмнө инженерээс дэлгэрэнгүй мэдээлэл, төлөвлөгөө гаргуулах бөгөөд барилга угсралтын ажил дууссаны дараа барилгын мэргэшсэн инженер нь уг байгууламжийг баталгаажуулсан гэрчилгээ олгох ёстой. Өөрөөр хэлбэл, ашиглахын өмнө түр барилга байгууламжийн зураг төсөл нь бүтцийн хувьд аюулгүй болохыг баталгаажуулсан барилгын мэргэшсэн инженерийн гэрчилгээ (Барилгын дүрмийн шаардлагын дагуу). Энэхүү гэрчилгээг эвент болохоос нэг сарын өмнө ЗДТГ-т ирүүлэх ёстой.

Байгууламжийн хувьд зөвхөн 50 м.кв-аас дээш талбайтай байгууламжид гэрчилгээ шаардлагатайг анхаарна уу.

Танай эвент аливаа амьтан оролцуулах бол ЗДТГ-аас зөвшөөрөл авах шаардлагатай.

**Ариун цэврийн байгууламж**

Эвентийн зохион байгуулагчид бие засах газар, гар угаах хэрэгсэл, ариун цэврийн хэрэглэл нь хүрэлцэхүйц тооны, тохиромжтой байршилд байх шаардлагатай. Мөн эвент дээр хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн бие засах газар заавал байх ёстой.

Ариун цэврийн байгууламж нь:

- ❖ Ариутгах татуурга, бохир ус цуглуулах, цэвэрлэх, зайлуулах шаардлагатай зохицуулалттай байх
- ❖ Эрүүл ахуйн шаардлага хангахын тулд цэвэр, эмх цэгцтэй, засвар үйлчилгээ хийх боломжтой байх
- ❖ Устай савыг цэвэр усан хангамжид холбож, саван эсвэл гар ариутгагчаар хангасан байх
- ❖ Хоол хийх болон хоол бэлтгэх талбайн эргэн тойронд биш, зохимжтой газарт байрлуулах, одоо байгаа ариун цэврийн байгууламж хангалтгүй үед зөөврийн бие засах газартай байх ёстой.

Эвентэд шаардагдах жорлонгийн тоог тооцоолох, үйлчилгээний эрүүл ахуйн чиглэлээр хууль тогтоомж, дүрэм журамд нийцүүлсэн байх шаардлагатай. Нэмэлт байгууламж, био нойлоор хангах замаар эвентийг илүү сайн удирдах боломжтой.

**Тээвэр**

Автомашины зогсоолын эрэлтийг бууруулахын тулд эвентийг зохион байгуулагчид нийтийн тээвэр, унадаг дугуй, автобус гэх мэт өөр хувилбаруудыг судалж, сурталчлах ёстой. Нэмэлт эрэлт хэрэгцээг хангахын тулд нэмэлт үйлчилгээ эсвэл том оврын автобус авах хүсэлт гаргахын тулд эвент зохион байгуулагчид Нийтийн тээврийн газартай холбогдох шаардлагатай. Энэ нь 5000 гаруй хүн оролцох төлөвтэй аливаа эвентэд тавигдах хууль ёсны шаардлага юм.

Хэрэв та дугуйн спортыг сурталчлах гэж байгаа бол уралдааны дугуйн замыг анхаарч үзэх хэрэгтэй бөгөөд дугуйны тавиур, түгжээтэй байх ёстой.

**Тээврийн хэрэгслийн зорчих хөдөлгөөнийг түр хаах**

Хэрэв та ямар нэгэн зам, нийтийн тээврийн хэрэгсэлд нөлөөлж, зам хаах шаардлагатай бол эвент болохоос дор хаяж 12 долоо хоногийн өмнө ЗДТГ-т мэдэгдэх шаардлагатай бөгөөд Замын хөдөлгөөний удирдлагын газраас зам хаах зөвшөөрөл авах үүрэгтэй.

ТУСГАЙ ЗАМ ХААХ:

• Дараах мэдээллийг агуулсан захидал:

- Үйл явдлын огноо
- Үйл явдлын цаг
- Замыг түр хааж эхлэх, дуусах хугацааг баталгаажуулах (энэ нь бодит үйл явдлын цаг хугацаанаас өөр байж болно)
- Байршил
- Зам дээрх аливаа дэд бүтцийн дэлгэрэнгүй мэдээлэл
- Аюулгүй байдлын заалтууд
- Архи согтууруулах ундааны зөвшөөрлийн дэлгэрэнгүй мэдээлэл

• Түр замыг батлуулахыг хүссэн тайланг ЗДТГ-т хүргүүлнэ
• Зөвшөөрөгдсөн тохиолдолд зөвлөгөө авахын тулд эвент болохоос дор хаяж 14 хоногийн өмнө эвентийн нэр, огноо, байршил, зохион байгуулагчийн нэр, холбоо барих утас, зам хаах байршил, нээлт хаалтын цаг, нийтийн тээврийн замд үзүүлэх нөлөөлөл, тээврийн хэрэгслийн нэвтрэх болон зогсоолын санал болгож буй өөр зохицуулалтыг багтаасан байх ёстой.
• Замын түр хаалтад өртөж болзошгүй бүх оршин суугчид болон/эсвэл бизнес эрхлэгчидтэй олон нийттэй зөвшилцсөн тухай бичгээр нотлох баримтыг ЗДТГ-т өгөх ёстой.

Энэ нь зөвшилцсөн этгээд, эд хөрөнгийн хаяг, овог нэр, зөвшөөрлийн гарын үсэг зэргийг тодорхойлсон мэдэгдэл хэлбэрээр байж болно.

• Үйл явдал болох газраас 1 км-ийн радиуст байрлах бизнес эрхлэгчид/оршин суугчдад мэдэгдэх захидлыг эвент болохоос дор хаяж 14 хоногийн өмнө илгээх шаардлагатай.
• Зам хаахтай холбоотой бүх хураамжийг төлөх; өргөдлийн хураамж, зам хаах мэдэгдэл, олон нийтийн хэлэлцүүлэг, хөдөлмөр, тоног төхөөрөмж гэх мэт.

Эвентийн зохион байгуулагч нь оролцогчдын аюулгүй байдлыг үргэлж хариуцдаг. ЗДТГ эвентийг зохион байгуулсны үр дүнд оролцогчид болон бусад гуравдагч этгээд, тэдний эд хөрөнгөд учирч болзошгүй аливаа гэмтэл, хохиролд хариуцлага хүлээхгүй.

**Түр зогсоолын хяналт (TPC)**

Түр зогсоолын хяналтыг тусгай эвентэд туслах зорилгоор зогсоолын хэсгийг хориглох, хязгаарлах, тусгаарлахад ашигладаг. Түр зуурын хяналт нь хөдөлгөөний аюулгүй байдал, замын хөдөлгөөний менежментэд нөлөөлж болзошгүй тул ЗДТГ-ын Замын хөдөлгөөний удирдлагын газартай зөвшилцөх шаардлагатай.

Зарим түр хяналт нь тухайн үйл явдалд шаардагдах тусгай зөвшөөрөл олгохыг шаарддаг.

Хэрэв танд Түр зогсоолын бүс, хязгаарлалт шаардлагатай бол ЗДТГ дор хаяж 4 долоо хоногийн өмнө мэдэгдэнэ.

Хүсэлтэд дараах мэдээллийг оруулна.
• Байршил
• Хүсэж буй хяналтын төрөл
• Түр зогсоолын хяналтын хугацаа
• Хяналтын талаархи тайлбар; танд хэрэгтэй байгаа шалтгаан гэх мэт
• Түр зогсоолын хяналтын төлөвлөгөөг бүртгэлтэй байгууллага боловсруулна
• Суурилуулах заавар

Түр зогсоолын хяналтыг хэрэгжүүлэхэд зар сурталчилгаа, олон нийтийн хэлэлцүүлэг, ЗДТГ-ын тайлан шаардлагагүй, гэхдээ хэрэв ЗДТГ-аас зогсоолын хяналтыг хэрэгжүүлэхэд зориулж дарцаг, замын конус хэлбэрт тэмдэг, төмөр тор хашдага гэх мэтээр хангавал холбогдох зардал гарч болзошгүй. Энэхүү зөвшөөрөл нь төлбөртэй байж болно.

Тухайн газарт хангалттай хэмжээний зогсоол байгаа эсвэл Түр зогсоолын хяналт нь тухайн бүс нутгийн оршин суугчид, зочид, бизнес эрхлэгчдэд нөлөөлнө гэж үзвэл түр зогсоолын хяналтаас татгалзаж болно.

**Нэвтрэх тээврийн хэрэгсэл**

УТХГН-ийн зарим бүсэд автомашины зогсоолыг дэмждэггүй. Гэсэн хэдий ч ЗДТГ нь зөвхөн ачих, буулгах зорилгоор тээврийн хэрэгслийн нөөц зогсоолд

зөвшөөрлийг олгож болно. Хэрэв ЗДТГ нөөц зогсоолыг зөвшөөрсөн бол Замын хөдөлгөөний дарга нар зогсоолыг зохицуулж, гэрлийн тусгал бүхий хантааз гэх мэт зохих хэрэгслийг ашиглах ёстой.

Нөөц зогсоолд тээврийн хэрэгслээр нэвтрэх шаардлагатай бол ЗДТГ-ын нэвтрэх зөвшөөрөл олгох өргөдлийг холбогдох бичиг баримтын хамт эвент болохоос ажлын 10-аас доошгүй хоногийн өмнө бөглөж хүргүүлэх ёстой.

Хэрэв танд олон тооны тээврийн хэрэгсэл нэвтрэх шаардлагатай бол нөөц газар байрлуулах, жишээлбэл; 10-аас дээш машинтай бол ЗДТГ-ын зөвшөөрөл олгох менежертэй холбогдох шаардлагатай.

**Дуу чимээний хязгаарлалт**

Эвент зохион байгуулагчид нөөц газар, задгай талбайд эвент зохион байгуулахдаа хүрээлэн буй орчны тохилог байдлыг алдагдуулахгүй байхыг анхаарч үзэх хэрэгтэй. Дуу чимээний түвшинг зохицуулах нь хотын бүх хүнд амьдрахад таатай, дэмжлэг үзүүлэх орчныг бүрдүүлэхэд чухал хэсэг юм.

Таны эвентийн үеэр дуу авианы өсгөгч эсвэл дуу/тоног төхөөрөмж 72 децибелээс хэтрэхгүй байх ёстой.

Эвент зохион байгуулагчид Байгаль орчныг хамгаалах (үйлдвэрлэлийн дуу чимээ) зөвшөөрөгдөх хэмжээнээс дээших хүсэлтээ Байгаль орчин, аялал жуулчлалын яаманд шууд гаргах шаардлагатай. Өргөдөл гаргахад шаардагдах мэдээлэлд тухайн эвентийн байршил, цаг, үргэлжлэх хугацаа, дууны төхөөрөмж багтана.

Шөнө дундаас өмнө дуусдаг концертын хувьд Байгаль орчныг хамгаалах газраас дуу чимээнээс чөлөөлөх шаардлагагүй гэж үзэж байна. Гэсэн хэдий ч эвент зохион байгуулагч нь аливаа шаардлагыг хангаж, удирдамжийг дагаж мөрдөхийн тулд холбогдох байгууллагатай холбогдохыг зөвлөж байна.

**Тухайн орон нутгийн засаг захиргааны эрх бүхий байгууллагад мэдэгдэх нь**

Та удахгүй болох эвентийнхээ талаар олон нийт, оршин суугчдад мэдэгдэл өгөх шаардлагатай байвал эвент болохоос дор хаяж нэг долоо хоногийн өмнө эвентээсээ 1 км-ийн радиус доторх оршин суугчид болон бизнесүүдэд захидал илгээнэ.

Захидал нь дараах зүйлийг агуулсан байх ёстой.

- Үйл явдлын нэр, огноо
- Үйл явдлын зорилго
- Оролцогчдын тоо эсвэл хүлээгдэж буй үзэгчдийн тоо
- Оршин суугчид болон аж ахуйн нэгжүүдэд нөлөөлж болохуйц хүчин зүйлсүүд
- Зам хаасан тухай
- Холбоо барих нэр, дугаар.

Энэхүү захидлын хуулбарыг эвент болохоос 2 долоо хоногийн өмнө Захиргааны ажилтан - Үйл явдлын ажилтанд зөвшөөрөл авахаар илгээнэ.

Ажилтнууд танд багтах нутаг дэвсгэр, гудамжийг тодорхойлоход тусална.

**Баннер ба тэмдэг**

***<u>Авто замын баннерууд:</u>***

Хэрэв та авто зам дагуух зарлалын самбаруудын аль нэгийг ашиглан олон нийтийн эвентээ сурталчлахыг хүсвэл холбогдох эзэн, байгууллагад мэдэгдэх шаардлагатай.

***<u>Хувийн болон нийтийн өмчийн тэмдэг ба баннер</u>***

Хэрэв та хувийн өмчийн газарт тэмдэг байрлуулахаар төлөвлөж байгаа бол өмчлөгчөөс зөвшөөрөл авах шаардлагатай бөгөөд уг тэмдэглэгээг Нутгийн

удирдлагын тухай хуульд нийцүүлэхийн тулд ЗДТГ-ын холбогдох ажилтнуудтай холбогдох ёстой. Холбогдох хууль тогтоомж, дүрэм, ЗДТГ-ын бодлогод нийцээгүй гэж үзвэл ажилтнууд тэмдэглэгээг арилгаж болохыг анхаарна уу.

Хэрэв тэмдэглэгээг нийтийн өмч, нөөц газар, явган хүний зам гэх мэт газарт байрлуулах бол төрийн байгууллагаас зөвшөөрөл авах шаардлагатай бөгөөд зөвшөөрөл авах өргөдлийг түр зуурын сурталчилгааны тэмдэгт бөглөж, холбогдох бүх төлбөрийг төлөх шаардлагатай.

Хэрэв та хот, суурин газрын хэмжээнд цахилгаан, гэрлийн шон дээр тэмдэг байрлуулахыг хүсвэл ЗДТГ-аас зөвшөөрөл өгөх шаардлагатай.

Шашин, боловсрол, соёл, улс төр, нийгэм, амралт зугаалгын шинж чанартай орон нутгийн үйл явдлыг зарлах түр зуурын тэмдгүүдэд барилгын зөвшөөрөл авах шаардлагагүй боловч дараах нөхцлийг хангасан байх ёстой.

• Нэг барилга, талбай дээрх энэ төрлийн бүх тэмдгүүдийн нийт сурталчилгааны талбай нь 2м2-аас ихгүй байна.

• Тэмдгийг үйл явдал болохоос нэг сарын өмнө, үйл явдал дууссанаас хойш долоо хоногоос илүүгүй хугацаанд байрлуулна.

**Хөдөлгөөнт буюу явуулын худалдаа эрхлэгчид**

Хэрэв та эвент дээрээ борлуулалт хийх гэж байгаа бол зөвшөөрөл авах шаардлагатай. Аливаа худалдаа эрхлэгч лангуу зөвшөөрөл авах шаардлагатай. Үйл ажиллагаанаас хамааран дараах зөвшөөрлүүдийн аль нэгийг өгөх шаардлагатай;

• Зөвшөөрөл авах өргөдөл – Гудамжны үйл ажиллагаа

• Зөвшөөрөл авах өргөдөл – Ачаа тээврийн хэрэгслийн түрээс

**Гэмт хэрэг, гэнэтийн халдлагын үеийн удирдамж, зааварчилгаа**

**Салют ба галын наадам**

Монгол улсад салют буудуулах нь зөвшөөрлийн дагуу хийгдэх ёстой бөгөөд зөвхөн лицензтэй 2 аж ахуй нэгж пиротехникийн хэрэгслийг импортлох, худалдан борлуулах зөвшөөрөлтэй байдаг.

Нийслэл болон аймгийн ОБГ болон нь салют буудуулах зөвшөөрөл олгох үүрэгтэй. Ингэхдээ эвент болохоос хамгийн багадаа 72 цагин өмнө үйл явдлын огноо, цаг, байршил зэрэг дэлгэрэнгүй мэдээллийг агуулсан хүсэлт гаргах ёстой.

Эвент зохион байгуулагч нь салют буудуулах шаардлагатай, мөн зөвлөгөө авах бол аймаг, нийслэлийн Онцгой байдлын албатай шууд холбоо барина.

Галт бамбар, галын наадам гэх мэт галтай холбогдолтой үзүүлбэр ашиглаж байгаа аливаа эвентийн хувьд зохион байгуулагч нь Онцгой Байдлын Алба-тэй шууд холбогдож зөвлөгөө, зөвшөөрөл авах ёстой. Онцгой Байдлын Алба нь аюулаас урьдчилан сэргийлэх, шаардлагатай бол гал унтраагчийг ажиллуулахын тулд бэлтгэгдсэн хүмүүсийн хамт гал унтраагуур (аюултай бодистой таарч) хангахыг шаарддаг.

**Зохиогчийн эрхтэй контент ашиглах**

Хэрэв та өөрийн Эвентэд хөгжим, кино зэрэг контентийг багтаахаар шийдсэн бол хөгжим, кино нь зохиогчийн эрхийн хуулиар хамгаалагдсан бөгөөд олон нийтэд үзүүлэх аливаа тоглолтод тусгай зөвшөөрөл шаардлагатай.

Зохиогчийн эрхийн тухай хуулийн талаар дэлгэрэнгүй мэдээлэл авч анхаарах шаардлагатай болдог.

**Цахилгаан Эрчим Хүч**

Бүх цахилгаан хэрэгсэл, тоног төхөөрөмж нь дүрэмд нийцсэн байх ёстой.

Эвентэд ашигласан цахилгаан тоног төхөөрөмжийг шошголож, туршсан байх ёстой. Хэрэв тоног төхөөрөмж нь шошгогүй, зөвшөөрөгдсөн кабелийн таглаагүй, эсвэл ЗДТГ-ын төлөөлөгч гэмтэлтэй гэж үзвэл ЗДТГ аюулыг арилгах эсвэл эвентийг зогсоох хүртэл уг төхөөрөмжийг салгах хүсэлт гаргах эрхтэй. Бүх цахилгаан хэрэгсэл нь хөдөлмөрийн аюулгүй ажиллагааны дүрэмд нийцсэн байх ёстой.

Интертаймэнт , лангууны операторууд өөрсдийн генератор эсвэл батарейны хүчийг ашиглаж болно.

Цахилгааны кабель ба утсыг явган хүний хөдөлгөөн, модны халхавч, усны эх үүсвэрээс хол, аюулгүй суурилуулсан байх ёстой.

**Цэвэрлэгээ ба хог хаягдлын менежмент**

Эвентийн төгсгөлд нөөц газар, цэцэрлэгт хүрээлэнг цэвэр, эмх цэгцтэй байлгах, бүх дэлгэц, сурталчилгааны материал, илүүдэл хог хаягдлыг арилгах нь эвент зохион байгуулагчийн үүрэг юм.

**Ус, мөсөн дээрх эвент**

Хэрэв таны эвент гол мөрөн, нуур, нуурын эргийн орчмын аль нэгийг ашиглах бол та аюулгүй байдалд онцгой анхааралаа хандуулж Онцгой Байдлын Газартай хамтран ажиллах хэрэгтэй юм.

## ХАВСРАЛТ 15. ЭВЕНТЭД ТАВИГДАХ ҮНДСЭН ШААРДЛАГА /ТӨСӨЛ/

**Эвентэд тавигдах үндсэн шаардлага**

1. **Хэрэглэх хүрээ**

Эдгээр шаардлагууд нь байгууллага, аж ахуй нэгж, хувь хүмүүсийн санаачлан зохион байгуулж буй урлаг, соёл, спорт, бизнесийн арга хэмжээнд тавих шаардлага болно.

2. **Норматив ишлэл**

Энэхүү стандартад дараах баримт бичгүүдээс иш татаж хэрэглэсэн.

- MNS 6426 : 2013 Тусгай хамгаалалттай газар нутаг дахь эко аялал жуулчлалын зориулалттай байр сууц. Үйлчилгээнд тавих нийтлэг шаардлага
- MNS 14001:2016 Байгаль орчны менежментийн тогтолцоо. Шаардлага, хэрэглэх арга зүйн заавар
- MNS 4588:2008 Хэрэглэгчдэд зориулсан үйлчилгээ. Зочид буудалд тавих ерөнхий шаардлага
- MNS 4946 : 2005 Хоолны газрын ангилал зэрэглэл. Үндсэн шаардлага
- MNS 4958 : 2000 Амралт, сувиллын газрын үйлчилгээ
- MNS 4244:94 Галын аюулгүй байдал. Ерөнхий шаардлага
- MNS 900:92 Ундны усны эрүүл ахуйн шаардлага
- Барилгын норм ба дүрэм 2.08.02-89
- Жуулчны авто тээврийн үйлчилгээ. Ерөнхий шаардлага /2006 оны 34, 2009 оны 38 дугаар тогтоолоор нэмэлт өөрчлөлт орсон/

3. **Нэр томъёо, тодорхойлолт**

**Эвент** – Гадаад дотоодын оролцогчдыг хамруулсан, сонирхлыг татахуйц урлаг, соёл, спорт, бизнесийн арга хэмжээ.

4. **Эвентэд тавих үндсэн шаардлага**

Эвент нь таних тэмдэг, тэмдэглэгээ бүхий талбайн зохион байгуулалттай, аюулгүй байдлыг хангасан орц гарцтай, гадаад, дотоод орчны тохижилт сайтай, нэр хаягтай, тээврийн хэрэгсэл зогсох зогсоолтой, хүний тооноос хамаарч анхны тусламжийн багтай байна.

Эвент нь оролцогчийг хүлээн авах, мэдээлэл өгөх хэсэг, нийтийн бие засах газартай байна.

Эвент нь байгаль, экологид ээлтэй, оршин суугчид, нутгийн иргэд, ЖДҮ-г дэмжихэд чиглэсэн эсвэл тэдэнд сөргөөр нөлөөлөхөөргүй байна.

Оролцогчдод зориулсан гол горхи бохирдуурлахгүй байх, нуурын усанд орох, самар жимс түүх, мал амьтадтай харьцах, халаасны хулгайгаас сэргийлэх, архи тамхи хэрэглэхгүй бүсийн талаар санамж, анхааруулга байрлуулсан байна.

Эвентийн үеэр гэнэтийн халдлага, үер, газар хөдлөлт, аянгын болон галын аюулгүй байдлыг хангасан байна.

Оролцогчид болон зохион байгуулагчид, жуулчдыг хүлээн авах, байрлуулах, үйлчлэх, үзүүлбэр үзүүлэх нөхцлийг бүрдүүлсэн зориулалтын тусгай талбайтай байна.

**А. Эвентийн байгууламж, техник хангамжид тавих шаардлага**

- Эвент зохион байгуулагдаж буй талбайн зохион байгуулалт, тайзны байгууламж, тоног төхөөрөмжүүд нь барилгын норм ба дүрэмд тавигдсан шаардлагыг хангасан байна.
- Барилгын орох, гарах хаалга нь чадварын бэрхшээлтэй хүмүүсийг хүлээн авах, үйлчлэх нөхцлийг хангасан зориулалтын замтай байна.
- Бүх төрлийн дулаан, цахилгаан болон ундны цэвэр усны хангамж, бохир ус зайлуулах тоног төхөөрөмжүүд нь техникийн ашиглалтын зохих норм дүрмийн дагуу ашиглагдана.
- 24 цагийн турш цахилгаан болон халуун хүйтэн усан хангамж, бохир ус зайлуулах тоног төхөөрөмжүүд нь техникийн ашиглалтын зохих норм дүрмийн дагуу ашиглагдана.
- Танхимд агаарын хэвийн солилцоог хангах ердийн болон механик салхивчтай байна.
- Эвентэд оролцогчдод зориулсан нийтийн үйлчилгээний цэгүүд, хоолны газрын хооллох танхим, бие засах газартай байх бөгөөд эвент үргэлжлэх хугацаанд гэрэлтүүлэгтэй байна.
- Эвентийн хамгийн их хүн цуглардаг төв хэсэгт ариун цэврийн газрын байрлалыг тодорхой заасан хаяг тэмдэг байрлуулна.

**Б. Галын аюулгүй байдалд тавих шаардлага**

- Барилгын байгууламж нь “Галын аюулгүй байдал, ерөнхий шаардлага” MNS 4244; 94 стандартын шаардлагыг хангасан байна.
- Эвент зохион байгуулагдаж буй барилгын давхар бүрт, хэрэв гадна талбайд зохион байгуулагдаж байгаа үйл ажиллагааны хэсэг бүрт гал унтраах хэрэгсэл, галын аюулгүйн таних тэмдэг бүхий, аваарын гарц, гарц, авралтын зураг, бүдүүвчтэй байна.
- Гадагш чиглэсэн тусдаа аваарын хаалгатай байна.

- Олон нийтийн танхимд галд тэсвэргүй материалаар хийгдсэн хулдаас, хивсэнцэр дэвсэхийг хориглоно.
- Техник, тоног төхөөрөмж, цахилгаан хэлхээг галын аюулгүйн болон техник ашиглалтын дүрмийн дагуу угсарсан байна.

**В. Хоолны газрууд, хоол үйлдвэрлэлд тавих шаардлага**

- Ундны ус нь " Ундны усны эрүүл ахуйн шаардлага" MNS 900:92 стандартын шаардлагыг хангасан байна.
- Хоол, үйлдвэрлэл, үйлчилгээ зохион байгуулалт нь " Хоолны газрын үйлчилгээ" MNS 4946:2000 стандартын шаардлагыг хангасан байна.
- Нийтийн үйлчилгээний өрөө, танхим нь эрүүл ахуйн шаардлагад нийцсэн агааржуулах төхөөрөмж, гэрэлтүүлэгтэй байна.
- Хоолны газрын үйлдвэрлэл, үйлчилгээний үйл ажиллагаанд нийтийн хоолны эрүүл ахуйн нийтлэг дүрмийг мөрдөж, хоолноос дээж авч бүртгэл хөтлөх ба үйлдвэрлэл үйлчилгээний тоног төхөөрөмж өдөр бүр цэвэрлэнэ.
- Эрх бүхий байгууллагаас баталгаажсан, эрүүл ахуйн шаардлага хангасан түүхий эд, хүнсний бүтээгдэхүүнээр хангаж, стандартын дагуу хадгална.
- Орон нутагт зохион байгуулагдаж буй эвентийн хоол үйлдвэрлэлийн газрууд хээрийн хоолны зориулалтын сав, хэрэглэл, нойтон салфеткаар үйлчилнэ.
- Үйлчилгээний зааланд цэвэрлэгээ, үйлчилгээ, хог хаягдал зайлуулах, хортон шавьжын эсрэг хамгаалалт зэрэг үйл ажиллагаанд эрүүл ахуйн норм дүрмийг мөрдөнө.
- Хоол бэлтгэх хэсэгт тогтмол цэвэрлэгээ хийнэ. Цэвэрлэгээний графиктай байна.

**Г. Эвент зохион байгуулагч, хүний нөөцөд тавих шаардлага**

- Эвент зохион байгуулагчид, мэдээллийн ажилчид, анхны тусламжийн багийнхан, цагдаа, онцгой байдлын газрын ажилтнуудыг гадаад байдлаас нь танигдахад хялбар болгох тусгай лого бүхий мандат, шаардлагатай тохиолдолд дүрэмт хувцас, энгэрийн тэмдэг хангана.
- Ажиллагсдын ажил үүргийн хуваарь, техник аюулгүй ажиллагааны дүрэмтэй байна.
- Эвентийн ажиллагсад нь эрүүл мэндийн үзлэгт бүрэн хамрагдан эрүүл болох нь нотлогдсон байна.
- Эвентийн мэдээллийн алба, хүлээн авах хэсгийн ажилтан олон нийттэй харилцах менежмент болон ёс зүйн хэм хэмжээ, ур чадварын сургалтанд хамрагдсан байна.
- Эвентэд оролцогчдын тооноос хамааран сайн дурын ажилтан, шаардлагатай тохиолдолд мэргэжлийн байгууллагуудаас гэрээт ажилчдыг ажиллуулна.
- Эвент зохион байгуулагч нь эвентийн талаарх мэдээлэл, маягт, тайлан, бүртгэлийг бүрэн хийж нийслэл, орон нутгийн аялал жуулчлалын газарт хүргэнэ.

**Д. Мэдээллийн алба, хүлээн авах хэсэгт тавих шаардлага**

- Эвент нь хүлээн авах, бүртгэх, үдэх, жуулчныг мэдээллээр хангах үйлчилгээг үзүүлнэ.
- Эвентийн хөтөлбөр, амралтын газар, тээврийн хэрэгсэл, бусад төрлийн үйлчилгээ болон үйлчилгээний үнэ тарифын мэдээллээр хангана.

- Эмнэлэгийн анхан шатны тусламж үзүүлэх зориулалттай эмийн сантай байна.
- Гээсэн эд зүйлсийг бүртгэн хадгалах түр байртай байна.
- Төөрсөн хүүхдийг түр байрлуулах газартай байна.

**Е. Нийтийн бие засах газарт тавих шаардлага**

- Эрэгтэй эмэгтэй бие засах суултуурыг тусад нь эсвэл нэг дор байрлуулж болох ч үйс тусгаарласан хаягтай, хаалга нь түгжээтэй байна.
- Ариун цэврийн өрөө нь угаалтуур, суултуур, ариун цэврийн цаастай байна.
- Хогийн саванд нэг удаагийн хэрэглээ бүхий уул хэрэглэнэ.
- Цахилгаан гар хатаагч байхгүй тохиолдолд нэг удаагийн ариутгагч, нойтон сальфеткаар үйлчилнэ.
- Бие засах газрыг холбогдох эрүүл ахуйн шаардлагын дагуу тогтмол ариутгал цэвэрлэгээ хийнэ.
- Ариун цэврийн байгууламжийн агаарыг нэг цагт 5-аас доошгүй удаа сэлгэх ба цонх хаалгаар агаар сайн нэвтрүүлэх боломжтой байна.
- Ариун цэврийн газрыг заасан сумны дагуу зөв байрлуулан, сумтай хаяган дээр дээр ариун цэврийн газар хэдэн метр байгааг бичиж тэмдэглэнэ.

**Ё. Эвентэд үйлчлэх тээврийн хэрэгсэл, зогсоолд тавих шаардлага**

- Эвентийн зогсоол нь MNS 5342:2003 “Автомашины зогсоол, ангилал, ерөнхий шаардлага” , MNS 5879 : 2012 “Нийтийн тээвэр Замналын зогсоол. Ангилал. Техникийн шаардлага” стандартад нийцсэн байна.
- УТХГН-ийн зарим бүсэд автомашины зогсоолыг дэмждэггүй. Эвент Тусгай Хамгаалалттай Газар Нутагт зохион байгуулагдаж байгаа тохиолдолд Хязгаарлалтын бүсэд батлагдсан зураг төсөл, зохих журмын дагуу зам тавих, тээврийн хэрэгслийн зогсоол гаргана.
- Зогсоолд, хөдөлгөөний урсгалын чиглэл, хурдын хязгаарын замын тэмдэг, тэмдэглэгээ, шугамын зурвас тавина6
- Хөгжлийн бэрхшээлтэй иргэний тээврийн хэрэгслийн зогсоолыг орц гарцад хамгийн ойр зайд төлөвлөнө.
- Эвентэд зориулан зам хаах шаардлагатай тохиолдолд өргөдөл, хураамж, мэдэгдэлийг зохих журмын дагуу хийнэ.
- Эвентэд 5000 гаруй хүн оролцох төлөвтэй нийтийн тээврийн газартай холбогдож эвент рүү чиглэсэн тусгай нийтийн тээврийн хэрэгслээр хангана.

**Ж. Оролцогчдод зориулсан үйлчилгээ, хүртээмжтэй байдалд тавих шаардлага**

- Эвент дээр утаат тамхи татахыг хязгаарлах, эсвэл тамхи татах цэгийг тусгайлан гаргахад анхаарч ойлгомжтой таних тэмдэгийг байрлуулна.
- Хөгжлийн бэрхшээлтэй иргэний тээврийн хэрэгслийн зогсоолыг орц гарцад хамгийн ойр зайд төлөвлөнө.
- Боломжтой бол нийтийн бие засах газрыг гурван хэсэгт хувааж эрэгтэй, эмэгтэй, хөгжлийн бэрхшээлтэй иргэнийх гэж ангилна.
- Цар тахал дэлгэрсэн үед эвентийг цар тахлын үеийн хуульд нийцүүлэн зохион байгуулна.

**3. Байгаль орчинд хог хаягдал**

- Эвентийн үеэр ажиллаж байгаа хоолны газар, хүнс борлуулагч нар байгальд ээлтэй бараа материалыг ашиглаж, ангилна.
- Эвентийн төгсгөлд ашигласан талбайг цэвэр, эмх цэгцтэй байлгах, бүх сурталчилгааны материал, илүүдэл хог хаягдлыг арилгана.
- Хогийн савыг хоол хүнс борлуулах газар болон орц гарцны ойролцоо, уулзвар цэгүүдэд байрлуулж, хогийн савыг дүүрэхээс нь өмнө нь тогтмол султгаж байна.

# АШИГЛАСАН МАТЕРИАЛЫН ЖАГСААЛТ


1. Asia-Pacific Economic Cooperation, Introduction to Risk Management in Tourism-Instructur’s Guide, 2018
2. Azoev G.L.Sumarokova E.V (2020) Benchmarking of Market capacity assessment methods and their application to digital products
3. Chaiwat Baimai, Jose Luis Daniel (2009) “Market Potential for Tourism in Emerging Markets”
4. Consumer potential of households, its differentiation and dynamics in the new economy: evidence from Russia, Advances in Social Science, Education and Humanities Research, volume 240, 2018
5. Donald Getz, “Event tourism: Definition, evolution, and research”, Tourism Management 29 (2008)
6. Emet GÜREL, SWOT Analysis: A Theoretical Review, 2017, Journal of International Social Research 10(51):994-1006
7. Estimating the economic impacts of festivals and events: a research guide, 2017
8. Gordon Shaw, M. Saayman, A. Saayman, Identifying risks facing the South African tourism industry, 2012
9. Institute of Risk Management, A Risk Practitioners Guide to ISO 31000: 2018
10. Market capacity assessment for educational service, Galina A.Kalugina,2020
11. Morgan Westcott and Wendy Anderson, Eds, Introduction to Tourism and Hospitality in BC – 2nd Edition, 2021
12. OECD (2017), “Major events as catalysts for tourism”, *OECD Tourism Papers*, 2017/02, OECD Publishing, Paris
13. Risk management – Risk assessment techniques, ISO 31010:2009
14. Risk Management Guidelines, ISO 31000:2018, 2018
15. Risk management-Vocabulary ISO Guide 73:2009
16. “Strategy development using TOWS matrix for international project risk management based on prioritization of risk categories”. Rahul Vishwanath_Dandage and others. 22 March 2019 . “International Journal of Managing Projects in Business”. ISSN: 1753-8378.
17. Surya Prakash, Gunjan Soni, Ajay Pal Singh Rathore, Mitigation strategies for risk management and sustainability in supply chain, 2015
18. The impact of 9/11 and other terrible global events on tourism in the U.S. and Hawaii
19. World Economic Forum, The Travel and Tourism Competitiveness Report 2019
20. Аялал жуулчлалын салбарын өнөөгийн байдал, шийдвэрлэх асуудлууд, Түүвэр судалгааны үр дүн Монголбанк, 2019
21. БОАЖЯ, “Байгаль орчин, Аялал жуулчлалын салбарын 2021-2024 оны стратеги төлөвлөгөө”, 2021,

22. Ч. Болорхүү, “Монголын аялал жуулчлалын эвентийн хөгжил, цаашдын хандлага” МАЖХ, 2019 он
23. Дэлхийн аялал жуулчлалын байгууллага, жилийн аялал жуулчлалын статистик мэдээлэл, 2018-2021
24. Дэлхийн аялал жуулчлалын байгууллагын тайлан, 2019
25. Импорттой өрсөлдөх аж үйлдвэрийн бүтээгдэхүүний шинжилгээ, Монголбанк, Судалгааны ажил, товхимол 14, 2019
26. Статистикийн эмхэтгэл, 2019, Иргэний нисэхийн ерөнхий газар
27. ИНЕГ-ын НААХЗА-ны дарга Ё.Эрдэнэбат. 2018 тайлан мэдээ
28. Монголбанк, Судалгааны ажил, товхимол 13, 2018
29. Төр хувийн хэвшлийн түншлэлийн гарын авлага (2014), Эдийн засгийн хөгжлийн яам
30. Уртнасан,Н. 2021.10.26, “Tourism forum Mongolia 2021”
31. Хувь хүний орлогын албан татварын тухай хууль
32. Түүвэр судалгааны тайлан, “АФИМ Монголиа” ТББ, 2021 он
33. Нийслэлийн байгаль орчин, аялал жуулчлалын газрын мэдээлэл, 2018-2021
34. Архангай аймгийн Байгаль орчин, аялал жуулчлалын газрын мэдээлэл, 2021
35. Баян-Өлгий аймгийн Байгаль орчин, аялал жуулчлалын газрын мэдээлэл, 2021
36. Баянхонгор аймгийн Байгаль орчин, аялал жуулчлалын газрын мэдээлэл, 2021
37. Булган аймгийн Байгаль орчин, аялал жуулчлалын газрын мэдээлэл, 2021
38. Говь-Алтай аймгийн Байгаль орчин, аялал жуулчлалын газрын мэдээлэл, 2021
39. Дорнод аймгийн Байгаль орчин, аялал жуулчлалын газрын мэдээлэл, 2021
40. Дорноговь аймгийн Байгаль орчин, аялал жуулчлалын газрын мэдээлэл, 2021
41. Дундговь аймгийн Байгаль орчин, аялал жуулчлалын газрын мэдээлэл, 2021
42. Завхан аймгийн Байгаль орчин, аялал жуулчлалын газрын мэдээлэл, 2021
43. Өмнөговь аймгийн Байгаль орчин, аялал жуулчлалын газрын мэдээлэл, 2021
44. Сүхбаатар аймгийн Байгаль орчин, аялал жуулчлалын газрын мэдээлэл, 2021
45. Орхон аймгийн Байгаль орчин, аялал жуулчлалын газрын мэдээлэл, 2018-2021
46. Төв аймгийн Байгаль орчин, аялал жуулчлалын газрын мэдээлэл, 2018-2021
47. Увс аймгийн Байгаль орчин, аялал жуулчлалын газрын мэдээлэл, 2021
48. Ховд аймгийн Байгаль орчин, аялал жуулчлалын газрын мэдээлэл, 2021
49. Хөвсгөл аймгийн Байгаль орчин, аялал жуулчлалын газрын мэдээлэл, 2021
50. Хэнтий аймгийн Байгаль орчин, аялал жуулчлалын газрын мэдээлэл, 2021
51. “Талын түмэн адуу 2019” эвентийн тайлан
52. “Талын түмэн адуу 2021” эвентийн тайлан


Цахим хуудас:


- БОАЖЯ: http://www.mne.mn/
- СТАТИСТИКИЙН МЭДЭЭЛЛИЙН НЭГДСЭН САН: www.1212.mn
- МОНГОЛ УЛСЫН ҮНДЭСНИЙ СТАТИСТИКИЙН ХОРОО: www.nso.mn
- МОНГОЛБАНК : www.mongolbank.mn
- ЭРХЗҮЙН МЭДЭЭЛЛИЙН НЭГДСЭН СИСТЕМ: https://www.legalinfo.mn
- The Organisation for Economic Co-operation and Development: www.oecd.org
- INTERNATIONAL OLYMPIC COMMITTEE:https://olympics.com
- ICE FESTIVAL HARBIN: https://www.icefestivalharbin.com
- INTERNATIONAL FEDERATION OF ASSOCIATION FOOTBALL: www.fifa.com
- НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГЫН ХЭРЭГЖҮҮЛЭГЧ АГЕНТЛАГ АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН ГАЗАР: https://tourism.ub.gov.mn/

- Business and economic data for 200 countries: www.theglobaleconomy.com/
- ЭДИЙН ЗАСГИЙН БОДЛОГО, ӨРСӨЛДӨХ ЧАДВАРЫН СУДАЛГААНЫ ТӨВ: www.ecrc.mn
- Glasgow City Council: https://www.glasgow.gov.uk/
- INTERNATIONAL ORGANIZATION FOR STANDARDIZATION: https://www.iso.org/
- New tourism strategy for Wales: www.visitmonmouthshire.com/events-management/aims.aspx
- The official website of the World Nomad Games: http://worldnomadgames.com/
- WORLD NOMADS: https://www.worldnomads.com/
- THE ASTANA TIMES: https://astanatimes.com
- United Nations Educational, Scientific and Cultural Organization: https://ich.unesco.org
- The Octoberfest international guide: https://www.oktoberfest.net/oktoberfest-statistics/
- The Forbes: https://www.forbes.com
- The Economy: https://www.theeconomyjournal.eu
- Хөгжмийн наадам: www.playtime.mn
- www.digitalhub.fifa.com/m/337fab75839abc76/original/
- https://www.thediplomaticaffairs.com
- https://www.thengfq.com/company/pga-tour/
- https://www.mardigrasneworleans.com/history/history-faqs
- www.stillmed.olympic.org
- http://rededoesporte.gov.br/en/news/tourists-give-olympic-games
- https://www.budgetyourtrip.com/china/harbin
- https://www.indiatvnews.com/sports/cricket/bcci-earns
- http://www.levyinstitute.org
- https://www.linkedin.com/pulse/us-china-international-trade-indices-comprehensive-2020
- https://www.holidify.com/pages/paro
- https://www.tourism.gov.bt
- http://revecon.ro/articles/